# ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАЙЛАН

*(Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, авлигатай тэмцэх үйл ажиллагаанд холбогдох эрх зүйн зохицуулалтад шинжилгээ хийж, тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, хууль тогтоомжийг боловсронгуй болгох хэрэгцээ шаардлагын тухай)*

Улаанбаатар хот

2022 он

**Судалгааг захиалагч:**

Авлигатай тэмцэх газар

**Судалгааны багийн ахлагч:**

Б.Нармандах

Шихихутуг их сургуулийн Судалгааны хүрээлэнгийн нарийн бичгийн дарга, Хууль зүйн доктор (Ph.D)

**Судалгааны багийн гишүүд:**

Б.Мөнх-Эрдэнэ
Хууль зүйн магистр (LL.M)
Г.Хонгор
Хууль зүйн магистр (LL.M)

**АГУУЛГА**

**ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ**

**УДИРТГАЛ**

**НЭГ. ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ**

1.1. Үнэлгээ хийх үндэслэл

1.2. Үнэлгээ хийх хүрээ

1.3. Шалгуур үзүүлэлтийг тогтоох

1.4. Шалгуур үзүүлэлтийг томьёолох

1.5. Мэдээлэл цуглуулах

**ХОЁР. ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН БАЙДАЛ**

2.1. Хууль тогтоомжийн хүрээнд асуудлыг үүсгэж буй шалтгаан нөхцөл

**ГУРАВ. ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ**

3.1. Хуулийн хэрэгжилт, практикт нийцэж байгаа эсэхийг судалгааны хүрээнд үнэлсэн байдал

**ДӨРӨВ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ**

4.1. Дүгнэлт

4.2. Зөвлөмж

**ХАВСРАЛТ**

**НОМ ЗҮЙ**

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

| | |
|---|---|
| АТГ | Авлигатай тэмцэх газар |
| ЗГ | Засгийн газар |
| УИХ | Улсын Их Хурал |
| ЭБАТ | Эрх бүхий албан тушаалтан |
| ЭХ | Эрүүгийн хууль |
| ЭХХШтХ | Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль |
| НҮБ | Нэгдсэн Үндэстний байгууллага |
| АЭК | Авлигын эсрэг конвенц |

# УДИРТГАЛ

Монгол Улсын Их Хурал 2016 оны 11 дүгээр сарын 3-ны өдөр нэгдсэн хуралдаанаараа “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын 51 дүгээр тогтоолыг батлан гаргасан билээ. Ингэснээрээ Монгол Улс 11 зорилт бүхий бодлогын баримт бичигтэй болж, авлигатай тэмцэх үйл ажиллагааг тодорхой стратегийн дагуу 2023 он хүртэл 2 үе шаттай явуулах боломж бүрдсэн. Түүнчлэн АТГ-аас “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-г иргэд, олон нийтээр хэлэлцүүлж, тэдний саналыг тусган боловсруулж, Засгийн газрын 2017 оны 4 дүгээр сарын 12-ны өдрийн 114 дүгээр тогтоолоор батлуулсан.

Гэсэн хэдий ч өгөөдөр манай улсад авлига гарч болох нөхцөл боломжийг бүрдүүлсэн, хүнд суртал, чирэгдэл учруулсан, үндэслэлгүй төлбөр хураамж тогтоосон, хуулиар тусгай эрх олгоогүй байхад эрх зүйн акт батлан мөрдүүлсэн зэрэг хууль тогтоомжид нийцээгүй, авлига, ашиг сонирхлын зөрчлийн шинжтэй үйлдлүүд гарсаар байна. Үүнээс сэргийлэх, авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, авлигатай тэмцэх үйл ажиллагаанд холбогдох эрх зүйн зохицуулалтад шинжилгээ хийж, авлига, ашиг сонирхлын зөрчилд өртөх эрсдэл өндөр салбарт урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, авлигын эсрэг стратеги, санаачилгыг тодорхойлох, хянан засахад анхаарах асуудал байгааг судлан гаргаж ирэх нь энэхүү судалгааны зорилго болно.

Авлигын эсрэг хууль тогтоомж хангалтгүй, боловсронгуй бус байгаагаас гадна эрх зүйн хийдэл, алдаа цөөнгүй байгаа нь эерэг үр дүн гаргахад сөргөөр нөлөөлөхийн зэрэгцээ өөр нэг асуудал бол олон нийтийн дэмжлэг дутагдах явдал юм. Олон нийтийн дэмжлэг авахад авлигын эсрэг урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлыг үр дүнтэй явуулах нөхцөл бүрддэг.

## НЭГ. ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ

Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, авлигатай тэмцэх үйл ажиллагаанд холбогдох эрх зүйн зохицуулалтад үнэлгээ хийх ажлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор баталсан "Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал"-ын дагуу төлөвлөх, хэрэгжүүлэх буюу дүн шинжилгээ хийх, үнэлэх гэсэн гурван үе шаттайгаар хэрэгжүүлсэн.

Төлөвлөх үе шатанд:

- Үнэлгээ хийх үндэслэлийг тодорхойлох;
- Үнэлгээ хийх хүрээг тогтоох;
- Шалгуур үзүүлэлтийг тогтоож, томьёолох;
- Мэдээлэл цуглуулах ажлыг хийж гүйцэтгэхээр төлөвлөсөн.

### 1.1.Үнэлгээ хийх шалтгаан, үндэслэл:

Нийгэм, төрийн үйл ажиллагаа авлигаас ангид байх суурь зарчмыг тодорхойлж, авлигатай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх эрх зүйн шинэ орчинг бүрдүүлэх зорилгоор Монгол Улс 2005 онд Авлигын эсрэг НҮБ-ын конвенцод нэгдэн орж[1], 2006 онд Авлигын эсрэг хууль, 2012 онд Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг батлан Эрүүгийн хууль, Төрийн албаны тухай хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль болон бусад хууль, УИХ-ын "Алсын хараа 2050-Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого батлах тухай" 2020 оны 52, "Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр" батлах тухай 2016 оны 51, "Авлигатай тэмцэх газрын зохион байгуулалтын бүтэц, орон тоо, албан хаагчийн албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 2019 оны 67 дугаар тогтоол, бусад хууль тогтоомжоор авлигын эсрэг харилцааг зохицуулж ирсэн.

Авлигын эсрэг хууль батлагдсанаас хойш өнөөдрийг хүртэлх хугацаанд 19 удаа нэмэлт, өөрчлөлт оруулж, авлигатай тэмцэх үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх эрх зүйн үндсийг бүрдүүлж, нийтийн албан тушаалтанд хориглох зүйлийг тодорхой болгох, хөрөнгө орлогын мэдүүлэг гаргах түүнийг бүртгэх, хадгалах, хянан шалгах, хариуцлага хүлээлгэх үндэслэл, журмыг боловсронгуй болгох, аж ахуй нэгж, байгууллага, иргэний авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд хүлээх үүргийг нь тодорхойлж, авлигын эсрэг хууль тогтоомжийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тодорхой болгох чиглэлээр хуулийн зохицуулалтыг боловсронгуй болгож ирсэн байна. (Хавсралт №1. Авлигын эсрэг хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтүүд)

Гэсэн хэдий ч авлигаас урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалт бүрэн хангагдаагүй, авлигатай тэмцэхэд олон нийтийг соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг тодорхойлсон боловч урьдчилан сэргийлэх зохицуулалт хийдэл, зөрчилдөөнтэй, эдийн засагт эрүүл бус орчин бий болгож, шударга ёс, тэгш байдлыг алдагдуулдаг, нийгэмд хууль бус сөрөг үзүүлж улмаар тухайн орны үндэсний аюулгүй байдал, тусгаар тогтнол, нэгэнт гарсан хууль тогтоомжийг үл хэрэгсэн дур зоргоор авирлах явдал хэвийн үзэгдэл болон хувирсан, уул уурхай хөгжсөн аймаг сум, хилийн бүсийн газруудыг авлигачдад худалдсан, өндөр түвшний авлигын гэмт хэргийн хариуцлага хууль тогтоомжид хангалттай тусгагдаагүй, авлига газар авсан нь үндэсний аюулгүй байдалд заналхийлж байна зэрэг шүүмжлэл цөөнгүй байсаар байна.

[1] Монгол улс АЭК-д 2005 оны дөрөвдүгээр сарын 29-ний өдөр нэгдэн орж, мөн оны 10 дугаар сарын 27-ны өдөр соёрхон баталсан бөгөөд Монгол Улсын эрх зүйн тогтолцооны салшгүй хэсэг мөн.

Эндээс харахад хууль тогтоомжийг хэрэгжүүлэх явцад түүний зохицуулалт бодит байдалтай нийцээгүй, тухайн харилцааг зохицуулах боломжгүй, эсхүл нийгмийн харилцааны өөрчлөлт, хөгжлөөс хоцорсон, зайлшгүй зохицуулах ёстой харилцааг хамарч зохицуулаагүй, эсхүл тэдгээрээс улбаалсан сөрөг үр дагавар бий болсон төдийгүй, нийгмийн бүлэг, төрийн бус байгууллага хуулийн хэрэгжилттэй холбоотой тодорхой асуудлаар түүнийг өөрчлөх, шинэчлэх эсхүл хүчингүй болгох талаар үндэслэл бүхий санал цөөнгүй гаргасан байна.2

Тиймээс өнөөгийн Монгол Улсын хууль тогтоомж нь авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, авлигатай тэмцэх үйл ажиллагаатай холбоотой харилцааг зохицуулж чадаж байгаа эсэх болон тухайн хууль тогтоомжийн нийгэмд үзүүлж байгаа эерэг, сөрөг нөлөөллийг илрүүлэх, үндэсний болон олон улсын түвшинд шинэ тутам үүсэж буй сорилтуудыг амжилттай даван туулах, авлигын эсрэг сайн засаглалын үндсэн зарчим болох хууль дээдлэх, ил тод, хариуцлагатай хамтран ажиллах шаардлагыг хангаж байгаа эсэх, хууль тогтоомжийн нийцлийг үнэлэх шаардлагын дагуу Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор баталсан "Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал"-ын 3 дугаар зүйлийн 3.2.2, 3.2.3 дахь хэсэгт заасны дагуу үнэлгээ хийх шаардлагатай гэж үзлээ.

### 1.2. Үнэлгээ хийх хүрээ

Үнэлгээний хүрээг тогтоох ажиллагаа нь хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврыг судлах явцад агуулгын хувьд чухал ач холбогдолтой, нөлөөлөл үзүүлэх гол зохицуулалтыг тодорхойлоход чиглэдэг.

Бид төлөвлөлтийн дагуу хуваарь гарган 2022.06.01-ний байдлаар Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжийг https://legalinfo.mn/mn сайтаас татан авч, хууль тогтоомжид авлигын эсрэг зохицуулалт хэрхэн тусгагдсан, тэдгээр нь зорилгодоо хүрч байгаа эсэх, хууль тогтоомжийн хоорондын уялдаа холбоо хангагдсан эсэх, болон хууль тогтоомжийн хэрэгжилт, түүний эерэг, сөрөг талыг үнэлэх шинжилгээ хийхээр судалгааны хүрээг тогтоосон болно.

Судалгааг гүйцэтгэхдээ Авлигатай тэмцэх тухай хуулийн зорилгыг хэрэгжүүлэхэд агуулгын хувьд ач холбогдолтой, тулгамдаж буй асуудалд холбогдох хууль тогтоомжийн зүйл, заалтыг түүвэрлэн авч үнэлгээний хүрээг тогтоов. Үүнд:

| Олон улсын гэрээ | Хууль | Тогтоомж |
|---|---|---|
| 1 | 814 | 3 |

Нөгөө талдаа авлигатай холбоотой эрх зүйн зохицуулалтад байгаа алдаа, хийдлийг тогтоож цаашид анхаарах асуудлыг гаргаж ирэх нь энэхүү судалгааны нэгэн чухал үр дүн мөн.

### 1.3.Шалгуур үзүүлэлтийг тогтоох, томьёолох

"Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал"-ын 3 дугаар зүйлийн 3.4 дэх хэсэгт заасны дагуу авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, авлигатай тэмцэх үйл ажиллагаанд холбогдох эрх зүйн зохицуулалтыг

---

[2] - Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаарх төсөөллийн 2019 оны судалгааны тайлан;
- Авлигатай тэмцэх хууль тогтоомжийн хэрэгжилт, авлигын ерөнхий нөхцөл байдал, авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт 2021;
- Авлигатай тэмцэх хууль тогтоомжийн хэрэгжилт, авлигын ерөнхий нөхцөл байдал, авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт 2020;
- Авлигатай тэмцэх хууль тогтоомжийн хэрэгжилт, авлигын ерөнхий нөхцөл байдал-2018, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт (2016-2018)

үнэлэхэд оновчтой, бодитой, хэмжиж болохуйц байдлыг баримталж, үнэлгээний хүрээ, онцлогоос хамааран дараах шалгуур үзүүлэлтийг сонгосон болно:

- зорилгод хүрсэн, хүлээн зөвшөөрөгдсөн байдал;
- практикт нийцэж байгаа байдал, бусад үр дагавар.

Үүнээс зорилтод хүрсэн эсэх болон хууль тогтоомжийн нийцэл хүлээн зөвшөөрөгдсөн байдлыг

- Авлигын эсрэг хууль тогтоомжийн нийцэл, хэрэгцээ, шаардлага, зорилгодоо хүрсэн эсэх;
- хууль тогтоомжийг нийгэм хүлээн зөвшөөрч, сайн дураар сахин биелүүлж байгаа эсэх;

Практикт нийцэж байгаа байдал, бусад үр дагаврыг

- авлигатай холбоотой зохицуулалт практикт хэрэгжиж буй байдал;
- Хэрэгжилтийн үр нөлөө, хүлээн зөвшөөрөгдсөн байдал, түүнийг хэрэгжүүлэхэд гарч байгаа эерэг, сөрөг үр дагавар зэргээр үнэлнэ.

### 1.4.Мэдээлэл цуглуулсан арга

Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, авлигатай тэмцэх үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтад шинжилгээ хийж, хууль тогтоомжийн өнөөгийн байдал, боловсронгуй болгох хэрэгцээ шаардлагыг судлах, тулгамдсан асуудлыг шийдвэрлэх зөвлөмж бүхий үнэлгээ, санал боловсруулах зорилгоор Авлигын эсрэг НҮБ-ын конвенц, Авлигатай тэмцэх тухай Монгол Улсын хууль болон бусад хууль тогтоомжийн авлигатай холбоотой зүйл, заалт, холбогдох ном, сурах бичиг, хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар холбогдох байгууллагаас гаргасан тайлан, судалгаа, бусад мэдээлэл (тухайн байдлын чанарын үзүүлэлт), эрдэм шинжилгээний илтгэл, өгүүлэл, статистик мэдээлэл, судалгааны бусад эх сурвалжид үндэслэн түүвэрлэх, харьцуулах, нэгтгэн дүгнэх, анализ хийх замаар судалсан.

Мөн тухайн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хариуцан зохион байгуулж байгаа болон чиг үүргээрээ түүнтэй холбоотой байгууллага, албан хаагч, хуулийн хэрэгжилтийг хангаж буй иргэн, албан тушаалтан, хуулийн этгээдээс нэмэлт мэдээлэл авах, асуулт, хариулт өрнүүлэх замаар фокус ярилцлага хийсэн болно.

## ХОЁР. ХЭРЭГЖҮҮЛЭХ БУЮУ ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ ҮЕ ШАТ

Төлөвлөлтийн дагуу авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, авлигатай тэмцэх үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтад шинжилгээ хийхдээ Legalinfo.mn цахим хуудсанд нийтлэгдсэн Монгол Улсын хуулиуд болон УИХ-аас тогтоолоор баталсан зарим журмуудыг эх сурвалж болгон тэдгээрийн агуулга, зарчмын хэрэгжилт бусад хууль тогтоомжтой хэрхэн уялдсан, нийцэл нь хангагдсан эсэхэд дүн шинжилгээ хийсэн. (Хавсралт №2. Авлигын эсрэг хууль тогтоомжийн нийцэл, хэрэгцээ, шаардлага, зорилготойгоо нийцэж байгаа эсэх талаарх дүн шинжилгээ)

Авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийг эрх зүйн онол, үнэлгээний шалгуурыг удирдлага болгохын зэрэгцээ Авлигын эсрэг хуулийн бүтэц, Авлигатай тэмцэх газрын чиг үүрэгтэй уялдуулан үнэлсэн.

Авлигын эсрэг хууль нь авлигатай тэмцэх үйл ажиллагааны нийтлэг зохицуулалтын үндэс мөн бөгөөд эрх зүйн онолын үүднээс зохицуулалтын арга зам, хэв маягийн онцлогийг тодорхойлбол:

Хуулийг хэрэгжилтийг хангах үндсийг тодорхойлсон, тунхагласан, засварласан, оператив хэм хэмжээнүүдийн зэрэгцээ авлигатай тэмцэх нийгэмд ашигтай харилцааны үндсийг ерөнхийд нь бэхжүүлсэн хэм хэмжээний зэрэгцээ авлигын эсрэг харилцаанд оролцогчдод тодорхой зан үйлийг хэрэгжүүлэх эрх олгосон, үүрэг болгосон, хориглосон, зөвшөөрсөн зохицуулах хэм хэмжээ, эсхүл тэдгээрийг зөрчигдсөн тохиолдолд үүсэх үр дагаврыг тодорхойлсон хамгаалах хэм хэмжээнээс бүрдэж байна. (Хавсралт №3. Авлигын эсрэг хуулийн зүйл заалтыг эрх зүйн чиг үүргийн шинжээр ангилан тодорхойлсон харьцуулалт)

Хамгаалах хэм хэмжээний хэрэгжилтийг хангах, зохицуулах хэм хэмжээ зөрчсөн этгээдэд хууль зүйн албадлага хэрэглэх, зөрчигдсөн эрхийг нөхөн сэргээх үйл ажиллагааны журмыг тогтоосон процедурын /үйл явцын/ хэм хэмжээнүүд нь бусад хууль тогтоомж, хуульчилсан актаар тогтоогдсон байна.Тухайлбал,

**Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны чиглэлээр:**

Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлд авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр төрийн байгууллага, аж ахуйн нэгж, байгууллага, иргэний хүлээх нийтлэг үүргийг хуульчилж, авлигын зөрчлийн үйлдлүүдийг хориглосон зохицуулалт оруулжээ.

Энэхүү үүрэг болгосон болон хориглосон хэм хэмжээний хэрэгжилтийг хангах хүрээнд:

- Авлигын эсрэг хууль
- Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль
- Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай
- Цагдаагийн албаны тухай хууль
- Нийтийн сонсголын тухай хууль
- Захиргааны ерөнхий хууль
- Төрийн хяналт шалгалтын тухай хууль
- Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Хөрөнгө оруулалтын тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай
- Төрийн албаны тухай хууль
- Залуучуудын хөгжлийг дэмжих тухай
- Зөвлөлдөх санал асуулгын тухай
- Төрийн бус байгууллагын тухай хууль
- Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай
- Эрүүл мэндийн даатгалын тухай
- Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиудад зарим зохицуулалтуудыг тусгасан байна.

**Олон нийтийг соён гэгээрүүлэх чиглэлээр:**

Авлигын эсрэг хуулийн 5 дугаар зүйлд олон нийтийг соён гэгээрүүлэх чиглэлээр аж ахуйн нэгж, байгууллага, иргэний хүлээх нийтлэг үүргийг хуульчилж түүний хэрэгжилтийг:

- Хууль тогтоомжийн тухай

- Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай
- Монгол Улсын их хурлын тухай
- Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль
- Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр зэрэг хууль тогтоомжоор зохицуулж байна.

**Хөрөнгө орлогын мэдүүлэг гаргах чиглэлээр:**

- Авлигын эсрэг хууль
- Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль
- Авлигын эсрэг хуулийн зарим заалтыг дагаж мөрдөх журмын тухай хууль
- Төрийн албаны тухай хууль
- Монгол улсын их хурлын тухай хууль
- Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль
- Монгол Улсын шүүхийн тухай хууль
- Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр зэрэг хууль тогтоомжоор нарийвчилсан зохицуулсан байна.

**Авлигатай тэмцэх байгууллагын чиг үүрэг, бүрэн эрхийг:**

Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлд тодорхойлж, бүрэн эрхийг хэрэгжүүлэх эрх зүйн орчныг:

- Авлигын эсрэг хууль
- Хууль тогтоомжийн тухай
- Захиргааны ерөнхий хууль
- Гүйцэтгэх ажлын тухай хууль
- Эрүүгийн хууль
- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль
- Зөрчлийн тухай хууль
- Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль
- Гэрч хохирогчийг хамгаалах тухай хууль
- Банкны тухай хууль
- Үндэсний төлбөрийн системийн тухай
- Төрийн болон албаны нууцын тухай хууль
- Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль
- Төрийн хэмнэлтийн тухай хууль
- Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль
- Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр зэрэг хууль тогтоомжоор бүрдүүлж байна.

### 2.2.Асуудал үүсгэж буй шалтгаан нөхцөл

Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, авлигатай тэмцэх үйл ажиллагаанд холбогдох харилцааг зохицуулж буй гол эх сурвалж болсон хууль тогтоомжуудад дүн шинжилгээ хийж үзвэл дараах тулгамдсан асуудлууд байна:

### 2.2.1.АВЛИГЫН ЭСРЭГ НҮБ-ЫН КОНВЕНЦИЙН ЗОХИЦУУЛАЛТ, ХЭРЭГЖИЛТ

НҮБ-ын Авлигын эсрэг конвенц нь НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 2003 оны 10 дугаар сарын 31-ны өдрийн АЭК-ийг соёрхон батлах тухай 58/4 тоот тогтоол гарч, улмаар 2005 оны 12 дугаар сарын 14-ны өдөр хүчин төгөлдөр болсон олон улсын түвшинд авлигатай тэмцэх, урьдчилан сэргийлэх талаарх хамгийн бодит арга зам, үйл ажиллагааг тодорхойлсон суурь эх сурвалж мөн.

Уг конвенцийг бодит байдалд хэрэгжүүлэх нь авлигаас урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэхэд чухал нөлөө үзүүлнэ.

Тус конвенцийн практикт хэрэгжиж буй байдал, хэрэгжилтийн үр нөлөө, хүлээн зөвшөөрөгдсөн байдал, түүнийг хэрэгжүүлэхэд гарч байгаа эерэг, сөрөг үр дагаврыг судлан үзвэл анхаарал татсан дараах асуудлууд байна:

| Авлигын эсрэг НҮБ-ын конвенцийн заалт | Хэрэгжилт | Анхаарах зүйлс |
|---|---|---|
| АЭК-ийн авлигын тодорхойлолт байхгүй боловч конвенцийн 15-27 дугаар зүйлд түүнд нэгдэн орсон улс орнууд нь тодорхой нэр заасан үйлдлүүдийг гэмт үйлдэлд тооцож хууль тогтоох болон бусад арга хэмжээ авах, хариуцлага ногдуулахыг үүрэг болгосон. | Уг үүргийн дагуу манай улс Авлигын эсрэг хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д "авлига" гэж энэ хуулийн 4.1-д заасан этгээд албан тушаалын эрх мэдлээ хувийн ашиг хонжоо олоход урвуулан ашиглах, бусдад давуу байдал олгох, иргэн, хуулийн этгээдээс тэрхүү хууль бус давуу байдлыг олж авах үйлдэл, эс үйлдэхүйгээр илрэх аливаа эрх зүйн зөрчлийг хэлнэ гэж тодорхойлж, авлигатай тэмцэх үйл ажиллагаа, авлигатай тэмцэх байгууллагын эрх зүйн үндсийг тодорхойлж, тэдгээртэй холбогдсон харилцааг тус хуулиар зохицуулж байна.<br>Эрүүгийн хуулийн хорин хоёрдугаар бүлэг авлигын гэмт хэрэг гэсэн бүлэгт:<br>22.1 дүгээр зүйл.Эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах<br>22.3 дугаар зүйл.Гадаад улсын төрийн байгууллага, олон улсын байгууллагын албан тушаалтан эрх мэдлээ урвуулан ашиглах<br>22.4 дүгээр зүйл.Хахууль авах<br>22.5 дугаар зүйл.Хахууль өгөх<br>22.6 дугаар зүйл.Гадаад улсын төрийн байгууллага, олон улсын байгууллагын албан тушаалтныг хахуульдах<br>22.7 дугаар зүйл.Улсын нөөцийг хууль бусаар зарцуулах, үрэгдүүлэх<br>22.8 дугаар зүйл.Төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах<br>22.9 дүгээр зүйл.Төрийн өмчийн төсвийн бус хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах<br>22.10 дугаар зүйл. Үндэслэлгүйгээр хөрөнгөжих<br>22.11 дүгээр зүйл. Дураараа аашлах | Өнөөдөр хүчин төгөлдөр үйлчилж буй Авлигын эсрэг хууль болон Эрүүгийн хууль дахь авлигын гэмт хэргийн талаарх тодорхойлолт, гэмт хэргийн бүрэлдэхүүний шинж нь төрлийн шинжээр тодорхойлосон байх бөгөөд энэ нь зарим гэмт хэргийн субъектийн хамрах хүрээг хязгаарласан, зарим гэмт хэргийн хувьд үйлдлийн шинжийг орхигдуулсан зэрэг нөхцөл байдал үүссэн байна.<br>Иймд цаашид авлигын гэмт хэргийн субъектийн цар хүрээг өргөтгөж төрийн болон төрийн бус бүх этгээдэд хамааруулах, зарим идэвхгүй хэлбэрийн гэмт үйлдлийг гэмт хэрэгт тооцох нь зүйтэй. |

| | | |
|---|---|---|
| | 22.12 дугаар зүйл.Хуулийн этгээдийн эрх мэдлийг урвуулан ашиглах гэсэн гэмт хэргүүдийг хуульчилсан байна. | |
| 29 дүгээр зүйл. Хөөн хэлэлцэх хугацаа<br>Оролцогч улс бүр энэхүү конвенцын дагуу тогтоосон аливаа гэмт хэрэгт хэрэг үүсгэх хөөн хэлэлцэх хугацааг уртаар тогтоож, сэжигтэн этгээд шүүн таслах ажиллагаанаас зайлсхийсэн бол хөөн хэлэлцэх хугацааг илүү уртаар тогтоох буюу хөөн хэлэлцэх хугацааг түдгэлзүүлэхээр дотоодын хууль тогтоомжийнхоо дагуу зохих тохиолдолд заахыг үүрэг болгосон байна. | Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 1.2-т зааснаар “энэ хуулийн тусгай ангид хорих ялын доод хэмжээг нэг жилээс дээш, дээд хэмжээг найман жил, түүнээс бага хугацаагаар тогтоосон, эсхүл зорчих эрхийг хязгаарлах ялын доод хэмжээг нэг жилээс дээш хугацаагаар тогтоосон гэмт хэрэг үйлдсэнээс хойш таван жил өнгөрсөн” гэж заасан;<br>Таван жил бол энэ гэмт хэргийн субъект болох нийтийн албан тушаалтны бүрэн эрхийн хугацаатай харгалзуулан авч үзэхэд харьцангуй бага хугацаа. | Нийтийн албан тушаалтан нь бусад ердийн субъекттэй гэмт хэрэгтэй харьцуулан авч үзэхэд илүү ёс зүй, үүрэг, хариуцлагын өндөр түвшний шаардлага зөрчдөг, зөвхөн хувь хүнд төдийгүй нийгэмд сөрөг үр дагавар үүсгэдэг нийгмийн хор аюулын шинжээрээ их байх тул хөөн хэлэлцэх хугацааг нэмэгдүүлэх нь зүйтэй |
| Авлигын эсрэг олон улсын болон олон улсын шинжтэй цөөнгүй гэрээнүүд[3] улс орнуудын авлигатай тэмцэх арга хандлага, оролцогчдыг тодорхойлж байна. | Манай улс нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4-т "нийтийн албан тушаалтан" гэж энэ хуулийн 4.1-д заасан этгээдийг хэлнэ гэж заасан бол Авлигын эсрэг хуулийн 4 дүгээр зүйлд хуулийн үйлчлэлд хамаарах этгээдийг жагсаалтын зарчмаар тогтоосон. | хувийн сектор, эрүүл мэнд, боловсрол, зам, тээвэр, уул уурхай, хэвлэл мэдээлэл, спорт, орон нутгийн засаг захиргааны байгууллага зэрэг салбарт мэргэжил, тусгай мэдлэгийн хүрээнд дүгнэлт, |

[3] - Америк тивийн улсуудын байгууллагаас 1996 оны 3 дугаар сарын 29-ний өдөр баталсан Авлигын эсрэг Америк тивийн улсуудын конвенц;
- Европын Холбооны Зөвлөлөөс 1997 оны 5 дугаар сарын 26-ны 6-ны өдөр баталсан Европын Холбооны болон түүний гишүүн орны албан тушаалтанд хамаарах авлигын эсрэг конвенц;
- Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагаас 1997 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр баталсан Олон улсын бизнесийн хэлэлцээрт гадаадын төрийн албан хаагчийг хахуульдахтай тэмцэх тухай конвенц;
- Европын Зөвлөлийн Сайд нарын хорооноос 1999 оны 1 дүгээр сарын 27-ны өдөр баталсан Авлигын талаарх эрүүгийн эрх зүйн тухай конвенц;
- Европын Зөвлөлийн Сайд нарын хорооноос 1999 оны 11 дүгээр сарын 4-ний өдөр баталсан Авлигын эсрэг иргэний эрх зүйн тухай конвенц;
- Африкийн холбооны төр, засгийн тэргүүнүүдийн 2003 оны 7 дугаар сарын 12-ны өдөр баталсан Авлигаас урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх тухай Африкийн холбооны конвенц
- НҮБ-аас 2003 оны 9 дүгээр сарын 29-ний өдөр хүчин төгөлдөр баталсан Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын конвенц

| | | |
|---|---|---|
| | | магадалгаа гаргах, үйлчилгээ үзүүлэх эрх бүхий нийтлэг үйлчилгээний албаны ажилтан" "хамтын шийдвэр гаргах чиг үүрэг бүхий аливаа хороо, комиссын гишүүн, дарга нар авлигын эрсдэл бүхий субъектүүд мөн тул энэ талаар хуульд нэмэлт оруулах шаардлагатай. |
| АЭК-ийн 13 дугаар зүйлийн 1.d-д оролцогч улс бүр авлигаас урьдчилан сэргийлж, тэмцэхэд хувь хүн болон иргэний нийгэм, төрийн бус байгууллага, иргэдийн нэгдэл хөдөлгөөнд тулгуурласан байгууллага зэрэг нийтийн албанаас гаднах бүлгийн идэвхитэй оролцоог хөхиүлэн дэмжих бөгөөд ... авлигатай холбоотой мэдээлэл хайх, авах, хэвлэн нийтлэх, түгээх эрх чөлөөг хүндэтгэх, хөхиүлэн дэмжих, хамгаалахаар заасан. | Хараат бус сэтгүүл зүй бол иргэдийг үнэн бодит мэдээллээр хангах, төрийг хянах, авлигаас сэргийлэх томоохон хүчин зүйл юм. Энэ талаар манай улсын АЭК-ийн хэрэгжилтийн тайлантай танилцаад өгсөн зөвлөмжид Хэвлэл мэдээллийн хэрэгслийн талаарх хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулж, хэвлэл мэдээллийн хэрэгслийг өмчлөгч нарыг танин тогтоох явдлыг илүү нээлттэй, ил тод болгох гэсэн зөвлөмж өгсөн байна. | Арилжааны телевизийн үйлчилгээ эрхлэгчдийн эзэмшигч болон хөрөнгө оруулагчдийн мэдээллийг ил тод болгох асуудлаар эрх зүйн зохицуулалт бий болгох шаардлагатай. Энэ нь ил тод хяналттай сэтгүүл зүйг хөгжүүлэх, улмаар авлигын үйлдлээс сэргийлэх нөхцөл болно. |

## 2.2.2.АВЛИГЫН ЭСРЭГ ХУУЛИЙН ЗОХИЦУУЛАЛТ, ХЭРЭГЖИЛТ

Монгол Улс анх 1996 оны 4 дүгээр сарын 5-ны өдөр Авлигын эсрэг хуулийг баталсан хэдий ч 2006 оны 7 дугаар сарын 6-ны өдөр Авлигын эсрэг хуулийг шинэчлэн баталж, авлигаас урьдчилан сэргийлэх, олон нийтэд авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, албан тушаалтны хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, авлигын гэмт хэргийг илрүүлэх, мөрдөн шалгах чиг үүрэг бүхий Авлигатай тэмцэх газар байгуулагдаж, авлигатай тэмцэх үйл ажиллагааны эрх зүйн гол эх сурвалж болон үйлчилж байна.

Тус хуулиар хуулийн үйлчлэлд хамаарах этгээдийг тодорхойлж, тэдний үйл ажиллагаанд хориглох үйлдлүүдийг тусгасан бөгөөд авлигын зөрчлүүдийг

тодорхойлж, авлигын тухай мэдэгдэх, өргөдөл, гомдол гаргах, мэдээлэл өгөх үүрэг, журмыг зохицуулсан.

Мөн уг хуулиар олон нийтийг соён гэгээрүүлэх болон авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны хүрээнд аж ахуйн нэгж, байгууллага, иргэний хүлээх нийтлэг үүрэг, төрийн албан тушаалтнуудын хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргах, хянан шалгах, нийтэд мэдээлэх, хариуцлага хүлээлгэх үүрэг, Авлигатай тэмцэх газрын бүрэн эрх, чиг үүрэг, үндсэн зарчим, бүтэц, байгууллагын удирдлагыг томилох, чөлөөлөх журам, албан хаагчид тавигдах шаардлага, хориглох зүйл, улс төр, эдийн засаг, нийгэм, хууль зүйн баталгаа зэрэг асуудлыг зохицуулсан байна.

Хууль батлагдсан цагаасаа хэд хэдэн удаа нэмэлт өөрчлөлт орсон бөгөөд хуулийн хэрэгжилтийн талаарх тайлан мэдээ, бусад эх сурвалжид үндэслэн үнэлгээ хийж үзвэл тус хуулийн тодорхой заалтуудыг боловсронгуй болгох шаардлага цөөнгүй байна. Тухайлбал: .

| Хуулийн зүйл, заалт | Хэрэгжилт | Анхаарах зүйлс |
|---|---|---|
| Хуулийн 29 дүгээр зүйлд "Авлигатай тэмцэх газрын зардлыг улсын төсвөөс санхүүжүүлж, үйл ажиллагаа явуулах эдийн засгийн баталгааг төр хангана." "Авлигатай тэмцэх газрын "тухайн жилийн төсвийг өмнөх оны батлагдсан төсвийн хэмжээнээс бууруулан батлахыг хориглоно." гэж заасныг УИХ-аас 2015 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн "Авлигын эсрэг хуулийн зарим хэсэг хүчингүй болсонд тооцох тухай" хуулиар хүчингүй болсонд тооцсон. | АТГ-ын "эдийн засгийн хувьд хараат бус байх", "төрөөс эдийн засгийн баталгааг хангах" талаарх Авлигын эсрэг хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсэгт заасан зарчмын хэрэгжих боломжийг хязгаарлах сөрөг үр дагавартай үүсгэсэн төдийгүй үйл ажиллагаагаа оновчтой, алсыг харсан байдлаар төлөвлөх боломжийг хязгаарлах, улмаар эдийн засгийн механизмаар дамжуулан хараат бус байдалд нь нөлөөлж болзошгүй эрсдэлийг учруулна. Энэ талаар ЭЗХАХ-ийн байгууллага[4], "Транспаренси Интернэшнл" байгууллагаас "төсвийн баталгаа, тогтвортой байдал"[5] нь "муу" гэж үнэлсэн ба "төсвийг бууруулан батлахыг хориглосон заалтыг сэргээж баталгаажуулах шаардлагатайг анхаарах" зөвлөмжийг өгсөн байна. | "Тухайн жилийн төсвийг өмнөх оны батлагдсан төсвийн хэмжээнээс бууруулан батлахыг хориглоно" гэсэн хуулийн заалтыг сэргээж баталгаажуулах шаардлагатай. |
| Авлигатай тэмцэх газар нь Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3-т заасны дагуу "авлигын хэлбэр, цар хүрээ, шалтгааныг 2 жилд нэгээс | Хуулийн энэ заалтын дагуу АТГ авлигын хэлбэр, цар хүрээ, шалтгааныг судлан | Дээрх чиг үүргийг нэг жил тутам гаргадаг байхаар зохицуулалт оруулах нь зүйтэй гэж үзэж байна. Учир нь |

[4] Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага "Монгол улс дахь авлигын эсрэг шинэтгэл" 2019 он
[5] https://www.transparency.mn/

| | | |
|---|---|---|
| доошгүй удаа судлан авлигын индексийг гаргаж олон нийтэд мэдээлэх", мөн хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.7-д заасны дагуу "төрийн үйлчилгээ авсан иргэд, байгууллагын судалгаанд тулгуурлан төрийн байгууллагын шударга байдлын түвшинд 2 жил тутамд үнэлгээ гаргаж, олон нийтэд мэдээлэх" чиг үүргийг хэрэгжүүлдэг. | авлигын индексийг гаргаж олон нийтэд мэдээлж ирсэн.[6] | авлигын эрсдэл өндөр гэж үзэж байгаа манай нийгэмд улс төр, шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаарх төсөөллийн судалгаа богино хугацаанд гарч байх нь авлигатай тэмцэхэд түлхэц болох талтай. |
| Хуулийн 13 дугаар зүйлийн 13.5-д зааснаар нийтийн албан тушаалтны хөрөнгө, орлогын мэдүүлгийг өргөдөл, гомдол, мэдээллийн мөрөөр, эсхүл төлөвлөгөөт хяналтаар шалгалтаар хянаж, мөн авлигын зөрчил илэрсэн бол хуульд заасан хариуцлага хүлээлгэхээр эрх бүхий байгууллагад хүргүүлж, хэрэгжилтэд нь хяналт тавихаар заасан.<br><br>32[1] дугаар зүйлд Авлигатай тэмцэх газар, Шүүхийн ерөнхий зөвлөлөөс бусад байгууллага, албан тушаалтан тус хуулийг хэрхэн дагаж мөрдөж байгааг АТГ хянан шалгахаар заасан. | Гэвч дээрх хяналтын бүрэн эрхийг хэрэгжүүлэх процедур хуульд тусгаагүй байх бөгөөд одоогоор АТГ-ын даргын тушаалаар баталсан журмыг баримталж ажилладаг байна.<br><br>Хяналт шалгалтын явцад тухайн хяналт шалгалтад хамрагдаж байгаа нийтийн албан тушаалтнуудад буюу гадагш чиглэсэн хэм хэмжээ тогтоох асуудал үүсэх талтай. | Иймд Авлигатай тэмцэх газрын даргад бүх нийтээр дагаж мөрдөх захиргааны хэм хэмжээний актыг батлах эрхийг олгох нь зүйтэй. |
| Хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д "Энэ хуулийн 4.1-д заасан этгээдэд бусад хууль тогтоомжид тусгайлан хориглосноос гадна авлигын дараах зөрчлийг хориглоно:" гээд 7.1.8-д "үндэслэлгүйгээр хөрөнгөжих. Тайлбар: Албан тушаалтан зургаан сарын албан тушаалын цалин хөлс, орлогоос илүү хөрөнгө, орлогыг хууль ёсны дагуу олсон болохыгоо үндэслэлтэй тайлбарлаж чадахгүй тохиолдолд үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэж үзнэ." гэжээ. | "Үндэслэлгүй хөрөнгөжих" зөрчлийн хууль зүйн тодорхойлолтыг нийтийн албан тушаалтны албан тушаалын цалин хөлсний орлоготой уялдуулан тогтоосон нь тэгш бус байдлыг үүсгэж, Үндсэн хуулийн "Арван дөрөвдүгээр зүйл"-ийн 1-д заасан ".Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.", 2-т заасан "Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно." гэсэн зарчим алдагдахад хүргэж байна. | Иймд Монгол Улсын Үндсэн хуульд заасан болон хариуцлага гарцаагүй байх, зөрчил үйлдэгдсэн нөхцөл байдал, зөрчлийн шинж, хохирлын хэр хэмжээнд тохирсон байх зарчмыг баримтлан нийтийн албан тушаалтны "үндэслэлгүй хөрөнгөжих" зөрчлийн шинжийг тэдгээрийн албан тушаалын цалин хөлсний орлогоор бус хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй уялдуулан тогтоох нь зүйтэй. |

[6] "Транспэрэнси Интэрнэшнл Монгол" ТББ-ын судалгаа

| | | |
|---|---|---|
| Хуулийн 6.1.2-т зааснаар төрийн байгууллага нь авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр тодорхой чиглэлээр бодлого боловсруулах, шийдвэр гаргахын өмнө олон нийтийн анхаарал татаж байгаа мэдээллийг нээлттэй болгох, сонирхогч нийгмийн бүлгүүдэд өөрийн бодлого, байр суурийг танилцуулах, хяналтын тодорхой аргыг дэвшүүлэн хэрэгжүүлэх бололцоо олгох зорилгоор харилцан зөвлөлдөж ажиллах боломжийг бүрдүүлэх үүрэгтэй хэмээн заасан. Энэ хүрээнд. Зөвлөлдөх санал асуулгын тухай хууль, Нийтийн сонсголын тухай хууль, Захиргааны ерөнхий хууль зэрэг хуулиудад нарийвчилсан зохицуулалтыг заасан. | Гэвч бодит байдал дээр төрийн байгууллагууд ажилтнуудын хөдөлмөрлөх эрхэд халдсан шийдвэр гаргах, төрийн албан хаагчийг орон байраар хангагдахад төрөөс дэмжлэг үзүүлэх эрх зүйн зохицуулалтыг хэрэгжүүлэх журам тодорхой бусаас өөрийн үзэмжээр шийдвэрлэдэг, төрийн байгууллагад “орон сууцны зориулалтаар” газар эзэмшүүлсэн, газар эзэмших эрхийг холбогдох хууль тогтоомж зөрчин иргэн, хуулийн этгээдэд шилжүүлсэн, хууль бус шийдвэр гаргаж, үйл ажиллагаа явуулсан нь шүүхийн шийдвэрээр тогтоогдсон, хуулиас давсан журам үйлчилдэг, байгууллагын мэдээллийн самбар дахь мэдээллийн ил тод байдлын хэрэгжилт хангалтгүй зэрэг зөрчил цөөнгүй гарсаар байна. | Үүнийг даван туулах арга зам нь иргэд, олон нийтийн хяналт байна.<br>Тиймээс Зөвлөлдөх санал асуулгын тухай, Нийтийн сонсголын тухай хуулийн хэрэгжилтийг сайжруулах олон нийтийн хяналтын механизмуудыг идэвхжүүлэх нь зүйтэй |
| Хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.3-т энэ хуулийн 7.1-д заасныг удаа дараа зөрчсөн этгээдийг төрийн албанаас халах, авлигын зөрчилтэй нөхцөлд гарсан шийдвэр байгаа бол түүнийг хүчингүй болгох;” гэж заасан.<br>. | Энэхүү хуулийн заалтыг үндэслэл болговол зөвхөн Төрийн албаны тухай болон холбогдох бусад хуульд зааснаар төрийн албан тушаалд томилолтын журмаар ажилладаг албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх хууль зүйн боломжтой харагдаж байна.<br>Гэвч Авлигын эсрэг хуулийн 4 дүгээр зүйлд заасан нийтийн албан тушаалтны ангилалд хамаардаг Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуулиар тогтоосон болзол, журам, шалгуурын дагуу сонгогддог болон уг сонгуулийн үр дүнд томилолтын журмаар ажиллах, мөн тэдгээрийн бүрэн эрхийн хугацаанд өөрт нь үйлчлэх орон тооны гэх мэт албан тушаал эрхэлж байгаа албан тушаалтан, албан хаагч хамаардаг тул хуулийг нэг мөр ойлгож | |

| | | |
|---|---|---|
| | хэрэглэх хэрэгцээ, иргэн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх зарчмын хэрэгжилтийг хангах, хууль зөрчсөн этгээд бүрд хариуцлага гарцаагүй хүлээлгэдэг байх шаардлагатай байна | |
| Хуулийн 6.1.3-т зааснаар төрийн байгууллага нь төрийн хяналтын үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах үүрэгтэй. Энэ хүрээнд төрийн хяналт, шалгалтын тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр зэрэг хууль тогтоомжид үүрэг болгосон эрх зүйн зохицуулалтууд цөөнгүй туссан байна. | Тухайлбал, Ашигт малтмалын тухай хуулийн хэрэгжилтийн үнэлгээнээс харахад давхардсан, ач холбогдол багатай олон тооны хяналт шалгалт нь компанийн үйл ажиллагааны тогтвортой байдалд нөлөөлж, хяналт, шалгалт хийж буй ажилтнуудын далд хэлбэрийн ашиг сонирхлыг нэмэгдүүлэх эрсдэл бий болгож байна.<br><br>Ялангуяа мэргэжлийн хяналтын байгууллага, Засаг дарга нараас хийх төлөвлөгөөт бус хяналт шалгалттай холбоотой авлигын эрсдэл байна. Хуулиар зарим хязгаарлалт хийдэг ч ийм төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийхдээ компаниудад урьдчилан мэдээлэл өгдөггүй, хяналтын удирдамж, арга зүй тодорхойгүй байдаг учраас авлигын эрсдэл үүсэх шалтгаан болдог. Компаниудын зүгээс зөвшөөрөл, хяналт шалгалттай холбоотой хууль эрх зүйн мэдлэг дутмаг байгаа нь хууль бус үйл ажиллагаа явуулах эсвэл хууль бус шалгалт, шахалтад өртөх, улмаар авлигын эрсдэл бий болгодог.<br><br>Уул уурхайн салбарт ил тод байдлыг хангах, авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, түүнийг гаргахгүй байх нэг чухал зохицуулалт нь АМТХ-ийн 48 дугаар зүйлд заасан ил тод байдлын тайлан юм. Энэхүү зохицуулалт нь практикт үр дүнгээ өгч байгаа учир улам бүр боловсронгуй болгож, | |

| | | |
|---|---|---|
| | илүү үр дүнтэй, бодитой хэрэгжих гарцыг нээж, энэхүү харилцааг тусгайлан зохицуулдаг эрх зүйн актыг батлан гаргах хэрэгцээ шаардлага бий болжээ. | |
| Хуулийн 6.1.4-т төсвийн орлого, түүний зарцуулалт, гадаадын зээл, тусламж, түүний хуваарилалтыг олон нийтэд тухай бүр нь мэдээлэх нь төрийн байгууллагын үүрэг мөн хэмээн заасан бөгөөд түүний хэрэгжилтийг хангах хүрээнд Төсвийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Хөрөнгө оруулалтын тухай хууль болон бусад хууль тогтоомжоор хэрэгжилт нь хангагдаж байна. | Энэ харилцаанд оролцогчдоос худалдан авах ажиллагааг хуульд заасан бүрэлдэхүүнээр зохион байгуулаагүй, үнэлгээний хорооны гишүүнээр нэг албан тушаалтныг олон давтамжтай ажиллуулдаг, үндэслэлгүйгээр төлбөр хураамж тогтоосон, эрүүл мэндийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг хадгалах харилцаанд хувийн ашиг сонирхол үүссэн зэрэг зөрчил гарсаар байна. | Тиймээс энэ харилцааг зохицуулж буй хууль тогтоомжийг боловсронгуй болгох шаардлага үүсэж байна. |
| Хуулийн 6.1.7-д зааснаар төрийн байгууллага нээлттэй, иргэдийн ашиг сонирхолд нийцсэн үйл ажиллагаа явуулж байгаа эсэхэд тавих хяналтад төрийн бус байгууллагын оролцоог нэмэгдүүлж, хамтран ажиллах, мэдээллийг харилцан солилцох, олон нийтэд мэдээллийг тогтмол хүргэж байх үүрэгтэй. Энэ үүргийн хэрэгжилт нь төрийн бус байгууллагын тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Захиргааны ерөнхий хууль | Төрийн байгууллагуудын цахим хуудсан дахь мэдээлэлтэй танилцахад Авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчилсан байдал хангалтгүй, боловсруулсан хууль, Улсын Их Хурал, Засгийн газрын тогтоол, нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төслийг цахим хуудсандаа байршуулдаггүй, эрх, зөвшөөрөл олгож буй шийдвэр, худалдан авах ажиллагааны тайлан, аудитын дүгнэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй шалтгааныг байршуулах ажил хэвшээгүй зэрэг зөрчил түгээмэл байна. | Иймд нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтэд тавих хяналтын механизмыг сайжруулах нь зүйтэй |
| Хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1-д авлигын гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг арилгах, зөрчигдсөн эрхийг сэргээн тогтоох, хууль бус аливаа шийдвэрийг хүчингүй болгох асуудлыг Иргэний хууль болон холбогдох бусад хуульд заасны дагуу шийдвэрлэнэ гэж заасан. | Гэвч түүнийг хэрэгжүүлэх арга барил шинэчлэгдээгүй, тодорхой аргачлал, журмуудыг шинээр батлан хэрэгжүүлээгүй, хууль сахиулагчдын хуучин хэвшмэл хандлагаас шалтгаалж гэмт хэргийн улмаас хохирсон хохирогчийн эрхийг хангах, түүнийг нөхөн сэргээх байдал хангалтгүй байна. Тухайлбал, хууль сахиулагч, прокурорын ажил дүгнэх үзүүлэлт | Гэмт хэргийн улмаас бусдын сэтгэл санаанд учирсан хохирлыг нөхөн төлж, үнэлж байгаа шүүхийн практик туйлын хангалтгүй байна. Сэтгэл санааны хохирлыг үнэлэх, үнэлгээжүүлэх, тооцох аргачлал, эрх орчин байхгүй учир гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг |

| | | |
|---|---|---|
| | шинэчлэгдээгүй, хохирол, хор уршгийг үнэлэх талаарх хуучин заавар, дүрэм, журам, практик өнөөг хүртэл мөрдөгдсөөр байгаа нь хууль дэвшүүлсэн зорилтдоо хүрэхэд саад учруулсаар байгаа болно. | Эрүүгийн шүүхийн шатанд ч, иргэний нэхэмжлэл гаргах замаар иргэний шүүхийн шатанд ч нөхөн төлүүлэх боломжгүй байна. |

### 2.2.3.НИЙТИЙН АЛБАНД НИЙТИЙН БОЛОН ХУВИЙН АШИГ СОНИРХЛЫГ ЗОХИЦУУЛАХ, АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ТУХАЙ ХУУЛИЙН ЗОХИЦУУЛАЛТ, ХЭРЭГЖИЛТ

Засаглалыг сайжруулах, авлигаас урьдчилан сэргийлэх, төрийн албаны ил тод, хариуцлагатай, шударга үйл ажиллагааг бэхжүүлэх, төрийн албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ төрийн ашиг сонирхлыг хувийн ашиг сонирхлоос дээгүүрт тавих зэрэг шаардлага байгааг үндэс болгон Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль 2012 оны 01 дүгээр сарын 19-ний өдөр батлагдснаас хойш өнөөдрийг хүртэл хугацаанд уг хуулийг дагаж мөрдөх хугацааны талаар, албан тушаалтны давхар ажил эрхлэлт, албан тушаалаас чөлөөлөгдсөний дараах болон аж ахуйн үйл ажиллагаа эрхлэхтэй холбогдсон хориглолт, хязгаарлалт, хариуцлагатай холбоотой зарим зүйл, заалтыг боловсронгүй болгох, оффшор бүсэд банкны данс эзэмших, хөдлөх, үл хөдлөх хөрөнгө өмчлөх, хуулийн этгээд байгуулахтай холбогдсон харилцааг шинээр зохицуулсан зэрэг 10 нэмэлт, өөрчлөлт оржээ.

Гэсэн хэдий ч өнөөдөр тус хуулийн хэрэгжилтийг сайжруулах хүрээнд анхаарвал зохих зүйлс байсаар байна. Үүнд:

| Хуулийн зүйл, заалт | Хэрэгжилт | Анхаарах зүйлс |
|---|---|---|
| Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.5-д ""хамаарал бүхий этгээд" гэж тухайн нийтийн албан тушаалтны эцэг, эх, төрсөн ах, эгч, дүү, гэр бүлийн гишүүн, хамтран амьдрагч, эхнэр /нөхөр/-ийн эцэг, эх, төрсөн ах, эгч, дүү, бусад нэгдмэл сонирхолтой этгээдийг" гэж, Гэр бүлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4-т "гэр бүлийн гишүүн" гэж гэрлэгчид, тэдэнтэй хамт амьдарч байгаа төрсөн, дагавар, үрчлэн авсан хүүхэд болон төрөл, садны хүнийг" гэж тодорхойлсон. | Гэтэл нийтийн албан тушаалтан хууль зөрчих замаар олж авсан хөрөнгө, орлогоо өрхийн бүртгэлд байхгүй, тусдаа амьдарч байгаа хүүхэд, тэдгээрийн гэр бүлийн гишүүдэд шилжүүлж, ашиг хүртэх замаар хуулийн хариуцлагаас чөлөөлөгддөг сөрөг үр дагаврыг үүсгэдэг.<br><br>Энэ нь олон нийтийн төрд болон АТГ-ын үйл ажиллагаанд итгэх итгэлд сөргөөр нөлөөлдөг. | Иймд хуулийг нэг мөр ойлгож хэрэглэх, нийтийн албан тушаалтнаас хуульд заасан хориглолт, хязгаарлалтыг мөрдөж, хариуцлагатай байх зарчмыг мөрдүүлэх шаардлагаар хуульд заасан "хамаарал бүхий этгээд" гэх нэр томьёонд нийтийн албан тушаалтны "хүүхэд, түүний гэр бүлийг" хамааруулан тусгах нь зүйтэй. |
| АЭК-ийн 2 дугаар зүйлийн (a)-д "Нийтийн албан тушаалтан" гэж: (i) оролцогч улсын хууль тогтоох, гүйцэтгэх, захиргааны буюу шүүхийн албан тушаалд | Нийтийн албан дахь нийтлэг үйлчилгээ үзүүлж буй боловсрол, шинжлэх ухаан, эрүүл мэнд, соёл, урлаг, спорт зэрэг салбарын төрийн үйлчилгээний | Иймд конвенцийн шаардлагыг хангах, иргэдийн эрх ашгийг хамгаалах зорилгын хүрээнд нийтийн албан тушаалтан хэмээх |

| | | |
|---|---|---|
| томилогдон буюу сонгогдон, байнга буюу түр хугацаагаар, цалинтай буюу цалингүйгээр ажилладаг аливаа хүнийг албан тушаалын зэрэглэлээс нь үл хамаарахаар заасан.<br><br>Гэтэл манай улс Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4-т "нийтийн албан тушаалтан" гэж энэ хуулийн 4.1-д заасан этгээдийг" хэлнэ гэж заасны дагуу Авлигын эсрэг хуулийн 4 дүгээр зүйлийг сурвалжлан үзвэл хуулийн үйлчлэлд "төрийн улс төрийн, захиргааны, тусгай албаны удирдах болон гүйцэтгэх албан тушаалтан; төрийн үйлчилгээний албаны удирдах албан тушаалтан болон ерөнхий нягтлан бодогч, ахлах нягтлан бодогч, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдах болон компанийн эрх бүхий албан тушаалтан ... хамаарахаар заасан байна. | байгууллагын гүйцэтгэх, туслах албан тушаалтнууд бусдад давуу байдал бий болгох, иргэн, хуулийн этгээдээс тэрхүү хууль бус давуу байдлыг олж авах үйлдэл, эс үйлдэхүйгээр илрэх аливаа эрх зүйн зөрчлийг гаргах нь түгээмэл байна. | тодорхойлолтын агуулгыг өргөтгөн тодорхойлох;<br><br>Мөн хувийн сектор, эрүүл мэнд, боловсрол, зам, тээвэр, уул уурхай, хэвлэл мэдээлэл, спорт, орон нутгийн засаг захиргааны байгууллага зэрэг салбарт мэргэжил, тусгай мэдлэгийн хүрээнд дүгнэлт, магадалгаа гаргах, үйлчилгээ үзүүлэх эрх бүхий төрийн үйлчилгээний албаны ажилтан" "хамтын шийдвэр гаргах чиг үүрэг бүхий аливаа хороо, комиссын гишүүн, дарга нар авлигын эрсдэл бүхий субъектүүд мөн тул эдгээрийг нийтийн албан тушаалтанд хамааруулах нь зүйтэй. |
| Хуулийн 7 дугаар зүйлд ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар төрийн байгууллагын хүлээх үүргийг заасан боловч 7.3-т "Энэ хуулийн 7.2.2, 7.2.3-т заасан шалгалтын явцад авлигын шинжтэй зөрчил илэрсэн бол Авлигатай тэмцэх газарт шилжүүлэн шалгуулна." гэж заасан | | Иймд хуулийн зорилтод нийцүүлэх, төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд хариуцлагатай байх, тэгш, шударга, хууль ёсны зарчмын хэрэгжилтийг хангах шаардлагаар зөвхөн "авлигын" төдийгүй ашиг сонирхлын шинжтэй зөрчил" илэрсэн тохиолдол бүрд АТГ-т шилжүүлэн шалгуулах эрх зүйн үндэслэлийг бүрдүүлэх нь зүйтэй |
| Хуулийн 8 дугаар зүйлийн 8.3-т "Ашиг сонирхлын зөрчил бүхий нөхцөл байдлын талаар мэдэж байгаа бусад этгээд энэ тухай холбогдох байгууллага, | Монгол Улсын Их Хурлаас 2019 онд Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн шинэчилсэн найруулга[7]-ыг баталсан нь 2020 оны 01 | Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон Авлигын эсрэг хуулийн 8 дугаар зүйл хоёрын зөрүүтэй байдлыг арилгах |

[7] https://www.legalinfo.mn/law/details/14700

| | | |
|---|---|---|
| албан тушаалтанд мэдээлж болно." гэсэн эрх олгосон заалтыг тусгасан. | дүгээр сарын 01-ний өдрөө хүчин төгөлдөр үйлчилж байгаа бөгөөд тус хуульд зааснаар гэмт хэрэг, зөрчлийн талаар мэдээлэх нь иргэний үүрэг юм. | |
| "*23.9* Энэ хуулийн 23.7-д заасан тохиолдолд нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээд мөн хуулийн 8 дугаар зүйлийг хэрэгжүүлж ажиллах талаар баталгаа гаргах бөгөөд түүнийг тухайн албан тушаалд томилох эсэхийг томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтан шийдвэрлэнэ.",<br>"23.10.Энэ хуулийн 23.9-д заасан баталгааны маягтыг Авлигатай тэмцэх газар батална." | Тухайн албан үүргийг хэрэгжүүлэхэд илт ашиг сонирхлын зөрчилтэй нөхцөл байдал тогтоогдсон ч томилогдон ажиллах боломжтой байгаа нь учир дутагдалтай байна.<br>Хуулийн 23 дугаар зүйлийн 23.5-д "Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтан хүлээн авч Авлигатай тэмцэх газарт хүргүүлнэ." гэж заасан боловч томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтан хуульд заасан энэ үүргээ биелүүлээгүй тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг хуульд тусгагдаагүй байна. | Иймд тухайн төрлийн харилцаанд оролцогчдын эрх зүйн байдлыг тодорхой болгож, эрх үүргийн нэгдлийг хангах, хуулийн хийдлийг арилгах хэрэгцээ, шаардлагыг үндэслэн "хууль тогтоомжийг зөрчсөн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол эрх бүхий албан тушаалтан дараах сахилгын шийтгэл хүлээлгэнэ." гэж заасан хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсгийн холбогдох заалтад хүлээлгэх хариуцлагыг тусгах шаардлагатай |
| "Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн маягт, түүнийг бүртгэх, хянах, хадгалах журам батлах тухай" 05 дугаар тогтоолоор зохицуулж байна.<br>. | Гэвч ЭБАТ-ыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, мэргэшүүлэх, тогтвортой ажиллуулах, ажлын үр дүнг тооцох, түүнчлэн ЭБАТ-ыг томилж, чөлөөлөх эрх бүхий байгууллагатай хамтран ажиллах, тогтвор суурьшилтай ажиллуулах, ЭБАТ-ын эрх, үүрэг зөрчигдсөн тохиолдолд авах арга хэмжээг тодорхойлох зэрэг ажил, арга хэмжээний зохицуулалт тус тогтоолд тусгагдаагүй, нөгөө талаар энэхүү чиг үүргийг АТГ хэрэгжүүлж байгаа тул зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлагатай байна | Хөрөнгө орлогын мэдүүлгийг бүртгэх, хяналт тавих, тайлагнах ажлыг хариуцан гүйцэтгэх эрх бүхий албан тушаалтан /ЭБАТ/-ны үйл ажиллагааны эрх зүйн үндэслэл, зохицуулалтыг хуульд албажуулж баталгаажуулах |
| Хуулийн 26 дугаар зүйлийн 26.5-д "Улсын Их Хурлын гишүүнээс бусад албан тушаалтан хувийн ашиг | Энэ нь хуулийн 28 дугаар зүйлд заасан хэм хэмжээтэй агуулгын хувьд зөрчилдөх, хувийн ашиг сонирхлын | |

| | | |
|---|---|---|
| сонирхлын мэдүүлгээ хугацаанд нь гаргаж өгөөгүй, эсхүл бүрэн гүйцэд гаргаагүй бол Авлигатай тэмцэх газар тухайн мэдүүлэг гаргагчийн хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг шалгана.", Хуулийн 26 дугаар зүйлийн 26.2-т "Улсын Их Хурлын гишүүний хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг иргэний өргөдөл, гомдолд үндэслэн Улсын Их Хурлын Ёс зүйн дэд хороо шалгана." гэж заасан | мэдүүлгийг хуульд заасны дагуу үнэн, зөв мэдүүлэх үүрэг бүхий улс төрийн албан тушаалтанд "давуу эрх" олгосон өөрийн үйлдлээ хянах гажуудлыг бий болгож байна.<br><br>Энэ хүрээнд гарч буй нийтлэг зөрчлүүдийн нэг нь "Албан тушаалтан, төрийн болон нутгийн захиргааны байгууллага нийтийн хэрэгцээнд зориулан иргэн, хуулийн этгээдээс бэлэг, бусад санхүүгийн туслалцаа, хандив авах, хүсэхийг хориглосон хууль тогтоомжийг мөрдөж ажилладаггүй."[8] явдал байдаг гэжээ. | |

## 2.2.4.ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ЗОХИЦУУЛАЛТ, ХЭРЭГЖИЛТ

Тус хуулиар төрийн албаны мэргэшсэн, тогтвортой, ил тод, хариуцлагатай байх эрх зүйн үндсийг бүрдүүлэх, төрийн албаны төв байгууллага, төрийн албан хаагчийн эрх зүйн байдал, нийгмийн баталгааг тогтоохтой холбогдсон харилцааг зохицуулж байгаа бөгөөд хуулийг хэрэгжүүлэх хүрээнд 40 орчим нийтлэг зохицуулалт бүхий дүрэм, журам, зааврыг баталж мөрдөж байна.

Дээрх хууль эрх зүйн актын хэрэгжилтийг хангах явцад авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэх нөхцөл болж болзошгүй зарим зохицуулалт байна гэж үзсэнийг доор хүснэгтлэн үзүүлэв. Үүнд:

| Хуулийн зүйл, заалт | Хэрэгжилт | Анхаарах зүйлс |
|---|---|---|
| Хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн эрх зүйн байдлыг хуулиар тогтоох бөгөөд хуульд өөрөөр заагаагүй бол энэ хуулийн холбогдох заалтыг дагаж мөрдөнө, 4.2-т төрийн жинхэнэ албан хаагчийн эрх зүйн байдлыг энэ хууль болон хууль тогтоомжийн бусад актаар тогтооно гэж заасан. | Төрийн албан хаагчийн эрх зүйн байдлыг хуульд өөрөөр заасан зохицуулалт зарим салбарын болон үйл ажиллагааны тухай органик хуулиудад цөөнгүй байна.<br>- Ингэхдээ салбарын болон байгууллагын удирдлагын амбиц, лоббиноос хамааралтайгаар төрийн албан хаагчийн эрх зүйн байдал, нийгмийн баталгааны хувьд хэт зөрүүтэй байдлыг бий болгосон.<br>- Хэт ялгамжтай дээрх эрх зүйн зохицуулалт нь төрийн албаны харилцаан дахь шударга бус байдал бий болох хөрс суурь болж байна. | Төрийн албаны харилцаанд тэгш байдлыг хангах хүрээнд нийтлэг зохицуулалттай стандарт тогтоох харилцааны хүрээг тодорхойлох, улмаар, албаны онцлогоос хамаарах тусгай эрх зүйн зохицуулалтын хүрээг төрийн албаны хуулиар нарийвчлан зааж өгөх шаардлагатай. |

[8] Авлигатай тэмцэх хууль тогтоомжийн хэрэгжилт, авлигын ерөнхий нөхцөл байдал-2018, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт (2016-2018). 2019 он, 29 дэх тал

| | | |
|---|---|---|
| Хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д “Улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн эрх зүйн байдлыг хуулиар тогтоох бөгөөд хуульд өөрөөр заагаагүй бол энэ хуулийн холбогдох заалтыг дагаж мөрдөнө” гэж заагаад хуулийн 7.1.3, 11.3, 32.4, 32.5, 32.6, 37.1.4, 39, 37.1.5, 39.1.5, 39.1.6, 39.1.13, 57.5.7, 57.6 зэрэг зүйл заалтуудад төрийн улс төрийн албан тушаалтны эрх зүйн байдлын ялгамжтай байх нөхцөлийг хуульчилсан. | - Төрийн албан тушаалын ангилалд улс төрийн албан тушаалыг хамааруулсан хэрнээ төрийн албаны харилцаанд оролцогчийн хувьд эдлэх эрх, үүрэг хариуцлагыг ялгамжтай байхаар зааж, төрийн албаны хуулийн үйлчлэх хүрээнээс хассан.<br>- Гэсэн хэрнээ улс төрийн албан тушаалтнуудын эрх, үүрэг хариуцлагыг тусгайлан зохицуулсан хууль тогтоомж нь хангалтгүй байна. | - Төрийн улс төрийн албан тушаалтны хариуцлагын тухай хуулийг баталж, эрх, үүргийн хэрэгжилтийг бодитой болгоход анхаарах нь зүйтэй.<br>- Албан тушаалтнууд, ялангуяа төрийн өндөр албан тушаалтны халдашгүй дархан байдалтай холбоотой хуулийн зохицуулалтыг эргэж харах, авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд халдашгүй байдлын зохицуулалт үйлчлэхгүй байх хэмжээнд хүртэл холбогдох хуулиудад өөрчлөлт оруулах |
| Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.5-д төрийн жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагаанд “улс төрийн намын гишүүн байх, улс төрийн нам, хөдөлгөөн, улс төрийн намын дэргэдэх төрийн бус байгууллага болон шашны байгууллагын үйл ажиллагаанд хуулиар зөвшөөрснөөс бусад тохиолдолд аливаа хэлбэрээр оролцох”-ыг хориглосон. | Гэсэн ч дээрх хуулийн тайлбар хэсэгт “Энэ хуулийн 39.1.5, 39.1.6, 39.1.13 дахь заалт нь төрийн улс төрийн албан хаагчид хамаарахгүй” гэж оруулжээ. | Эндээс үзэхэд Орон нутгийн сонгуулиар сонгогдсон /улс төрийн намын гишүүн, эсхүл үйл ажиллагаанд оролцож буй/ этгээдүүд төрийн жинхэнэ албанд томилогдох эсэх болон дээрх зөрүүтэй байдлыг арилгах шаардлагатай[9] нөхцөл байдал үүсжээ. |

[9] Мөн тэнд.

| | | |
|---|---|---|
| Хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн албаны төв байгууллага өөрөө, эсхүл иргэний гомдол, мэдээллийн дагуу төрийн жинхэнэ албан хаагчийг сонгон шалгаруулж томилох үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийнэ.<br>30.2.Энэ хуулийн 30.1-д заасан хяналт, шалгалтын явцад хууль тогтоомж зөрчиж сонгон шалгаруулалт явуулсан, төрийн албан хаагчийг томилсон нь тогтоогдсон бол зөрчлийг арилгах хугацаатай үүрэг, даалгавар өгч, биелэлтийг хангуулна.<br>30.3.Энэ хуулийн 30.2-т заасан үүрэг, даалгаврыг биелүүлээгүй бол төрийн албаны төв байгууллага хууль тогтоомж зөрчсөн шийдвэрийг хүчингүй болгоно. | Төрийн албан хаагчийг сонгон шалгаруулалтгүй томилдог асуудал ялангуяа Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн үйлчлэлийн үед ихээр гарсан. | Төрийн албаны тухай хууль болон бусад хууль тогтоомжид заасан болзол шалгуурыг хэрхэн хангаж байгаа, сонгон шалгаруулалтад орж тэнцсэн, нөөцөд авагдсан эсэх, тухайн ажлын байранд тавигдах, шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангаж байгаа эсэхэд болон төрийн албанаас чөлөөлөгдсөн, халагдсан этгээд дахин өөр албан тушаалд томилогдохоор нэр дэвшсэн байдалд хяналт тавих, Төрийн албан хаагчийн улсын нэгдсэн тоо бүртгэлийн системтэй ХАСУМ-ийн цахим системийг уялдуулж, хяналтын механизмыг сайжруулах |
| Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгыг батлахдаа Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.7 дахь хэсгийг дагалдуулан "23.7.Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээд тухайн албан үүргийг гүйцэтгэхэд илт ашиг сонирхлын зөрчил | Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдээс урьдчилсан байдлаар хувийн ашиг сонирхлын мэдүүлэг авахаар хуульд тусгасан ч бодит байдалдаа урьдчилсан мэдүүлгийг хянуулахгүйгээр нийтийн албанд томилж байгаа, томилсны дараа хянуулахаар АТГ-т ирүүлдэг, мэдүүлгийг батлагдсан маягтын дагуу биш өөр маягтаар хүлээн авдаг, мэдүүлэгт заасан холбогдох материалыг дутуу ирүүлдэг зөрчил гарч байна.<br>Энэхүү зөрчил нь нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн ХАСУМ-ийг АТГ хянаад илт ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдлыг тогтоосон талаар албан бичиг хүргүүлсэн ч тухайн байгууллагын удирдлага нь түүнийг томилох, ашиг сонирхлын | ХАСУМ-ийг АТГ-т хянуулалгүйгээр томилсон албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх хуулийн зохицуулалт тодорхой болгох |

| | | |
|---|---|---|
| үүсч болох нь тогтоогдсон бол Авлигатай тэмцэх газар илт ашиг сонирхлын зөрчил үүсч болзошгүй нөхцөл байдлын талаар энэ хуулийн 23.6-д заасан мэдэгдэлд тодорхой дурдана” гэж өөрчлөн найруулсан. | зөрчилтэй нөхцөл байдалд албан үүрэг гүйцэтгүүлэх боломжтой болсон байна.<br>Мөн нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн ХАСУМ-ийг АТГ-т хянуулалгүйгээр томилсон албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх хуулийн зохицуулалт тодорхойгүйгээс авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх хууль тогтоомжийн хэрэгжилтэд сөргөөр нөлөөлж байна<br>Энэ нь дээрх хуулийн үндсэн агуулга, үзэл баримтлалыг алдагдуулж, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн 4.1.1.1- д заасан “хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянасан байдлыг үндэслэн албан тушаалд томилох тухай хуулийн хэрэгжилтийг хангах, хариуцлагыг дээшлүүлэх” арга хэмжээтэй уялдаагүй, зөрүүтэй, Үндэсний хөтөлбөрийн 2.1.1-д тусгагдсан “шударга, хариуцлагатай, ил тод нийтийн албыг бэхжүүлэх замаар авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, төрийн жинхэнэ албан хаагчийн сонгон шалгаруулалт болон томилгоонд улс төрийн нөлөөллөөс ангид, мэдлэг, боловсролд суурилсан мерит зарчмыг хэрэгжүүлэх” зорилтоос ухарсан шийдвэр болжээ | |
| Хуулийн 17 дугаар зүйлийн 17.1-д Төрийн өндөр албан тушаалтны зэрэг зиндаа, түүнтэй адилтгах төрийн албан тушаалтны зэрэглэлийг төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн Улсын Их Хурал тогтооно гэж заасны дагуу УИХ-аас 2019 оны 19 дүгээр тогтоолоор баталсан. | Гэтэл өнөөдрийг хүртэл хугацаанд Төрийн өндөр албан тушаалтны зэрэг зиндаа, түүнтэй адилтгах төрийн албан тушаалтны зэрэглэлийг тогтоох тухай тогтоолд 5 удаа нэмэлт оруулж, байнга хамрах хүрээг нэмэгдүүлж ирсэн. | Энэ нь Төрийн өндөр албан тушаалтны эрх ямба, халдашгүй байдал эдлэгчийн тоог нэмэгдүүлж ирснийг харуулж байна. |
| Төрийн албаны тухай хуулийн 56 дугаар зүйлд “Төрийн үйлчилгээний чанар, хүртээмж, үр нөлөөнд олон нийтийн хяналт тавих чиг үүргийг Олон нийтийн хяналтын зөвлөл гүйцэтгэнэ. Зөвлөлийг сонгон шалгаруулах, олон нийтийн | Үүний дагуу Төрийн албаны зөвлөлийн хурлаар “Олон нийтийн хяналтын зөвлөлийн дүрэм”-ийн төслийг хэлэлцэн баталсан байна.<br>Гэвч тус зөвлөлийг өнөөдрийг хүртэл байгуулаагүй байна. | Энэ нь төрийн албан дахь хуулийн хэрэгжилтэд хяналт тавих, ил тод байдлыг хангах шаардлага хэрэгжихгүй байгааг харуулж байна.<br>Энэ нь авлига, ашиг сонирхлын зөрчил |

| | | |
|---|---|---|
| хяналтыг хэрэгжүүлэх, зөвлөлийн ажиллах дүрмийг төрийн албаны төв байгууллага батална" гэж заасан. | | гарах нөхцөл болж байна |
| Төрийн албаны тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.4-т "Сахилгын зөрчлийг илрүүлснээс хойш 6 сар, зөрчил гаргаснаас хойш 12 сараас илүү хугацаа өнгөрсөн бол сахилгын шийтгэл ногдуулж болохгүй." гэж заасан. | Гэтэл авлига нь ихэвчлэн далд, нууц, нуугдмал байдлаар үйлдэгддэг тул энэ төрлийн гэмт хэрэг, зөрчлийг илрүүлэхэд цаг хугацаа их шаарддаг, хуульд зааснаар нийтийн албан тушаалтан хөрөнгө орлогын мэдүүлгээ жилд 1 удаа буюу жил бүрийн 02 дугаар сарын 15-ны дотор мэдүүлдэг, авлига, ашиг сонирхлын зөрчилд холбогдох гомдол, мэдээллийг тухайн албан тушаалтны сүүлийн 3-5 жилийн хугацааны мэдүүлгийг харьцуулан судалсны үндсэн дээр хариуцлага хүлээлгэх эсэх асуудлыг шийдвэрлэдэг онцлогтой. Гэвч дээр дурдсан нөхцөл байдлын улмаас Төрийн албаны тухай хуульд заасан хугацаанд авлигын болон ашиг сонирхлын зөрчил гаргасан нийтийн албан тушаалтанд хууль зүйн хариуцлага хүлээлгэх боломжгүй үр дагавар үүсэж хууль зүйн хариуцлагын урьдчилан сэргийлэх, цээрлүүлэх зорилго үгүй болох, АТГ-т болон төрд итгэх олон нийтийн итгэлд сөрөг нөлөө үзүүлдэг. | Иймд хариуцлага гарцаагүй байх зарчмыг үндэслэн авлига, ашиг сонирхлын зөрчлийн онцлогийг харгалзаж хөөн хэлэлцэх хугацааг тухайн төрлийн харилцааг зохицуулж байгаа хуульд өөрөөр тогтоож мөрдөх нь дээр дурдсан сөрөг үр дагаврыг арилгаж, хууль нэг мөр мөрдөгдөх нөхцөлийг бүрдүүлэх;<br><br>Эс бөгөөд хуулийн дээрх зөрчилд хөөн хэлэлцэх хугацаа тооцдоггүй олон улсыын зарим орны жишгийг хэрэглэх нь зүйтэй. |
| Хуулийн 64 дүгээр зүйлийн 64.2.6-д Засгийн газар төрийн албаны шинэтгэлийн бодлого, стратеги, хүний нөөцийн бодлогын хэрэгжилтийн явц, үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, түүний үр дүнг дээшлүүлэх талаар санал, зөвлөмж боловсруулах бүрэн эрхийг хэрэгжүүлэхээр заасан боловч мөн хуулийн 66 дугаар зүйлийн 66.1.8-д ТАЗ нь төрийн албаны шинэтгэлийн бодлого, стратеги, хүний нөөцийн бодлогын | Нэг чиг үүргийг 2 өөр байгууллагад олгосон нь уг чиг үүрэг хэрэгжихгүй байх, эсхүл дээрх байгууллагууд эрх хэмжээний зөрчилдөөн үүсэх үндэс болж байна. | Нөгөө талаас нь харвал төрийн албаны шинэтгэлийн бодлого, стратеги, хүний нөөцийн бодлогын хэрэгжилтийн явц, үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, түүний үр дүнг дээшлүүлэх асуудлыг эрхэн гүйцэтгэх сонирхол дээрх хоёр байгууллагад байгаа гэж хардах үндэс болж байна. |

<table>
<tr>
<td>хэрэгжилтийн явц, үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, түүний үр дүнг дээшлүүлэх талаар санал, зөвлөмж боловсруулах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ гэж заасан байна.</td>
<td></td>
<td></td>
</tr>
<tr>
<td>Төрийн албаны тухай хууль /шинэчилсэн найруулга/ /2017/-ийн 57 дугаар зүйлийн 57.4-т зааснаар “Улс төрийн болон тусгай албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагч /сум, дүүргийн Засаг дарга, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын орлогч, зэвсэгт хүчин, хилийн цэрэг ба дотоодын цэрэг, онцгой байдал, тагнуул, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тусгай албан тушаалаас бусад/-ийн албан тушаалын цалингийн хэмжээ, сүлжээг төрийн албаны төв байгууллагатай зөвшилцсөний үндсэн дээр Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал тогтооно.”, Компанийн тухай хуульд зааснаар гүйцэтгэх захирал, төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллын</td>
<td>Үндэсний статистикийн хорооноос жил тутамд гаргадаг “Статистикийн мэдээллийн нэгдсэн сан”-д байгаа дундаж цалин хөлсний тоон мэдээллээс үзэхэд Төрийн өмчит үйлдвэрийн газар, орон нутгийн өмчит үйлдвэрийн газар, төсөвт байгууллага төрийн өмчийн аж ахуйн нэгж, орон нутгийн өмчийн аж ахуйн нэгж, төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, төрийн өмчийн оролцоотой гадаадын аж ахуйн нэгжтэй хамтарсан байгууллага, орон нутгийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжид ажиллагж буй алба хаагчдын дундаж цалин эрс ялгаатай байна.
<table>
<tr><th>Өмчийн хэлбэр</th><th>2019</th><th>2020</th><th>2021</th></tr>
<tr><td>Төрийн өмчийн</td><td>1083.5</td><td>1221</td><td>1275.5</td></tr>
<tr><td>Төрийн - Өмчийн оролцоотой</td><td>1199</td><td>1422.7</td><td>1516</td></tr>
<tr><td>Төрийн - Гадаадтай хамтарсан</td><td>3339.8</td><td>3688.1</td><td>3874.2</td></tr>
<tr><td>Хувийн - Монгол Улсын иргэний</td><td>888.5</td><td>977.8</td><td>1058.9</td></tr>
<tr><td>Хувийн - Гадаадтай хамтарсан</td><td>1253</td><td>1377.9</td><td>1372.8</td></tr>
<tr><td>Хувийн - Гадаад улсын</td><td>2244.2</td><td>2141.7</td><td>2177.6</td></tr>
<tr><td>Орон нутгийн өмчийн</td><td>824.4</td><td>943.4</td><td>969</td></tr>
<tr><td>Орон нутгийн - Өмчийн оролцоотой</td><td>858</td><td>1080.5</td><td>1224.6</td></tr>
<tr><td>Орон нутгийн - Цэвэр гадаадын</td><td>817.4</td><td>898.5</td><td>970.2</td></tr>
</table>
</td>
<td>Энэхүү цалин хөлсний харилцан адилгүй байдал нь “үндэслэлгүй хөрөнгөжих” зөрчил гаргасан нийтийн албан тушаалтанд Авлигын эсрэг хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2-т заасан “....энэ хуулийн 7.1-д заасныг зөрчсөн этгээдэд албан тушаал бууруулах, хэрэв албан тушаалыг нь бууруулах боломжгүй албан тушаал бол албан тушаалын цалингийн хэмжээг гурван сар хүртэл хугацаагаар 30 хувиар бууруулах,” ...хууль зүйн хариуцлага хүлээлгэхэд учир дутагдалтай буюу<br><br>Иймд Монгол Улсын Үндсэн хуульд заасан болон хариуцлага гарцаагүй байх, зөрчил үйлдэгдсэн нөхцөл байдал, зөрчлийн шинж, хохирлын хэр хэмжээнд тохирсон байх</td>
</tr>
</table>

| | | |
|---|---|---|
| хэмжээг компанийн дүрмээр, эсхүл хувьцаа эзэмшигчдийн хурлаас тогтоон мөрдүүлэх зэргээр харилцан адилгүй зохицуулалттай байна. | хөрөнгө оруулалттай | зарчмыг баримтлан нийтийн албан тушаалтны “үндэслэлгүй хөрөнгөжих” зөрчлийн шинжийг тэдгээрийн албан тушаалын цалин хөлсний орлогоор бус хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй уялдуулан, хариуцлага хүлээлгэх нь зүйтэй байна. |

## 2.2.5.ГЭРЧ, ХОХИРОГЧИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ЗОХИЦУУЛАЛТ, ХЭРЭГЖИЛТ

Тус хуулиар эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гэрч, хохирогчийн амь нас, эрүүл мэндийг хамгаалах, тэднийг мэдээллээр хангах, дэмжлэг, туслалцаа үзүүлэх харилцааг зохицуулж байгаа бөгөөд АТГ-ын эрх хэмжээг нэмэгдүүлэх чиглэлээр дараах зохицуулалтыг боловсронгуй болгох нь зүйтэй гэж үзэж байна.

| Хуулийн зүйл, заалт | Хэрэгжилт | Анхаарах зүйлс |
|---|---|---|
| Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 23 дугаар 23.5-д “Авлигатай тэмцэх газар, Тагнуулын ерөнхий газар энэ хуулийн 7.1.1-7.1.6-д заасан арга хэмжээг өөрийн харьяалах асуудлын хүрээнд хэрэгжүүлэхээр заасны дотор “Гэрч, хохирогчийн амь нас, эрүүл мэндийг гэмт халдлагаас хамгаалах зорилгоор биечилсэн хамгаалалтад авах...” арга хэмжээг хэрэгжүүлэхээр заасан. | Гэрч, хохирогчийг хамгаалах хуульд заасан энэхүү чиг үүргээс гадна Төрийн албаны тухай хууль[10]д зааснаар төрийн албан хаагч, түүний гэр бүлийн гишүүнийг албан үүргээ гүйцэтгэж байгаатай нь холбогдуулан хүчирхийлэх, заналхийлэх, доромжлох, гүтгэх болон бусад хууль бус үйлдэл, үйл ажиллагаанаас хамгаалах олон арга хэмжээний дотор чирч болох эрсдэл, аюулаас хамгаалах зорилгоор зэвсэг, тусгай хэрэгсэл, мэх хэрэглэх шаардлага гардаг. | Авлигын эсрэг хуульд гэрч, хохирогч болон албан хаагчийн аюулгүй байдлыг хангах, биечилсэн хамгаалалт хийх үед байгууллагын аюулгүй байдлыг хариуцах чиг үүрэг бүхий албан хаагч галт зэвсэг, тусгай хэрэгсэл, мэх хэрэглэх үндэслэл тусгагдаагүй тул энэ эрхийг баталгаажуулах аюулгүй байдал, хяналт шалгалт, нууцын албаны эрх бүхий албан үүргээ гүйцэтгэх явцдаа галт зэвсэг, бие хамгаалах тусгай хэрэгсэл, мэх хэрэглэх эрхийг олгох нь зүйтэй. |

[10] https://www.legalinfo.mn/law/details/13025

### 2.2.6. ЭРҮҮГИЙН ХУУЛИЙН ЗОХИЦУУЛАЛТ, ХЭРЭГЖИЛТ

Авлигын эсрэг хууль 2006 оны 7 дугаар сарын 6-ны өдөр Улсын Их Хурлаас батлагдан 2006 оны 11 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн даган мөрдөгдөж байгаа ба тус хуульд 2012, 2014, 2016, 2019 онд тус тус нэмэлт, өөрчлөлт оруулж, өөрчлөн найруулсан. 2002 оны Эрүүгийн хуулийн "Албан тушаалын гэмт хэрэг" гэсэн бүлэгт "Хээл хахууль авах", "Хээл хахууль өгөх" гэсэн нэр томьёогоор тодорхойлж байсан бол 2015 оны Эрүүгийн хуульд 22 дугаар бүлгийг "Авлигын гэмт хэрэг" нэрээр тодорхойлж, уг бүлэгт 11 төрлийн гэмт хэргийг хуульчилсан байна. "Хээл хахууль" гэсэн нэр томьёог өөрчилж "Хахууль авах", "Хахууль өгөх" гэж тодорхойлсон.

Авлигатай тэмцэх газар Эрүүгийн хуулийн 22 дугаар бүлэгт заасан Авлигын гэмт хэрэг болон мөрдөн шалгах ажиллагааны явцад өөрсдийн илрүүлсэн Мөнгө угаах гэмт хэрэгт эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулдаг.

Энэ хуулийн дагуу АТГ-ын Мөрдөн шалгах хэлтэст 2022 оны эхний улиралд авлигын 124 хэрэг бүртгэгджээ. Энэ нь өмнөх оны эхний улиралтай харьцуулахад 35-аар буюу 39.3% өссөн дүн юм. Авлигын гэмт хэрэг өмнөх оны мөн үеэс өсөхөд эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах гэмт хэрэг 28-аар буюу 39.4% өссөн нь голлон нөлөөлснийг Үндэсний статистикийн хорооны мэдээлэл гарсан.

Бүртгэгдсэн авлигын 124 хавтаст хэргийг Монгол Улсын Эрүүгийн хуулийн 22 дугаар бүлгийн зүйлээр ангилахад

99 (75.6%) нь эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах

17 (13.0%) нь хахууль авах гэмт хэрэг

7 (5.3%) нь хахууль өгөх гэмт хэрэг

4 (3.0%) нь үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт хэрэг

1 (0.8%) нь дураараа аашлах гэмт хэрэг

2 (1.5%) нь төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах гэмт хэрэг 1 (0.8%) нь хуулийн этгээдийн эрх мэдлийг урвуулан ашиглах гэмт хэрэг байна[11].

Хуулийн хэрэгжилт болон нийтцлийн хүрээнд анхаарал татсан зарим асуудлыг хүснэгтэд нэгтгэн харуулбал:

| Хуулийн зүйл, заалт | Хэрэгжилт | Анхаарах зүйлс |
|---|---|---|
| Эрүүгийн хуулийн 22.2 буюу Албаны эрх нөлөөг урвуулан ашиглах гэмт хэрэг нь 2017 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон. | Одоо мөрдөж буй Эрүүгийн хуулийн хэм хэмжээ нь нийтийн албан тушаалтныг өөрийнхөө гэм буруугүг нотлохыг үүрэгжүүлсэн буюу Монгол Улсын Үндсэн хуулийн суурь зарчимд харшлах нөхцөлийг бүрдүүлж байна гэж үзэх үндэслэлтэй байна. | Тиймээс цаашид энэ гэмт хэргийг дахин Эрүүгийн хуулиар зохицуулах нь зүйтэй.<br>Энэхүү заалт нь авлигын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох зорилготой чухал агуулга бүхий гэмт хэрэг гэж үзэн Олон Улсын байгууллагаас заавал Эрүүгийн хууль тогтоомждоо оруулахыг зөвлөдөг болно. |

[11] Ikon.mn. 2022 он 4 сар.

| | | |
|---|---|---|
| | | ЭХ-ийн 22 дугаар бүлэгт заасан авлигын гэмт хэргийн томьёолол, харилцан хамаарал, логик дарааллыг эрүүгийн хуулийн тусгай ангид заасан бусад гэмт хэргийг томьёолж буй аргачлалаар, Авлигын эсрэг НҮБ-ын конвенцод нийцүүлэн шинэчлэн найруулах шаардлагатай гэж үзэж байна. Ингэснээр албаны эрх нөлөөг урвуулан ашиглах гэмт үйлдэл, эс үйлдлийг өөр төрлийн буюу бие даасан гэмт хэрэг болгон зүйлчлэх боломж бүрдэнэ. |
| 22.4 дүгээр зүйл.Нийтийн албан тушаалтан хахууль авах,<br>22.5 дугаар зүйл.Хахууль өгөх | Улс төрийн үйл ажиллагаанд оролцох, ямарваа улс төрийн албан тушаал эзлэхийн төлөө сонгууль явагдах үеэр нэр дэвшигч, улс төрийн намыг дэмжиж, эсвэл эсэргүүцэж үг хэлсний төлөө, ерөнхий болон тусгай сонгуулийн үеэр хэн нэгэнд ажилд оруулж өгөх болон бусад ашиг амласан этгээд нь авлигын хэргээр хариуцлага хүлээдэг болгох | |
| Хорин хоёрдугаар бүлэг<br>Авлигын гэмт хэрэг | Мөнгө угаах гэмт хэргийн зүйлчлэлээр зүйлчлэгдсэн хэргүүд дунд авлигын хэрэг гэхээс илүүтэй ахуйн хэрэг болох хулгай болон дээрмийн гэмт хэргийн улмаас олсон мөнгөө бусдад худалдаалан ашиг олсон гэх хэргүүд байна. Энэ нь практикт хэр үр дүнтэй байгаа эсэхийг харгалзан эрх зүйн зохицуулалтыг нарийн гаргаж өгөх хэрэгтэй. Өөрөөр хэлбэл авлигын болон эдийн засгийн мөнгө угаасан хэргүүд мөнгө угаах гэмт хэргээр давхар зүйлчлэгдэхгүй орхигдох нөхцөл үүсээд байна. Иймд энэ төрлийг хэргийг шийдэхдээ шүүхийн албан бус жишиг бий болгох эсхүл Улсын Дээд Шүүхээс тайлбар гаргаж асуудлыг нэг мөр шийдэх хэрэгтэй.<br>Авлигын гэмт хэргийн талаарх зарим эрх зүйн зохицуулалтыг хуулиар шинэчлэх, үүнд: гадаадын болон олон улсын байгууллагын албан тушаалтны хээл хахуулийн идэвхтэй ба идэвхгүй хэлбэрийг гэмт хэрэгт тооцох шаардлагатай. | |
| Албан тушаалтан л үйлдэх боломжтой нийт 20 гэмт хэргийн нэгээс бусад бүх хэрэгт хөөн хэлэлцэх хугацаа таван жил байхаар заасан байна.<br>5-15 жилийн хорих ял оноохоор Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэрэг үйлдвэл 12 жил өнгөрөхөд хөөн хэлэлцэх | Авлига, албан тушаалын гэмт хэрэг нь бусад төрлийн гэмт хэргүүдээс үйлдлийн арга, үйлдэгдсэн нөхцөл байдал, субъектийн хувьд өөрийн онцлогтой, ээдрээ төвөгтэй, өргөн цар хүрээнд шалгалтыг хийдэг тул мөрдөн шалгахад нэлээд цаг хугацаа шаарддаг бөгөөд эдгээр гэмт хэргийн хувьд одоогийн үйлчилж буй | Иймд Авлигын гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг Авлигын эсрэг конвенцид нийцүүлэн эрүүгийн хуулийн тусгай ангид засан бусад бүлгийн гэмт хэргээс аль болох уртаар буюу 5-аас доошгүй жилээр тогтоох талаар хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах<br>Япон улсад Эрүүгийн хэрэг хянан шийтгэх тухай |

| | | |
|---|---|---|
| хугацаа дуусч хэрэгсэхгүй болгоно. | хуулиар тогтоосон хөөн хэлэлцэх хугацаа нь практик дээр гэмт хэргийг илрүүлэн эцэслэн шалгаж шийдвэрлэхэд сөргөөр нөлөөлж байна.<br><br>Нөгөө талдаа зарим гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацааг тооцох хуулийн үндэслэл эргэлзээтэй байгааг өөрчилж засах шаардлагатай. | хуулийн 254 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар хэргийн оролцогчийн аль нэгийг нь яллах дүгнэлт үйлдүүлэх замаар хөөн хэлэлцэх хугацааг түдгэлзүүлэх үйл ажиллагаа нь бусад хамтран гүйцэтгэгч нараас хамаардаг. Өөрөөр хэлбэл авлигын хэрэгт хэн нэгэн хамтран оролцогч этгээдийн асуудлыг ярихын тулд бусдынх нь хөөн хэлэлцэх хугацааг зогсоодог жишгийг нэвтрүүлэх<br><br>Эсхүл зарим улсын жишгийн дагуу Авлигын гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацаа хэрэглэхгүй байх зохицуулалтыг бий болгох нь авлигын эсрэг тууштай тэмцэх нэг нөхцөл болно. |
| | | Иймд авлигын гэмт хэрэгтэй шийдвэртэй тэмцэхэд хорих эсхүл торгох ял шийтгэлийг сонгох үндэслэл, нөхцөлийг тухайн гэмт хэргийн шинж, хүнд хөнгөний байдлаас хамаарч шатлалтайгаар тогтоодог зохицуулалтыг бий болгох хэрэгтэй байна. Түүнчлэн авлигын хэрэгт тэнсэх албадлагын арга хэмжээ хэрэглэхгүй байх зэргээр ялын бодлогыг чангатгах |
| | Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан зөрчлийн хувьд хөөн хэлэлцэх хугацааг тогтоон, хязгаарлаагүй. Гэвч шүүхийн практикт энэ төрлийн зөрчлийг Төрийн албаны тухай хуульд заасан сахилгын зөрчилтэй адилтган, хөөн хэлэлцэх хугацааг нэг жилээр авч үзэх практик тогтож байгаагаас гадна авлига, ашиг сонирхлын зөрчлийн шинж чанартай уялдаагүй, зөрчил гаргасан албан тушаалтан хариуцлагаас гадуур үлдэх эрсдэлийг бий болгон, хуулийн үндсэн зорилгыг алдагдуулж, хяналт шалгалтын ажлын үр дүнд сөргөөр нөлөөлж байгаа тул авлига, ашиг сонирхлын зөрчлийн хөөн хэлэлцэх хугацааг нэг мөр ойлгуулахаар зохицуулалтыг залруулах; | |
| | Бусдын хүсэлтээр Улсын хилээр бэлэн мөнгө, эд бараа тээвэрлэх, хувийн мэдээллээ алдах, өөрийн | Иймд энэ төрлийг хэргийг шийдэхдээ шүүхийн албан бус жишиг бий болгох эсхүл Улсын Дээд Шүүхээс |

| | | |
|---|---|---|
| | бичиг баримтыг хэрэглүүлэх, өөрийн дансыг ашиглуулах боломж олгох зэрэг нь гэмт хэрэгтэн болгох эрсдэлийг дагуулж байгаа авлигын болон бусад албан тушаалын болоод эдийн засгийн гэмт хэргүүдийн араас тууштай мөрдөн мөшгөх бололцоог багасгаж буй бөгөөд иргэдийн эрх зүйн мэдлэг ухамсар бага байгаа нь мөнгө угаах хэрэгт холбогдох эрсдэл дагуулж байна. Тиймээс мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргийн шинж тэмдгийг таних, ялгах, зүйлчлэн хэрэглэх ойлголт жигдрээгүй байна гэж үзэж болно. Үүний цаана авлигын болон эдийн засгийн мөнгө угаасан хэргүүд мөнгө угаах гэмт хэргээр давхар зүйлчлэгдэхгүй орхигдох нөхцөл үүсээд байна. | тайлбар гаргаж асуудлыг нэг мөр шийдэх хэрэгцээ бий болжээ |

Хуулийн зүйл заалтыг боловсронгуй болгох хүрээнд харгалзан үзэх шаардлагын үүднээс зарим орны эрх зүйн зохицуулалтын талаар шигтгээ болгон орууллаа. Үүнд:

Япон улсын Эрүүгийн хэрэг хянан шийтгэх тухай хуулийн 255 дугаар зүйлд сэжигтэн, яллагдагч гадаадад гарсан, гадаад улсад нуугдаж байгаа бол яллах дүгнэлт үйлдэх боломжгүй бол энэ хугацаанд хөөн хэлэлцэх хугацааг түдгэлзүүлэх, зогсоодог жишгийг нэвтрүүлэх

Өөрөөр хэлбэл дээрх заалт нь гадаадад гарч зугтаж байгаа л бол хөөн хэлэлцэх хугацааг түдгэлзүүлэх явдал юм.Үүний нэг жишээ бол Япон улсын Йодо группын Такахиро Кониши, Кимихиро Уомото, Мориаки Вакабаяши, Широ Акаги нарын залилан, авлигын хэрэг юм. 2009 оны 10-р сарын 20-ны өдөр Японы Дээд шүүх үл хөдлөх хөрөнгийн зуучлагчаас нийт 33 сая орчим иен залилан мэхэлсэн, авлигад өгсөн хэргээр эрүүгийн хэрэг үүсгэн шалгаж байх үед дээрх этгээдүүд гадаадад 56 удаа аялж, нийт 324 хоног гадаадад байсан нь тогтоогдсон бөгөөд дээрх хугацааг хөөн хэлэлцэх хугацаанд оруулж тооцоогүй байдаг. Дээрх Японы Эрүүгийн хэрэг хянан шийтгэх тухай хуулийн 255 дугаар зүйлд гэмт хэрэгтэн гадаадад гарсан, гадаад улсад нуугдаж байхад яллах дүгнэлт үйлдэх боломжгүй бол энэ хугацаанд хөөн хэлэлцэх хугацааг түдгэлзүүлнэ гэж заасан заалттай ижил төстэй байдлаар хөөн хэлэлцэх хугацааг түдгэлзүүлэх үндэслэлүүдийг гаргаж хуульчлах  хэрэгцээ манай улсад байна.

Түүнчлэн яллах дүгнэлтийг хүргүүлээгүй тохиолдолд, яллах дүгнэлт үйлдэж ирүүлээгүй тохиолдолд хөөн хэлэлцэх хугацааг түдгэлзүүлэх эсэх асуудал яригддаг. Хуульд заасан хугацаанд  прокурор яллах бодолтой байгаагаа илэрхийлсэн л бол ял хөнгөрүүлэх, нотлох баримтыг сарниулахаас урьдчилан сэргийлж хөөн хэлэлцэх

хугацааг түдгэлзүүлснийг хүлээн зөвшөөрсөн тохиолдол бий12. Тиймээс 1995 онд Гунма мужийн Такасаки хотын эрүүл мэндийн хүнсний борлуулалтын компанийн ерөнхийлөгчийн татвараас зайлсхийсэн хэрэгт түүнийг хаана байгааг нь тогтоохгүйгээр хэрэг үүсгэж байсан. 1999 оны 3-р сараас эхлэн яллах дүгнэлт үйлдээгүй, шүүхээс яллах бүрэлдэхүүнийг хэрэгсэхгүй болгох шийдвэр гаргахад өмнөх ерөнхийлөгчийг цагдан хорих хүртэл нийт 42 удаа яллах дүгнэлт үйлдэж прокурорын тогтоолыг 5 жил зогсоож 2007 оны 3-р сард шийдсэн тохиолдлууд байдаг[13] Мөн Кагава мужийн Такамацу хотод тусгай асрамжийн газар барихтай холбоотой авлигын хэргээр баривчлагдсан хотын зөвлөлийн дарга асан Казүто Миямотогоос 2005 онд Кагава мужийн цагдаагийн газраас нөхцөл байдлын талаар ярилцлага авсны дараа үргэлжлүүлэн зугтсан тул Такамацу дүүргийн прокурорын газар хөөн хэлэлцэх хугацааг дуусгахаас урьдчилан сэргийлэхийн тулд хоёр удаа хээл хахуулийн хэрэг үүсгэсэн түүхтэй. Тиймээс авлигын гэмт хэрэгтэй тэмцэхэд дээрх агуулгуудыг Эрүүгийн хуулийн хөөн хэлэлцэх хугацаанд оруулж өгөх шаардлагатай гэж үзэж байна. Авлига, албан тушаалын гэмт хэрэгтэй тэмцэх бодлого барьж буй л бол хөөн хэлэлцэх хугацааг Эрүүгийн хуульд тусгайлан зааж өгөх боломжтой. Тухайлбал, Эрүүгийн хуулийн нэмэлт өөрчлөлтөд татвар төлөхөөс зайлсхийх гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг онцгойлон таван жил байна гэж заасантай адил шууд 8 эсвэл 10 жил байхаар авлигын хэргийн хөөн хэлэлцэх хугацааг хуульчлах боломжтой. Зарим улсад хөөн хэлэлцэх хугацааг авлигын хэрэгт тоолдоггүй тохиолдол ч бий.

ХБНГУ-ын Эрүүгийн хуулийн Тусгай ангийн 30 дугаар хэсгийн 331-358 дугаар зүйлүүдэд албан тушаалын гэмт хэргийн талаар заагдсан байна. Германы хуулиар хээл хахууль өгөх ба авах хэрэгт эрүүгийн хариуцлага ноогдуулахдаа тухайн албан тушаалтан өөрийн албан үүрэгт хамрагдах хууль ёсны үйлдэл хийгээд авсан уу, эсвэл албан үүрэгт нь хамаарахгүй хууль бус үйлдэл хийгээд авсан уу гэдгээр нь ангилан ханддаг[14] байна. Түүнчлэн Германы Эрүүгийн хуулийн 331 дүгээр зүйлд ёсоор албан тушаалтан ямар нэг үйлдлийг тухайн хугацаанд хийх юм уу ирээдүйд хийхийн тулд бусдаас эд хөрөнгийн болон өөр ашиг нэхсэн, эсвэл авсан, эсвэл авахаар амлуулсан бол торгох юм уу хоёр жил хүртэл хугацаагаар хорих ялаар шийтгэгдэнэ. Хэрэв дээрх хэргийг шүүгч үйлдсэн бол торгох юм уу гурав хүртэл жил хорих ялаар шийтгэгдэнэ гэж зохицуулалт оруулсан байдаг. Гэхдээ энэ зүйлд албан тушаалтан этгээд нэхсэн ашгаа бодитоор авах юм уу амлалт авахдаа урьдчилан зохих эрх мэдэлтэнд мэдэгдэж зөвшөөрөл авсан, эсвэл авмагцаа уг хахуулийг өгсөн, авсан тухай мэдэгдвэл шийтгэл оноохгүй гэж заасан[15] байгаа нь өвөрмөц зохицуулалт гэлтэй. Шүүгчийн авлигын хэргийг хүндрүүлэх нь шүүхийн бие даасан хараат бус байдлыг баталгаажуулах гэсэн нэгэн онцлог зохицуулалт юм. Монгол улсын хувьд ч энэхүү Герман улсын эрүүгийн зохицуулалтуудаас өөрсдийн авлигын гэмт хэрэгтэй тэмцэх хүрээнд санаа авч хууль тогтоомждоо тусгах хэрэгцээ байгааг үгүйсгэхгүй.

Түүнчлэн Эрүүгийн хуулийн Тусгай ангийн 30 дугаар хэсгийн 332 дугаар зүйлээр 331 дүгээр зүйлд дурдсан хэргийг үйлдэхдээ албан тушаалтан өөрийн албан үүргээ зөрчин хийсэн бол зургаан сараас таван жил хүртэл хугацаагаар хорих ял оноох, хөнгөн тохиолдолд торгох юм уу гурав хүртэл жил хорих ял оноох гэж заажээ. Хэрэв энэ хэргийг шүүгч үйлдсэн бол нэг жилээс арван жил хүртэл

[12]最高裁決定昭和55年5月12日”. 裁判所. 2015年8月22日閲覧。

[13]脱税で43回起訴 元社長に有罪判決 前橋地裁＝群馬 読売新聞 2007年7月12日

[14] Монгол Улсын Их хурлын тамгын газар. Судалгааны төв. Б. Буяндэлгэр, Р. Хатанбаатар, П. Амаржаргал, К. Пүрэвсүрэн, Б. Цолмонбаяр. Судалгааны эмхтгэл, XII боть. УБ:,2012 он. 20 дахь тал.

[15] Мөн тэнд. 20 дахь тал.

хугацаагаар, хөнгөн тохиолдолд зургаан сараас таван жил хүртэл хугацаагаар хорих ял оноодог[16] байна. Эрүүгийн хуулийн 333 дугаар зүйлд дээрх хоёр зүйлд заасан хээл хахуулийн хэргийн хахууль өгөгч этгээдэд оноох ял нь хахууль авагчийнхтай адил байхаар зохицуулжээ. Харин 334 дүгээр зүйлээр хахууль өгөгч этгээд хахууль өгөх юм уу амлахдаа албан тушаалтан өөрийн үүргээ зөрчин хийхээр тохиолдолд түлхсэн бол хахууль авсан этгээдтэй адилаар 332 дугаар зүйлд заасантай адил ялаар шийтгэгдэхээр зохицуулжээ[17]. Энэхүү ХБНГУ-ын Эрүүгийн хуулийн зохицуулалтууд нь Монгол Улсын эрүүгийн эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгоход анхаарч харьцуулан үзэх боломжтой нарийвчилсан заалтууд гэж үзэж байна.

Улс төрийн үйл ажиллагаанд оролцох, ямарваа улс төрийн албан тушаал эзлэхийн төлөө сонгууль явагдах үеэр нэр дэвшигч, улс төрийн намыг дэмжиж, эсвэл эсэргүүцэж үг хэлсний төлөө, ерөнхий болон тусгай сонгуулийн үеэр хэн нэгэнд ажилд оруулж өгөх болон бусад ашиг амласан этгээд нь авлигын хэргээр хариуцлага хүлээнэ[18] боломжтойгоор зохицуулалт зарим улсад хийгдсэн байгаагаас харахад авлигыг өргөн хүрээнд хуульчилж арга хэмжээ авах нөхцөлийг хуулиар бүрдүүлжээ.

“Албан тушаалтан хууль ёсны орлогоос нь их хэмжээгээр илүү гарсан хөрөнгийг хэрхэн олж авсан талаар үндэслэлтэй тайлбарлаж чадахгүй бол” гэсэн үйл явцтай холбоотой нийтлэг зохицуулалт бол 1. Илүү гарсан хөрөнгийг төрд хураан авах 2.Ажлаас халах, дахиж төрийн албанд ажиллахгүй байх 3. Хорих[19] гэсэн зохицуулалт АНУ-д үйлчилж байна.

### 2.2.7.ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛИЙН ЗОХИЦУУЛАЛТ, ХЭРЭГЖИЛТ

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.4.7-д “Эрүүгийн хууль тогтоомжийн эрх зүйн шинэчлэлийг гүнзгийрүүлж, гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тогтолцоо, бодлого, арга барилыг боловсронгуй болгоно.” гэж, Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор баталсан “Шинэ сэргэлтийн бодлого”-ын Зургаа дахь хэсгийн “Төрийн бүтээмжийн сэргэлт”-ийн 6.5-д “Авлига, албан тушаалын гэмт хэрэгт оногдуулах ялын бодлогыг чангатгана” гэж эрх зүйн зохицуулалтуудыг хийж өгсөн байдаг. Эрүүгийн хуульд Хахууль авах, Үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт хэргийн субъектийг өргөжүүлж байгаатай холбогдуулан авлигатай тэмцэх байгууллагын мөрдөн шалгах харьяалалд холбогдох өөрчлөлтийг тусгах шаардлага үүсээд байна.

Авлигатай тэмцэх эрх зүйн орчинг сайжруулахын тулд ЭХХШтХ-ын тодорхой хэсгүүдэд нэмэлт өөрчлөлт оруулах хэрэгцээ шаардлага бий. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд ч “Хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх зарчим”-ыг баталгаажуулсан байдаг. Гэвч сүүлийн үед тодорхой албан тушаалтны хараат бус, халдашгүй байдал, эрх зүйн баталгаатай холбоотойгоор Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар зохицуулаагүй харилцааг салбар хуулиудаар тогтоож байгаа нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд сөргөөр нөлөөлөх нөхцөлийг бүрдүүлсээр байна.

---

[16] Мөн тэнд.
[17] Мөн тэнд.
[18]Ашигласан материал: http://www.law.cornell.edu/uscode•/, Cornell University Cornell Law School, Legal Information Institute.
[19] Монгол Улсын Их хурлын тамгын газар. Судалгааны төв. Б. Буяндэлгэр, Р. Хатанбаатар, П. Амаржаргал, К. Пүрэвсүрэн, Б. Цолмонбаяр. Судалгааны эмхтгэл, XII боть. УБ:,2012 он. 22 дахь тал.

Эрүүгийн хууль болон Эрүүгийн процессын хуулиудыг бусад салбар хуулиудаар зохицуулах буюу төсөөтэй хэрэглэх, нөхөж зохицуулах онолын болон практик хэрэглээний асуудал байдаггүй. Гэтэл Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 9.6 дугаар зүйлд “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий нөхцөл байдлыг мэдэж байгаа хүнийг гэрч” гэнэ гэж тодорхойлоод гэрч нь хуулийн байгууллагын дуудсанаар хүрэлцэн ирж, хэргийн талаар өөрийн мэдэх зүйлийг үнэн, зөв мэдүүлэх үүрэгтэй гэж заажээ.

Харин Төрийн аудитын тухай хуулийн 38.6-д “Монгол Улсын ерөнхий аудиторыг УИХ-ын зөвшөөрлөөр, төрийн аудитын байгууллагын бусад албан хаагчийг Монгол Улсын ерөнхий аудиторын зөвшөөрлөөр гаргасан аудитын тайлан, дүгнэлттэй нь холбогдуулан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж байгаа байгууллага, албан тушаалтан гэрчийн мэдүүлэг авч болно” гэсэн зохицуулалт нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогч, хэрэгжүүлэгч биш субъектээс мөрдөн шалгах ажиллагааны зөвшөөрөл авах зохицуулалт тогтоосон асуудал харагдаж байна.[20]

Энэ нь Эрүүгийн процессын ажиллагааг тодорхой үүрэг хүлээж эрх эдлэж буй субьект хэрэгжүүлэх хуулийн зохицуулалтуудыг зарчимтай нь үгүйсгэж байгаа хэрэг мөн. Ийм зохицуулалтууд УИХ-ын тухай хууль болон Шүүх, Прокурор, Тагнуул, Төрийн аудитын тухай хуулиудад байгааг хууль тогтоогч нар эргэж харахгүй бол авлига, албан тушаалын хэргүүдийг илрүүлэхтэй холбоотой эрүүгийн процессын ажиллагааг хууль ёсны дагуу хэрэгжих нөхцөлийг бүрдүүлэхгүй байх эрсдэл бий болжээ.

ЭХХштХ-ийн 45 дугаар бүлгийн хэрэгжилтийг хангахын тулд хүний зөрчигдсөн эрхийг сэргээхдээ “мөрдөгч, прокурор болон шүүгчийн буруутай эсэхээс үл хамааран төр хариуцан арилгах” үүргийг тодорхой болгох. Тухайлбал, ЭХХштХ-ийн 45 дугаар бүлгийн гарчиг болон зарим зүйл хэсэгт 2020 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн “хууль зөрчсөн ажиллагааны улмаас” гэсэн томьёоллыг хүчингүй болгох, Иргэний хуулийн 498 дугаар зүйлд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай гэж судлаач нар үзсэн[21] байна. Түүнчлэн хэрэг бүртгэлтийн хэргийг хаах, эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгохын өмнө бие даасан, хараат бус хороо шийдвэрийг хянадаг тогтолцоог хуулийн байгууллагын бүтцэд бүрдүүлэх. Энэ боломжийг бүрдүүлэх өөрчлөлтийг Авлигын эсрэг хууль, ЭХХШтХ-д оруулах хэрэгцээ шаардлага байна. Нөлөө бүхий албан тушаалтан үйлдсэн, ээдрээ төвөгтэй, олон холбогдогчтой авлигын хэргийг бүрэлдэхүүнтэй шийддэг байх зохицуулалтыг ЭХХШтХ-д оруулах шаардлагатай гэж үзэж байна. Учир нь улс төрд нөлөө бүхий албан тушаалтны хэргийг нэг шүүгч хэрэг маргааныг шийдвэрлэх нь олон талын эрсдэл дагуулж байна. Тухайлбал шүүгчид хууль бусаар нөлөөлөх болоод бусад байдлаар хэргийг үнэн шийдвэрлэхэд нь саад учруулах эрсдэл өндөр. Хохирогч, нэхэмжлэгч тогтоогдоогүй, мөн нэргүй гомдол, мэдээлэлд хамаарах хохирогчийн эрхийг хөндлөнгийн, хараат бус этгээдэд шилжүүлж болох заалтыг хуульд оруулах[22] хэрэгтэй гэж үзэж байна.

Эрүүгийн хуулийн тусгай ангийн Хорин хоёрдугаар бүлгийн зарим зүйлд заасан авлигын гэмт хэрэг, Хорин есдүгээр бүлэгт заасан Хүн төрөлхтний аюулгүй

[20] Х.Буянтүмэн. Авлигын хэрэгт оноох хариуцлагыг төр, олон нийтэд учруулсан хор хохиролтой харьцуулахад хөнгөн байгаа нь үнэн. УБ., Авлигатай тэмцэх газар. Албан ёсны цахим хуудас. 2021-09-10. Ярилцлага.

[21] Нээлттэй нийгэм форум. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 45 дугаар бүлгийн хэрэгжилт. Судалгааны тайлан. УБ.,2021 он.

[22] Авлигатай тэмцэх хууль тогтоомжийн хэрэгжилт, Авлигын ерөнхий нөхцөл байдал, авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт. УБ., 2020 он.

байдал, энх тайвны эсрэг гэмт хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэхгүй байх, авлигын хэргийг түргэн шуурхай шийдвэрлэх, мэргэшсэн шүүгчээр шийдвэрлүүлэх үүднээс давж заалдах шатны шүүх анхан шатны журмаар шийдвэрлэдэг байх, давж заалдах эрхийг Улсын дээд шүүхэд хангахтай холбоотой нэмэлт оруулах шаардлагатай[23] гэж үзэж байна.

### 2.2.8.МӨНГӨ УГААХ БОЛОН ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ ТУХАЙ ХУУЛИЙН ЗОХИЦУУЛАЛТ, ХЭРЭГЖИЛТ

Хууль бус хөрөнгө мөнгө ихээр зах зээлд эргэлдэж буй улс орнууд хууль дээдлэх ёсыг зөрчихдөө өртөмтгий байдаг тул мөнгө угаах гэмт хэрэг нь олон улсад ноцтой аюул учруулдаг. Үүн дээр төрийн албан хаагчдын авлига, тэдний эдийн засгийг тогтворгүй байдал мөнгө угаах шинжтэй гэмт хэрэг үйлдэхэд тодорхой хэмжээнд нөлөөлсөөр байгаа юм. Монгол улс 2013 онд анх удаа FATF[24]-ын “Саарал жагсаалт”-д орж дараа жил нь 2014 онд гарч амжсан. Гэтэл 2019 оны 10 дугаар сарын 18-нд FATF-ийн чуулганаар хэлэлцэн авлигын эсрэг эрх зүйн орчинг сайн бүрдүүлээгүй хэмээн саарал жагсаалтад Монгол улсыг дахин оруулсан билээ. Энэ нь манай улсын мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэж буй үйл ажиллагаанд муу дүн тавьж байгаатай ижил утга илэрхийлж буй хэрэг. 2020 оны 10 дугаар сард саарал жагсаалтаас гарсан. Тиймээс 2023 онд Монгол Улсад “5 дахь жилийн явцын үнэлгээ”-г FATF-аас хийх бөгөөд энэ хүрээнд бид шууд хэрэгжилтийн 11 үзүүлэлтийн үнэлгээг ахиулах боломжтой юм. Ялангуяа эрх зүйн хүрээнд тулгамдаж буй асуудлуудыг гаргаж тавих тал дээр түлхүү анхаарч ажиллах хэрэгтэй байна.

Мөнгө угаах гэмт хэрэгт хамгийн ихээр өртөж болох салбараар Монгол Улсын хэмжээнд санхүүгийн салбарын дийлэнх хувийг эзэлж байгаа банкны салбар зүй ёсоор багтсан бол үл хөдлөх хөрөнгийн салбар хоёрдугаарт орох үнэлгээ гаргасан[25] юм. Хууль хяналтын байгууллагад шалгагдсан авлига, албан тушаалын гэмт хэргийн хөрөнгө, ашиг, орлогыг нуун далдлах үйл ажиллагаанд гэмт этгээд өөрийн ах, дүү, хамаатан садан, ойрын төрлийн аливаа хүмүүс, найз нөхөд, танил тал, хүүхдүүдийг хүртэл ашиглаж байгаа нь тогтоогдож байна.

2011-2014 оны хооронд үндэсний мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог сайжруулах эрх зүйн шинэчлэлийн үр дүнд Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулинд “улс төрд нөлөө бүхий этгээд”, эцсийн өмчлөгч, халхавч банк гэсэн шинэлэг ойлголтууд хэрэглээнд нэвтрүүлсэн нь эрх зүйн зохицуулалтын хүрээнд чухал алхам байв. Монгол Улсын Зөрчлийн хуулийн 11.29 дүгээр зүйлд заасан Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль зөрчих зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд дараах хариуцлага хүлээлгэнэ. 2015 оны Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгаар 18.6 дугаар зүйлд заасны дагуу Мөнгө угаах гэмт хэргийн шинжийг тодорхойлсон. Өнөөдөр дэлхийд мөнгө угаахтай тэмцэх хоёр үндсэн стратеги байна. (1) мөнгө угаах бүх хэлбэрийг гэмт хэрэгт тооцож хууль бусаар

[23] Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээ. УБ., 2022 он.
1. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 10 дахь хэсэг.
17.1 дүгээр зүйлийн 6 дахь хэсэг. Эрүүгийн хуулийн Хорин хоёрдугаар бүлэг, Хорин есдүгээр бүлэгт заасан гэмт хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэхгүй.
2. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 18 дахь хэсэг.
39.1 дүгээр зүйлийн 9 дэх хэсэг. Давж заалдах шатны шүүх Эрүүгийн хуулийн Хорин хоёрдугаар бүлэгт заасан авлигын гэмт хэргийг анхан шатны журмаар хянан шийдвэрлэнэ.
[24] Financial Action Task Force. Олон улсын санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага.
[25] Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх үндэсний эрсдэлийн үнэлгээ. УБ., 2016 он. 10 дахь тал.

олсон орлогыг хураах замаар эрүүгийн эрх зүйн тогтолцооны үр ашгийг дээшлүүлэх, (2) хууль бусаар олсон орлогыг хураах үйл ажиллагааг нарийн тооцоолж гаргах. зээл, санхүүгийн байгууллагуудад чиглэсэн, санхүүгийн үйл ажиллагааны ил тод байдлыг нэмэгдүүлэх зорилготой урьдчилан сэргийлэх цуврал арга хэмжээ авах юм[26]. Дээрх хоёр стратеги арга хэмжээнүүд нь үйлчлүүлэгчээ мэдэх дүрэм буюу тухайлбал данс нээлгэх, санхүүгийн гүйлгээ хийх үйлчлүүлэгчийг тодорхойлох журам, холбогдох баримт бичгийг зохих хугацаанд хадгалах болоод бүх гүйлгээг холбогдох хууль хяналтын байгууллагад тайлагнах зэргээр илрэн гардаг.

Монгол улсын мөнгө угаахтай тэмцэх арга хэмжээ нь олон улсын хамтын нийгэмлэгийн хөдөлгөөнтэй уялдуулан аажмаар ахиц дэвшил гаргаж байна. Гэхдээ манай улсад бусад улсын сайн жишгээс суралцах хэрэгцээ шаардлага бий. Их Британийн санхүүгийн систем нь санхүүгийн байгууллагуудын аюулгүй байдлыг хангах чиг үүрэгтэй ажилладаг. Санхүүгийн удирдлагын газар нь Их Британид мөнгө угаахтай тэмцэх дүрэм журмын хэрэгжилтэд хяналт тавьдаг бөгөөд мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой гэмт хэргийг бусад хууль сахиулах байгууллагууд, эрх мэдэлтнүүдтэй хамтран шалгах эрхтэй. Их Британийн бүх банк, санхүүгийн байгууллагууд санхүүгийн удирдлагын газарт бүртгүүлэх ёстой[27] байдаг. Түүнчлэн мөнгө угаах гэмт хэргийг мөрдөх үүргийг санхүүгийн удирдлагын газартай хамтран хийдэг. Энэхүү байгууллага нь Их Британид мөнгө угаахтай тэмцэх талаарх зааварчилгаа гаргадаг бөгөөд үүнд харилцагчдын нягт нямбай байдал, гүйлгээг хянахад тавигдах шаардлага, мөнгө угаахтай тэмцэх бодлогын мэдэгдэл гаргах зэрэг ордог байна. Үндэсний гэмт хэрэгтэй тэмцэх төв[28] нь Их Британи улсад хамгийн их эрсдэл учруулж болзошгүй гэмт хэрэгтнүүдийг онилж, мөрдөн мөшгөж олон нийтийг хамгаалж, ноцтой, зохион байгуулалттай гэмт хэргийг таслан зогсоохын тулд Их Британийн гэмт хэргийн тэмцлийг удирддаг. Үндэсний гэмт хэрэгтэй тэмцэх төв нь эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэх, түүнд үзүүлэх нөлөөнд өөрчлөлт оруулах алхмыг өөрчлөх зорилгоор эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэх үндэсний төвийг байгуулсан. Их Британийн санхүүгийн мэдээллийн алба нь сэжиг бүхий үйл ажиллагааны тайлангаас цуглуулсан санхүүгийн мэдээллийг хүлээн авах, дүн шинжилгээ хийх, түгээх үүргийг үндэсний хэмжээнд хариуцдаг. Сэжигтэй үйл ажиллагааны тайлан нь мөнгө угаах, терроризм, ноцтой, зохион байгуулалттай гэмт хэрэг, авлига, залилантай тэмцэх чухал тагнуулын нөөц юм. Их Британийн санхүүгийн мэдээллийн алба нь жилд 460,000 гаруй сэжигтэй үйл ажиллагааны тайлан авдаг. Их Британийн санхүүгийн мэдээллийн алба нь дэлхий даяар СМА-тай холбоотой мэдээлэл хүлээн авах, хуваалцах найдвартай сүлжээтэй бөгөөд олон улсын гол байгууллагуудтай мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй нягт хамтран ажилладаг нь манай улсын хувьд анхаарч ажиллах сайн туршлага гэж үзэж байна.

Мөнгө угаахтай тэмцэх хууль тогтоомж зөрчсөн хуулийн этгээдэд үр нөлөөтэй, ижил тэгш захиргааны болон эрүүгийн хариуцлага оногдуулдаг байх, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд бэлэн бус гүйлгээг заавал тайлагнах, тайлагнаагүй тохиолдолд хариуцлага тооцох талаар хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хэрэгтэй байна. Түүнчлэн Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үүрэгтэй ТЕГ, ЦЕГ, ГЕГ, Хилийн алба, Ерөнхий прокурорын газар, Монгол банк, СЗХ зэрэг байгууллагууд дээр нэмж Татварын ерөнхий газрын үйл ажиллагааг нягт уялдуулах хэрэгтэй. Тиймээс Мөнгө

---

[26]農林水産省, 経済産業省. 商品先物取引業におけるマネー・ローンダリング及びテロ資金供与対策に関するガイドライン. 2021 年 10 月 19 日.

[27] С.Удамзаяа. Финтекийг ашиглан мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх, хяналтын тогтолцоог сайжруулах нь. УБ., 2021 он. 56 дахь тал.

[28] National Crime Agency (NCA)

угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд мэдээлэх үүрэгтэй этгээд гэдэгт Татварын ерөнхий газрыг багтааж оруулах шаардлагатай. Мэдээлэх үүрэгтэй этгээд нь хуулиар хүлээсэн дээрх үүргийг хэрэгжүүлэхэд гар аргаар хяналт хийх боломжгүй ба харилцагчийн эрсдэлийг үнэлэх, гүйлгээний хяналт хийхэд тусгай автоматжуулсан программыг ашиглах шаардлагатай. Программыг үр дүнтэй ашиглахын тулд харилцагч таньж мэдэх ажиллагааг бүрэн хийж харилцагчийн эрсдэлийг үнэлэн /бага, дунд, өндөр г.м/ судалгаа хийж харилцагчийг албан тушаал, бизнесийн чиглэл, гүйлгээний онцлогоор нь төрөлжүүлэн тохирсон хяналтын дүрмүүдийг боловсруулах нөхцөлийг бүрдүүлэх хэрэгтэй.

## 2.2.9.ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ЗОХИЦУУЛАЛТ, ХЭРЭГЖИЛТ

Энэ хууль улс, орон нутгийн төсөв, улсын болон орон нутгийн өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн удирдлагыг хэрэгжүүлэх шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоог бүрдүүлэх зорилгоор батлагдсан.

Гэтэл төрийн болон орон нутгийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан, их хэмжээгээр хувьдаа завшсан, авлига, хээл хахууль өгсөн, авсан гэх гэмт хэрэг зөрчил байнга гарсаар байгаа нь тус хуулийн зорилго хангагдахгүй байгаагийн илэрхийлэл юм.

Шилэн дансны тухай хуулиар хүлээсэн үүргээ төрийн байгууллагууд хангалтгүй хэрэгжүүлж байгаа нь харагдаж байна. Яамдын цахим хуудсан дахь мэдээлэлтэй танилцахад Авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчилсан байдал хангалтгүй, Улсын Их Хурал, Засгийн газрын шийдвэр, нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төслийг цахим хуудсандаа байршуулаагүй, хүний нөөцийн сул орон тооны зар, худалдан авах ажиллагааны тайлан, аудитын дүгнэлт, тендерийн шалгарсан болон шалгараагүй шалтгааныг байршуулахгүй байх асуудлууд их практикт их гарч байна.

Тиймээс дараах асуудлуудад анхаарах зүй ёсны хэрэгцээ шаардлага үүсжээ. Тухайлбал:

| Хуулийн зүйл, заалт | Хэрэгжилт | Анхаарах зүйлс |
|---|---|---|
| 6.4.Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ:<br>6.4.4.таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг;<br>6.4.5.цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр; | Авлига, ашиг сонирхлын зөрчлийн асуудал нь эцсийн дүндээ мөнгөн дүнгийн илэрхийллээр бус нийтлэг үйлчилгээ үзүүлж буй төрийн зорилт чиг үүргийг хэрэгжүүлж буй этгээлийн албаны хариуцлага, ёс зүйн шаардлагын хэрэгжилттэй шууд хамааралтай. | Иймд шилэн дансны цахим сайтад 5 сая төгрөгөөс дээш орлого, зарлагын мөнгөн гүйлгээг долоо хоногийн дотор байршуулахаар заасныг нийт орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гэж өөрчлөх хэрэгтэй. |

| | | |
|---|---|---|
| 3.1.Доор дурдсан байгууллага, түүний эд хөрөнгө захиран зарцуулах эрх бүхий албан тушаалтан энэ хуулийн үйлчлэлд хамаарна:<br>3.1.1.төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд;<br>3.1.2.төрийн өмчит үйлдвэрийн газар;<br>3.1.3.хяналтын багц буюу түүнээс дээш хэмжээний хувьцааг нь төр, орон нутаг болон тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд эзэмшиж байгаа компани;<br>3.1.4.улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, ажил, үйлчилгээ гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгж, байгууллага;<br>3.1.5.төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч. | Хуулийн үйлчлэлд хамаарах этгээдүүдийн өсөв, санхүүгийн үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл, хэрэгжилт, тайлагнал эдгээртэй холбоотой мөнгөн болон бусад гүйлгээ, түүний гүйцэтгэл, хэрэгжилт, тайлагналтын механизм ил тод бус байгаа нь шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хянахад хүндрэл үүсгэж төрд их хэмжээний хохирол учруулах суурь нөхцөл болж байна. | Шилэн дансны тухай хуулийн дээрх заалтыг Төсвийн тухай хуульд нийцүүлэх шаардлагатай байна. Шилэн дансны нэгдсэн цахим хуудасны мэдээлэл байршуулах хандалтын системийг санхүү, төрийн сан, хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагааны болон хуулийн үйлчлэлд хамрагдаж буй байгууллагуудын санхүүгийн болон дотооддоо хөтөлж буй программ хангамжтай холбох замаар мэдээлэл байршуулах үйл ажиллагааг албан тушаалтнаас хамааралгүй байдлаар зохион байгуулах шаардлагатай байна. |
| Хуулийн 10 дугаар зүйлийн 10.1-д Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ. | Хуулийн 3 дугаар зүйлийн хуулийн 3.1.4, 3.1.5-д заасан хуулийн этгээд цахим хуудаст мэдээллээ тогтоосон хугацаанд бүрэн мэдээлээгүй тохиолдолд хариуцлага хүлээлгэх зохицуулалтыг Шилэн дансны тухай хууль болон холбогдох журамд нарийвчлан тусгаагүйгээс зөрчил давтагдсаар байна.<br><br>хөрөнгө оруулалт, Орон нутгийн хөгжлийн сангийн төсөл, арга хэмжээг гүйцэтгэгч аж ахуйн нэгж, байгууллагууд “Шилэн дансны нэгдсэн цахим хуудас”-т хамрагдалт дунджаар 10.0 хувьтай байгаа нь хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд иргэд, олон нийт хяналт тавих, холбогдох мэдээлэл авах боломж бүрдээгүй байгааг засах. Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.5-д заасан төрийн чиг үүрэгт хамаарах ажил, | Иймд хяналт, хариуцлагын механизмын ажиллах үйл явцыг журамласан хэм хэмжээ тогтоож, түүнийг зөрчигчдөд хариуцлага хүлээлгэх зохицуулалтыг тодорхой болгох шаардлагатай байна. |

| | | |
|---|---|---|
| | үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч хувийн хэвшлийн байгууллагуудад санхүүжилт олгохдоо шилэн дансны мэдээллээ бүрэн байршуулсан эсэхийг харгалзан үзэх, ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч хувийн хэвшлийн байгууллагууд уг хуулийн хэрэгжилтэд анхаарах нь зүйтэй байна. Хуулийн 3 дугаар зүйлд заасан байгууллагууд мөнгөн дүнгийн хэмжээнээс үл хамааран бүх гүйлгээг шилэн дансаар мэдээлдэг болгох[29] боломжтой. | |

## 2.2.10.УЛС ТӨРИЙН НАМЫН ТУХАЙ ХУУЛИЙН ЗОХИЦУУЛАЛТ, ХЭРЭГЖИЛТ

Улс төрийн намын үйл ажиллагааг авлига хээл хахуулиас ангид, ил тод, тогтвортой болгосноор өнөө цагт үүсээд буй засаглалын хямралыг даваж гарах нөхцөл бүрдэх ба Засгийн газрууд урт хугацаанд бодлогоо тодорхойлон хэрэгжүүлэх боломжтой болно. Ингэснээр улс төрийн бодлого, тэр дундаа гадаад бодлогын шийдвэр гаргалтын нэгдмэл байдал, залгамж чанар хадгалагдана. Энэ нь Монгол улсын гадаад нэр хүндэд эергээр нөлөөлөх төдийгүй манай улсад итгэх гадаад улс орнууд төдийгүй, гадаадын хөрөнгө оруулагчдын тоо нэмэгдэхэд чухал үзүүлэлт мөн.

Улс төрийн нам /цаашид "нам" гэх/ байгуулах, үйл ажиллагааг нь зогсоох, тараах, улсын бүртгэлд бүртгэх, намын зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтоож, үүнтэй холбогдон үүсэх харилцааг Улс төрийн намын тухай хуулиар зохицуулж байгаа бөгөөд улс төрийн нам, эвсэл, улс төрийн хүрээн дэх авлигыг бууруулах нь улс төрийн тогтвортой байдалд эергээр нөлөөлөөд зогсохгүй улс төрийн бодлогын шийдвэр үүнийг дагаад нэгдмэл болж, залгамж чанар нь хадгалагдах үндэс болно.

Манай улс дахь улс төрийн намын үйл ажиллагаа, хуулийн хэрэгжилтийн хүрээнд анхаарал татсан дараах асуудал байгааг хүснэгтлэн харуулав.

| Хуулийн зүйл, заалт | Хэрэгжилт | Анхаарах зүйлс |
|---|---|---|
| 16 дугаар зүйл. Намын хөрөнгө, орлого<br>16.1.Намын эд хөрөнгөд үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгө байна.<br>16.2.Намын хөрөнгөд дараахь зүйл хамаарна:<br>16.2.1.гишүүний татвар; | АТГ-ын уг судалгааны улс төрийн авлигын хэлбэр гэсэн шалгуур үзүүлэлтийг харвал улс төрийн зорилгоор хандив өгөх, авах байдал хамгийн их хувь буюу 0.30 пунктээр, аж ахуйн нэгжид давуу байдал | Монгол Улс эрх зүйн орчинд улс төрийн намын санхүүжилтийн эрх зүйн орчинг сайжруулах, НҮБ-ын Авлигын эсрэг конвенц, OECD-ээс өгсөн зөвлөмжийн дагуу Улс төрийн намын тухай хуулийг |

[29]Сангийн яам. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан. УБ.,2021 он.

| | | |
|---|---|---|
| 16.2.2.гишүүн, талархан дэмжигч иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандив;<br>16.2.3.төрөөс үзүүлэх санхүүгийн дэмжлэг;<br>16.2.4.намын бэлэгдэл бүхий бэлэг дурсгалын зүйлс, намын өмчлөлд байгаа эд юмс;<br>16.2.5.намын хэвлэл, мэдээлэл, сурталчилгааны орлого;<br>16.2.6.өөрийн өмчлөлийн эд хөрөнгийг худалдах буюу түрээслүүлж ашиглуулснаас олсон орлого;<br>16.2.7.намын мөнгөн хөрөнгийг банкинд хадгалуулсны хүү.<br>19 дүгээр зүйл.Төрөөс үзүүлэх санхүүгийн дэмжлэг<br>19.2.Улсын Их Хуралд суудал бүхий намд түүний авсан суудлын тоогоор Улсын Их Хурлын гишүүний нэг суудлыг жилд арван сая төгрөгөөр тооцож, Улсын Их Хурлын тухайн бүрэн эрхийн хугацаанд улирал тутам улсын төсвөөс санхүүжилт олгоно. Энэхүү санхүүжилтийн 50 хувийг Улсын Их Хурлын гишүүдийн сонгуулийн тойрогт явуулах үйл ажиллагаанд зарцуулна. | бий болгох байдал дараагийн өсөлттэй үзүүлэлт буюу 0.28 пунктээр, бизнесийн бүлэглэлийн захиалгаар хууль тогтоомж санаачлан батлуулах, дэмжих үйл ажиллагаа нь 0.21 пунктээр тус тус өссөн нь улс төрийн авлигын хэлбэр индекс өсөхөд нөлөөлөх гол хүчин зүйл болжээ.<br>“Улс төрийн авлигад нөлөөлсөн хүчин зүйлс”-ийн үнэлгээний үзүүлэлтийг гаргахдаа улс төрийн авлигын нөлөөллийг 11 дэд хүчин зүйлсээр үнэлсний 4 дэд хүчин зүйлсийн үнэлгээ буурсан эерэг үнэлгээтэй байгаа хэдий ч 7 дэд хүчин зүйлсийн үнэлгээ өссөн сөрөг дүн гарсан байна. Эдгээрээс сонгуулийн санхүүжилтийн механизм 0.27 пункт, улс төрийн хүрээн дэх бизнес бүлэглэлүүдийн ашиг сонирхлын зөрчил 0.25 пункт, намын санхүүжилтийн механизм 0.20 пунктээр тус тус өссөн сөрөг үнэлгээтэй[30] гарснаас үзэхэд мөн л улс төрийн намын хүрээний хүчин зүйлс авлигад нөлөөлөх гол хүчин зүйл болсон байна.<br>Дараагийн нэг үзүүлэлт нь “авлигын хүрээний түгээмэл байдал“ хэмээх үзүүлэлт бөгөөд уг үзүүлэлтээр судалгааг хийсэн шинжээчид Монгол Улсын авлигын цар хүрээг тодорхойлохыг зорьжээ. Нийт 11 дэд хүрээнээс улс төрийн нам 4.33 пункт, засгийн газар 4.05 пунктээр авлигын тархалтын үзүүлэлт хамгийн өндөр пункттэй гарчээ. Шинжээчдийн үнэлгээнээс үзвэл төрийн дээд шатны | шинэчлэх замаар намын гишүүний татвар, татааст хязгаар тогтоох, “хандив” гэх нэр томьёог өргөн хүрээтэй тодорхойлох, мөнгөн бус туслалцаа гэх ойлголтыг хамруулах, намын санхүүжилтийг бүрэн ил тод болгож хандив өгсөн бүх этгээд, тэдгээрийн хандив, түүнчлэн намын жилийн эцсийн санхүүгийн дэлгэрэнгүй тайланг тогтсон стандартад оруулж, иргэд олон нийтэд ил тод нээлттэйгээр интернэтэд нийтэлдэг болгох, намын санхүүжилтэд хяналт тавих эрх мэдлийг авлигатай тэмцэх байгууллагад өгөх асуудлыг авч үзэх шаардлага бий болсон |

[30] Мөн тэнд.

| | | |
|---|---|---|
| | байгууллага болон улс төрийн намын хүрээнд авлига илүү түгээмэл байсан гэж дүгнэж болохоор байна. Эдгээр судалгааны хариунаас улбаалан уг судалгааг хийсэн шинжээчид “улс төрийн намуудын авлигад автсан байдал“-ын судалгааг хийхэд дараах үр дүн гарчээ. Үүнд: 2016 онд улс төрийн намуудын авлигад автсан байдлыг тус бүрд нь тооцож үзвэл АН 35.4 хувь, МАН 31.1 хувь, МАХН 18.3 хувь, ИЗНН 6.1 хувьтай эхний дөрвөн байрт жагсаж байна. Судалгааны мэдээллээс дүгнэвэл хамгийн их авлигад автсан намаар АН болон МАН-ыг тус тус нэрлэсэн байна.[31] | |
| 18 дугаар зүйл.Гишүүний татвар, намд өгөх хандив<br>18.3.Намд зориулж нэг удаа өгөх хандивын дээд хэмжээ хуулийн этгээдээс арван сая, иргэдээс нэг сая төгрөгөөс хэтэрч болохгүй бөгөөд нэг хандивлагч намын нэг байгууллагад жилд 2-оос дээш удаа хандив өгөхийг хориглоно. Намд хандив өгсний төлөө албан тушаал, хувийн эрх ашиг хөөцөлдөх, шахалт үзүүлэхийг хориглоно.<br>18.4.Нам хандивынхаа талаар нийтэд мэдээлж байна. | Улс төр, мөнгөний хэт хамаарлыг багасгах, тэдгээрийг тусгаарлах улс төрийн намын санхүүжилтийн эрх зүйн зохицуулалтыг дэлхийн улс орнуудад чухалчилсаар ирсэн.<br><br>Улс төрийн намууд үр ашиггүй ажиллаж, авлигад өртөж эхлэх нь иргэн, нам хоёрын дунд үл ойлголцол бий болгож, улмаар сонгуулийн үр дүнд шууд нөлөөлөх байдал үүсдэг. Монголд улс төрийн намтай холбоотойгоор үүсэж буй авлига, хээл хахуулийн хэргүүд гааль, шүүх, эмнэлэг, боловсролын байгууллага зэрэг бусад салбарт гардаг авлигын асуудлуудаас илүү хүнд нөхцөл байдлыг үүсгэсэн. | Тиймээс төрийн алба болон төсвийн зарцуулалтыг ашиг сонирхлын зөрчлөөс ангид байлгах, улс төрийн санхүүжилтийг хянаж, санхүүжүүлэгчээс улс төрд нөлөөлөх нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, төрийн албанаас чөлөөлөгдсөний дараа үүсэж болох ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах, сонгуулийг шударга явуулах, зөрчил гаргасан этгээдэд хариуцлага тооцох механизмыг бүрдүүлэх, иргэд, хүний эрхийн төлөө тэмцэгчид, шүгэл үлээгчид ба сэтгүүлчдийг чадавхжуулж эрхийг нь хамгаалах зэрэг асуудлыг анхаарч ажиллахын зэрэгцээ эрх зүйн хүрээнд баталгаажуулах шаардлагатай байна.<br><br>Авлига, хээл хахуультай нэр холбогдсон улс төрчдийн улс төрийн карьерийг |

[31] Мөн тэнд

| | | |
|---|---|---|
| | | зогсоох, тэдэнтэй хатуу хариуцлага тооцох эрх зүйн тогтолцоог бүрдүүлэх |
| 7 дугаар зүйл.Намын гишүүний болон төрийн албан хаагчийн үүргийг зааглах<br><br>7.1.Намын зүгээс төрийн байгууллага, тэдгээрийн албан тушаалтны үйл ажиллагаанд хутгалдан оролцохыг хориглоно.<br><br>7.2.Төрийн жинхэнэ албан хаагч албан үүргээ гүйцэтгэхдээ хуулийг чанд баримтлах бөгөөд албан тушаалынхаа эрх мэдлийг аль нэгэн намын эрх ашигт нийцүүлэн ашиглахыг хориглоно.<br><br>7.3.Улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагч өөрийн албан тушаалын хүрээнд хамаарах албан үүрэг гүйцэтгэхдээ аль нэг намын эрх ашгийг хамгаалсан шийдвэр гаргах, сурталчилгаа хийх, нэр дэвшигчийн сонгуулийн сурталчилгаанд оролцохыг хориглоно. | Өнөөдөр хүчин төгөлдөр үйлчилж буй 70 орчим хуульд төрийн албан хаагчийг төрийн албанаас чөлөөлөх, огцруулах үндэслэлийг заасан нь төрийн албаны үндсэн зарчим зөрчигдөхөөс сэргийлж, төрийн албанд хариуцлагыг бэхжүүлэх чухал нөхцөл болсон.<br><br>Гэсэн хэдий ч төрийн эрх мэдэл хуваарилах зарчим, сонгогдсон албан тушаалтан болон төрийн өндөр албан тушаалтны эрхзүйн байдлын онцлог зэргээс хамаарч Төрийн албаны тухай хуульд заасан сахилгын хариуцлагын тогтолцоо төрийн албаны бүх хүрээнд үйлчилдэггүй, албан тушаалтныг огцруулах, чөлөөлөх зохицуулалт нь бодит байдал дээр хэрэгждэггүй явдал их байна.<br><br>Улс төрийн намын болон улс төрийн албан тушаалтнуудад хариуцлага хүлээлгэх эрх зүйн орчин бүрдээгүй нь улс төрийн албан тушаалтнууд, улс төрийн намын удирдлагуудаас төрийн үйл ажиллагааны зарчим, хэм хэмжээг гажуудуулах зөрчил ихээр гарч байна. | Иймд сонгогдсон болон томилогдсон төрийн өндөр албан тушаалтанд хариуцлага тооцох үндэслэл, журмыг тодорхой болгож, Улс төрийн албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх тухай хуулийг батлах шаардлагатай байна. |

Улс төрийн намын санхүүжилтийн механизмын нэг чухал зарчим нь ил тод байдал. Төрөөс улс төрийн намд олгосон санхүүжилтийн мэдээллийг олон нийтэд нээлттэй байлгадаг. Бундестаг намуудад олгосон санхүүжилтийн дэлгэрэнгүй тайлангаа жил бүр ил тод мэдээлэх ёстой. Нөгөө талаар улс төрийн намууд ч санхүүжилтийн тайлангаа олон нийтэд ил тод болгох үүрэг хүлээнэ. Түүнчлэн улс төрийн нам санхүүжилтийн тайлангаа ил гаргаагүй, эсвэл бодит байдлыг нуун дарагдуулж мэдээлсэн тохиолдолд тухайн жилийнхээ санхүүжилтийг алддаг. Хандивын тайлан алдаатай, бүртгэлийг дүрэм журмын дагуу хийгээгүй бол мөн л тухайн хандивт ногдох нэмэлт санхүүжилтийг авах боломжгүй болно. Түүгээр зогсохгүй зөрчил бүхий хандивын дүнг 3 дахин үржүүлсэнтэй тэнцэх хэмжээний торгуулиар тухайн намыг торгодог байна.

Япон улсын хувьд энэ талаар баримталж буй гол бодлого нь Улс төрийн намуудын санхүүжилтийн эх үүсвэрийг нээлттэй болгох. Энэ бол олигархийг хязгаарлах гол арга замын нэгд тооцогдоно. Тухайлбал: 1948 онд батлагдаж, 1994 онд шинэчилсэн “Улс төрийн санхүүжилтийг хянах тухай хууль”[32] 1995 онд батлагдсан “Намын татаасын тухай хууль эсхүл Намыг төрөөс санхүүжүүлэх тухай хууль”, Сонгуулийн байгууллагын тухай хууль зэргээр улс төрийн нам, сонгуулийн санхүүжилт, төрөөс өгөх санхүүжилтийг зохицуулсан байна Улс төрийн намд төрөөс санхүүжилт олгохдоо хүн амын сүүлчийн тооллогын дүнг үндэслэн иргэн бүрт 250 иенээр тооцож төсөвт суулгаад түүнээс дээр дурдсан нөхцөл журмын дагуу намуудыг санхүүжүүлдэг. “Улс төрийн санхүүжилтийг хянах тухай”, ““Намын татаасын тухай”” тухай хуулиудаас гадна “Төрийн байгууллагуудын сонгуулийн тухай” хууль нь улс төрийн нам, сонгуульд нэр дэвшигчдийн сонгуулийн компанийн санхүүжилтийн орлого, зарлагыг хянах, тэдгээрийн хязгаарлалтыг тогтоох эрх зүйн үндэс нь болдог байна.

Японы сонгуулийн тогтолцооны 1994 оны шинэчлэл нь сонгуулийн үеэрх мөнгөний урсгалыг цэвэршүүлсэн төдийгүй орон нутгийн намын байгууллагын нэр хүндийг нэр хүнд бүхий улс төрчдөөр дамжуулан өсгөж чадсан зэрэг олон талын эерэг зүйлийг авчирсан гэж судлаачид дүгнэсэн байна. Японы сонгуулийн тогтолцооны шинэчлэлийн хүрээнд улс төрийн санхүүжилтийн хувьд дор дурдсан хоёр шинэчлэлийн асуудлыг шийдэж чадсан гэж үздэг. Үүнд: Улс төрийн санхүүжилтийн менежментийн хүрээнд улс төрийн хандивыг улс төрийн нам, эвсэл, дэмжигчдийн холбоодоор дамжуулан авах болсноос гадна тэдгээрийг бэлнээр бус банкин дахь дансаар шилжүүлж авах болсон нь хяналт тавих боломжийг нээж өгсөн. Улс төрийн санхүүжилтийг тайлагнах тогтолцоог нарийвчилж, хариуцлагатай болгож чадсан[33] зэрэг нь улс төрийн авлигын асуудлыг шийдэж чадсан гэж үздэг.

Канад улсын улс төрийн намын хандивын эрх зүйн зохицуулалтын хувьд 2003 онд шинэчилсэн Канадын сонгуулийн тухай хууль, 2006 онд батлагдсан Холбооны бүртгэлийн тухай хууль зэрэг эрх зүйн актуудаар сонгуулийн хандивын харилцаатай холбоотой нэлээд гол түлхүүр асуудлуудыг зохицуулсан байна. Үүнд: Зөвхөн албан ёсоор байнга оршин сууж буй Канадын иргэд нь бүртгэгдсэн нам эвсэл, нэр дэвшигчид, дүүргийн сонгуулийн хороодод хандив өгнө. Сонгуульд нэр дэвшиж буй нэр дэвшигч болон намуудад 1000$ жилд хандивлах эрхтэй байхаар заажээ. Мөн хувь хандивлагчид нь 1000$ хэтрүүлэхгүйгээр бүртгэгдсэн нам эвсэл, нэр дэвшигчдэд хэдэн ч удаа хамаагүй хандив өгч болохоор зохицуулалт хийсэн байна. Корпорац, худалдааны холбоо, бусад хуулийн этгээдүүд нь бүртгэгдсэн нам эвсэл нэр дэвшигчид, дүүргийн сонгуулийн хороодод ямар нэг хандив өгөх эрхгүй[34] байхаар тус тус зохицуулсан нь улс төрийн авлигын асуудлыг цэгцлэн шийдэж чадсан байна.

## 2.2.11.ЭМНЭЛГИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ЗОХИЦУУЛАЛТ, ХЭРЭГЖИЛТ

Монгол Улсад авлига хамгийн их тархсан институцийн талаарх судалгаагаар эрүүл мэндийн байгууллага, шүүх, газрын алба, гаалийн байгууллага, цагдаагийн байгууллага эхний 5-д эрэмбэлэгджээ. Иргэдийн төлөөлөл эрүүл мэндийн байгууллагыг хамгийн их авлига тархсан институц гэж үзсэн бол албан хаагч, бодлогод оролцогчид шүүхийн байгууллагыг нэгдүгээрт эрэмбэлсэн байна[35].

---

[32] Political Funds Control Law of Japan.

[33] Монгол Улсын Их хурлын тамгын газар. Судалгааны төв. Судалгааны эмхтгэл, XIV боть. УБ:,2013 он. 410 дахь тал.

[34] Мөн тэнд. 412 дахь тал.

[35] Авлигатай тэмцэх газрын Судалгаа шинжилгээний алба. Шударга байдлын үнэлгээ. УБ.,2021 он.

Эрүүл мэндийн сайдын 2013 оны арван нэгдүгээр сарын 25-ны 446 дугаар тушаалаар баталсан “Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээ” гэж эмч, эрүүл мэндийн байгууллагын ажилтнуудын баримталж байх ёстой эрх зүйн баримт бичиг бий. Энэхүү баримт бичгийн 3.18-д “Үйлчлүүлэгчид тусламж үйлчилгээ үзүүлэх боломжтой байхад хувийн ашиг сонирхлын үүднээс өөр эмнэлгийн мэргэжилтэн, эмнэлгийн байгууллагаар үйлчлүүлэхийг албадах, үйлчилгээний тодорхой хувилбарыг үйлчлүүлэгчид тулгах нь ёс зүйд үл нийцнэ” гэж заасан. Мөн тус хэм хэмжээний 3.23-т нь “Эмнэлгийн мэргэжилтэн нь үйлчлүүлэгчийг эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авах, эрүүл мэндийн байгууллага, эмчээ сонгох эрхээ эдэлж, сонголт хийхэд нь хувийн ашиг сонирхлын үүднээс хандаж нөлөө үзүүлэхгүй байх” гэж бичсэн.

Амьдрал дээр эмч нар хувь, хувьсгалын гэлтгүй дээрх ёс зүйн хэм хэмжээний заалтыг зөрчин “Тэр эмийн сангаас очиж, тийм нэртэй эм авах хэрэгтэй” гэдэг нь эргээд авлига, ашиг сонирхолын асуудал нь нийгэмд тодорхой бухимдал үүсгээд байна. Түүнчлэн Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээний 3.25 дахь заалтад “Эмнэлгийн мэргэжилтэн нь эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлснийхээ төлөө үйлчлүүлэгчээс авлига, хууль бус шан харамж, хандив, бэлэг, албан бус төлбөр авахгүй ба үйлчлүүлэгчтэй давхар харилцаанд орохгүй байх”, 6.2-т “Эмнэлгийн мэргэжилтэн нь эрүүл мэндийн байгууллагын өмчийн хэлбэрээс үл хамааран өөрийн хувийн ашиг сонирхлоос нийгэм, олон нийтийн эрх ашгийг дээгүүрт тавина” хэмээн заажээ.  Өнөөдөр дэлхий дээр эрүүл мэндийн салбарын хээл хахуулийн хамгийн бага хэмжээ нь Словени, Эстони, Польш, Гүрж, Чехэд байдаг бол хамгийн өндөр авлигатай улсуудад Азербайжан, Молдав, Тажикстан [36] зэрэг улс багтаж байна.

Эмнэлгийн салбарт авлига, ашиг сонирхлын зөрчил үүсэхэд санхүүжилт, үйлчилгээг салгах нь эргээд асуудал дагуулдаг. Энэ тохиолдолд төлбөр болон нөхөн төлбөрийн урсгалыг өөрчлөх замаар мөнгө завших нь ихэсдэг байна. Энэ нь санхүүжүүлэгч үйлчилгээний төлбөрийг хийх ямар хэлбэр сонгосонтой салшгүй холбоотой байдаг. Тухайлбал эмч мэргэжилтнүүд үзүүлсэн үйлчилгээ тус бүртээ улсаас нөхөн төлбөр авдаг бол ажлаа таслах сонирхолгүй байх нь мэдээж бөгөөд үйлчилгээгээ хэтрүүлэн үнэлэх, үзүүлээгүй үйлчилгээндээ төлбөр нэхэмжлэх, эсвэл эмчилгээнд тусгаагүй үзлэг, шинжилгээ өгөхийг шаардах зэрэг зөрчил гаргах эрс буурах болно. Нөгөө талдаа эмч мэргэжилтнүүдийн үзүүлэх үйлчилгээнд төсвөөс багц мөнгө тооцож олгох нь тэднийг эмчилгээнээс илүү урьдчилан сэргийлэх арга хэмжээнд анхаарал хандуулах боломжийг олгож болох ч шударга бус нэг нь шаардлагатай үйлчилгээг үзүүлэхгүй, хүлээн зөвшөөрөгдсөн стандартаас доогуур чанаргүй үйлчилгээ үзүүлэхэд хүргэх аюул давхар дагуулдаг.

Өнөөдөр эмнэлгийн салбарт үүсэж буй авлига, ашиг сонирхлын хэргүүд нь улсаас төсөвлөсөн хөрөнгийг бусдын мэдэлд шилжүүлэх, хуурамч туслан гүйцэтгэх гэрээ байгуулах замаар найз нөхөд, ойр дотынхондоо мөнгө шилжүүлэх, хууль бусаар бүртгэх, бүртгэлээс хасах өөрөөр хэлбэл хүндээр өвдсөн өвчтөнийг эмнэлгээс гаргах, өвчтөнд эмчилгээ хийхээс татгалзах зэрэг болно. Мөн харьцангүй эрүүл үйлчлүүлэгчдийг хахууль өгөх, авах замаар эмчилгээнд хамруулах нухацтай шинжилгээ хийлгүйгээр яаран эмчилгээ хийхээс татгалзуулах, өвчтнүүдэд тэдний эрхийн талаар мэдээлэхгүй байх,  үйлчлүүлэгчийг шаардлагатай эмч, мэргэжилтнүүдээр хангахгүй хайнга хандах, өвчтнүүдэд эмчилгээ хийлгэхийн тулд хэт олон шат дамжлага дамжих зэрэг дарамт зориуд үүсгэх зэрэг үйлдлүүд багтана.

[36] Ural Federal university. Corruption in healthcare worsens the health of patients and the quality of nutrition. 1-Jun-2021.

Албан тушаалтнууд мөнгө, хөрөнгийг зүй бусаар ашиглах эсвэл хувийн санхүүгийн ашиг хонжоо олохын тулд зориулалтыг өөрчлөх гэх мэтчилэн өөрсдөө авлига үйлдэж байж болох талтай. Цаашлаад, эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлдэг хувийн ах ахуй эрхлэгчид улсаас нөхөн төлбөр авахыг зөвшөөрдөг эрүүл мэндийн тогтолцоотой улсад тус үйл ажиллагааг удирдах өргөн хүрээтэй зохицуулалт бий болгох шаардлагатай байдаг. Тиймээс засгийн газраас хувийн наад захын чанарын стандартуудыг мөрдүүлэх журмуудыг тогтмол гаргадаг байна[37]. Ийм журмууд бий болсноор лицензийн эрх авах, хяналт шалгалтын ажиллагааны явцад авлига үүсэх боломжийг бий болгож байдаг.

## 2.2.12.НИЙТИЙН МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ЗОХИЦУУЛАЛТ, ХЭРЭГЖИЛТ

Тус хуулиар хуульд заасан үндэслэл, журмын дагуу иргэний мэдээлэл хайх, хүлээн авах эрхийг хангах, нийтийн мэдээллийн дэд бүтцийн эрх зүйн үндсийг тогтоох, төрийн үйл ажиллагааг цахим хэлбэрээр явуулах, нээлттэй, ил тод, шуурхай байлгах, төрийн үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгохтой холбоотой харилцааг зохицуулж байна.

Хэдийгээр энэ хууль шинэ тутам батлагдан хэрэгжиж байгаа боловч урьд нь Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулиар зохицуулагдаж ирсэн.

Хуулийн 8 дугаар зүйлд заасан нээлттэй мэдээллийг ил тод байлгах үүргийн хэрэгжилт хангалтгүй байна.

- Авлига, албан тушаалын гэмт хэрэг, зөрчлийн талаар мэдээлэл авах үйл ажиллагааны арга хэлбэрийг сайжруулах, иргэд, байгууллагаас өргөдөл, гомдол, мэдээлэл утсаар өгөх боломжийг бүрдүүлэх хэрэгцээ шаардлага үүсжээ.
- санхүүгийн хариуцлагыг дээшлүүлж, авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор санхүүгийн аливаа гүйлгээг хүлээн авагчийн жинхэнэ нэрээр нь гүйцэтгэх эрх зүйн орчинг бий болгох шаардлагатай байна.
- Авлига, албан тушаалын гэмт хэргийн шийдвэрлэлт, шалтгаан, нөхцөлд дүн шинжилгээ хийх, үр дүнг урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг сайжруулах болон хууль тогтоомжийг боловсронгуй болгоход ашиглах,
- прокурор, шүүгчийг мэргэшүүлэх сургалтын хөтөлбөрийг шинэчлэн, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөнд авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хянан шийдвэрлэх асуудлыг оруулах,
- шинээр томилогдсон шүүгч, прокурорт сургалтын хөтөлбөрийн дагуу авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, авлигын гэмт хэргийг хянан шийдвэрлэх сэдвээр сургалтыг зохион байгуулах зэрэг асуудлыг шийдвэрлэх хэрэгцээ шаардлага болоод шалтгаан нөхцөл бий.

Мөн хууль сахиулах байгууллагын ажилтан, албан хаагчдад эрэн сурвалжлах сэтгүүл зүй, сэтгүүлчдийн аюулгүй байдлыг хангах талаар сургалт хийх, тэдний мэдлэг ойлголтыг дээшлүүлэх, сэтгүүлчийн аюулгүй байдлын талаар судалгаа, хяналт мониторинг хийх, авлига, албан тушаалын гэмт хэргийг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийг олон нийтэд хүргэх арга хэлбэрийг сайжруулах болоод авлига, албан тушаалын гэмт хэргийг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийг хуульд заасан үндэслэл, журмын дагуу олон нийтэд мэдээлэх ажиллагаанд дүн шинжилгээ хийх, авлигын гэмт хэрэг, зөрчлийг олж илрүүлсэн, мөрдөн шалгасан, хянан

---

[37] Трансперенси Интернейшнл. Авилга, хээх хахууль ба эрүүл мэндийн халамж, үйлчилгээний зардал. УБ.,2006 он.

шийдвэрлэсэн байдалд дүн шинжилгээ хийж, мэдээллийн санг үүсгэн, сургалтад ашиглах зэрэг олон асуудлыг шийдэх хэрэгцээ шаардлага байна.

Одоо байгаа хууль тогтоомжуудын хүрээнд хууль бус нөлөөлөл үзүүлсэн этгээдэд хариуцлага хүлээлгэх тогтолцоог боловсронгуй болгож чадсан эсэхийг тогтоох, хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актын төсөлд авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр санал, зөвлөмж гаргах тогтолцоог бүрэн бүрдүүлэх боломж байгаа үгүйг нягтлан дүгнэх, хувийн хэвшлийн байгууллагуудын авлигын эсрэг сүлжээний үйл ажиллагааг дэмжих, авлигын эсрэг түншлэлийн харилцааг эрх зүйн хүрээнд зохицуулж өгөх нь авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, ёс зүй, ил тод байдлыг сайжруулах, хүнд суртал, чирэгдлийг арилгах чиглэлээр дотоод, гадаадын сайн туршлага, оновчтой шийдлийг сурталчлах, түгээх боломжийг бүрдүүлж өгөх юм.

Мэдээлэлгүй иргэдийн шүүмжлэл, эсэргүүцэл нь төрийн үйл ажиллагаанд гацаа тээг болдог бол, мэдээлэлтэй иргэн нь хөгжлийн хүч болдог төдийгүй төрийн албанд бодит хяналтыг бий болгож чаддаг. Тиймээс энэхүү зохицуулалтыг дахин анхаарч харах шаардлагатай гэж үзэж байна.

## 2.2.13.ТӨРИЙН ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН ТУХАЙ ХУУЛИЙН ЗОХИЦУУЛАЛТ, ХЭРЭГЖИЛТ

Энэ хууль нь төрийн хяналт шалгалтын тогтолцоо, төрийн захиргааны хяналт шалгалтын эрх зүйн үндсийг тодорхойлж, төрийн хяналт шалгалтыг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахаар 2003 оноос  хүчин төгөлдөр болж үйлчилж байна.

Хуулийн хэрэгжилтийн талаарх тайлан мэдээ, бусад судалгаанд үндэслэн авлигын болон ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргилэх, түүнтэй тэмэх зорилтын хүрээнд гүйцэтгэх буй үүргийг үнэлж үзвэл:

| Хуулийн зүйл, заалт | Хэрэгжилт | Анхаарах зүйлс |
|---|---|---|
| **ТӨРИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬ**<br>**3 дугаар зүйл.Төрийн хяналт шалгалтын тогтолцоо, хүрээ**<br>3.1.Төрийн хяналт шалгалт нь Улсын Их Хурал, Ерөнхийлөгч,Төрийн аудитын байгууллага болон төрийн захиргааны байгууллагын хяналт шалгалт /цаашид "мэргэжлийн хяналт" гэх/, Үндсэн хуулийн Цэц, шүүх, прокурорын хяналт, нутгийн өөрөө удирдах байгууллагаас энэ хуулийн дагуу хэрэгжүүлэх хяналт шалгалтаас бүрдэнэ.<br>3.2.Улсын Их Хурал, Ерөнхийлөгчийн хяналт | Ашигт малтмалын тухай хуулийн хэрэгжилтийн үнэлгээнээс харахад Давхардсан, ач холбогдол багатай олон тооны хяналт шалгалт нь компанийн үйл ажиллагааны тогтвортой байдалд нөлөөлж, хяналт, шалгалт хийж буй ажилтнуудын далд хэлбэрийн ашиг сонирхлыг нэмэгдүүлэх эрсдэл бий болгож байна. Ялангуяа мэргэжлийн хяналтын байгууллага, Засаг дарга нараас хийх төлөвлөгөөт бус хяналт шалгалттай холбоотой авлигын эрсдэл байна. Хуулиар зарим хязгаарлалт хийдэг ч ийм төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийхдээ компаниудад урьдчилан | Энэхүү зохицуулалт нь практикт үр дүнгээ өгч байгаа учир улам бүр боловсронгуй болгож, илүү үр дүнтэй, бодитой хэрэгжих гарцыг нээж, энэхүү харилцааг тусгайлан зохицуулдаг тусгай эрх зүйн актыг батлан гаргах хэрэгцээ шаадлага бий болжээ. |

| | | |
|---|---|---|
| шалгалт, Үндсэн хуулийн цэц, шүүх, прокурорын хяналт болон Төрийн аудитын үйл ажиллагаатай холбогдсон харилцааг тус тусын хууль тогтоомжоор зохицуулна.<br><br>3.3.Засгийн газар, яам, агентлаг, аймаг, сум, баг, нийслэл, дүүрэг, хорооны Засаг даргын хяналт шалгалт, хууль тогтоомжоор тусгайлан эрх олгогдсон мэргэжлийн хяналт, түүнчлэн нутгийн өөрөө удирдах байгууллагаас энэ хуулийн дагуу хэрэгжүүлэх хяналт шалгалттай холбогдсон харилцааг энэ хуулиар зохицуулна. | мэдээлэл өгдөггүй, хяналтын удирдамж, арга зүй тодорхойгүй байдаг учраас авлигын эрсдэл үүсэх шалтгаан болдог. Компаниудын зүгээс зөвшөөрөл, хяналт шалгалттай холбоотой хууль эрх зүйн мэдлэг дутмаг байгаа нь хууль бус үйл ажиллагаа явуулах эсвэл хууль бус шалгалт, шахалтанд өртөх, улмаар авлигын эрсдэл бий болгодог.<br><br>Уул уурхайн салбарт ил тод байдлыг хангах, авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, түүнийг гаргахгүй байх нэг чухал зохицуулалт нь АМТХ-ийн 48 дугаар зүйлд заасан ил тод байдлын тайлан юм. | |

### 2.2.14.БОЛОВСРОЛЫН ТУХАЙ БАГЦ ХУУЛИЙН ЗОХИЦУУЛАЛТ, ХЭРЭГЖИЛТ

Аливаа улс орны хувьд боловсролын салбар нь авлига хээл хахуульд идэгдсэн тохиолдолд хөгжил цэцэглэлт яригдах боломжгүй болдог. Энэ салбар дахь авлига нь чанар муутай боловсрол, гүйцэтгэл муу ажлын үзүүлэлтүүдийг бий болгож улмаар ядуурал, ажилгүйдэл, тэгш бус байдлын түвшин нэмэгдэхэд хүргэдэг. Боловсролын салбар дахь авлигыг хэмжихэд хэцүү ч олон улсад тодорхойлолт өгөх гэж чармайж байна. Чухамдаа Ойрхи Дорнод, Сахарын цөлийн Африк, Хойд Африк, Өмнөд Ази зэрэг хөгжиж буй олон бүс нутгийн нийт хүн амын ойролцоогоор тавны нэгийг залуучууд бүрдүүлж байгаа тул боловсролд хөрөнгө оруулж, энэ салбарын бүрэн бүтэн байдал, ил тод байдлыг бэхжүүлэх нь авлигаас урьдчилан сэргийлэх, тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд эерэг нөлөө үзүүлнэ[38] гэж судлаачид дүгнэж байна.

Монгол улс Боловсролын тухай хуулийг шинэчилэн баталснаас хойш өнөөдрийг хүртэлх хугацаанд 20 гаран удаа нэмэлт, өөрчлөлт оруулаад байна. Гэсэн хэдий ч боловсролын хөгжлийн глобал чиг хандлага, дэлхий дахинаа сургалтын арга, агуулга, суралцах орчны өөрчлөлт, мэдээлэл харилцааны технологийн тусламжтай сурах боломж эрс нэмэгдсэн зэрэг шинэ нөхцөлд иргэдийн хэрэгцээ, сонирхолд нийцсэн чанартай боловсрол эзэмшүүлэх нийгмийн хэрэгцээ, шаардлагыг харгалзан хууль, эрх зүйн болон бодлогын орчноо тасралтгүй сайжруулах, боловсронгуй болгох хэрэгцээ шаардлагыг хангах тал дээр анхаарахгүй бол боловсролын салбар дахь авлигын үзүүлэлт буурахгүй байх нөхцөл бүрдсэн байна.[39]

---

[38]Corruption in Education. https://grace.unodc.org/grace/uploads/documents/academics/Anti Corruption_Module_9_Corruption_in_Education.pdf.
[39] https://network.mn/post/15194.

| Хуулийн зүйл, заалт | Хэрэгжилт | Анхаарах зүйлс |
|---|---|---|
| 39.3.Боловсролын сургалтын байгууллага санхүүгийн эх үүсвэрээ нэмэгдүүлэх, багш, ажилтан, суралцагчийн нийгмийн баталгааг дээшлүүлэх зорилгоор хууль тогтоомжид нийцүүлэн аж ахуйн үйл ажиллагаа явуулж болох бөгөөд түүнээс олсон орлогоо энэ хуульд заасан зориулалтын дагуу захиран зарцуулах эрхийг боловсролын сургалтын байгууллагын захирал, эрхлэгч эдэлнэ.<br>39.12.Төрийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг өөрийн үйл ажиллагаанаас орлого олох, түүнийг зарцуулах, тайлагнах журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран батална. | Боловсролын салбар нь улсын төсвөөс санхүүждэг, төрөөс үзүүлэх дэмжлэг жил бүр байнга өсдөг нь улс төрийн хүрээнийхний анхаарлын төвд байж, тэдний нөлөөнд шууд автах нь хялбар байдаг.[40] Авлигын эсрэг бодлогын түвшинд боловсролын төсөвт эх үүсвэрийн хуваарилалтыг хүндрүүлж, энэ салбарыг эх үүсвэрийг хяналтгүй болгох нь эргээд хариуцлага ярихад төвөгтэй болгож байна.[41]<br>Сургуулийн удирдлагуудын зүгээс хөрөнгийг шамшигдуулах, өөр тийш нь шилжүүлэх байдлаар хувьдаа завших зэргээр сургуулиудыг жигд үйл ажиллагаа явуулах нөөцгүй болгох байдлаар түгээмэл илэрч байгаа талаар судалгаа цөөнгүй байна. | - төсөв, санхүүжилтийг нэмэгдүүлэх<br>- нээлттэй ил тод байдлыг хангах,<br>- боловсролын салбарыг улс төрийн нөлөөнөөс ангид байлгах, бүх талуудын ёс суртахууныг дээшлүүлэх зэрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах механизмыг сайжруулах, хяналтыг нэмэгдүүлэх нь зүйтэй. |
| 5.1.3.боловсрол эзэмшүүлэх арга, хэлбэр, суралцагчийн хэрэгцээ, хувийн болон хөгжлийн онцлогт нийцсэн олон хувилбартай, чөлөөтэй, нээлттэй байна;<br>5.1.4.иргэнийг сурч боловсроход үндэс угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, хөгжлийн онцлог, эрүүл мэнд, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодлоор нь ялгаварлан гадуурхахгүй байх, эх хэлээрээ сурч боловсрох тэгш боломж, нөхцөлөөр хангана | Хүний нөөцийн сонгон шалгаруулалт, албан тушаал дэвших, томилгоо, шагнал урамшуулал олгох үйл ажиллагаанд авлига, ашиг сонирхлын зөрчил “их” мэдлэг, чадваргүй багш нарыг ажилд авах асуудал байгаа талаар олон нийт шүүмжилдэг, энэ талаарх судалгаа харуулсан байна. | Иргэдийн шаардар эрхийн хэрэгжилтийг нэмэгдүүлэх замаар авлига, ашиг сонирхлын зөрчөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны үр нөлөөг нэмэгдүүлэх нь зүйтэй. |
| 44.2.Багш дараахь үүрэгтэй: | Багш нарын хувьд бэлэг өгөхийг оюутан, сурагч | сургалтын хөтөлбөрт үнэт зүйл, шударга ёс, |

[40] Транспэрэнси Интернэшнл. Боловсролын салбар дахь авлига. УБ.,2014 он.
[41] P.Mauro: The Effects of Corruption on Growth, Investment, and Government Expenditure: A crosscountry Analysis in Corruption and the Global Economy, 83-107 (1997), edited by Kimberly Ann Elliot, Washington: The Institute for International Economics.

| | | |
|---|---|---|
| 44.2.1.багшийн ёс зүй, нэр төрийг эрхэмлэн сахих;<br>44.2.2.боловсролын стандартыг хэрэгжүүлэх;<br>44.2.3.онолын мэдлэг, заах арга, ур чадвараа дээшлүүлэх;<br>44.2.4.суралцагчдыг ялгаварлан гадуурхахгүй байх, нэр төрийг нь хүндэтгэн хамгаалах; | нараас шаардах, үнэ төлбөргүй байх ёстой боловсролын үйлчилгээний хариуд хахууль авах, бусад эд материалын дэмжлэг үзүүлэхийг далд болон ил утгаар илэрхийлдэг<br>Боловсролын салбарын дотоод үйл ажиллагаа, томилгоо, шагнал урамшуулал, санхүү төсөв, худалдан авалт, өмч хөрөнгийн ашиглалт, зарцуулалт ил тод нээлттэй бус, авлига, хээл хахууль, ашиг сонирхлын зөрчил байгааг судалгаанууд харуулж байна. | авлигын эсрэг боловсролыг тусгах нь НҮБ[42]-ын Авлигын эсрэг конвенцид заасан урт хугацааны стратеги бөгөөд дэлхийн улс орнуудад хэрэгжиж байгааг ашиглан сургалтын орчин дахь авлигын үзүүлэлтийг сайжруулах боломж байна.<br>Бэлэг сэлт, хээл хахууль авахаас сэргийлэх:<br>Ажил, үүргээ гүйцэтгэсний төлөө сурагч, эцэг эхээс шан харамж, хээл хахууль авах, өгөхөөс татгалзах, зуучлахгүй байх<br>Төгсөлт, элсэлт зэрэг албан ёсны арга хэмжээ, баяр ёслолын үед хүүхэд, тэдний асран хамгаалагч, эцэг эхийн зөвлөлийг үнэтэй бэлэг өгөхөөс аргагүй байдалд хүргэхгүй байх<br>Хуульд заасан төлбөр, хураамж, хандив, хөрөнгийн зарцуулалттай холбоотой тайлан мэдээг цаг тухайд нь шударга, ил тод тайлагнадаг байх[43] нь чухал байна |
| | Монголын боловсролын тогтолцоо нь улс орныхоо хөнжилд хувь нэмэр оруулж чадахахуйц мэдлэг, чадвартай иргэдийг сургаж, төлөвшүүлэх үүргээ бүрэн биелүүлж чадахгүй байна. Тиймээс ч өсвөр, идэр насныхан багаасаа л | Сургууль, их дээд сургуулийн авлигын эсрэг боловсрол нь ёс суртахууны үйл ажиллагааны түвшинд чиглэгдэх ёстой. Хүүхдийг ёс суртахууны үйл ажиллагааны үе шатанд сургах нь ёс |

[42] Нэгдсэн Үндэсний байгууллага.
[43] Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, албан бус, насан туршийн боловсролын төвийн багш, удирдах болон бусад ажилтны ёс зүйн дүрэм. 2018 оны 5 дугаар сарын 1-ний өдөр.

| | | |
|---|---|---|
| | шударга бус, ёс зүйгүй байдлыг амьдралд байж болохуйц үзэгдэл, нийгмийн хэвийн зүйл мэтээр ойлгох болсон нь харамсалтай. Нэгэнт итгэл үнэмшил, ёс зүйгүй төлөвшсөн хүмүүс ажил, албандаа ёс зүйгүй үйлдлийн чөлөөтэй хийж, "авлига"-ыг байдаг л зүйл хэмээн ойлгоход хүрчээ.<br><br>Сургуулийн түвшинд авлига нь сайн дүн, амжилттай төгсөх зэргээр эцэг эхчүүдийн төлдөг хахуулийн хэлбэрээр явагддаг. Илүү өргөн утгаар нь авч үзвэл сурагчдыг үндэс угсаа, хүйсээр нь ялгаварлан гадуурхах, мөн эрх мэдлээ урвуулан ашиглах зэрэг нь авлигын үйлдлийн хэлбэр мөн юм. Боловсролын ерөнхий газраас гаргасан тушаалаар 5 чиглэлээр 20 орчим ёс зүйн дүрмийг гаргасан байдаг. Тухайн дүрэмд багш, боловсролын байгууллагын ажилтан бэлэг сэлтийг энгийн зүйл гэх ойлголтыг халах хэрэгтэй гэж заасан байдаг.[44] Гэвч энэхүү заалт бодит байдал дээрээ хэрэгждэггүй юм байна. Хэрэв боловсролын байгууллагын ажилтан, албан хаагчид 300 мянган төгрөгөөс дээш үнийн дүнтэй бэлэг сэлт авбал авлигын шинж чанартай үйлдэл гэж үздэг. Харин тухайн ажилтан авлига авсан тохиолдолд Эрүүгийн болон ёс зүйн хариуцлага хүлээлгэх байдлаар авлигатай тэмцэх эрх зүйн зохицуулалт яригддаг. Боловсролын салбар дахь авлигатай холбоотой сүүлийн үеийн судалгаанд дараах үр дүн гарчээ. | суртахууны мэдлэг, дараа нь ёс суртахууны мэдрэмж Авлигатай тэмцэхээс гадна урт хугацаанд авлигаас урьдчилан сэргийлэх нь илүү чухал бөгөөд урт хугацаандаа үр дүн гаргах боломж бол соён гэгээрэл гэдэгтэй улс орнууд санал нэгдээд байна. Энд албан боловсрол нь бага сургуулиас ахлах анги хүртэл авлигын эсрэг үнэт зүйлсийг төлөвшүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг.Авлигаас урьдчилан сэргийлэх боловсрол нь үндэсний зан чанарыг төлөвшүүлэхийн нэг илрэл болох үнэт зүйлсийн боловсрол ба нийгмийн боловсрол хоёрын оглолцсон хэлбэртэй байх ёстой байдаг. Авлигын эсрэг боловсролыг иргэний нийгмийн боловсролын сургалтын хөтөлбөрийн агуулгад тусгах эсвэл хичээлээс гадуурх үйл ажиллагаанд тусад нь оруулах, мөн энэ нь сургалтын үнэт зүйлс, нөхцөл байдлын заах аргад тулгуурласан байх ёстой. Авлигын эсрэг боловсролын сургалтын загвар нь бага болон ахлах ангийн сурагчдын хэрэгцээнд нийцсэн, оюутнуудыг түвшинд хүрсэн байх ёстой.<br><br>суулгах юм. Ёс суртахууны мэдлэг нь хүүхдүүдэд ёс суртахууны талаар ойлголт өгөх үе шат мөн. Ёс суртахууны мэдрэмжийн үе шат нь хүүхдүүдэд заасан ёс |

[44] Транспэрэнси Интернэшнл. Боловсролын салбар дахь авлига. УБ.,2014 он.

| | | |
|---|---|---|
| | | суртахууны мэдлэгийг шингээж, өөрийгөө ухамсарлахад нь туслах явдал юм. Заасан ёс суртахууны мэдлэг бол хийх ёстой зүйл бөгөөд ёс суртахууны мэдлэгийг бодит үйлдэл болгох арга зам бол ёс суртахууны үйл ажиллагаа юм.Үйлдэл нь өмнөх хоёр үе шатын үр дүн болдог. Гурван үе шат нь тэнцвэртэй байх ёстой бөгөөд ингэснээр оюутнуудын эзэмшсэн потенциалыг оновчтой хөгжүүлэх боломжтой болгож авлига өгөх, авах тухай ойлголтгүй төлөвшиж |

## 2.2.15.АУДИТЫН ТУХАЙ ХУУЛИЙН ЗОХИЦУУЛАЛТ, ХЭРЭГЖИЛТ

Энэ хуулийн зорилт нь аудитын үйл ажиллагааны зарчим, зохион байгуулалтын эрх зүйн үндсийг тодорхойлж, аудитын үйл ажиллагаа эрхлэх, эрх олгох, хэрэгжүүлэх, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулах явдал бөгөөд Төрийн аудитын зүгээс авлигыг хянахад гүйцэтгэх үүрэг, түүний төрийн байгууллагын үйл ажиллагаа, татварын орлогод үзүүлэх нөлөө их.

Тиймээс тус хуулийн хэрэгжилийг сайжруулах, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох хүрээнд дараах зүйлсийг анхааран шийдвэрлэх нь зүйтэй. Үүнд:

| Хуулийн зүйл, заалт | Хэрэгжилт | Анхаарах зүйлс |
|---|---|---|
| Улсын Их Хурлаас 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтөд “Төрийн санхүү, төсвийн хяналтыг хараат бусаар хэрэгжүүлэх байгууллагын бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно.” гэж, “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх, түүнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын хавсралтын 1.2.5-д “төрийн санхүү, | Үндэсний аудитын газраас мэдээлснээр, Засгийн газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын дүгнэлтээр 10.5 их наяд төгрөгийн 17513 алдаа, зөрчил илэрчээ. Аудит хийх явцад Худалдан авах ажиллагааны журам заавар зөрчиж, шууд гэрээ байгуулж, бараа ажил үйлчилгээ худалдан авсан, тендер зарлахаас зайлсхийж, тендерийг хувааж, харьцуулалтын аргаар гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан зэрэг зөрчил илэрсэн байна. Тухайлбал, тендерийн үнэлгээг буруу хийсэн, цахим системээр зарлаагүй зэрэг худалдан | Төсвийн ерөнхийлөн захирагчдын дотоод аудитын үйл ажиллагааг зохицуулсан хууль, эрх зүйн орчин нэгдмэл бус энэ үүргийг хэрэгжүүлэгч бүтэц, орон тоо, тогтолцоо оновчтой бус, үйл ажиллагаа хангалтгүйгээс санхүүгийн тайлангийн аудитаар илэрч байгаа алдаа, зөрчил буурахгүй, өгсөн зөвлөмж, албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлдэггүй байдал түгээмэл байдаг байна.<br>Энэ нь авлигын эрсдэлийг нэмэгдүүлж, урьдчилан сэргийлэхэд дотоод хяналтыг үр дүнтэй зохион |

| | | |
|---|---|---|
| төсвийн хяналт /аудит/-ыг хараат бусаар хэрэгжүүлэх байгууллагын бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтоох;”, 1.2.6-д “төрийн нийтийн өмчийг зохистой ашиглах, зарцуулахад тавих хяналтыг боловсронгуй болгох” гэж тодорхойлсон.<br><br>Дээрх үзэл баримтлалын хүрээнд төрийн санхүү, төсвийн хяналтыг хараат бусаар хэрэгжүүлэх, татвар болон татварын бус орлого, байгалийн баялгийн ашиглалтаас бүрдсэн нийтийн өмчийг зохистойгоор төлөвлөх, тайлагнах, ашиглах, зарцуулах үйл ажиллагаанд тавих хяналтын эрх зүйн үндсийг тогтоох зорилгоор Төрийн аудитын тухай хуулийг шинэчлэн баталсан. | авах ажиллагаатай холбоотой 31.4 тэрбум төгрөгийн зөрчил илэрчээ.<br><br>Үндэсний аудитын газраас "Гадаад зээлийн хөрөнгийн эх үүсвэрээс дамжуулан зээлдүүлсэн зээлийн хугацаа хэтэрсэн, эргэн төлөлт зогссон, эзэн холбогч тодорхойгүй, олон болсон болсон гэх зэрэг нийт 533.9 тэрбум төгрөгийн авлагыг барагдуулах талаар арга хэмжээ аваагүй байна. | байгуулан ажиллах шаардлагатайг харуулж байна. |
| ЗЕХ-ийн 103 дугаар зүйлийн 103.1.Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ.<br><br>103.2.Энэ хуулийн 103.1-д заасан үүргийг тухайн захиргааны байгууллагын дээд шатны байгууллагын дотоод аудитын нэгж хариуцна.<br><br>103.3.Энэ хуулийн 103.2-т заасан дээд шатны байгууллагын дотоод аудитын нэгж байхгүй бол гэм буруутай этгээдээр хохирлыг төлүүлэх үүргийг төрийн аудитын байгууллага хариуцна. | ҮАЕГ-аас хохирол нөхөн төлөх үүргийн хэрэгжилтийг хангаж төрд урчирсан хохирлын дүн, түүнийг барагдуулсан байдал зэргийг ерөнхий дүнгээр тайлагнаж ирсэн. | Аудитын байгууллага болон төрийн байгууллагаасаль байгууллагын хэн гэж албан тушаалтны буруутай албан тушаалтны улмаас төрд хэчнээг төгрөгний хохирол учирсан, хохирлын хэдэн төгрөгийг хэрхэн барагдуулсан зэрэг тайлан мэдээг ил тайлагнах зохицуулалтыг Шилэн дансны хуульд зааж өгөх |

### 2.2.16.ТӨСВИЙН БОЛОН ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ЗОХИЦУУЛАЛТ, ХЭРЭГЖИЛТ

Тус хуулиар өнөөдрийн Монгол Улсын төсөв, түүний зарчим, тогтолцоо, бүрэлдэхүүн, ангиллыг тогтоож, төсвийн тусгай шаардлагыг хэрэгжүүлэх, төсвийн харилцаанд оролцогчийн эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлж, төсөв боловсруулах, батлах, зарцуулах, бүртгэх, тайлагнах, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулж байна. Монгол Улсын Төсвийн тухай хууль болон бусад холбогдох хуулиудад төсвийн зорилгын хүрээнд нийгэм, эдийн засгийн үр ашиг, тогтвортой хөгжил, баялгийн хуваарилалт, тогтвортой байдал, өрийн удирдлага, ил тод байдал, олон нийтийн оролцоо зэргийг тодорхой зааж өгсөн нь төсвийн төлөвлөлт, хэрэгжилт хангалттай байх боломжийг бий болгожээ.

Төрийн төсөв, санхүүгийн үйл ажиллагааг Төсвийн тухай хууль, төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Өрийн удирдлагын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжоор зохицуулж байгаа бөгөөд энэ нь Монгол Улсын төсөв, санхүүгийн үйл ажиллагааны ил тод, нээлттэй, хариуцлагатай байх шаардлгыг бүрэн хангаж чадахгүй байна.

Энэ хуульд батлагдсан үеэс хойш өнөөдрийг хүртэл хугацаанд 53 удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан бөгөөд тэдгээрийг агуулгын хувьд нэгтгэн дүгнэж, дүн шинжилгээ хийж үзвэл 40 удаагийн нэмэлтээр 100 гаруй зүйл, заалт нэмсэн бол, 28 удаагийн өөрчлөлтөөр 200 гаруй зүйл, заалтыг өөрчлөн найруулсан байна. Мөн хуулийн зарим зүйл заалтыг хүчингүй болгох өөрчлөлтийг 18 удаа, зарим зүйл заалт хасах өөрчлөлтийг 13 удаа оруулжээ.

Харин Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд батлагдсанаас хойш 13 удаа нэмэлт өөрчлөлт оруулсан байх бөгөөд энэ өөрчлөлтүүдээр хуулиар тогтоосон төсвийн тусгай шаардлагын хэрэгжих боломжийг байнга алдагдуулж ирсэн байна.

| Хуулийн зүйл, заалт | Хэрэгжилт | Анхаарах зүйлс |
|---|---|---|
| 6.1.3.Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл нь тухайн төсвийн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний хоёр хувиас илүүгүй алдагдалтай, эсхүл ашигтай байх | хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4-т заасан Засгийн газрын өрийн үлдэгдлийг тогтоосон төсвийн тусгай шаардлагыг **нэгдүгээрт,** хувь хэмжээгээр, **хоёрдугаарт,** дагаж мөрдөх хугацаагаар нь, **гуравдугаарт,** улсын өрийн хувь хэмжээнд тоон хязгаар тогтоож байсан зохицуулалтыг Засгийн газрын өр хэмээн явцуу агуулгаар тодорхойлж, улмаар Засгийн газрын өрд хамаарах бүрэлдэхүүнээс зарим өрийг хасаж тооцох агуулгаар, **дөрөвдүгээрт,** удаа дараа өөрчилж, өрийн хэмжээг хянах боломжийг алдагдуулах, улсын төсвийн төсвийн тусгай шаардлагын үйлчлэлийг түр хугацаагаар түдгэлзүүлэх үндэслэл нэмэх замаар төсвийн алдагдлыг нэмэгдүүлэх эрсдлийг | Макро эдийн засгийн төсөв, мөнгөний бодлогын уялдааг хангах тал дээр хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хуулийн хүрээний зохицуулалтуудыг чанд мөрдөж, улс төрийн нөлөөг багасгах. |

| | | |
|---|---|---|
| | хуулиар дэмжсэн нэмэлт, өөрчлөлтүүдийг оруулж иржээ. | |
| 5.1.Төсөв нь Улсын болон Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх бөгөөд төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад дараах зарчмыг баримтална:<br>...5.1.4.ил тод байдлыг хангасан байх;<br>... 6.5.Энэ хуулийн 5.1.4-т заасан төсвийн ил тод байдлыг хангасан байх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ:<br>6.5.1.төсөв хэлэлцэх, батлах үйл ажиллагааг нийтэд нээлттэй байлгаж, төсвийн төлөвлөгөө, гүйцэтгэл, тайлагналын талаар тогтоосон хугацаанд нийтэд ойлгомжтой, хүртээмжтэй байдлаар мэдээлэх;<br>6.5.2.төсвийг төлөвлөх, бүрдүүлэх, хуваарилах, тайлагнах үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог хангах;<br>6.5.3.төсвийн гүйцэтгэл, зарцуулалт нь батлагдсан төлөвлөгөөний дагуу хэрэгжиж байгаа эсэхэд олон нийт хяналт тавих боломжоор хангах;<br>6.5.4.төрөөс үзүүлж байгаа аливаа ажил, үйлчилгээ, хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, тэдгээрийн хүрээнд худалдан авч байгаа бараа, ажил, үйлчилгээнд олон нийт хяналт тавих боломжоор хангах;<br>6.5.5.хөтөлбөр, төсөл, арга хэмжээний ач холбогдлын эрэмбэ, хэрэгжүүлэх дараалал, арга замыг тодорхойлох шийдвэрт | Манай улс Төсвийн тогтвортой байдлын зөвлөл (ТТБЗ)-ийн дүрэм журмуудыг 2017 оны 12 дугаар сард УИХ-аар баталж, 2018 оны 10 дугаар сард зөвлөлийг албан ёсоор байгуулсан. Энэ нь төсвийн хяналтыг сайжруулах чухал алхам болсон. Гэвч ОУВС-гийн үзэж буйгаар ТТБЗ-ийн хараат бус байдал хангалтгүй байна. Түүнчлэн 2018 оны хөндлөнгийн судалгаанд ТТБЗ-ийн хэд, хэдэн дутагдалтай талуудыг дурьдсан ба олон улсын жишигтэй харьцуулах замаар эдгээрийг сайжруулах зөвлөмжүүдийг өгсөн байна<br>- худалдан авах ажиллагааг хуульд заасан бүрэлдэхүүнээр зохион байгуулаагүй,<br>- үнэлгээний хорооны гишүүнээр нэг албан тушаалтныг олон давтамжтай ажиллуулдаг,<br>- үндэслэлгүйгээр төлбөр хураамж тогтоосон,<br>эрүүл мэндийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг хадгалах харилцаанд хувийн ашиг сонирхол үүссэн | Төсвийн ил тод байдал, хариуцлагыг хангах хүрээнд ажиллаж буй Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийг чадавхжуулах, энэ талаарх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох |

| | | |
|---|---|---|
| олон нийтийн саналыг харгалзан үзэх;<br><br>6.5.6.төсвийн асуудлаар иргэд, төрийн бус байгууллагаас гаргасан санал, дүгнэлтийг эрх бүхий этгээд нь шийдвэртээ хэрхэн тусгасан тухай, төсвийн үйл ажиллагаан дахь олон нийтийн оролцоог хангаж ажилласан дүнг тэдэнд тухай бүр мэдээлж байх.<br><br>10.2.Төсөв, санхүү, эдийн засгийн бодлогын төлөвлөлтийг сайжруулах, түүний тайлагналт, ил тод байдлыг хангах, олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх зорилготой татвар төлөгчдийн төлөөлөл бүхий төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоод болон салбарын эрдэмтдээс бүрдсэн 9 гишүүний бүрэлдэхүүнтэй орон тооны бус төсөв, санхүү, эдийн засгийн үндэсний зөвлөлийг Ерөнхий сайдын дэргэд байгуулж ажиллуулна.<br><br>10.3.Энэ хуулийн 10.2-т заасан үндэсний зөвлөл нь төсвийн төсөл болон улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төслийг хэлэлцэж, санал, дүгнэлтээ Засгийн газарт хүргүүлнэ. | | |

## 2.2.17.БАНКНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ЗОХИЦУУЛАЛТ, ХЭРЭГЖИЛТ

| Хуулийн зүйл, заалт | Хэрэгжилт | Анхаарах зүйлс |
|---|---|---|
| Авлигын эсрэг хууль, нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан үндэслэл, журмын дагуу нийтийн албан тушаалтан оффшор бүсэд хуулийн этгээд байгуулах, данс эзэмших, мөнгөн хөрөнгө | Нийтийн албан тушаалтны хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгийг хянан шалгах үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд албан тушаалтан, түүний хамаарал бүхий этгээдүүдийн банкны данс, гүйлгээтэй холбоотой мэдээллийг гаргуулан авах боломжийг хуульчлан тогтоогоогүй нь албан тушаалтны үндэслэлгүйгээр | Иймд Банкны тухай хуульд холбогдох нэмэлтийг оруулах шаардлагатай байна. |

| | | |
|---|---|---|
| байршуулахтай холбоотой хориглолт, хязгаарлалтын хэрэгжилтэд хяналт тавих, зөрчлийг илрүүлэх чиг үүрэгтэй холбогдуулан, албан тушаалтны банкны дансны орлого, зарлагын гүйлгээг хянан шалгах зорилгоор холбогдох мэдээллүүдийг шалган тогтоох зайлшгүй нөхцөл байдал бий болж байна. | хөрөнгөжих гэмт хэрэг, нуугдмал хөрөнгийг илрүүлэх ажиллагаанд томоохон бэрхшээл учруулж байгаа ба тухайн албан тушаалтны зөвхөн өөрийн гарган өгч буй мэдээллээр хязгаарлагдах, хяналт шалгалтын үйл ажиллагаанд шаардлагатай хөндлөнгийн нотолгоог бүрэн цуглуулах боломжгүй, хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүрэн гүйцэд шалгах, үндэслэлгүй хөрөнгөжих, нуугдмал хөрөнгийг илрүүлэх үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж байна. | |

## 3.ДҮГНЭЛТ

Авлига нь ард иргэдээс төрд итгэх итгэлийг бууруулж, нийгэм, сэтгэл тэгш бус ханамжгүй байдлыг бий болгохын зэрэгцээ улс орны хөгжил, дэвшилд саад учруулагч нийгмийн сөрөг үзэгдлүүдийн нэг мөн. Тиймээс ч улс орон бүр нийгмийн энэ тахалтай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх асуудалд хүн хүч, санхүүгийн нөөцөө зарцуулсаар ирсэн бөгөөд түүнтэй тэмцэх үйл ажиллагааг илүү үр ашигтай байлгахыг чармайж ирсэн. Үүний нэг нь тухайн улс орны хууль тогтоомжийн нийцэл, хэрэгжилтийн үр нөлөөний асуудал яах аргагүй мөн.

Манай улсад эрх зүйн шинэчлэл, шинэтгэлийн үйл явц тодорхой үе шаттайгаар хэрэгжиж ирсний үр дүнд бид нийгмийн амин чухал харилцааг хууль тогтоомжоор зохицуулах зорилтыг тухай бүр хангаж ирсэн.

Монгол Улсын авлигатай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх, олон нийтийг соён гэгээрүүлэх ажил жилээс жилд сайжирч, НҮБ-аас Монгол Улс энэ чиглэлд тогтвортой, байнга ажиллаж байна гэж үнэлсэн ч хууль тогтоомжийн нийцэл, харилцан хамаарал, хэрэгжилтийг хангах хэрэгцээ шаардлага байгаасаар байгааг авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэж буй зарим хуулийн хүрээнд фокуслан судалсан болно.

Энэ хүрээнд авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, авлигатай тэмцэх үйл ажиллагаанд холбогдох эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох зарим саналыг нэгтгэн харууллаа. Үүнд:

1. Нийтлэг үйлчилгээ үзүүлдэг эрүүл мэнд, боловсрол, зам, тээвэр, уул уурхай, хэвлэл мэдээлэл, спортын зэрэг салбарын хувийн хэвшлийн болон орон нутгийн захиргааны байгууллагын үйлчилгээ үзүүлэх, мэргэжил, тусгай мэдлэгийн хүрээнд дүгнэлт магадалгаа гаргах, эрх бүхий нийтлэг үйлчилгээний албаны ажилтан, хамтын шийдвэр гаргах чиг үүрэг бүхий аливаа хороо, комиссын гишүүн, дарга нар авлигын эрсдэл бүхий субъектүүд мөн тул Авлигын эсрэг конвенцийн шаардлагыг хангах хүрээнд авлига, ашиг сонирхлын гэмт хэрэг, зөрчлийн субъектийн цар хүрээг өргөтгөж, “нийтийн албан тушаалтан” хэмээх ойлголтод хамааруулах;
2. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.5-д “хамаарал бүхий этгээд” гэх нэр томьёонд нийтийн албан тушаалтны “хүүхэд, түүний гэр бүлийг” хамааруулан тусгах;
3. Авлигын болон ашиг сонирхлын зөрчлийн шинжтэй зарим идэвхгүй хэлбэрийн гэмт үйлдлийг гэмт хэрэгт тооцох;
4. Эрүүгийн хуулийн 22 дугаар бүлэгт заасан авлигын гэмт хэргийн томьёолол, харилцан хамаарал, логик дарааллыг эрүүгийн хуулийн тусгай ангид заасан бусад гэмт хэргийг томьёолж буй аргачлалаар, Авлигын эсрэг НҮБ-ын конвенцод нийцүүлэн шинэчлэн найруулах шаардлагатай гэж үзэж байна. Ингэснээр албаны эрх нөлөөг урвуулан ашиглах гэмт үйлдэл, эс үйлдлийг өөр төрлийн буюу бие даасан гэмт хэрэг болгон зүйлчлэх боломж бүрдэнэ
5. Нийтийн албан тушаалтан нь бусад ердийн субъекттэй гэмт хэрэгтэй харьцуулан авч үзэхэд илүү ёс зүй, үүрэг, хариуцлагын өндөр түвшний шаардлага зөрчдөг, зөвхөн хувь хүнд төдийгүй нийгэмд сөрөг үр дагавар үүсгэдэг нийгмийн хор аюулын шинжээрээ их байх тул энэ төрлийн гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг нэмэгдүүлэх, эсхүл зарим улсын жишгийн дагуу Авлигын гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацаа хэрэглэхгүй байх зохицуулалтыг бий болгох;
6. Авлигаас урьдчилан сэргийийлэх зорилтын хүрээнд арилжааны телевизийн үйлчилгээ эрхлэгчдийн эзэмшигч болон хөрөнгө оруулагчдийн мэдээллийг ил тод болгох асуудлаар эрх зүйн зохицуулалт бий болгох;

7. Авлигын эсрэг хуульд “Авлигатай тэмцэх газрын тухайн жилийн төсвийг өмнөх оны батлагдсан төсвийн хэмжээнээс бууруулан батлахыг хориглоно” гэсэн хуулийн заалтыг сэргээж хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах;

8. Төрийн үйлчилгээ авсан иргэд, байгууллагын судалгаанд тулгуурлан төрийн байгууллагын шударга байдлын түвшинд 2 жил тутамд үнэлгээ хийж, олон нийтэд мэдээлэх үйл ажиллагааг жил тутам хэрэгжүүлж байхаар өөрчлөх;

9. АТГ-ын хяналт шалгалтын чиг үүргийн хүрээнд Авлигатай тэмцэх газрын даргад бүх нийтээр дагаж мөрдөх захиргааны хэм хэмжээний актыг батлах эрхийг олгох;

10. Төсвийн орлого, түүний зарцуулалт, гадаадын зээл, тусламж, түүний хуваарилалтыг олон нийтэд тухай бүр нь мэдээлэх, зарцуулалтын үр ашгийг нэмэгдүүлэх, төрийн болон нийтийн албаны үйл ажиллагааны ил тод, хариуцлагатай байдлыг нэмэгдүүлэх эрх зүйн зохицуулалтын хэрэгжилт, тайлагналтыг боловсронгуй болгох;

11. Монгол Улсын Их Хурлаас 2019 онд баталсан Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд зааснаар гэмт хэрэг, зөрчлийн талаар мэдээлэх нь иргэний үүрэг юм. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон Авлигын эсрэг хуулийн 8 дугаар зүйл хоёрын зөрүүтэй байдлыг арилгах;

12. Хуулийн 23 дугаар зүйлийн 23.5-д “Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтан хүлээн авч Авлигатай тэмцэх газарт хүргүүлнэ.” гэж заасны дагуу ХАСУМ-ийг АТГ-т хянуулалгүйгээр томилсон байгууллага, албан тушаалтан хуульд заасан энэ үүргээ биелүүлээгүй тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг хуульчлах;

13. Төрийн албаны харилцаанд алба хаагчдын цалин хөлс, нийгмийн баталгааны эрс ялгаатай байдал нь авлига, ашиг сонирхлын гэмт хэрэг, зөрчлийг тодорхойлох, шалган шийдвэрлэх явдалд тэгш буй байдал үүсгэх, иргэдийн эрх, эрх чөлөөг зөрчих, сөрөг нөлөөлөл бий болгож байгааг арилгаж, зарим төрлийн харилцаанд нийтлэг зохицуулалттай стандарт тогтоохоор заах, мөн албаны онцлогоос хамаарах тусгай эрх зүйн зохицуулалтын хүрээг хуулиар нарийвчлан зааж өгөх шаардлагатай. Тухайлбал, төрийн албан хаагчдын цалин хөлсний харилцан адилгүй байдал нь “үндэслэлгүй хөрөнгөжих” зөрчил гаргасан нийтийн албан тушаалтанд Авлигын эсрэг хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2-т заасан “....энэ хуулийн 7.1-д заасныг зөрчсөн этгээдэд албан тушаал бууруулах, хэрэв албан тушаалыг нь бууруулах боломжгүй албан тушаал бол албан тушаалын цалингийн хэмжээг гурван сар хүртэл хугацаагаар 30 хувиар бууруулах,” ...хууль зүйн хариуцлага хүлээлгэх зөрчлийг шийдвэрлэхэд учир дутагдалтай. Иймд Монгол Улсын Үндсэн хуульд заасан болон хариуцлага гарцаагүй байх, зөрчил үйлдэгдсэн нөхцөл байдал, зөрчлийн шинж, хохирлын хэр хэмжээнд тохирсон байх зарчмыг баримтлан нийтийн албан тушаалтны “үндэслэлгүй хөрөнгөжих” зөрчлийн шинжийг тэдгээрийн албан тушаалын цалин хөлсний орлогоор бус хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй уялдуулан, хариуцлага хүлээлгэхээр өөрчлөх;

14. Төрийн улс төрийн албан тушаалтанд хүлээлгэх хариуцлагын тухай хуулийг баталж, эрх, үүргийн хэрэгжилтийг бодитой болгох, авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд төрийн өндөр албан тушаалтны халдашгүй байдлын зохицуулалт үйлчлэхгүй байх хэмжээнд хүртэл холбогдох хуулиудад өөрчлөлт оруулах;

15. Төрийн албаны тухай хууль болон бусад хууль тогтоомжид заасан болзол шалгуурыг хэрхэн хангаж байгаа, сонгон шалгаруулалтад орж тэнцсэн, нөөцөд авагдсан эсэх, тухайн ажлын байранд тавигдах, шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангаж байгаа эсэхэд болон төрийн албанаас чөлөөлөгдсөн, халагдсан этгээд дахин өөр албан тушаалд томилогдохоор нэр дэвшсэн байдалд хяналт

тавих, Төрийн албан хаагчийн улсын нэгдсэн тоо бүртгэлийн системтэй ХАСУМ-ийн цахим системийг уялдуулж, хяналтын механизмыг сайжруулах;

16. Төрийн албаны тухай хуулиар “төрийн албаны шинэтгэлийн бодлого, стратеги, хүний нөөцийн бодлогын хэрэгжилтийн явц, үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, түүний үр дүнг дээшлүүлэх асуудлыг эрхлэн гүйцэтгэх” бүрэн эрхийг Засгийн газар, ТАЗ хоёрт давхардуулан олгосон зохицуулалтыг өөрчлөх;

17. Авлигын эсрэг хуульд гэрч, хохирогч болон албан хаагчийн аюулгүй байдлыг хангах, биечилсэн хамгаалалт хийх үед байгууллагын аюулгүй байдлыг хариуцах чиг үүрэг бүхий албан хаагч галт зэвсэг, тусгай хэрэгсэл, мэх хэрэглэх үндэслэл тусгагдаагүй тул энэ эрхийг баталгаажуулах аюулгүй байдал, хяналт шалгалт, нууцын албаны эрх бүхий албан үүргээ гүйцэтгэх явцдаа галт зэвсэг, бие хамгаалах тусгай хэрэгсэл, мэх хэрэглэх эрхийг олгох;

18. Улс төрийн үйл ажиллагаанд оролцох, ямарваа улс төрийн албан тушаал эрхлэхийн төлөө сонгууль явагдах үеэр нэр дэвшигч, улс төрийн намыг дэмжиж, эсвэл эсэргүүцэж үг хэлсний төлөө, ерөнхий болон тусгай сонгуулийн үеэр хэн нэгэнд ажилд оруулж өгөх болон бусад ашиг амласан этгээд нь авлигын хэргээр хариуцлага хүлээдэг болгох;

19. Авлигын гэмт хэрэгтэй шийдвэртэй тэмцэхэд хорих эсхүл торгох ял шийтгэлийг сонгох үндэслэл, нөхцөлийг тухайн гэмт хэргийн шинж, хүнд хөнгөний байдлаас хамаарч шатлалтайгаар тогтоодог зохицуулалтыг бий болгох хэрэгтэй байна. Түүнчлэн авлигын хэрэгт тэнсэх албадлагын арга хэмжээ хэрэглэхгүй байх зэргээр ялын бодлогыг чангатгах;

20. Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан зөрчлийн хувьд хөөн хэлэлцэх хугацааг тогтоон, хязгаарлаагүй. Гэвч шүүхийн практикт энэ төрлийн зөрчлийг Төрийн албаны тухай хуульд заасан сахилгын зөрчилтэй адилтган, хөөн хэлэлцэх хугацааг нэг жилээр авч үзэх практик тогтож байгаагаас гадна авлига, ашиг сонирхлын зөрчлийн шинж чанартай уялдаагүй, зөрчил гаргасан албан тушаалтан хариуцлагаас гадуур үлдэх эрсдэлийг бий болгон, хуулийн үндсэн зорилгыг алдагдуулж, хяналт шалгалтын ажлын үр дүнд сөргөөр нөлөөлж байгаа тул авлига, ашиг сонирхлын зөрчлийн хөөн хэлэлцэх хугацааг нэг мөр ойлгуулахаар зохицуулалтыг залруулах;

21. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 9.6 дугаар зүйлд “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий нөхцөл байдлыг мэдэж байгаа хүнийг гэрч” гэнэ гэж тодорхойлоод гэрч нь хуулийн байгууллагын дуудсанаар хүрэлцэн ирж, хэргийн талаар өөрийн мэдэх зүйлийг үнэн, зөв мэдүүлэх үүрэгтэй гэж заасан боловч Төрийн аудитын тухай хуулийн 38.6-д “Монгол Улсын ерөнхий аудиторыг УИХ-ын зөвшөөрлөөр, төрийн аудитын байгууллагын бусад албан хаагчийг Монгол Улсын ерөнхий аудиторын зөвшөөрлөөр гаргасан аудитын тайлан, дүгнэлттэй нь холбогдуулан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж байгаа байгууллага, албан тушаалтан гэрчийн мэдүүлэг авч болно” гэсэн зохицуулалт нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогч, хэрэгжүүлэгч биш субъектээс мөрдөн шалгах ажиллагааны зөвшөөрөл авах зохицуулалт тогтоосон асуудал харагдаж байна. Иймд УИХ-ын тухай хууль болон Шүүх, Прокурор, Тагнуул, Төрийн аудитын тухай хуулиудад байгаа заалтуудыг хасах;

22. ЭХХштХ-ийн 45 дугаар бүлгийн хэрэгжилтийг хангахын тулд хүний зөрчигдсөн эрхийг сэргээхдээ “мөрдөгч, прокурор болон шүүгчийн буруутай эсэхээс үл хамааран төр хариуцан арилгах” үүргийг тодорхой болгох. Тухайлбал, ЭХХштХ-ийн 45 дугаар бүлгийн гарчиг болон зарим зүйл хэсэгт 2020 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн “хууль зөрчсөн ажиллагааны улмаас” гэсэн томьёоллыг хүчингүй болгох, Иргэний хуулийн 498 дугаар зүйлд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай

гэж судлаач нар үзсэн45 байна. Түүнчлэн хэрэг бүртгэлтийн хэргийг хаах, эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгохын өмнө бие даасан, хараат бус хороо шийдвэрийг хянадаг тогтолцоог хуулийн байгууллагын бүтцэд бүрдүүлэх. Энэ боломжийг бүрдүүлэх өөрчлөлтийг Авлигын эсрэг хууль, ЭХХШтХ-д оруулах

23. Хохирогч, нэхэмжлэгч тогтоогдоогүй, мөн нэргүй гомдол, мэдээлэлд хамаарах хохирогчийн эрхийг хөндлөнгийн, хараат бус этгээдэд шилжүүлж болох заалтыг хуульд оруулах;

24. Эрүүгийн хуулийн тусгай ангийн Хорин хоёрдугаар бүлгийн зарим зүйлд заасан авлигын гэмт хэрэг, Хорин есдүгээр бүлэгт заасан Хүн төрөлхтний аюулгүй байдал, энх тайвны эсрэг гэмт хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэхгүй байх, авлигын хэргийг түргэн шуурхай шийдвэрлэх, мэргэшсэн шүүгчээр шийдвэрлүүлэх үүднээс давж заалдах шатны шүүх анхан шатны журмаар шийдвэрлэдэг байх, давж заалдах эрхийг Улсын дээд шүүхэд хангахтай холбоотой нэмэлт оруулах шаардлагатай;

25. Мөнгө угаахтай тэмцэх хууль тогтоомж зөрчсөн хуулийн этгээдэд үр нөлөөтэй, ижил тэгш захиргааны болон эрүүгийн хариуцлага оногдуулдаг байх, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд бэлэн бус гүйлгээг заавал тайлагнах, тайлагнаагүй тохиолдолд хариуцлага тооцох талаар хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хэрэгтэй байна. Түүнчлэн Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үүрэгтэй ТЕГ, ЦЕГ, ГЕГ, Хилийн алба, Ерөнхий прокурорын газар, Монгол банк, СЗХ зэрэг байгууллагууд дээр нэмж Татварын ерөнхий газрын үйл ажиллагааг нягт уялдуулах хэрэгтэй. Тиймээс Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд мэдээлэх үүрэгтэй этгээд гэдэгт Татварын ерөнхий газрыг багтааж оруулах шаардлагатай. Мэдээлэх үүрэгтэй этгээд нь хуулиар хүлээсэн дээрх үүргийг хэрэгжүүлэхэд гар аргаар хяналт хийх боломжгүй ба харилцагчийн эрсдэлийг үнэлэх, гүйлгээний хяналт хийхэд тусгай автоматжуулсан программыг ашиглах шаардлагатай. Программыг үр дүнтэй ашиглахын тулд харилцагч таньж мэдэх ажиллагааг бүрэн хийж харилцагчийн эрсдэлийг үнэлэн судалгаа хийж харилцагчийг албан тушаал, бизнесийн чиглэл, гүйлгээний онцлогоор нь төрөлжүүлэн тохирсон хяналтын дүрмүүдийг боловсруулах нөхцөлийг бүрдүүлэх;

26. Шилэн дансны хуулийн дагуу холбогдох байгууллагууд цахим сайтдаа 5 сая төгрөгөөс дээш орлого, зарлагын мөнгөн гүйлгээг долоо хоногийн дотор байршуулахаар заасныг нийт орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гэж өөрчлөх;

27. Шилэн дансны нэгдсэн цахим хуудасны мэдээлэл байршуулах хандалтын системийг санхүү, төрийн сан, хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагааны болон хуулийн үйлчлэлд хамрагдаж буй байгууллагуудын санхүүгийн болон дотооддоо хөтөлж буй программ хангамжтай холбох замаар мэдээлэл байршуулах үйл ажиллагааг албан тушаалтнаас хамааралгүй байдлаар зохион байгуулах;

28. Сонгогдсон болон томилогдсон төрийн өндөр албан тушаалтанд хариуцлага тооцох үндэслэл, журмыг тодорхой болгож, Улс төрийн албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх тухай хуулийг батлах;

29. Уул уурхайн салбарт ил тод байдлыг хангах, авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, түүнийг гаргахгүй байх нэг чухал зохицуулалт нь АМТХ-ийн 48 дугаар зүйлд заасан ил тод байдлын тайлан юм. Энэхүү зохицуулалт нь практикт үр дүнгээ өгч байгаа учир улам бүр боловсронгуй болгож, илүү үр дүнтэй, бодитой хэрэгжих гарцыг нээж, энэхүү харилцааг тусгайлан зохицуулдаг тусгай эрх зүйн актыг батлан гаргах;

[45] Нээлттэй нийгэм форум. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 45 дугаар бүлгийн хэрэгжилт. Судалгааны тайлан. УБ.,2021 он.

30. Боловсролын салбарыг улс төрийн нөлөөнөөс ангид байлгах, бүх талуудын ёс суртахууныг дээшлүүлэх зэрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах механизмыг сайжруулах, хяналтыг нэмэгдүүлэх зорилгоор сургалтын хөтөлбөрт үнэт зүйл, шударга ёс, авлигын эсрэг боловсролыг тусгах НҮБ-ын Авлигын эсрэг конвенцын урт хугацааны стратегийн хүрээнд суралцагчид болон эцэг, эх, асран хамгаалагчдын шаардах эрхийн хэрэгжилтийг нэмэгдүүлэх;

31. Аудитын байгууллага болон төрийн байгууллагууд ямар байгууллагын хэн гэж албан тушаалтны буруутай албан тушаалтны улмаас төрд хэчнээн төгрөгийн хохирол учруулсан, хохирлын хэдэн төгрөгийг хэрхэн барагдуулсан зэрэг тайлан мэдээг ил тайлагнаж зохицуулалтыг Шилэн дансны хуульд зааж өгөх нь зүйтэй;

32. Макро эдийн засгийн төсөв, мөнгөний бодлогын уялдааг хангах тал дээр хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хуулийн зохицуулалтыг чанд мөрдөж, шийдвэр гаргалт дах улс төрийн нөлөөг багасгах;

33. Төсвийн ил тод байдал, хариуцлагыг хангах хүрээнд ажиллаж буй Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийг чадавхжуулах, энэ талаарх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох г.м.

Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, авлигатай тэмцэх үйл ажиллагаанд холбогдох хууль тогтоомжийн өнөөгийн байдал, эрх зүйн зохицуулалт, хэрэгжилтийн байдалд хийсэн үнэлгээний дүнд тулгамдсан асуудлыг нэгтгэн дүгнэвэл хууль тогтоомжийг боловсронгуй болгох чиглэлээр анхаарах зүйлс цөөнгүй байна. Үүнд:

***Нэг.Хуулиудад хэрэглэж буй нэр томьёоны нийцэл хангагдаагүйн улмаас авлига, албан тушаалын гэмт хэрэг зөрчил, ашиг сонирхлын зөрчлөөс иргэдийн эрх ашгийг хамгаалах боломжийг хязгаарлах байдал үүсгэж байна. Тухайлбал,***

1.1.Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн зорилтод “*нийтийн албаны үйл ажиллагааг нийтийн ашиг сонирхолд нийцүүлэх нөхцөлийг баталгаажуулах*” гэж заасан ч хуулийн нэр томьёо болон үйлчлэлд хамаарах этгээдийг тодорхойлохдоо хуулийн үйлчлэлийг явцууруулсан байна. Нийтийн албаны үйл ажиллагаа гэдгийг тус хуульд заасан нийтийн албан тушаалтны үйл ажиллагаагаар хязгаарласнаар нийтийн албан дахь нийтийн ашиг сонирхлын зөрчлийг хязгаарлах, зохицуулах боломжийг хязгаарласан байна.

1.2.Төрийн албаны тухай хуулийг төрийн албаны мэргэшсэн, тогтвортой, ил тод, хариуцлагатай байх эрх зүйн үндсийг бүрдүүлэх, төрийн албаны төв байгууллага, төрийн албан хаагчийн эрх зүйн байдал, нийгмийн баталгааг тогтоохтой холбогдсон харилцааг зохицуулах зорилттойгоор баталсан боловч хуулийн холбогдох зүйл заалтаар төрийн албаны харилцаанаас улс төрийн албан тушаалтнуудыг тусгаарласан нь хуулийн шаардлага нэгдмэл байдлаар хангагдах боломжийг хязгаарлаж байна.

1.3.Гэмт хэрэг, зөрчлийн улмаас бусдад үүсэж буй сөрөг үр дагаврыг холбогдох хуулиудад гэмт хэрэг зөрчлийн улмаас учирсан хохирол, хор уршиг, эдийн бус гэм хор, сэтгэцэд учирсан хор уршиг зэргээр тодорхойлж, түүнийг арилгах арга замыг тодорхойлсон боловч сэтгэл санааны хохирлыг ямар тохиолдолд хэрхэн тодорхойлох, хэрхэн барагдуулах асуудал өнөөг хүртэл зохицуулалтгүй байна.

***Хоёр. Хуулиудад авлига, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэн, түүнийг таслан зогсооход чиглэсэн зохицуулах болон хамгаалах хэм хэмжээ харьцангуй хангалттай түвшинд хуульчлагдсан байна. Гэхдээ хууль***

***тогтоомжийн бичилтийн техник, агуулгын илэрхийлэмжийн оновчтой бус байдлаас хуулиуд зорилтынхоо хүрээнд хэрэгжих боломжийг хязгаарласан тохиолдол цөөнгүй байна. Тухайлбал,***

2.1.Хууль тогтоомжууд дийлэнхдээ эрх, үүрэг, хариуцлага, хориглох зүйл, үйл ажиллагааны хэлбэр зэрэг материаллаг нөхцөлийг хуульчилсан байх нь түгээмэл байна. Харин тэдгээрийг хэрэгжүүлэгч этгээд эрх хэмжээний хүрээнд шийдвэрлэх асуудлын процессын зураглал хийгддэггүй, ил тод байдал хангагддаггүй байдал нь хуулийн хэрэгжилт хангагдахгүй, нийтийн албан тушаалтнууд авлига, ашиг сонирхлын зөрчил гаргах нөхцөл байдлыг үүсгэж байна.

2.2.Хууль тогтоомжуудад заасан авлига, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэн, түүнийг таслан зогсооход чиглэсэн хуулийн зарим зохицуулалт тоочилтын буюу жагсаалтын зарчмаар бичигдсэнээр хуулийн үйлчлэлийг явцууруулах, зарим зүйлийг тоочилгүй үлдээх зэрэг сөрөг үр дагаврыг үүсгэсэн байна. Иймд хууль тогтоомж дахь аливаа ойлголт, түүнд хамаарах этгээдийг тодорхойлохдоо тоочилтын буюу жагсаалтын зарчмаас татгалзаж агуулга, мөн чанарыг илэрхийлсэн бичилт ашиглах нь зүйтэй байна.

***Гурав. Хууль тогтоомжуудад нийцлийн шинжилгээ хийх явцад хуулийн хэрэгжилтийн талаарх судалгаа, тайланг өргөнөөр ашигласан бөгөөд тэдгээрт дурдсанаар авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэж буй гол шалтгаан нөхцөл нь төр, хувийн хэвшлийн нийтлэг үйлчилгээний хүртээмж хангалтгүй, чанарын тэгш бус байдал, ил тод бус байдал, үйлчилгээ үзүүлэгчийн ур чадвар, ёс зүй, шуурхай байдлын хангалтгүй байдал нь авлига, ашиг сонирхлын зөрчил үүсэх хөрс суурь болсоор байна. Иймд хуулийн хэрэгжилтийг сайжруулах хүрээнд дараах арга хэмжээг системтэйгээр хэрэгжүүлэх нь зүйтэй. Үүнд:***

1.Боловсрол, эрүүл мэнд, нийгмийн халамж зэрэг нийтлэг үйлчилгээний салбарт үйлчилгээний чанар хүртээмж, шуурхай байдлыг нэмэгдүүлэх;

2.Нийтлэг үйлчилгээний ил тод байдлыг хангах, нийтлэг үйлчилгээний алба хаагчдын ур чадвар ёс зүйн шаардлагыг дээшлүүлэх;

3.Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх, таслан зогсоох үйл ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэх нь зүйтэй.

Хууль хэрэгжүүлэх явцад дээрх шаардлага бүрэн хангагдаагүйгээр хүнд суртал үүсэж, улмаар авлига, ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөлийг бүрдүүлж байна.

Хууль, тогтоомжуудыг нийцэл, хэрэгжилтийн байдлыг сайжруулах саналыг нэгтгэн үзвэл:

# ЗӨВЛӨМЖ

Судалгааны үр дүнг үндэслэн дараах арга хэмжээг хэрэгжүүлэхийг зөвлөмж болгож байна:

1. Авлига ашиг сонирхлын зөрчлийг зөвхөн төрийн албаны хүрээнд бус нийтийн эрх зүйн болон хувийн хэвшлийн хуулийн этгээдийн хүрээнд өргөн агуулгаар авч үзэх;

2.Судалгааны ажлын үндсэн хэсэгт хуулийн хэрэгжилтийг сайжруулах хүрээнд гаргаж тавьсан саналуудыг хууль тогтоомжид тусгах замаар авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох үйл ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэх;

3.Хууль тогтоомжид консолидаци буюу төрөлжүүлэн нэгтгэж хуульчлах системчлэлийг хийх замаар ойлголтын нэгдмэл байдлыг хангах, энэ талаар судалгааны ажлыг системтэйгээр хэрэгжүүлэх;

4.Хууль, тогтоомжийн хэрэгжилтийг дараах процедурын дагуу хангах үйл явцын зураглалыг хийж хэрэгжилтийн үр нөлөөг сайжруулах;

5.Хүнд суртал нь авлигын урьдач нөхцөл болдог бөгөөд хүнд суртлаас үүдэн хүн ам авлигад өртөх хандлага үүсдэг гэж үзвэл судалгааны үр дүнгээр авлига, хүнд суртал нь нийлбэр дүнгээрээ Орхон аймгийн хэмжээнд тулгамдаж буй нэн тэргүүний асуудал төдийгүй, хүн амын дунд нийтлэг үзэгдэл мэтээр ойлгогдох болжээ. Иймд авлигад өртөмтгий салбаруудын ажиллагсдын эрх үүргийн хуваарилалтыг тэгшитгэх, нийгмийн баталгааг хангах, үйл ажиллагааны хяналт, хариуцлагын тогтолцоог сайжруулах, эрүүл мэнд болон боловсролын салбарын хүртээмжийг нэмэгдүүлэх;

6.Авлигад өртсөн иргэн, албан тушаалтан, аж ахуйн нэгж байгууллага, хуулийн этгээдүүдийн талаарх мэдээллийг олон нийтэд нээлттэй мэдээлж, хариуцлагын тогтолцоог нэмэгдүүлэх. Авлига, хээл хахууль, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх, мөнгө угаах зэрэг санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх, гэмт хэргийн эрсдэлийг бууруулах зорилгоор холбогдох мэдээллийг тодорхойлох, цуглуулах, тайлагнах, олон нийтэд хүргэж мэдээллийн ил тод байдлыг хангах нөхцөлийг бүрдүүлсэн, энэ салбарын дэлхийн чиг хандлага, хөгжлийн бодлоготой уялдуулах;

7.Иргэдийн хувьд авлигын эсрэг мэдээлэл өгөх эрмэлзлэл бараг тэнцүү хувьтай байдаг ба дийлэнх иргэд авлигын эсрэг мэдээллийн талаар хаана хандахаа мэддэггүйгээс мэдээлэл өгөх нь бага байдаг бөгөөд авлигын эсрэг хийх тэмцлийг иргэд, олон нийтийн байгууллага манлайлах нь зүйтэй бөгөөд авлигын эсрэг мэдээлэл өгөх боломжоор иргэдийг хангах, мэдээллийн үнэ цэнийн үнэлэмжийг бий болгох, тэдний аюулгүй байдал, эрх ашгийг хамгаалах, авлигын эсрэг олон нийтийн оролцоог хангасан төрийн болон төрийн бус байгууллагыг үүсгэн байгуулах, үйл ажиллагааг хөхүүлэн дэмжих;

8.Иргэдийн сарын дундаж орлогын хэмжээнээс үл хамааран авлигад өртөх хандлага их байдаг ба сарын 1,5 сая ба түүнээс дээш төгрөгийн дундаж орлоготой иргэдийн авлигад өртөх хандлага нь 1,5 сая төгрөгөөс бага орлоготой иргэдийнхийг бодвол ялимгүй өндөр байдаг байна. Мөн авлигад өртөх хандлага нь хүн амын боловсролын түвшин, ажил эрхлэлтийн байдлаас хамаарахгүйгээр өндөр байгааг анхаарч авлигын эсрэг хуулийг олон нийтэд сурталчлах, тэднийг соён гэгээрүүлэх үйл ажиллагааг идэвхтэй өрнүүлэх, авлигын нийгэмд үзүүлэх сөрөг үр дагаврыг ойлгуулах сургалт, сурталчилгааг бүх насныханд тогтмол явуулж байх;

9.Иргэд өөртөө тулгамдаж буй асуудлаа шийдвэрлэхийн тулд амьдрах орчин, эзэмшсэн боловсролоосоо үл хамааран авлига өгөх сонирхол их байгаа ба тэр

дундаа 26-45 насныханд уг сонирхол илүү байдаг байна. Мөн ажил хөдөлмөр эрхэлж буй хүмүүс болон ажил эрхлэлтийн насны ажилгүй иргэд нийгэм-эдийн засгийн харилцаанд идэвхтэй оролцдог тул авлига өгөх сонирхол их байдаг бол оюутан суралцагчид болон тэтгэврийн насныханд уг сонирхол нь харьцангуй бага байна. Авлигад өртсөн иргэн, албан тушаалтан, аж ахуйн нэгж байгууллага, хуулийн этгээдүүдийн талаарх мэдээллийг олон нийтэд нээлттэй мэдээлж, хариуцлагын тогтолцоог чанаржуулах;

10.Авлигаас урьдчилан сэргийлэхэд олон нийтийн оролцоо, хяналт нь авлигатай тэмцэх үйл ажиллагаанд чухал байр суурьтай гэсэн үүднээс “Авлигаас урьдчилан сэргийлэхэд олон нийтийн оролцооны эрх зүйн зохицуулалтын үзэл номлол” бий болгох. Өөрөөр хэлбэл авлигаас урьдчилан сэргийлэхэд олон нийтийн хяналт, оролцооны арга, хэлбэрийг хүлээн зөвшөөрч, тэдгээрийн нууцлал, аюулгүй байдал, хамгаалалтыг хуульчлан зохицуулах нь чухал байна.

## НОМ ЗҮЙ


### I. Олон улсын гэрээ конвенц

1. Палермогийн конвенц 2000 он
2. Терроризмыг санхүүжүүлэхийг хориглох тухай конвенц 1999 он
3. Авлигын эсрэг конвенц 2003 он
4. Меридагийн конвенц
5. ФАТФ буюу Олон улсын санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх байгууллагаас гаргасан 40 зөвлөмж. https://mongolbank.mn/listCMA.aspx?id=6

### II. Ном, сурах бичиг

1. Д.Гантөмөр. Мөнгө угаах гэмт хэргийн эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох асуудал. УБ., 2015 он.
2. Санхүүгийн зохицуулах хороо. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, үл хөдлөх эд хөрөнгө зуучлал, үнэт эдлэлийн зохицуулалтын дүрэм, журмын эмхэтгэл. УБ., 2021 он.
3. Хуульчийн ёс зүйн хууль, дүрэм, журмын эмхэтгэл, УБ хот, 2016 он
4. “Өмгөөлөл судлал” эмхэтгэл, I боть, УБ хот, 2015 он
5. Олон Улсын эрх зүйн сан. “Шударга ёсыг үнэлэх нь Эрүүгийн хэрэгт хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэгчийн чанарыг тодорхойлж, үнэлгээ өгөх нь” УБ., 2016 он
6. Моригива Ясутомо. Хуульчийн ёс зүй. УБ:,2007 он
7. Ж.Төгс-Очир, Ц.Насанбат. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэгтэй тэмцэхэд тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга зам. Гэмт явдалтай тэмцэх асуудал сэтгүүл. 2020 №01 (71)

### III. Гадаад эх сурвалж

1. ECHR case MOR c. France of 15 December 2011; ECHR case Morice / France, April 2015
2. ABA Model Rule 6.1 Voluntary Pro Bono Service.’ Pro Bono and Public Service. Retrieved 2 10. June 2007
3. New York City Bar Association Releases Statement of Pro Bono Principles.’ Retrieved 2 June 11. 2007
4. Killian J McCarthy, “Why Do Some States Tolerate Money Laundering? On the Competition for Illegal Money” in Unger & van der Linde, eds., (2013) 127 at 138.
5. John A Kelley, “International Anti-Money Laundering and Professional Ethics” (2006).
6. 弁護士法. 1933年.
7. 外国弁護士による法律事務の取扱いに関する特別措置法. 1986年.
8. なぜ弁護士会の会費は世界一高いのか？（黒猫のつぶやき）
9. 弁護士はどんな仕事をしているの？”. 日弁連子どもページ. 2021年7月30日閲覧。
10. 農林水産省, 経済産業省. 商品先物取引業におけるマネー・ローンダリング及びテロ資金供与対策に関するガイドライン. 2021 年 10 月 19 日.
11. 「弁護士に対する『疑わしい取引』の報告義務の制度化に関する会長声明 （2005 年 11 月 18 日）参照。
12. 柏原千英.「企業統治改革に関する国際機関の援助アプローチ——アジアにおける取組み」（今泉慎也・安倍誠編『東アジア諸国の企業統治と企業法改革』日本貿易振興機構アジア経済研究所.
13. 谷口 栄治. マネーロンダリング・テロ資金対策の 高度化に向けて求められる視点. 2021 年 10 月 14 日 No.2021-033.

## IV. Цахим эх сурвалж


1. Япон улсын Хуульчдын Холбооны албан ёсны цахим хуудас:https://www.nichibenren.or.jp/
2. Америкийн Нэгдсэн улсын Хуульчдын Холбооны албан ёсны цахим хуудас: https://www.americanbarfoundation.org/index.html

Хавсралт №1

# АВЛИГЫН ЭСРЭГ ХУУЛЬД ОРУУЛСАН НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТҮҮД

| № | Огноо | Агуулга |
|---|---|---|
| 1. | 2022 оны 04 сарын 22 өдөр | АВЛИГЫН ЭСРЭГ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ<br>1 дүгээр зүйл.Авлигын эсрэг хуулийн 10 дугаар зүйлийн 10.6 дахь хэсэг, 11 дүгээр зүйлийн 11.1.4 дэх заалт, мөн зүйлийн 11.4 дэх хэсэг, 18 дугаар зүйлийн 18.1.2 дахь заалтын "нийслэл, сум," гэснийг "сум, нийслэл," гэж тус тус өөрчилсүгэй.<br>2 дугаар зүйл.Авлигын эсрэг хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.20 дахь заалтын "Тэргүүлэгчдийн" гэснийг хассугай. |
| 2. | 2021 оны 12 сарын 17 өдөр | АВЛИГЫН ЭСРЭГ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ<br>1 дүгээр зүйл.Авлигын эсрэг хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсгийн "төр, байгууллага, хувь хүний нууцын тухай" гэснийг "Төрийн болон албаны нууцын тухай, Байгууллагын нууцын тухай, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай" гэж, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийн "хувь хүний нууцад хамаарах бөгөөд түүнтэй холбогдох асуудлыг Хувь хүний нууцын тухай[5]" гэснийг"хүний хувийн мэдээлэлд хамаарах бөгөөд түүнтэй холбогдох асуудлыг Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай" гэж, 12.3 дахь хэсгийн "Хувь хүний нууцын тухай" гэснийг "Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай" гэж, 25 дугаар зүйлийн 25.1.2 дахь заалтын "төр, байгууллага, хувь хүний нууцыг" гэснийг "төрийн болон албаны нууц, байгууллагын нууц, хүний эмзэг мэдээллийг" гэж тус тус өөрчилсүгэй.<br>2 дугаар зүйл.Энэ хуулийг Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө. |
| 3. | 2020 оны 12 сарын 31 өдөр | АВЛИГЫН ЭСРЭГ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ<br>1 дүгээр зүйл.Авлигын эсрэг хуулийн 21 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:<br>"21 дүгээр зүйл.Авлигатай тэмцэх газрын дарга, дэд даргыг томилох, тэдгээрийн бүрэн эрхийн хугацаа<br>21.1.Авлигатай тэмцэх газрын даргыг Ерөнхий сайдын санал болгосноор Улсын Их Хурал томилгооны сонсгол хийж 6 жилийн хугацаагаар томилно.<br>21.2.Авлигатай тэмцэх газар дэд даргатай байна. Дэд даргыг Авлигатай тэмцэх газрын даргын санал болгосноор Улсын Их Хурал томилгооны сонсгол хийж 6 жилийн хугацаагаар томилно.<br>21.3.Авлигатай тэмцэх газрын дарга, дэд дарга энэ хуулийн 19.1-д зааснаас гадна дараах шаардлагыг хангасан байна:<br>21.3.1.Авлигатай тэмцэх газрын дарга төрийн албанд 15-аас доошгүй жил ажилласан, 45 нас хүрсэн, эрх зүйч мэргэжилтэй, удирдах болон мэргэжлийн ажлын мэдлэг туршлагатай, сүүлийн 5 жил улс төрийн албан тушаал эрхэлж байгаагүй;<br>21.3.2.Авлигатай тэмцэх газрын дэд дарга төрийн албанд 10-аас доошгүй жил ажилласан, эрх зүйч мэргэжилтэй, гүйцэтгэх болон мөрдөн байцаах ажлын мэдлэг, туршлагатай, сүүлийн 5 жил улс төрийн албан тушаал эрхэлж байгаагүй.<br>21.4.Авлигатай тэмцэх газрын дарга, дэд даргыг нэг удаа улируулан томилж болно.<br>21.5.Авлигатай тэмцэх газрын дарга, дэд даргын бүрэн эрх нь түүнийг томилсон тухай Улсын Их Хурлын шийдвэр гарснаар эхэлж, дараагийн дарга, дэд дарга томилогдсоноор дуусгавар болно. |

| | | |
|---|---|---|
| | | 21.6.Авлигатай тэмцэх газрын дарга, дэд дарга нөхөн томилогдвол түүний бүрэн эрх нь томилогдсон өдрөөс эхлэн энэ хуулийн 21.1, 21.2-т заасан бүрэн эрхийн үлдсэн хугацааг дуустал үргэлжилнэ."<br><br>2 дугаар зүйл.Авлигын эсрэг хуулийн 22 дугаар зүйлийн 22.4 дэх хэсгийн ", эсхүл Монгол Улсын Ерөнхийлөгч Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмжийг" гэснийг хассугай. |
| 4. | 2020 оны 04 сарын 24 өдөр | АВЛИГЫН ЭСРЭГ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ<br><br>1 дүгээр зүйл.Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлийн 18.4.12 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:<br><br>"18.4.12.Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд заасан хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх;"<br><br>2 дугаар зүйл.Энэ хуулийг Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө. |
| 5. | 2019 оны 12 сарын 20 өдөр | АВЛИГЫН ЭСРЭГ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ<br><br>1 дүгээр зүйл.Авлигын эсрэг хуулийн 14 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 14.1.22 дахь заалт нэмсүгэй:<br><br>"14.1.22.Монгол Улсын Ерөнхийлөгчийн болон Монгол Улсын Их Хурлын гишүүнд нэр дэвшигч."<br><br>2 дугаар зүйл.Авлигын эсрэг хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:<br><br>"11.2.Монгол Улсын Ерөнхийлөгчийн болон Монгол Улсын Их Хурлын гишүүнд нэр дэвшигчийн хөрөнгө, орлогын мэдүүлгийг Авлигатай тэмцэх газар бүртгэж, хадгална."<br><br>3 дугаар зүйл.Авлигын эсрэг хуулийн 10 дугаар зүйлийн 10.6 дахь хэсгийн "Монгол Улсын Ерөнхийлөгчид нэр дэвшигч Сонгуулийн ерөнхий хороонд, Улсын Их Хурлын сонгуульд нэр дэвшигч сонгуулийн тойргийн хороонд," гэснийг "Монгол Улсын Ерөнхийлөгчийн болон Монгол Улсын Их Хурлын сонгуульд нэр дэвшигч Авлигатай тэмцэх газарт," гэж, 11 дүгээр зүйлийн 11.4 дэх хэсгийн "Энэ хуулийн 11.2-т заасан сонгуулийн хороо" гэснийг "Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын" гэж тус тус өөрчилсүгэй.<br><br>4 дүгээр зүйл.Энэ хуулийг Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө. |
| 6. | 2019 оны 06 сарын 06 өдөр | АВЛИГЫН ЭСРЭГ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ<br><br>1 дүгээр зүйл.Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1 дэх заалт, 6.5 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:<br><br>1/6 дугаар зүйлийн 6.1.1 дэх заалт:<br><br>"6.1.1.Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 25-29 дүгээр зүйлд заасан нийтлэг үүрэг;"<br><br>2/6 дугаар зүйлийн 6.5 дахь хэсэг:<br><br>"6.5.Авлигаас урьдчилан сэргийлэх талаар аж ахуйн нэгж, байгууллага, иргэн нь Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 30, 31 дүгээр зүйлд заасан эрх, нийтлэг үүргээс гадна дараах үүрэг хүлээнэ:<br><br>6.5.1.төрийн бус байгууллага гишүүнийхээ ёс зүйн дүрмийг батлаж, үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангаа ил тод мэдээлж байх;<br><br>6.5.2.хувийн хэвшлийн байгууллага үйл ажиллагааныхаа ёс зүйн зарчмуудыг тогтоож, дагаж мөрдөх."<br><br>2 дугаар зүйл.Энэ хуулийг Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө. |

| | | |
|---|---|---|
| 7. | 2019 оны 3 дугаар сарын 27-ны өдөр | АВЛИГЫН ЭСРЭГ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ<br>("Төрийн мэдээлэл", 2019 он, №13)<br>1 дүгээр зүйл.Авлигын эсрэг хуулийн 22 дугаар зүйлийн 22.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:<br>"22.4.Авлигатай тэмцэх газрын дарга, дэд дарга гэмт хэрэгт холбогдсон, түүнчлэн энэ хуулийн 31.2-т заасны дагуу баривчлагдсан бөгөөд Улсын ерөнхий прокурор түүний бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх тухай санал, эсхүл Монгол Улсын Ерөнхийлөгч Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмжийг Улсын Их Хуралд оруулсан бол уг саналыг хүлээж авснаас хойш 14 хоногийн дотор хэлэлцэж шийдвэрлэнэ."<br>2 дугаар зүйл.Энэ хуулийг 2019 оны 03 дугаар сарын 27-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө. |
| 8. | 2017 оны 5 дугаар сарын 18-ны өдөр | АВЛИГЫН ЭСРЭГ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ<br>("Төрийн мэдээлэл", 2017 он, №23)<br>1 дүгээр зүйл.Авлигын эсрэг хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.7 дахь заалтын "байцаан шийтгэх" гэснийг "хэрэг хянан шийдвэрлэх" гэж, 18 дугаар зүйлийн 18.6 дахь хэсэг, 24 дүгээр зүйлийн 24.1.2 дахь заалт, 26 дугаар зүйлийн 26.3 дахь хэсгийн "байцаан шийтгэх" гэснийг "хэрэг хянан шийдвэрлэх тухай" гэж, 24 дүгээр зүйлийн 24.1.2 дахь заалтын "хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчийн" гэснийг "мөрдөгчийн" гэж, 30 дугаар зүйлийн 30.6, 30.9 дэх хэсгийн "хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчаар" гэснийг "мөрдөгчөөр" гэж, 30.10 дахь хэсгийн "хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч" гэснийг "мөрдөгч" гэж тус тус өөрчилсүгэй.<br>2 дугаар зүйл.Энэ хуулийг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө. |
| 9. | 2016 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр | АВЛИГЫН ЭСРЭГ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ<br>("Төрийн мэдээлэл", 2016 он, №44)<br>1 дүгээр зүйл.Авлигын эсрэг хуулийн 30 дугаар зүйлийн 30.4 дэх хэсгийн "12" гэснийг "36" гэж өөрчилсүгэй.<br>2 дугаар зүйл.Энэ хуулийг 2016 оны 09 дүгээр сарын 09-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө. |
| 10. | 2016 оны 9 дүгээр сарын 7-ны өдөр | АВЛИГЫН ЭСРЭГ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ<br>("Төрийн мэдээлэл", 2016 он, №37)<br>1 дүгээр зүйл.Авлигын эсрэг хуулийн 30 дугаар зүйлийн 30.4 дэх хэсгийн "36" гэснийг "12" гэж өөрчилсүгэй.<br>2 дугаар зүйл.Энэ хуулийг Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө. |
| 11. | 2016 оны 7 дугаар сарын 21-ний өдөр | АВЛИГЫН ЭСРЭГ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ<br>("Төрийн мэдээлэл", 2016 он, №28)<br>1 дүгээр зүйл.Авлигын эсрэг хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.3 дахь заалтын "сайд" гэсний дараа ", дэд сайд" гэж нэмсүгэй.<br>2 дугаар зүйл.Энэ хуулийг 2016 оны 07 дугаар сарын 21-ний өдөр баталсан Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө. |
| 12. | 2016 оны 2 дугаар сарын 5-ны өдөр | АВЛИГЫН ЭСРЭГ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ<br>("Төрийн мэдээлэл", 2016 он, №09) |

| | | |
|---|---|---|
| | | 1 дүгээр зүйл.Авлигын эсрэг хуулийн 4 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 4.1.9 дэх заалт нэмсүгэй:<br>4.1.9. Ирээдүйн өв сангийн тухай хуулийн 4.1.7-д заасан Ирээдүйн өв сан корпорацийн эрх бүхий албан тушаалтан, хяналтын зөвлөлийн гишүүн."<br>2 дугаар зүйл.Энэ хуулийг 2017 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө. |
| 13. | 2015 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр | АВЛИГЫН ЭСРЭГ ХУУЛИЙН ЗАРИМ ХЭСЭГ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ<br>("Төрийн мэдээлэл", 2015 он, №45)<br>1 дүгээр зүйл.Авлигын эсрэг хуулийн 29 дүгээр зүйлийн<br>2 дугаар зүйл.Энэ хуулийг 2016 оны 01 дүгээр сарын 01-ний эхлэн дагаж мөрдөнө. |
| 14. | 2015 оны 10 дугаар сарын 30-ны өдөр | АВЛИГЫН ЭСРЭГ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ<br>("Төрийн мэдээлэл", 2015 он, №43)<br>1 дүгээр зүйл.Авлигын эсрэг хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.3 дахь заалтын дэд сайд гэснийг хассугай.<br>Хэвлэх<br>2 дугаар зүйл.Энэ хуулийг 2015 оны 10 дугаар сарын 30-ны өдөр баталсан Монгол Улсын 2015 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө. |
| 15. | 2015 оны 5 дугаар сарын 29-ний өдөр | АВЛИГЫН ЭСРЭГ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ<br>("Төрийн мэдээлэл", 2015 он, №25)<br>1 дүгээр зүйл.Авлигын эсрэг хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсгийн Төрийн мэдээлэл эмхтгэлд хэвлэн нийтлэх ба" гэснийг хассугай.<br>Хэвлэх<br>2 дугаар зүйл.Энэ хуулийг Хууль тогтоомжийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө. |
| 16. | 2014 оны 1 дүгээр сарын 24-ний өдөр | АВЛИГЫН ЭСРЭГ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ<br>("Төрийн мэдээлэл", 2014 он, №05)<br>1 дүгээр зүйл.Авлигын эсрэг хуульд доор дурдсан агуулгатай дараах зүйл, хэсэг, заалт нэмсүгэй:<br>1/$2^1$дүгээр зүйл:<br>"$2^1$дүгээр зүйл.Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр<br>$2^1$.1.Улсын Их Хурал Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр батлах бөгөөд түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрт заасан хугацаагаар батална."<br>2/6 дугаар зүйлийн 6.1.14 дэх заалт:<br>"6.1.14.энэ хуулийн $2^1$дүгээр зүйлд заасан Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг төрийн байгууллага, албан тушаалтан биелүүлэх, биелэлтийг холбогдох байгууллагад тайлагнах."<br>3/30 дугаар зүйлийн 30.9, 30.10 дахь хэсэг:<br>30.9.Авлигатай тэмцэх газарт гүйцэтгэх ажилтан, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчаар ажилласан хугацааг цэргийн алба хаасан хугацаанд тооцно. |

| | | |
|---|---|---|
| | | 30.10.Авлигатай тэмцэх газрын хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, гүйцэтгэх ажилтан тусгай ажиллагаанд оролцохдоо байгууллагын бэлгэ тэмдэг бүхий зориулалтын хувцас хэрэглэх бөгөөд уг хувцасны загварыг Авлигатай тэмцэх газрын дарга батална."<br><br>2 дугаар зүйл.Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.11 дэх заалтын "шат дамжлагыг цөөрүүлэх" гэсний дараа ", энэ чиглэлээр өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх;" гэж, мөн зүйлийн 6.6 дахь хэсгийн "шийдвэрийг" гэсний өмнө "хууль ёсны шаардлага," гэж, "байгууллага" гэсний дараа ", албан тушаалтан," гэж, 13 дугаар зүйлийн 13.8.3 дахь заалтын "бууруулах" гэсний дараа ", эсхүл албан тушаалын цалингийн хэмжээг гурван сар хүртэл хугацаагаар 30 хувиар бууруулах" гэж, 18 дугаар зүйлийн 18.4.11 дэх заалтын "шилжүүлэх" гэсний дараа ", энэ хуулийн 6.6, 7.1.7, 7.1.8-д заасан зөрчлийг хянан шалгаж, эрх бүхий байгууллагад хүргүүлэх" гэж, 18.4.15 дахь заалтын "хяналт тавих," гэсний дараа "шалгах," гэж тус тус нэмсүгэй.<br><br>3 дугаар зүйл.Авлигын эсрэг хуулийн дараах зүйл, хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:<br><br>1/4 дүгээр зүйл:<br><br>"4 дүгээр зүйл.Хуулийн үйлчлэлд хамаарах этгээд<br><br>4.1.Доор дурдсан этгээд энэ хуулийн үйлчлэлд хамаарна:<br><br>4.1.1.төрийн улс төрийн, захиргааны, тусгай албаны удирдах болон гүйцэтгэх албан тушаалтан;<br><br>4.1.2.төрийн үйлчилгээний албаны удирдах албан тушаалтан болон ерөнхий нягтлан бодогч, ахлах нягтлан бодогч;<br><br>4.1.3.төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдах болон компанийн эрх бүхий албан тушаалтан;<br><br>4.1.4.олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн дарга, гишүүн, ерөнхий захирал;<br><br>4.1.5.улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжилт авч төрийн тодорхой чиг үүргийг хууль тогтоомжийн дагуу гүйцэтгэж байгаа төрийн бус байгууллагын удирдах албан тушаалтан;<br><br>4.1.6.Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд нэр дэвшигч;<br><br>4.1.7.бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, төлөөлөгч;<br><br>4.1.8.эрх бүхий байгууллагаас баталсан жагсаалтад заасан албан тушаалтан."<br><br>2/10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсэг:<br><br>"10.2.Мэдүүлэг гаргагч нь өөрийн болон гэр бүлийн гишүүдийн хөрөнгө, орлого, зээлийг үнэн зөв мэдүүлэх үүрэгтэй."<br><br>3/10 дугаар зүйлийн 10.4 дэх хэсэг:<br><br>"10.4.Мэдүүлэг гаргагч энэ хуулийн 10.3-т заасан хугацаанд мэдүүлгээ мэдүүлсний дараа хөрөнгө, орлого нь нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх буюу түүнээс дээш хэмжээгээр өөрчлөгдсөн бол түүнийг тухай бүр 30 хоногийн дотор мэдүүлнэ."<br><br>4 дүгээр зүйл.Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.13 дахь заалтын "дэмжих." гэснийг "дэмжих;" гэж, 13 дугаар зүйлийн 13.8.1, 13.8.2 дахь заалтын "цалинтай" гэснийг "цалин хөлстэй" гэж, 21 дүгээр зүйлийн 21.2.1 дэх заалтын "55" гэснийг "45" гэж тус тус өөрчилсүгэй.<br><br>5 дугаар зүйл.Энэ хуулийг 2014 оны 1 дүгээр сарын 24-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө. |

| | | |
|---|---|---|
| 17. | 2012 оны 5 дугаар сарын 18-ны өдөр | АВЛИГЫН ЭСРЭГ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ<br>("Төрийн мэдээлэл", 2012 он, №23)<br>1 дүгээр зүйл.Авлигын эсрэг хуулийн 4 дүгээр зүйлд дор дурдсан агуулгатай 4.1.6 дахь заалт нэмсүгэй:<br>4.1.6.энэ хуулийн 10.1-д заасан хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргах албан тушаалын жагсаалтад орсон албан тушаалтан."<br>2 дугаар зүйл.Авлигын эсрэг хуулийн дараах хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:<br>1/13 дугаар зүйлийн 13.4 дэх хэсэг:<br>"13.4.Монгол Улсын Их Хурлын гишүүн Засгийн газрын гишүүний албан тушаалыг хавсарч байгаа бол тухайн гишүүний хөрөнгө, орлогын мэдүүлгийг Авлигатай тэмцэх газар шалгана."<br>2/19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэг:<br>"19.1.Авлигатай тэмцэх газрын удирдах болон гүйцэтгэх албан тушаалд мэргэжлийн болон зохих нөхцөл, шалгуурыг хангасан, авлига, албан тушаалын хэргээр шалгагдаж сахилгын, захиргааны, эрүүгийн хариуцлага хүлээж байгаагүй иргэнийг томилно."<br>3 дугаар зүйл.Авлигын эсрэг хуулийн 19 дүгээр зүйлийн 19.5 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.<br>4 дүгээр зүйл.Энэ хуулийг 2012 оны 5 дугаар сарын 18–ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө. |
| 18. | 2012 оны 1 дүгээр сарын 19-ний өдөр | АВЛИГЫН ЭСРЭГ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ<br>("Төрийн мэдээлэл", 2012 он, №08)<br>1 дүгээр зүйл.Авлигын эсрэг хуульд дор дурдсан агуулгатай дараах зүйл, хэсэг нэмсүгэй:<br>1/19 дүгээр зүйлийн 19.5 дахь хэсэг:<br>"19.5.Авлигын болон албан тушаалын хэргээр шалгагдаж сахилгын, захиргааны, эрүүгийн хариуцлага хүлээж байсан этгээдийг Авлигатай тэмцэх газрын удирдах болон гүйцэтгэх албан тушаалд томилохыг хориглоно."<br>2/Зургадугаар бүлгийн $32^1$дүгээр зүйл:<br>"$32^1$дүгээр зүйл.Хуулийн хэрэгжилтэд хяналт тавих этгээд<br>$32^1$.1.Энэ хуулийг холбогдох байгууллага, албан тушаалтан хэрхэн дагаж мөрдөж байгаад дараах байгууллага хяналт тавина:<br>$32^1$.1.1.Авлигатай тэмцэх газар, Шүүхийн ерөнхий зөвлөлийн үйл ажиллагааг Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо;<br>$32^1$.1.2.энэ хуулийн $32^1$.1.1-д зааснаас бусад төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагааг Авлигатай тэмцэх газар;<br>$32^1$.1.3.Олон нийтийн зөвлөл нь Авлигатай тэмцэх газрын хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт болон гүйцэтгэх ажил явуулахаас бусад үйл ажиллагаанд хяналт тавих."<br>2 дугаар зүйл.Авлигын эсрэг хуулийн дараах зүйлийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:<br>1/7, 8 дугаар зүйл:<br>"7 дугаар зүйл.Хориглох зүйл<br>7.1.Энэ хуулийн 4.1-д заасан этгээдэд бусад хууль тогтоомжид тусгайлан хориглосноос гадна авлигын дараах зөрчлийг хориглоно: |

| | | |
|---|---|---|
| | | 7.1.1.албан үүргээ зохих ёсоор гүйцэтгэж байгаа төрийн албан хаагчид дарамт, шахалт үзүүлэх, хөндлөнгөөс оролцох, нөлөөлөх;<br>7.1.2.бусдад шан харамж өгөх, өгөхөөр амлах, зуучлах;<br>7.1.3.албан үүргээ гүйцэтгэхдээ хууль бусаар аливаа хувь хүн, хуулийн этгээдэд давуу байдал олгох, олгохоор амлах, бусдын эрхийг хязгаарлах;<br>7.1.4.төсвийн болон хандив, тусламжийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах;<br>7.1.5.албан үүргээ гүйцэтгэх, эсхүл гүйцэтгэхгүй байхтай холбогдуулан бусдаас шан харамж шаардах;<br>7.1.6.албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулах, хэтрүүлэх;<br>7.1.7.албан тушаалын байдлаа ашиглан эд хөрөнгө олж авах, давуу эрх эдлэх;<br>7.1.8.үндэслэлгүйгээр хөрөнгөжих.<br>8 дугаар зүйл.Авлигын тухай мэдэгдэх<br>8.1.Энэ хуулийн 4.1-д заасан этгээд албан үүрэг гүйцэтгэх явцдаа олж мэдсэн авлигын талаарх мэдээллийг Авлигатай тэмцэх газарт нэн даруй мэдээлэх үүрэгтэй.<br>8.2.Энэ хуулийн 8.1-д заасан мэдээлэх үүргийг хэрэгжүүлэхэд төр, байгууллага, хувь хүний нууцын тухай хуулиар тогтоосон хязгаарлалт хамаарахгүй."<br>2/10, 11 дүгээр зүйл:<br>"10 дугаар зүйл.Хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргах<br>10.1.Энэ хуулийн 4.1-д заасан этгээд /цаашид "мэдүүлэг гаргагч" гэх/ хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргах бөгөөд шаардлагатай тохиолдолд Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо Авлигатай тэмцэх газрын саналыг үндэслэн хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргах албан тушаалын жагсаалтыг батална.<br>10.2.Хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргагч нь хөрөнгө орлогын мэдүүлгээ өөрөө үнэн зөв гаргах үүрэгтэй.<br>10.3.Мэдүүлэг гаргагч хөрөнгө, орлогын мэдүүлгээ тухайн албан тушаалд томилогдсон буюу сонгогдсон өдрөөс хойш 30 хоногийн дотор, цаашид тухайн алба хааж байгаа хугацаандаа жил бүрийн 02 дугаар сарын 15-ны дотор шинэчлэн гаргаж энэ хуулийн 11 дүгээр зүйлд заасан байгууллага, албан тушаалтанд өгөх үүрэгтэй.<br>10.4.Хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргасан этгээд энэ хуулийн 10.3-т заасан хугацаанд мэдүүлгээ бүртгүүлсний дараа хөрөнгө орлогод нь зургаан сарын цалинтай тэнцэх буюу түүнээс их хэмжээний өөрчлөлт орсон бол түүнийг 30 хоногийн дотор мэдүүлж бүртгүүлнэ.<br>10.5.Хөрөнгө, орлогын мэдүүлгийг энэ хуулийн 10.3, 10.4-т заасан хугацаанаас хожимдуулж гаргасан нь хүндэтгэн үзэх шалтгаангүй бол гаргаж өгөөгүйд тооцно.<br>10.6.Монгол Улсын Ерөнхийлөгчид нэр дэвшигч Сонгуулийн ерөнхий хороонд, Улсын Их Хурлын сонгуульд нэр дэвшигч сонгуулийн тойргийн хороонд, бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд нэр дэвшигч тухайн аймаг, нийслэл, сум, дүүргийн сонгуулийн хороонд сонгуулийн хуульд заасан хугацаанд тус тус хөрөнгө, орлогын мэдүүлгээ гаргана.<br>10.7.Хөрөнгө, орлогын мэдүүлгийн маягт, түүнийг бүртгэх, хадгалах журмыг Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо батална.<br>11 дүгээр зүйл.Хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хадгалах |

| | | |
|---|---|---|
| | | 11.1.Хөрөнгө, орлогын мэдүүлгийг дараах байгууллага, албан тушаалтан хуульд заасан хугацаанд бүртгэж, хадгална:<br><br>11.1.1.Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн, Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, түүнчлэн Улсын Их Хурал, Монгол Улсын Ерөнхийлөгч, Засгийн газраас томилогддог албан тушаалтны хөрөнгө, орлогын мэдүүлгийг Авлигатай тэмцэх газар;<br><br>11.1.2.Авлигатай тэмцэх газрын удирдах болон гүйцэтгэх албан тушаалтны хөрөнгө, орлогын мэдүүлгийг Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо;<br><br>11.1.3.Үндсэн хуулийн цэцийн гишүүн болон бүх шатны шүүхийн шүүгчийн хөрөнгө, орлогын мэдүүлгийг Шүүхийн ерөнхий зөвлөл;<br><br>11.1.4.Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчийн хөрөнгө, орлогын мэдүүлгийг тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын алба;<br><br>11.1.5.бусад албан тушаалтны хөрөнгө, орлогын мэдүүлгийг түүнийг томилсон, эсхүл удирдах эрх бүхий албан тушаалтан.<br><br>11.2.Сонгуулийн ерөнхий хороо Монгол Улсын Ерөнхийлөгчийн, сонгуулийн тойргийн хороо Улсын Их Хурлын, аймаг, нийслэл, сум, дүүргийн сонгуулийн хороо бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд нэр дэвшигчийн хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэж, холбогдох хуульд заасан журмын дагуу Сонгуулийн ерөнхий хороонд хүлээлгэн өгнө.<br><br>11.3.Энэ хуулийн 11.1.4, 11.1.5-д заасан хөрөнгө орлогын мэдүүлгийг бүртгэх эрх бүхий байгууллага, албан тушаалтан энэ хуулийн 10.3-т заасан хугацаанд хөрөнгө, орлогын мэдүүлгийг авч дууссанаас хойш 14 хоногийн дотор хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргах журмын биелэлтийн талаарх тайланг, хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргасан этгээдийн нэрсийн хамт Авлигатай тэмцэх газарт ирүүлнэ.<br><br>11.4.Энэ хуулийн 11.2-т заасан сонгуулийн хороо сонгуулийн нэгдсэн дүн гарсны дараа тухайн сонгуульд сонгогдогчийн хөрөнгө, орлогын мэдүүлгийг санал хураалт дууссанаас хойш 14 хоногийн дотор Авлигатай тэмцэх газарт ирүүлж, хадгалуулна.<br><br>11.5.Авлигатай тэмцэх газар хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргах хууль тогтоомжийн биелэлтийн талаарх мэдээллийг жил бүрийн 4 дүгээр сарын 15-ны дотор Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороонд гаргаж өгнө."<br><br>3/13 дугаар зүйл:<br><br>"13 дугаар зүйл.Хөрөнгө, орлогын мэдүүлгийг хянан шалгах, хариуцлага хүлээлгэх үндэслэл<br><br>13.1.Авлигатай тэмцэх газар энэ хуулийн 11.1.2-т заасНаас бусад албан тушаалтны хөрөнгө, орлогын мэдүүлгийн бүрдүүлэлтэд хяналт тавьж, дүн шинжилгээ хийнэ.<br><br>13.2.Улсын Их Хурлын гишүүний хөрөнгө, орлогын мэдүүлгийг Улсын Их Хурлын Ёс зүйн дэд хороо, энэ хуулийн 11.1.2-т заасан хөрөнгө, орлогын мэдүүлгийг Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо тус тус өргөдөл, гомдолд үндэслэн шалгах бөгөөд эрүүгийн хариуцлага хүлээлгэх зөрчил илэрвэл зохих байгууллагад шилжүүлнэ.<br><br>13.3.Хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх эрх бүхий албан тушаалтан мэдүүлэг засваргүй, бүрэн гүйцэд бөглөгдсөн, хугацаандаа өгсөн эсэхэд хяналт тавьж, мэдүүлгийг зохих журмын дагуу гаргаж өгөхийг шаардах, хууль зөрчсөн гэж үзэх үндэслэл байвал бүрэн эрхийнхээ хүрээнд хянан шалгах буюу Авлигатай тэмцэх газарт шилжүүлэн шалгуулах үүрэгтэй.<br><br>13.4.Улсын Их Хурлын гишүүн Засгийн газрын гишүүний албан тушаалыг хавсарч байгаа бол хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргах, хянаж, шалгуулах нь 11.1.1-д заасан журмаар зохицуулагдана. |

| | | |
|---|---|---|
| | | 13.5.Авлигатай тэмцэх газар өргөдөл, гомдол, мэдээллийн мөрөөр, эсхүл төлөвлөгөөт хяналтаар шалгалт явуулж болно.<br><br>13.6.Энэ хуулийн 4.1-д заасан этгээд хөрөнгө, орлогын мэдүүлгээ хугацаанд нь гаргаж өгөөгүй, эсхүл эх үүсвэрийг нь заагаагүй буюу түүнийг хэрхэн олсон талаар тайлбар гаргаагүй бол Авлигатай тэмцэх газар тухайн мэдүүлэг гаргагчийн хөрөнгө, орлогын мэдүүлгийг шалгана.<br><br>13.7.Мэдүүлэг гаргагч хөрөнгө, орлогын эх үүсвэрээ бодитой, үнэн зөв тайлбарлах үүрэгтэй.<br><br>13.8.Мэдүүлэг гаргагч хөрөнгө, орлогын мэдүүлгээ хугацаа хожимдуулж гаргасан, эсхүл бүртгүүлээгүй буюу худал мэдүүлсэн бол дараах хариуцлага хүлээлгэнэ:<br><br>13.8.1.нэг сарын цалинтай тэнцэх хэмжээний хөрөнгө, орлогыг мэдүүлээгүй буюу худал мэдүүлсэн, хөрөнгө, орлогын мэдүүлгийг энэ хуулийн 10.4, 10.5-д заасан хугацаанаас хожимдуулсан нь хүндэтгэн үзэх шалтгаантай бол сануулах;<br><br>13.8.2.зургаа хүртэл сарын цалинтай тэнцэх хэмжээний хөрөнгө, орлогыг мэдүүлээгүй буюу худал мэдүүлсэн, хөрөнгө, орлогын мэдүүлгээ удаа дараа хугацаа хожимдуулж гаргасан бол албан тушаалын цалингийн хэмжээг гурван сар хүртэл хугацаагаар 3О хувиар бууруулах;<br><br>13.8.3.зургаан сараас дээш нэг жил хүртэлх хугацааны цалинтай тэнцэх хэмжээний хөрөнгө, орлогыг мэдүүлээгүй буюу худал мэдүүлсэн бол албан тушаал бууруулах;<br><br>13.8.4.нэг жилийн цалинтай тэнцэх буюу түүнээс их хэмжээний хөрөнгө, орлогыг мэдүүлээгүй, худал мэдүүлсэн, эсхүл хөрөнгө, орлогын мэдүүлгийг гаргаж өгөөгүй, гаргахаас татгалзсан бол албан тушаалаас нь огцруулах буюу ажлаас халах.<br><br>13.9.Хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хяналт тавих үүргээ биелүүлээгүй, эсхүл холбогдох материалыг энэ хуулийн 10.3-т заасан хугацаанд ирүүлээгүй албан тушаалтныг эрх бүхий байгууллага, албан тушаалтан албан тушаалын цалингийн хэмжээг гурван сар хүртэл хугацаагаар 30 хувиар бууруулах, уг зөрчлийг удаа дараа гаргасан бол албан тушаал бууруулах сахилгын шийтгэл ногдуулна."<br><br>4/ 33 дугаар зүйл:<br><br>"33 дугаар зүйл.Авлигын эсрэг хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага<br><br>33.1.Авлигын эсрэг хууль тогтоомжийг зөрчсөн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол эрх бүхий байгууллага, албан тушаалтан дараах хариуцлага хүлээлгэнэ:<br><br>33.1.1.энэ хуулийн 8.1-д заасан мэдээлэх үүргээ биелүүлээгүй этгээдийн албан тушаалын цалингийн хэмжээг гурван сар хүртэл хугацаагаар 30 хувиар бууруулах;<br><br>33.1.2.энэ хуулийн 8.1-д заасан мэдээлэх үүргээ удаа дараа биелүүлээгүй, эсхүл энэ хуулийн 7.1-д заасныг зөрчсөн этгээдэд албан тушаал бууруулах, хэрэв албан тушаалыг нь бууруулах боломжгүй албан тушаал бол албан тушаалын цалингийн хэмжээг гурван сар хүртэл хугацаагаар 30 хувиар бууруулах, авлигын зөрчилтэй нөхцөлд гарсан шийдвэр байгаа бол түүнийг хүчингүй болгох;<br><br>33.1.3.энэ хуулийн 7.1-д заасныг удаа дараа зөрчсөн этгээдийг төрийн албанаас халах, авлигын зөрчилтэй нөхцөлд гарсан шийдвэр байгаа бол түүнийг хүчингүй болгох;<br><br>33.2.Шүүгч энэ хуулийн 7.1.7, 7.1.8-д заасныг зөрчсөн этгээдийн тухайн олсон эд хөрөнгө, орлогыг хураах буюу давуу эрхийг хүчингүй болгох." |

| | | |
|---|---|---|
| | | 3 дугаар зүйл.Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.9-д заасан "150000-200000" гэснийг "шүүгч нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэгээс тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний" гэж өөрчилсүгэй.<br><br>Хэвлэх<br><br>4 дүгээр зүйл.Энэ хуулийг Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө. |
| 19. | 2008 оны 5 дугаар сарын 29-ний өдөр | АВЛИГЫН ЭСРЭГ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ<br><br>("Төрийн мэдээлэл", 2008 он, №21)<br><br>1 дүгээр зүйл.Авлигын эсрэг хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-ийн хэлэлцэнэ. гэснийг мэдээлнэ. гэж өөрчилсүгэй.<br><br>2 дугаар зүйл.Авлигын эсрэг хуулийн 13 дугаар зүйлийн 13.3-ын аливаа гэснийг хассугай.<br><br>3 дугаар зүйл.Энэ хуулийг батлагдсан өдрөөс буюу 2008 оны 5 дугаар сарын 29-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө. |

**Хавсралт №2**

## АВЛИГЫН ЭСРЭГ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН НИЙЦЭЛ, ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГА, ЗОРИЛГОТОЙГОО НИЙЦЭЖ БАЙГАА ЭСЭХ ДҮН ШИНЖИЛГЭЭ

**2022.06.01.**

| Үйл ажилла-гааны чиглэл | Авлигын эсрэг хуулийн холбогдох зүйл заалт | Хууль тогтоомжийн нийцэл,<br>хэрэгцээ, шаардлага, зорилготойгоо нийцэж байгаа эсэх | | Хэрэгжилтийн үр нөлөө буюу зорилгод хүрсэн, хүлээн зөвшөөрөгдсөн байдал, түүнийг хэрэгжүүлэхэд гарч байгаа эерэг, сөрөг үр дагавар |
|---|---|---|---|---|
| АВЛИГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА | 6.1. энэ хуулийн 3.1.6-д заасан арга хэмжээг хэрэгжүүлэх чиглэлээр ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА дараах нийтлэг үүрэг хүлээнэ | ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ХУУЛЬ<br>25 дугаар зүйл.Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар Засгийн газрын бүрэн эрх<br>25.1.Засгийн газар гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:<br>25.1.1.гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх нэгдсэн бодлого, чиглэлийг тодорхойлж хэрэгжүүлэх;<br>25.1.2.гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор тодорхой харилцааг зохицуулсан хэм хэмжээний акт батлах;<br>25.1.3.гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тогтолцооны үр нөлөөг сайжруулах, энэ чиглэлээр хэрэгжүүлэх үйл ажиллагааг | АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР[46]<br>4.1.5.Шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагын шударга, ил тод, хараат бус байдлыг бэхжүүлэх, авлигын эсрэг хамтын ажиллагааг сайжруулах зорилтыг хангах чиглэлээр дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:<br>4.1.5.1.шүүх эрх мэдлийн байгууллагыг улс төрийн нам, бүлгээс хараат бус ажиллах, шүүгч, прокурорыг сонгон шалгаруулах, томилох үйл явцыг улс төрийн оролцоо, нөлөөллөөс ангид, шударга, ил тод явуулах чиглэлээр эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох;<br>...4.1.5.4.авлига, албан тушаалын гэмт хэргийн шийдвэрлэлтийн мэдээлэлд дүгнэлт | 1. УИХ-ын 2020 оны 08 сарын 28 өдрийн 24 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4 дүгээр бүлгийн 4.2.1-д “Засаглалын бодлогын хүрээнд “Мэргэшсэн,хариуцлагатай төрийн албыг бэхжүүлэх, Төрийн байгууллагуудын үйл ажиллагааны давхардлыг арилгах, төрийн чиг үүргийн уялдааг хангах замаар бүтэц, зохион байгуулалтыг оновчтой, цомхон болгох зорилтын хүрээнд төрийн бүх шатанд байгаа авлигыг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх хөтөлбөр хэрэгжүүлж, авлигын гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг нэмэгдүүлж, төр иргэдийн мэдээлэл солилцох тогтолцоог боловсронгуй болгоно.” хэмээн зааж, хөтөлбөрийг |

[46] Авлигатай тэмцэх газраас “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-г иргэд, олон нийтээр хэлэлцүүлж, тэдний саналыг тусган боловсруулж, Засгийн газрын 2017 оны 4 дүгээр сарын 12-ны өдрийн 114 дүгээр тогтоолоор баталсан.

| | | | | |
|---|---|---|---|---|
| | 6.1.1.Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 25-29 дүгээр зүйлд заасан нийтлэг үүрэг; | боловсронгуй болгох, хууль тогтоомжийн төсөл боловсруулах;<br>25.1.4.гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар энэ хуулийн 6.1.1, 6.1.2, 6.1.4-т заасан чиглэлийг хэрэгжүүлэх арга хэмжээний хөтөлбөр, төлөвлөгөөг батлах;<br>25.1.5.энэ хуулийн 25.1.4-т заасан хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардлагатай зардлыг жил бүрийн улсын төсөвт тусгаж, Улсын Их Хуралд танилцуулах;<br>25.1.6.гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын нэгдсэн тайлан, мэдээ гаргах, түүнд дүн шинжилгээ хийх болон гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын үр дүнг үнэлэх журмыг батлах;<br>25.1.7.хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний саналыг үндэслэн Зохицуулах зөвлөлийн журам, бүрэлдэхүүнийг батлах;<br>25.1.8.төрийн захиргааны төв болон Засгийн газрын агентлагийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд хяналт тавих;<br>25.1.9.гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр олон улсын хамтын ажиллагааг бэхжүүлэх, мэргэшсэн нэгж, мэргэжилтэн бэлтгэх.<br>25.1.10.энэ хуулийн 8.2.10-т заасан зорчигчийн мэдээллийг урьдчилан авах, харилцан мэдээлэл солилцох, түүний аюулгүй байдлыг хангах журам батлах.<br>25.2.Засгийн газар нутгийн захиргааны байгууллагад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд дэмжлэг үзүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. | хийх тогтолцоог бүрдүүлэх, энэ талаархи эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох;<br>4.1.5.16.хууль тогтоомж болон захиргааны хэм хэмжээний актын төсөлд авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр санал, зөвлөмж гаргах тогтолцоог бүрдүүлэх;<br>...4.1.6.Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилтыг хангах чиглэлээр дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:<br>4.1.6.1.хувийн хэвшлийн байгууллагуудын авлигын эсрэг сүлжээний үйл ажиллагааг дэмжих, дэлхийн эдийн засгийн форумын авлигын эсрэг түншлэлийн хамтын ажиллагааг идэвхжүүлэх;<br>4.1.6.2.хувийн хэвшлийн байгууллагуудыг чадавхжуулж, төрийн зарим чиг үүргийг гүйцэтгүүлэх боломжийг судлан хэрэгжүүлэх, төр, хувийн хэвшлийн түншлэлийн заагийг тодорхойлох;<br>4.1.6.3.төр, хувийн хэвшлийн болон хувийн хэвшил хоорондын авлигаас урьдчилан сэргийлэх хамтын ажиллагааг өргөжүүлж, аливаа санал, санаачилгыг дэмжиж, хамтран ажиллах;<br>4.1.6.4.картель, шударга бус өрсөлдөөнийг хязгаарласан эрх зүйн орчинг сайжруулах;<br>...4.1.7.Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд иргэд, олон нийтийн хяналт, иргэний нийгмийн байгууллагын үүрэг, оролцоог нэмэгдүүлэн, идэвх санаачилгыг дэмжих зорилтыг хангах чиглэлээр дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ: | хэрэгжүүлэх төлөвлөгөөнд тусгай арга хэмжээ болж тодорхойлсон байна.<br>2. Засгийн газрын 2015 оны 346 дугаар тогтоолоор "Гэрч, хохирогчийг хамгаалах, туслалцаа үзүүлэх үндэсний хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг жил бүрийн улсын төсвийн төсөлд тусгах, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг татан оролцуулах, хандивлагч орон, олон улсын байгууллагын зээл, тусламжид хамруулах замаар санхүүжүүлэх арга хэмжээ авч, хэрэгжилтийг зохион байгуулан хяналт тавьж ажиллахыг АТГ-т зөвлөсөн.<br>3. Засгийн газрын 2017 оны 114 дүгээр тогтоолоор "Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-г баталсан.<br>4. Засгийн газрын 2021 оны 247 дугаар тогтоолоор "Цахим засаглалд шилжих, хүнд суртал, авлигагүй төрийн үйлчилгээг бүрдүүлэх үндэсний хорооны бүрэлдэхүүн"-ийг баталсан. |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | 26 дугаар зүйл.Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний бүрэн эрх<br><br>26.1.Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:<br><br>26.1.1.төрийн захиргааны төв, нутгийн захиргааны болон шүүх, прокурор, хууль сахиулах бусад байгууллагаас гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаар зохион байгуулж байгаа ажлыг уялдуулан зохицуулах, Зохицуулах зөвлөлийг удирдах;<br><br>26.1.2.гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн биелэлтэд эрх хэмжээнийхээ хүрээнд хяналт тавих, шалгах;<br><br>26.1.3.шүүх, прокурор, цагдаа болон хууль сахиулах бусад байгууллагатай зөвшилцөн улсын хэмжээнд гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаар авах арга хэмжээний хөтөлбөр, төлөвлөгөөний төслийг боловсруулж, Засгийн газарт хүргүүлэх;<br><br>26.1.4.гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаар зөвлөмж гаргах;<br><br>26.1.5.гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх асуудлаар гадаад улстай хамтын ажиллагааг хөгжүүлэх;<br><br>26.1.6.гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан, нөхцөлийг судлах эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг зохион байгуулах. | 4.1.7.1.төрийн бодлого боловсруулах, хэлэлцэх, батлах зэрэг шийдвэр гаргах бүх шатанд тухайн асуудлаар үйл ажиллагаа явуулдаг иргэний нийгмийн байгууллагыг татан оролцуулах замаар авлигатай тэмцэх, авлигаас урьдчилан сэргийлэхэд иргэний нийгмийн байгууллагын оролцоог дэмжих;<br><br>...4.1.11.Авлигатай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны хүрээнд олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх, олон улсын байгууллагын санал, зөвлөмжийг авч хэрэгжүүлэх зорилтыг хангах чиглэлээр дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:<br><br>4.1.11.1.Авлигын эсрэг Нэгдсэн Үндэстний Байгууллагын /цаашид “НҮБ” гэх/ конвенцийг эрх зүйн харилцан туслалцааны үндэслэл болгон хэрэглэх, эрх зүйн харилцан туслалцааны гэрээг бусад улс оронтой байгуулах ажлыг эрчимжүүлэх, дотоодын байгууллагуудын үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулах;<br><br>4.1.11.2.Авлигын эсрэг НҮБ-ын конвенцийг хэрэгжүүлэх чиглэлээр НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх алба болон бусад олон улсын байгууллагатай хамтран ажиллах;<br><br>4.1.11.3.гадаад улсын авлигатай тэмцэх болон хууль сахиулах байгууллагатай хамтын ажиллагааг өргөжүүлж, авлига, албан тушаалын гэмт хэргийн улмаас гадаад улсад гарсан хөрөнгийг буцаан авахтай холбоотой асуудлыг нарийвчлан зохицуулах;<br><br>4.1.11.4.авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдсэн этгээдийг харилцан шилжүүлэхтэй холбоотой харилцааг нарийвчлан зохицуулах; | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | 4.1.11.5.авлигын эсрэг олон улсын сүлжээ, санал санаачилгыг дэмжиж, хамтын ажиллагааг өргөжүүлэх.<br><br>...5.2.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хоёр дахь үе шат /2020-2023 он/-нд хүрэх үр дүн:<br><br>5.2.1.“Транспарэнси Интернэшнл” байгууллагын судалгаагаар Монгол Улсын авлигын төсөөллийн индексийн үзүүлэлт өмнөх үзүүлэлтээс сайжирсан байх;<br><br>5.2.2.төрийн байгууллагын шударга байдлын үнэлгээ өмнөх үзүүлэлтээс өссөн байх;<br><br>5.2.3.улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээний авлигын төсөөллийн судалгааны дүн сайжирсан байх;<br><br>5.2.4.төрийн үйлчилгээний ил тод, нээлттэй байдал хангагдсан байх;<br><br>5.2.5.улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээнд авлигатай тэмцэх, урьдчилан сэргийлэх тогтолцоог бүрдүүлж, авлига, албан тушаалын гэмт хэрэг, зөрчлийн мэдээллийг шалгах, мэдээлэгчийг хамгаалахад иргэн хяналт тавих бололцоо бүрдсэн байх; | |
| | | ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ХУУЛЬ<br><br>27 дугаар зүйл.Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар төрийн байгууллагын үүрэг<br><br>27.1.Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар бүх шатны төрийн байгууллага энэ хуулийн 30.1-д зааснаас гадна дараах үүрэг хүлээнэ:<br><br>27.1.1.хариуцсан чиг үүрэг, эрх хэмжээнийхээ хүрээнд хууль тогтоомжийг олон нийтэд | Цагдаа, тагнуул, мэргэжлийн хяналт, аудит, онцгой байдал, гааль, татвар зэрэг төрийн байгууллагууд салбарын хууль, эрх хэмжээнийхээ хүрээнд аливаа гэмт хэрэг, зөрчлөөс сэргийлэх, түүний шалтгаан нөхцөлийг тогтоох, түүнийг арилгах талаар мэдэгдэл, зөвлөмж, шаардлага хүргүүлэх зэргээр ажиллаж байна.<br><br>АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | таниулах, иргэдэд хуулийг сахин биелүүлэх дадал бий болгоход чиглэсэн цогц арга хэмжээг авч хэрэгжүүлэх;<br><br>27.1.2.хуульд заасан эрх хэмжээний хүрээнд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар бусад байгууллагад дэмжлэг үзүүлэх, харилцан мэдээлэл солилцох, хамтран ажиллах;<br><br>27.1.3.эрхлэх асуудлынхаа хүрээнд гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг боловсруулж, хэрэгжүүлэх, холбогдох хууль тогтоомжийг мэдээлэх, сурталчлах, сургалт зохион байгуулах;<br><br>27.1.4.эрхэлсэн асуудлынхаа хүрээнд гэмт хэрэг, зөрчил гарч байгаа шалтгаан, нөхцөл, гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэхэд нөлөөлж байгаа хүчин зүйлсийг тогтоож, түүнийг арилгах тухай мэдэгдэл хүргүүлэх, биелэлтэд хяналт тавих;<br><br>27.1.5.хууль тогтоомжид заасан бусад. | ... 4.1.5.3.шүүгч, прокурорын сургалтын хөтөлбөрийг шинэчлэх, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх;<br><br>4.1.5.11.хууль сахиулах байгууллагын алба хаагчийн авлига, албан тушаалын гэмт хэргийг олж илрүүлэх, мөрдөн шалгах, хянан шийдвэрлэх талаархи мэдлэг туршлага, ур чадварыг сайжруулах;<br><br>4.1.5.12.хууль сахиулах байгууллагын алба хаагчийн давтан сургалтын хөтөлбөрийн агуулгад авлига, албан тушаалын гэмт хэрэг, зөрчлийг шийдвэрлэх асуудлыг тусгаж, хэрэгжүүлэх;<br><br>МОНГОЛ УЛСЫН ШҮҮХИЙН ТУХАЙ<br><br>73 дугаар зүйл.Шүүгчийн хараат бус байдлыг хангах, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах<br><br>...73.1.3.авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг хуульд заасны дагуу зохион байгуулах; | |
| | | ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ХУУЛЬ<br><br>28 дугаар зүйл.Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар нутгийн захиргааны байгууллагын үүрэг<br><br>28.1.Нутгийн захиргааны бүх шатны байгууллага гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар дараах үүрэг хүлээнэ:<br><br>28.1.1.нутгийн захиргааны бүх шатны байгууллага өөрийн эрх хэмжээний хүрээнд хэрэгжүүлж байгаа гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг дээд шатны байгууллагаас хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаатай уялдуулан зохион байгуулах; | МОНГОЛ УЛСЫН ЗАСАГ ЗАХИРГАА, НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖ, ТҮҮНИЙ УДИРДЛАГЫН ТУХАЙ<br><br>27 дугаар зүйл.Нэгжийн удирдлагаар төлөөлөн гүйцэтгүүлэх төрийн чиг үүрэг<br><br>27.1.Энэ хуулийн 27.5-д заасан төрийн зарим чиг үүргийг хууль, нийтийн эрх зүйн гэрээний үндсэн дээр засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагаар төлөөлөн гүйцэтгүүлэхээр шилжүүлж болно.<br><br>27.2.Энэ хуулийн 27.1-д заасан нэгжийн удирдлагад төрийн зарим чиг үүргийг төлөөлөн гүйцэтгүүлэхээр шилжүүлэхдээ тухайн чиг үүргийг гүйцэтгэхэд шаардагдах | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | 28.1.2.харьяа нутаг дэвсгэртээ гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг нэгдсэн хөтөлбөр, төлөвлөгөөтэйгөөр зохион байгуулах;<br><br>28.1.3.гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын зардлыг өөрийн төсвөөс тусгайлан төлөвлөж санхүүжүүлэх;<br><br>28.1.4.шүүх, прокурор, хууль сахиулах байгууллагатай хамтран ажиллах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг хэрэгжүүлж байгаа төрийн бус байгууллага, иргэдийн үйл ажиллагаа, санал, санаачилгыг дэмжин туслах;<br><br>28.1.5.харьяа нутаг дэвсгэрийн иргэдэд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар зохион байгуулж байгаа ажлын талаар мэдээлэл өгөх;<br><br>28.1.6.Салбар зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, боловсронгуй болгох;<br><br>28.1.7.нутаг дэвсгэртээ бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн байдалд дүгнэлт хийж, түүний шалтгаан, нөхцөлийг арилгах талаар мэргэжлийн байгууллага, эрдэмтэн, судлаач, шинжээчтэй хамтран ажиллах;<br><br>28.1.8.ажилгүйдэл, ядуурлыг бууруулах, хүүхэд, залуучуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх чиглэлээр идэвх санаачилгатай ажилласан хуулийн этгээд, иргэний үйл ажиллагааг дэмжих;<br><br>28.1.9.нутаг дэвсгэр хариуцсан хууль сахиулах байгууллагын үйл ажиллагааны үр нөлөөнд үнэлэлт, дүгнэлт өгөх;<br><br>28.1.10.хууль тогтоомжид заасан бүрэн эрх, чиг үүргээ хэрэгжүүлэх, шийдвэр гаргахдаа | хөрөнгийн эх үүсвэрийг хамтад нь шийдвэрлэнэ.<br><br>27.3.Өөр өөр шатны засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид төрийн зарим чиг үүргийг төлөөлөн гүйцэтгүүлэхээр шилжүүлэхдээ түүний хүрээ, хязгаарлалтыг нэгж тус бүрээр тодорхойлж, тайлагнах, хяналт тавих журмыг хууль, гэрээнд тодорхой заана.<br><br>27.4.Энэ хуулийн 27.1-д заасны дагуу төрийн зарим чиг үүргийг төлөөлөн гүйцэтгүүлэхээр шилжүүлэхдээ нэгж тус бүрийн чиг үүрэг, онцлогийг харгалзана.<br><br>27.5.Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагаар дараах төрийн чиг үүргийг төлөөлөн гүйцэтгүүлнэ:<br><br>...27.5.21.гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нийгмийн хэв журам сахиулах үйл ажиллагаа;<br><br>58 дугаар зүйл.Багийн Засаг даргын бүрэн эрх<br><br>...58.1.8.гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх ажлыг холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулах, энэ ажилд иргэдийг татан оролцуулах, санал, санаачилгыг нь дэмжих;<br><br>59 дүгээр зүйл.Сумын Засаг даргын бүрэн эрх<br><br>...59.1.10.гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нийгмийн хэв журмыг сахиулах чиглэлээр холбогдох хуулиар олгогдсон бүрэн эрхийг хэрэгжүүлэх;<br><br>61 дүгээр зүйл.Хорооны Засаг даргын бүрэн эрх<br><br>61.1.17.гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх ажлыг холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулах, энэ ажилд иргэдийг татан оролцуулах, санал, санаачилгыг нь дэмжих; | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх бодлого баримтлах;<br>28.1.11.харьяа нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулж байгаа цахим тоглоомын газар, интернэт кафе болон барьцаалан зээлдүүлэх үйлчилгээ эрхлэгчид тавих шаардлага, ажиллах цагийн хуваарийг аймаг, нийслэлийн Засаг дарга баталж, мөрдүүлэх;<br>28.1.12.харьяа нутаг дэвсгэрийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа согтууруулах ундаа үйлдвэрлэх, худалдах, түүгээр үйлчлэх болон мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, тэдгээрийн угтвар бодисыг үйлдвэрлэх, импортлох, худалдах тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдийн үйл ажиллагаанд эрх хэмжээнийхээ хүрээнд хяналт тавих;<br>28.1.13.гэмт хэрэг үйлдэж, ял шийтгүүлж байсан хүнийг гэмт хэрэг, зөрчил үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор ажлын байр бий болгох, хөдөлмөрлөх дадал, туршлага олоход нь дэмжлэг үзүүлэх;<br>28.1.14.нийтийн хэв журмыг сахиулах зорилгоор олон нийтийн байцаагч томилон ажиллуулах;<br>28.1.15.иргэдийн аюулгүй байдлыг хангах зорилгоор нийтийн эзэмшлийн гудамж, талбайд байршуулан ашиглаж байгаа дүрс бичлэгийн техник, хэрэгслийн бүрэн бүтэн байдал, хадгалалтын аюулгүй байдал, хэвийн ажиллах нөхцөл, боломжийг байнгын бүрдүүлж, арчлан хамгаалах, шаардагдах зардлыг хариуцах;<br>28.1.16.хууль тогтоомжид заасан бусад. | 62 дугаар зүйл.Дүүргийн Засаг даргын бүрэн эрх<br>...62.1.9.гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нийгмийн хэв журмыг сахиулах чиглэлээр холбогдох хуулиар олгосон бүрэн эрхийг хэрэгжүүлэх; | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ТУХАЙ ХУУЛЬ<br><br>29 дүгээр зүйл.Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар хууль сахиулах болон төрийн хяналт шалгалтын байгууллагын үүрэг<br><br>29.1.Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар хууль сахиулах болон төрийн хяналт шалгалтын байгууллага дараах үүрэг хүлээнэ:<br><br>29.1.1.гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан, нөхцөлийг илрүүлэх, дүн шинжилгээ хийх, түүнийг арилгах;<br><br>29.1.2.гэмт хэрэг, зөрчил үйлдэж болзошгүй этгээдийг тогтоох, урьдчилан сэргийлэх бүртгэлд хамруулах;<br><br>29.1.3.гэмт хэрэг, зөрчил үйлдэхээр бэлтгэж байгаа этгээдийг олж илрүүлэх, гэмт хэрэг, зөрчлийг таслан зогсоох;<br><br>29.1.4.гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд төрийн бус байгууллага, хуулийн этгээд, иргэдийн оролцоог хангах, хамтран ажиллах;<br><br>29.1.5.гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, хуульд заасан эрх хэмжээний хүрээнд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын тэргүүлэх чиглэлийг тогтоох;<br><br>29.1.6.гэмт хэргийн нөхцөл байдал хүндэрсэн тохиолдолд авах арга хэмжээний төлөвлөгөө гаргах, харьяа нэгж, байгууллага, алба хаагчийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх; | ЦАГДААГИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬ<br><br>10.1.Цагдаагийн байгууллага гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүргийн хүрээнд дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:<br><br>10.1.1.гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг гарсан шалтгаан, нөхцөлийг тогтоох, арилгуулах;<br><br>10.1.2.гэмт хэрэг үйлдэхээр бэлтгэж, завдаж байгаа тухай мэдээллийг хүлээж авах, бүртгэх, олзлох, цуглуулах, олж авмагц таслан зогсоох, учирч болох хор хохирлыг гаргуулахгүй, нэмэгдүүлэхгүй байх арга хэмжээ авах, гэмт хэргийг илрүүлэх;<br><br>10.1.3.гэмт хэрэг гарсан тухай мэдээллийг хүлээн авмагц гэмт хэргийн газрыг хамгаалах, үзлэг хийх, нотлох баримт илрүүлэх, бэхжүүлэх, цуглуулах, гэмт этгээдийг олж тогтоох, эрэн сурвалжлах, баривчлах;<br><br>10.1.4.хуулиар харьяалуулсан гэмт хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах;<br><br>10.1.5.хууль тогтоомжид заасан үндэслэл, журмын дагуу гүйцэтгэх ажил явуулах;<br><br>10.1.6.гүйцэтгэх ажил явуулах эрх бүхий бусад байгууллагатай хамтран ажиллах;<br><br>10.1.7.хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүхээс оргон зайлсан сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, гэмт хэрэг үйлдсэнд сэрдэгдсэн хүнийг эрэн сурвалжлах, баривчлах;<br><br>10.1.8.Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд заасны дагуу гэрч, хохирогчийг хамгаалах;<br><br>10.1.9.шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах; | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | 29.1.7.гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар хууль тогтоомж, захиргааны байгууллагын шийдвэрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийх, сайжруулах талаар санал боловсруулах;<br><br>29.1.8.хариуцсан нутаг дэвсгэр, чиг үүргийн хүрээнд гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдалд дүн шинжилгээ тогтмол хийх;<br><br>29.1.9.харьяа нэгж, байгууллага, алба хаагчийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар авч хэрэгжүүлсэн үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт тогтмол өгч, үйл ажиллагааг нь сайжруулах арга хэмжээг авах;<br><br>29.1.10.нутгийн захиргааны байгууллага, хариуцсан нутаг дэвсгэр, чиг үүрэгт хамаарах хуулийн этгээд, түүний албан тушаалтанд гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан, нөхцөл болон түүнийг арилгах тодорхой арга хэмжээний талаар мэдэгдэл, зөвлөмж хүргүүлэх;<br><br>29.1.11.хууль тогтоомжид заасны дагуу ял шийтгүүлсэн этгээдэд хяналт тавих;<br><br>29.1.12.хууль тогтоомжид заасан бусад | 10.1.10.гэмт хэрэг, зөрчил, тэдгээрт шийтгүүлсэн этгээдийн нэгдсэн тоо бүртгэл хөтлөх, лавлагаа гаргах;<br><br>10.1.11.гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр судалгаа, шинжилгээний ажилд мэргэжлийн байгууллага, мэргэжилтний туслалцаа авах, татан оролцуулах.<br><br>68 дугаар зүйл. Цагдаагийн алба хаагчийн эрх, үүрэг<br><br>68.9.Гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан, нөхцөлийг тогтоох, арилгуулах, хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд учирч болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх зорилгоор иргэн, хуулийн этгээдэд хуульд нийцсэн мэдэгдэл, шаардлага хүргүүлж, биелэлтэд хяналт тавина.<br><br>ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ТУХАЙ<br><br>4 дүгээр зүйл.Залуучууд шийдвэр гаргах үйл ажиллагаанд оролцох, нөлөөлөл үзүүлэх<br><br>14.1.2.сайн засаглалыг хөгжүүлэх, авлигатай тэмцэх, түүнийг бууруулах үйл ажиллагаанд залуучуудын оролцоог дэмжих.<br><br>АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР<br><br>...4.1.5.8.авлигын эсрэг үйл ажиллагаанд мэдээллийн орчин үеийн технологийг ашиглах, авлига, албан тушаалын гэмт хэргийн илрүүлэлтэд шинжлэх ухаан, технологийн дэвшилтэт аргыг нэвтрүүлэх; | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | 4.1.5.9.авлига, албан тушаалын гэмт хэрэг, зөрчлийн шийдвэрлэлтэд тавих олон нийтийн хяналтыг сайжруулах зорилгоор хууль сахиулах байгууллагыг нэгдсэн мэдээллийн сантай болгох;<br>4.1.5.10.үйлдэгдэж байгаа авлига, албан тушаалын гэмт хэрэг болон түүний шийдвэрлэлтийн талаар хуульд заасан үндэслэл, журмын дагуу олон нийтэд тогтмол мэдээлэх; | |
| | 6.1.2.тод орхой чиглэлээр бодлого боловсруулах, шийдвэр гаргахын өмнө олон нийтийн анхаарал татаж байгаа мэдээллийг нээлттэй болгох, сонирхогч нийгмийн бүлгүүдэд өөрийн бодлого, байр суурийг танилцуу | ЗӨВЛӨЛДӨХ САНАЛ АСУУЛГЫН ТУХАЙ<br>1 дүгээр зүйл. Хуулийн зорилт<br>1.1.Энэ хуулийн зорилт нь нийтийн эрх зүйн хүрээнд зөвлөлдөх санал асуулгыг энэ хуульд заасан асуудлаар зохион байгуулж төрийн үйл хэрэгт зөвлөлдөх арга хэлбэрээр иргэдийн оролцоог хангахад оршино.<br>3 дугаар зүйл. Хуулийн нэр томьёоны тодорхойлолт<br>3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томьёог доор дурдсан утгаар ойлгоно:<br>3.1.1."зөвлөлдөх санал асуулга" гэж нийтийн ашиг сонирхлыг хөндсөн асуудлаар энэ хуулийн 3.1.3-т заасан этгээд шийдвэр гаргахын өмнө болон түүнийг хэрэгжүүлж, сахин мөрдөж байгаа байдлын талаар тохиолдлын зарчмаар түүвэрлэн сонгосон иргэдээс тусгай бэлтгэсэн асуултаар санал авах замаар иргэдийг төрийн үйл хэрэгт оролцуулах цогц үйл ажиллагааг;<br>...3.1.3."шийдвэр гаргах эрх бүхий этгээд" гэж хууль тогтоох болон гүйцэтгэх эрх мэдлийн бүх шатны байгууллага, хуулиар тусгайлан олгосон бүрэн эрхийн дагуу захиргааны хэм | НИЙТИЙН СОНСГОЛЫН ТУХАЙ ХУУЛЬ<br>...4.2.Нийтийн сонсголыг доор дурдсан асуудлыг хэлэлцэх, шийдвэр гаргахын өмнө зохион байгуулна:<br>4.2.1.эрх бүхий этгээдээс боловсруулах хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний акт;<br>4.2.2.энэ хуульд заасан нийтийн ашиг сонирхлыг хөндсөн асуудал;<br>4.2.3.хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актын хэрэгжилтэд тавих хяналт;<br>4.2.4.татварын хууль тогтоомж болон төсөв батлах, төсвийн орлого ба зарцуулалтад тавих хяналт;<br>4.2.5.Улсын Их Хурлаас томилогдох албан тушаалтны асуудал.<br>4.3.Энэ хуулийн 4.2-т зааснаас бусад асуудлаар нийтийн сонсгол явуулахад энэ хуульд заасан зарчим, журмыг баримтална.<br>6 дугаар зүйл.Сонсгол, сонсголын төрөл, хэлбэр<br>6.1.Аливаа шийдвэр гаргах үйл ажиллагаа нь сонсголын үйл ажиллагаанаас тусдаа байна. | - ажилтнуудын хөдөлмөрлөх эрхэд халдсан шийдвэр гаргах,<br>- төрийн албан хаагчийг орон байраар хангагдахад төрөөс дэмжлэг үзүүлэх эрх зүйн зохицуулалтыг хэрэгжүүлэх журам тодорхой бус,<br>- төрийн байгууллагад “орон сууцны зориулалтаар” газар эзэмшүүлсэн, газар эзэмших эрхийг холбогдох хууль тогтоомж зөрчин иргэн, хуулийн этгээдэд шилжүүлсэн,<br>- газар зохион байгуулалтын үйл ажиллагаанд орон нутгийн удирдлагаас болон улс төрийн зүйл бус нөлөөлөл их байдаг,<br>- хууль бус шийдвэр гаргаж, үйл ажиллагаа явуулсан нь шүүхийн шийдвэрээр тогтоогдсон, хуулиас давсан журам үйлчилдэг,<br>- байгууллагын мэдээллийн самбар дахь мэдээллийн ил тод байдлын хэрэгжилт хангалтгүй, |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | лах, хяналтын тодорхой аргыг дэвшүүлэн хэрэгжүүлэх бололцоо олгох зорилгоор харилцан зөвлөлдөж ажиллах боломжийг бүрдүүлэх; | хэмжээний акт гаргах нийтийн эрх зүйн бусад этгээд, бүх шатны нутгийн өөрөө удирдах байгууллагыг.<br><br>4 дүгээр зүйл. Зөвлөлдөх санал асуулгын зорилго<br><br>4.1.Зөвлөлдөх санал асуулгыг дараахь үндсэн зорилгоор зохион байгуулна:<br><br>4.1.1.нийгэм, эдийн засгийн тулгамдсан асуудлыг иргэдийн туслалцаатай олж илрүүлэх;<br><br>4.1.2.тухайн асуудлын эрэмбэ, түүнийг шийдвэрлэх арга зам, гаргах шийдвэрийн талаар иргэдтэй зөвлөлдөх;<br><br>4.1.3.иргэд, олон нийтэд тулгамдсан асуудлын талаар мэдлэг, мэдээлэл өгөх;<br><br>4.1.4.Монгол Улсын Үндсэн хуулийн Гуравдугаар зүйлд заасан төрийн үйл хэрэгт оролцох иргэдийн оролцоог хангах.<br><br>5 дугаар зүйл. Зөвлөлдөх санал асуулгын зарчим<br><br>5.1.Монгол Улсын Үндсэн хуулийн Гуравдугаар зүйлийг удирдлага болгон зөвлөлдөх санал асуулгыг дараахь зарчмыг баримтлан явуулна:<br><br>5.1.1.хууль дээдлэх;<br><br>5.1.2.иргэний бодитой, шууд оролцоог хангах;<br><br>5.1.3.иргэний үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөг хангах;<br><br>5.1.4.олон талт мэдээллээр тэгш хангах;<br><br>5.1.5.ил тод, нээлттэй байх;<br><br>5.1.6.хараат бус байх; | 6.2.Сонсгол нь дараах төрөлтэй байна:<br><br>6.2.1.хууль тогтоох;<br><br>6.2.2.ерөнхий хяналтын;<br><br>6.2.3.төсвийн хяналтын;<br><br>6.2.4.томилгооны;<br><br>6.2.5.захиргааны хэм хэмжээний болон төлөвлөлтийн;<br><br>6.2.6.орон нутгийн.<br><br>6.2.7.танилцах сонсгол.<br><br>6.2.8.зөвшилцөх сонсгол;<br><br>6.2.9.хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой хяналтын<br><br>6.3.Сонсголыг нээлттэй, хаалттай хэлбэрээр зохион байгуулах бөгөөд хувь хүн, байгууллага, төрийн нууцад хамаарах болон үндэсний аюулгүй байдлыг хангахтай холбоотойгоос бусад асуудлаар сонсголыг хаалттай явуулахыг хориглоно.<br><br>6.4.Энэ хуулийн 6.2.5-д заасан сонсголыг захиргааны хэм хэмжээний актыг батлах, нийтийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргахын өмнө зохион байгуулах бөгөөд уг сонсгол зохион байгуулах нарийвчилсан үндэслэл, журмыг холбогдох хууль болон энэ хуулийн 18.7-д заасан журмаар зохицуулна.<br><br>ЗАХИРГААНЫ ЕРӨНХИЙ ХУУЛЬ<br><br>Гуравдугаар бүлэг. Захиргааны шийдвэр гаргах ажиллагаа. | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | 5.1.7.харилцан зөвлөлдөх;<br><br>5.1.8.үр нөлөөтэй байх. | 11-36 дугаар зүйл | |
| | 6.1.3.төрийн хяналтын үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах; | ТӨРИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬ<br><br>3 дугаар зүйл.Төрийн хяналт шалгалтын тогтолцоо, хүрээ<br><br>3.1.Төрийн хяналт шалгалт нь Улсын Их Хурал, Ерөнхийлөгч,Төрийн аудитын байгууллага болон төрийн захиргааны байгууллагын хяналт шалгалт /цаашид "мэргэжлийн хяналт" гэх/, Үндсэн хуулийн Цэц, шүүх, прокурорын хяналт, нутгийн өөрөө удирдах байгууллагаас энэ хуулийн дагуу хэрэгжүүлэх хяналт шалгалтаас бүрдэнэ.<br><br>3.2.Улсын Их Хурал, Ерөнхийлөгчийн хяналт шалгалт, Үндсэн хуулийн цэц, шүүх, прокурорын хяналт болон Төрийн аудитын үйл ажиллагаатай холбогдсон харилцааг тус тусын хууль тогтоомжоор зохицуулна.<br><br>3.3.Засгийн газар, яам, агентлаг, аймаг, сум, баг, нийслэл, дүүрэг, хорооны Засаг даргын хяналт шалгалт, хууль тогтоомжоор тусгайлан эрх олгогдсон мэргэжлийн хяналт, түүнчлэн нутгийн өөрөө удирдах байгууллагаас энэ хуулийн дагуу хэрэгжүүлэх хяналт шалгалттай холбогдсон харилцааг энэ хуулиар зохицуулна.<br><br>4 дүгээр зүйл.Төрийн хяналт шалгалтын зарчим<br><br>4.1.Төрийн хяналт шалгалт (цаашид "хяналт шалгалт" гэх) хийхэд дараахь зарчмыг баримтална: | НИЙТИЙН МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬ<br><br>8 дугаар зүйл.Нээлттэй мэдээлэл<br><br>8.1.Төрийн үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах, төрийн үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгох зорилгоор мэдээлэл хариуцагчийн чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалт, хүний нөөц, төсөв, санхүү, худалдан авах ажиллагаа, үзүүлж байгаа үйлчилгээ болон хуулиар хаалттай, хязгаарлалттай гэж тогтоосноос бусад мэдээллийг ил тод, нээлттэй байлгана.<br><br>8.2.Мэдээлэл хариуцагч өөрийн чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх дараах мэдээллийг байнга ил тод, нээлттэй байлгана:<br><br>...8.2.3.эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт, үйл ажиллагааны тайлан, мэдээлэл хариуцагчийн үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын тайлан, акт, дүгнэлт, албан шаардлага, зөвлөмж;<br><br>8.10.Мэдээлэл хариуцагчийн үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын тайлан, акт, дүгнэлт, албан шаардлага, зөвлөмж, хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан, ажлын байрны сул орон тоо, мэдээлэл хариуцагчийн зардлаар суралцагчийн талаарх зэрэг бусад мэдээллийг | Жишээ нь Ашигт малтмалын тухай хуулийн хэрэгжилтийн үнэлгээнээс харахад Давхардсан, ач холбогдол багатай олон тооны хяналт шалгалт нь компанийн үйл ажиллагааны тогтвортой байдалд нөлөөлж, хяналт, шалгалт хийж буй ажилтнуудын далд хэлбэрийн ашиг сонирхлыг нэмэгдүүлэх эрсдэл бий болгож байна. Ялангуяа мэргэжлийн хяналтын байгууллага, Засаг дарга нараас хийх төлөвлөгөөт бус хяналт шалгалттай холбоотой авлигын эрсдэл байна. Хуулиар зарим хязгаарлалт хийдэг ч ийм төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийхдээ компаниудад урьдчилан мэдээлэл өгдөггүй, хяналтын удирдамж, арга зүй тодорхойгүй байдаг учраас авлигын эрсдэл үүсэх шалтгаан болдог. Компаниудын зүгээс зөвшөөрөл, хяналт шалгалттай холбоотой хууль эрх зүйн мэдлэг дутмаг байгаа нь хууль бус үйл ажиллагаа явуулах эсвэл хууль бус шалгалт, шахалтанд өртөх, улмаар авлигын эрсдэл бий болгодог.<br><br>Уул уурхайн салбарт ил тод байдлыг хангах, авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, түүнийг гаргахгүй байх нэг чухал зохицуулалт нь АМТХ-ийн 48 дугаар зүйлд заасан ил тод байдлын тайлан юм. Энэхүү зохицуулалт нь практикт үр дүнгээ өгч байгаа учир улам бүр боловсронгуй болгож, илүү үр дүнтэй, бодитой |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | 4.1.1.хүний амь нас, эрүүл мэнд, нийгмийн болон орчны аюулгүй байдал нь бусад аливаа сонирхол, зорилгоос илүүд байх;<br>4.1.2.хяналт шалгалтыг хуульд заасан үндэслэлийн дагуу явуулах бөгөөд энэхүү хяналт шалгалт нь хараат бус, шударга, хяналт шалгалтыг хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагын үйл ажиллагаа нээлттэй, ил тод байх;<br>4.1.3.хяналт шалгалттай холбоотой зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэх бөгөөд хуульд зааснаас бусад тохиолдолд хяналт шалгалтын үйл ажиллагаатай холбоотой аливаа төлбөрийг шалгуулагч этгээдээс шаардахгүй байх;<br>4.1.4.шалгуулагч этгээдэд адил тэгш хандаж, түүний хууль ёсны эрх, ашиг сонирхол, нэр төрийг хүндэтгэн харилцах;<br>4.1.5.хяналт шалгалтыг төлөвлөхдөө тухайн объектын эрсдэлийн ангиллыг үндэслэх;<br>4.1.6.хяналт шалгалтыг зөвхөн хууль болон нийтээр дагаж мөрдөхөөр бүртгэгдсэн эрх зүйн актыг үндэслэн явуулах ба гагцхүү хуулиар эрх олгосон хяналт шалгалтын байгууллага, албан тушаалтан хэрэгжүүлэх;<br>4.1.7.хяналт шалгалтыг давхардуулахгүй бөгөөд төрийн эрх бүхий байгууллагаас хийсэн шинжилгээний дүн, дүгнэлтийг хяналт шалгалтыг хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага харилцан хүлээн зөвшөөрөх. | мэдээлэл хариуцагч тухай бүр нь цахим хуудсандаа байршуулна.<br><br>АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР 4.1.2.4.эрсдэлд суурилсан төрийн хяналт шалгалт болон аж ахуйн нэгжийн дотоод хяналтыг бэхжүүлэх, хяналт шалгалтын 70 хувийг урьдчилан сэргийлэх зорилгоор зохион байгуулах, чиглэлийг цөөрүүлэх замаар төрийн хяналт шалгалтын тогтолцоог боловсронгуй болгох; | хэрэгжих гарцыг нээж, энэхүү харилцааг тусгайлан зохицуулдаг тусгай эрх зүйн актыг батлан гаргах хэрэгцээ шаардлага бий болжээ. |
| | 6.1.4.төсвийн орлого, түүний | ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬ<br>5.1.Төсөв нь Улсын болон Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх бөгөөд төсвийг | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬ<br>9.2.4.Төв банк, хөдөлмөр эрхлэлт, татвар, гааль, нийгмийн даатгал, бүртгэл, гадаадын иргэн, харьяатын асуудал эрхэлсэн төрийн | - худалдан авах ажиллагааг хуульд заасан бүрэлдэхүүнээр зохион байгуулаагүй, |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | зарцуулалт, гадаадын зээл, тусламж, түүний хуваарилалтыг олон нийтэд тухай бүр нь мэдээлэх; | төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад дараах зарчмыг баримтална:<br>...5.1.4.ил тод байдлыг хангасан байх;<br>... 6.5.Энэ хуулийн 5.1.4-т заасан төсвийн ил тод байдлыг хангасан байх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ:<br>6.5.1.төсөв хэлэлцэх, батлах үйл ажиллагааг нийтэд нээлттэй байлгаж, төсвийн төлөвлөгөө, гүйцэтгэл, тайлагналын талаар тогтоосон хугацаанд нийтэд ойлгомжтой, хүртээмжтэй байдлаар мэдээлэх;<br>6.5.2.төсвийг төлөвлөх, бүрдүүлэх, хуваарилах, тайлагнах үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог хангах;<br>6.5.3.төсвийн гүйцэтгэл, зарцуулалт нь батлагдсан төлөвлөгөөний дагуу хэрэгжиж байгаа эсэхэд олон нийт хяналт тавих боломжоор хангах;<br>6.5.4.төрөөс үзүүлж байгаа аливаа ажил, үйлчилгээ, хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, тэдгээрийн хүрээнд худалдан авч байгаа бараа, ажил, үйлчилгээнд олон нийт хяналт тавих боломжоор хангах;<br>6.5.5.хөтөлбөр, төсөл, арга хэмжээний ач холбогдлын эрэмбэ, хэрэгжүүлэх дараалал, арга замыг тодорхойлох шийдвэрт олон нийтийн саналыг харгалзан үзэх;<br>6.5.6.төсвийн асуудлаар иргэд, төрийн бус байгууллагаас гаргасан санал, дүгнэлтийг эрх бүхий этгээд нь шийдвэртээ хэрхэн тусгасан тухай, төсвийн үйл ажиллагаан дахь олон нийтийн оролцоог хангаж ажилласан дүнг тэдэнд тухай бүр мэдээлж байх. | захиргааны байгууллагуудаас хөрөнгө оруулалттай холбоотой дараах мэдээллийг хагас, бүтэн жилээр гаргуулж, хөрөнгө оруулалтын статистик мэдээллийг гаргах:<br>9.2.4.а.хөрөнгө оруулалтын эх үүсвэр, хэмжээ;<br>9.2.4.б.татвар төлөлт;<br>9.2.4.в.ажлын байрын тоо;<br>9.2.4.г.гадаадын иргэний оршин суух зөвшөөрөл;<br>9.2.4.д.гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн тоо;<br>9.2.4.е.бараа, үйлчилгээний импортоор хийсэн хөрөнгийн оруулалтын хэмжээ.<br>9.2.5.хөрөнгө оруулалтыг татах цогц үйл ажиллагаа хэрэгжүүлэх;<br>9.2.6.хөрөнгө оруулагчийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалах чиглэлээр дэмжлэг, үйлчилгээ үзүүлэх;<br>9.2.7.хөрөнгө оруулалтын талаарх эрх зүйн орчин, дотоод зах зээлийн таатай нөхцөлийг хөрөнгө оруулагчид сурталчлах;<br>9.2.8.хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулалтын төлөвлөлт хийхэд дэмжлэг үзүүлэх;<br>9.2.9.хөрөнгө оруулалттай холбоотойгоор төрийн бусад үйлчилгээний талаар зөвлөх болон цахим нэг цонхны үйлчилгээ үзүүлэх;<br>9.2.10.энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан шалгуурыг хангасан хөрөнгө оруулагч хуулийн этгээдэд тогтворжуулах гэрчилгээ олгох;<br>9.2.11.тогтворжуулах гэрчилгээ эзэмшигч хуулийн этгээдийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа нь төслийн бизнес төлөвлөгөө, | - үнэлгээний хорооны гишүүнээр нэг албан тушаалтныг олон давтамжтай ажиллуулдаг,<br>- үндэслэлгүйгээр төлбөр хураамж тогтоосон,<br>- эрүүл мэндийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг хадгалах харилцаанд хувийн ашиг сонирхол үүссэн |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | 10.2.Төсөв, санхүү, эдийн засгийн бодлогын төлөвлөлтийг сайжруулах, түүний тайлагналт, ил тод байдлыг хангах, олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх зорилготой татвар төлөгчдийн төлөөлөл бүхий төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоод болон салбарын эрдэмтдээс бүрдсэн 9 гишүүний бүрэлдэхүүнтэй орон тооны бус төсөв, санхүү, эдийн засгийн үндэсний зөвлөлийг Ерөнхий сайдын дэргэд байгуулж ажиллуулна.<br><br>10.3.Энэ хуулийн 10.2-т заасан үндэсний зөвлөл нь төсвийн төсөл болон улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төслийг хэлэлцэж, санал, дүгнэлтээ Засгийн газарт хүргүүлнэ.<br><br>41 дүгээр зүйл.Төсвийн хэрэгжилтийг зохион байгуулах<br><br>41.7.Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, өөрийн орлого, зарлагын хэмнэлт, тэдгээрийн зарцуулалт, гүйцэтгэлийн ил тод байдлыг хангах, олон нийт, байгууллагын хамт олонд нээлттэй байх шаардлага, нөхцөлийг тогтоосон журмыг Засгийн газар батална.<br><br>68 дугаар зүйл.Орон нутгийн төсөв батлах<br><br>...68.3.Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан тухайн жилийн төсвийг ил тод, олон нийтэд хүртээмжтэй байдлаар мэдээлнэ.<br><br>ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛЬ<br><br>1 дүгээр зүйл.Энэ хуулийн ийн зорилт нь улс, орон нутгийн төсөв, улсын болон орон нутгийн өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн удирдлагыг хэрэгжүүлэх шийдвэр, үйл ажиллагаа ил тод, | техник, эдийн засгийн үндэслэл болон энэ хуулийн 16.2-т заасан хөрөнгө оруулалтаа хийж дуусах хугацааны дагуу явагдаж байгаа байдалд хяналт тавих;<br><br>9.2.12.энэ хуулийн 9.2.11-д заасан чиг үүргээ хэрэгжүүлэх зорилгоор тогтворжуулах гэрчилгээ эзэмшигч хуулийн этгээдийн санхүүгийн тайланг татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас, шаардлагатай тохиолдолд тухайн хуулийн этгээдээс тус тус гаргуулан авах;<br><br>9.2.13.тогтворжуулах гэрчилгээ эзэмшигчийн улсын бүртгэл хөтлөх;<br><br>9.2.14.хөрөнгө оруулалтыг тогтвортой үргэлжлүүлэхэд дэмжлэг үзүүлэх.<br><br>АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР<br><br>2.1.Хөтөлбөрийн зорилтыг хэрэгжүүлэх үе шат<br><br>2.1.3.төсөв, санхүү, аудитын үйл ажиллагааны удирдлага, хяналтыг сайжруулах, ил тод байдлыг хангах, төсвийн хөрөнгө, гадаадын зээл, тусламжийг үр ашигтай, зориулалтын дагуу зарцуулах, хариуцлагыг дээшлүүлэх;<br><br>4.1.3.Төсөв, санхүү, аудитын үйл ажиллагааны ил тод байдлыг хангах, хариуцлагыг дээшлүүлэх буюу төсөв, санхүү, аудитын үйл ажиллагааны удирдлага, хяналтыг сайжруулах, ил тод байдлыг хангах, төсвийн хөрөнгө, гадаадын зээл, тусламжийг үр ашигтай, зориулалтын дагуу зарцуулах, хариуцлагыг дээшлүүлэх чиглэлээр дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ: | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоо /цаашид "шилэн данс" гэх/-г бүрдүүлэхэд оршино.<br><br>3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ<br><br>3.1.Доор дурдсан байгууллага, түүний эд хөрөнгө захиран зарцуулах эрх бүхий албан тушаалтан энэ хуулийн үйлчлэлд хамаарна:<br><br>3.1.1.төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд;<br><br>3.1.2.төрийн өмчит үйлдвэрийн газар;<br><br>3.1.3.хяналтын багц буюу түүнээс дээш хэмжээний хувьцааг нь төр, орон нутаг болон тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд эзэмшиж байгаа компани;<br><br>3.1.4.улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, ажил, үйлчилгээ гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгж, байгууллага;<br><br>3.1.5.төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч.<br><br>3.2.Энэ хуульд дараах төсөв, санхүүгийн үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл, хэрэгжилт, тайлагнал эдгээртэй холбоотой мөнгөн болон бусад гүйлгээ хамаарна:<br><br>3.2.1.улс, орон нутгийн төсөв болон Нийгмийн даатгалын сангийн төсөв;<br><br>3.2.2.орон нутгийн хөгжлийн сан;<br><br>3.2.3.Засгийн газрын тусгай сан;<br><br>3.2.4.төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах үйл ажиллагаа; | 4.1.3.1.улсын болон орон нутгийн төсөв, санхүүгийн удирдлагын тогтолцоог сайжруулах, ил тод, нээлттэй, хариуцлагатай байх зарчмыг мөрдүүлэх;<br><br>4.1.3.2.төсвийн төлөвлөлтийн үр ашигтай байдал, гүйцэтгэл, зарцуулалтын хөндлөнгийн хяналт, хариуцлагыг дээшлүүлэх;<br><br>4.1.3.3.Засгийн газрын тусгай сангийн санхүүжилт, зарцуулалтыг ил тод, хяналттай болгох;<br><br>4.1.3.4.төсвийн төсөл хэлэлцэхэд олон нийтийн оролцоог хангах;<br><br>4.1.3.5.банк, санхүүгийн байгууллагын санхүү, зээлийн бодлогыг боловсронгуй болгож, давуу байдлаа ашиглан иргэн, аж ахуйн нэгжид хүндрэл учруулдаг байдлыг таслан зогсоох;<br><br>4.1.3.6.нийтийн албаны санхүүгийн дотоод аудит, хяналт шалгалтын үйл ажиллагаа, хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгох;<br><br>4.1.3.7.аудитын дүгнэлтийн дагуу авах арга хэмжээ, хариуцлагын тогтолцоог сайжруулах;<br><br>4.1.3.8.аудитын үйл ажиллагааг хараат бус, хуулийн дагуу гүйцэтгэх нөхцөл боломжийг бүрдүүлэх, шаардлагатай зарим тохиолдолд олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн гадаад улсын аудитын хуулийн этгээдийг ажиллуулах эрх зүйн орчинг бий болгох;<br><br>4.1.3.9.төрийн аудитын байгууллагын хараат бус байдал, чадавхийг бэхжүүлэн аудитын чанар, үр нөлөөг дээшлүүлж, авлигаас урьдчилан сэргийлэх нөхцөлийг хангахад дэмжлэг үзүүлэх; | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | 3.2.5.Засгийн газар, орон нутгийн өрийн бичиг, санхүүгийн бусад хэрэгсэл;<br>3.2.6.Засгийн газар, орон нутгийн гадаад болон дотоод зээл, буцалтгүй тусламж;<br>3.2.7.төр, хувийн хэвшлийн түншлэл, концесс;<br>3.2.8.Засгийн газар, орон нутгийн баталгаа болон төсвийн өр, авлага үүсгэх аливаа бусад шийдвэр.<br>3.3.Төрийн нууцад хамаарах төсөв, үндэсний аюулгүй байдлыг хангахтай холбогдсон гүйцэтгэх ажил эрхлэх эрх бүхий байгууллагын гүйцэтгэх ажилтай холбоотой төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, хэрэгжилт, тайлагнал энэ хуульд хамаарахгүй.<br>3.4.Төрийн нууцад хамаарахаас бусад төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, хэрэгжилт, тайлагналыг байгууллагын нууцад хамааруулан нийтэд мэдээлэхээс зайлсхийхийг хориглоно.<br>4 дүгээр зүйл.Шилэн дансны зарчим<br>4.1.Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална:<br>4.1.1.мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх;<br>4.1.2.мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх;<br>4.1.3.тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх;<br>4.1.4.хуулийн дагуу нууцад хамааруулснаас бусад бүх мэдээлэл нээлттэй байх. | 4.1.3.10.төрийн аудитын байгууллагаас хийсэн аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийг олон нийтэд ил тод мэдээлэх тогтолцоог боловсронгуй болгож, нийтийн алба, албан тушаалтны үйл ажиллагаа, түүний үр дүнг иргэд, олон нийтийн хяналтад оруулах. | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | 6.1.5.тухайн байгууллагын чиг үүргийн дагуу зөвшөөрөл, эрх олгох, бүртгэл хийх, хяналт тавих, сонгон шалгаруулалт явуулах зэрэг асуудлыг шийдвэрлэх журмыг хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол олон нийтэд ил тод байлгаж, түүнтэй танилцах боломжоор хангах; | АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ<br>5 дугаар зүйл. Тусгай зөвшөөрлийн үйлчлэх хүрээ<br>5.1. Тусгай зөвшөөрөл шаардах аж ахуйн үйл ажиллагааг хэрэв тусгайлан заасан бол тухайн нутаг дэвсгэрт явуулна.<br>5.2. Тусгай зөвшөөрөл шаардахаас бусад төрлийн аж ахуйн үйл ажиллагааг хууль тогтоомж, стандарт шаардлагад нийцүүлэн, зөвхөн татварын байгууллагад бүртгүүлсний үндсэн дээр чөлөөтэй эрхэлж болно.<br>5.3. Тусгай зөвшөөрлийг хуульд заснаас бусад тохиолдолд бусдад худалдах, бэлэглэх, барьцаалах зэргээр шилжүүлж үл болно.<br>5.4. Тусгай зөвшөөрөл шаардагдах үйл ажиллагааг эрхлэх эрх энэ хуульд заасны дагуу тусгай зөвшөөрлийг авсан өдрөөс үүснэ.<br>6 дугаар зүйл. Тусгай зөвшөөрлийн хугацаа, түүнийг сунгах<br>6.1. Хуульд өөрөөр заагаагүй бол тусгай зөвшөөрлийг 3 жилээс доошгүй хугацаагаар олгоно.<br>6.2. Тусгай зөвшөөрлийг хуульд өөрөөр заагаагүй бол анх олгосон хугацаанаас нь доошгүй хугацаагаар сунгаж болно.<br>6.3. Хэрэв хуульд өөрөөр заагаагүй, энэ хуулийн 13.1-д заасан нөхцөл байдал илрээгүй тохиолдолд зөвхөн зөвшөөрөл эзэмшигчийн өргөдлийг үндэслэн 3 хоногийн дотор тусгай зөвшөөрлийн хугацааг сунгана. | АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР<br>Хоёр. Хөтөлбөрийн зорилт<br>2.1.Энэхүү хөтөлбөрийн 1.1-д заасан зорилгод хүрэхийн тулд дараах зорилтыг үе шаттай хэрэгжүүлнэ:<br>2.1.1.шударга, хариуцлагатай, ил тод нийтийн албыг бэхжүүлэх замаар авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, төрийн жинхэнэ албан хаагчийн сонгон шалгаруулалт болон томилгоонд улс төрийн нөлөөллөөс ангид, мэдлэг, боловсролд суурилсан мерит зарчмыг хэрэгжүүлэх;<br>2.1.2.төрийн үйлчилгээний нээлттэй байдлыг хангаж, цахим үйлчилгээг хөгжүүлж чанар хүртээмжийг нь сайжруулах, үйлчлүүлэгчийн эрх ашгийг дээдэлж, төрийн албан хаагчийн хариуцлагыг дээшлүүлэх;<br>2.1.3.төсөв, санхүү, аудитын үйл ажиллагааны удирдлага, хяналтыг сайжруулах, ил тод байдлыг хангах, төсвийн хөрөнгө, гадаадын зээл, тусламжийг үр ашигтай, зориулалтын дагуу зарцуулах, хариуцлагыг дээшлүүлэх;<br>2.1.4.худалдан авах ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгож, үр ашигтай, шударга, ил тод, нээлттэй байдлыг нэмэгдүүлж, хяналт, хариуцлагыг дээшлүүлэх;<br>4.1.2.Төрийн үйлчилгээний нээлттэй байдлыг хангаж, цахим үйлчилгээг хөгжүүлэх, чанар хүртээмжийг нь сайжруулах, үйлчлүүлэгчийн эрх ашгийг дээдэлж, төрийн албан хаагчийн хариуцлагыг дээшлүүлэх зорилтыг | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | 6.4. Тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг зөрчсөн тохиолдолд тусгай зөвшөөрлийн хугацааг сунгахгүй. | хангах чиглэлээр дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:<br>...4.1.2.2.зөвшөөрөл олгох журмыг хялбарчилж, түүнд тавих хяналтын тогтолцоог бүрдүүлэх, зарим төрлийн зөвшөөрөл олгох, хяналт тавих чиг үүргийг төрийн бус байгууллагад шилжүүлэх; | |
| | 6.1.6.төрийн албан хаагч бүрийн ажил үүргийн хуваарийг тодорхой болгох, эрхэлж байгаа ажлын онцлоготой нь холбогдуулж түүнд хориглох зүйлийг Төрийн албаны тухай хууль болон энэ хуульд заасны дагуу | ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬ<br>22 дугаар зүйл.Төрийн жинхэнэ албан тушаалд тавих нийтлэг шаардлага<br>22.1.3.Эрүүгийн хуульд заасан авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдэж шүүхээр ял шийтгүүлж байгаагүй байх;<br>...2.3.3.Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн жинхэнэ албаны удирдах, гүйцэтгэх албан тушаалд тавигдах тусгай шаардлага болон албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журмыг төрийн албаны төв байгууллага батална.<br>23.4.Төрийн захиргааны албаны албан тушаалын тодорхойлолтыг энэ хуулийн 23.3-т заасан журамд нийцүүлэн боловсруулж, төрийн албаны төв байгууллагын зөвшөөрлийг үндэслэн тухайн албан хаагчийг томилох эрх бүхий этгээд албан тушаал тус бүрээр батална.<br>23.5.Тухайн байгууллагын чиг үүрэгт хууль тогтоомжоор өөрчлөлт орсноос бусад тохиолдолд энэ хуулийн 23.3-т заасан тусгай шаардлага болон албан тушаалын тодорхойлолтод өөрчлөлт оруулахыг хориглоно. | АВЛИГЫН ЭСРЭГ ХУУЛЬ<br>7 дугаар зүйл.Хориглох зүйл<br>7.1.Энэ хуулийн 4.1-д заасан этгээдэд бусад хууль тогтоомжид тусгайлан хориглосноос гадна авлигын дараах зөрчлийг хориглоно:<br>7.1.1.албан үүргээ зохих ёсоор гүйцэтгэж байгаа төрийн албан хаагчид дарамт, шахалт үзүүлэх, хөндлөнгөөс оролцох, нөлөөлөх;<br>7.1.2.бусдад шан харамж өгөх, өгөхөөр амлах, зуучлах;<br>7.1.3.албан үүргээ гүйцэтгэхдээ хууль бусаар аливаа хувь хүн, хуулийн этгээдэд давуу байдал олгох, олгохоор амлах, бусдын эрхийг хязгаарлах;<br>7.1.4.төсвийн болон хандив, тусламжийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах;<br>7.1.5.албан үүргээ гүйцэтгэх, эсхүл гүйцэтгэхгүй байхтай холбогдуулан бусдаас шан харамж шаардах;<br>7.1.6.албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулах, хэтрүүлэх;<br>7.1.7.албан тушаалын байдлаа ашиглан эд хөрөнгө олж авах, давуу эрх эдлэх;<br>7.1.8.үндэслэлгүйгээр хөрөнгөжих. | Салбарын болон төрөлжсөн бусад хуулиудаар хоирглосон хэм хэмжээг тогтоож байгаа<br>Энэ нь Авлигын эсрэг хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д “Энэ хуулийн 4.1-д заасан этгээдэд бусад хууль тогтоомжид тусгайлан хориглосноос гадна авлигын дараах зөрчлийг хориглоно:” гээд 7.1.8-д “үндэслэлгүйгээр хөрөнгөжих. Тайлбар: Албан тушаалтан зургаан сарын албан тушаалын цалин хөлс, орлогоос илүү хөрөнгө, орлогыг хууль ёсны дагуу олсон болохыгоо үндэслэлтэй тайлбарлаж чадахгүй тохиолдолд үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэж үзнэ.” гэжээ.<br>Мөн хуулийн 4 дүгээр зүйлд заасан “Хуулийн үйлчлэлд хамаарах этгээд”-ийн дотор төрийн албан хаагчдаас гадна “төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдах болон компанийн эрх бүхий албан тушаалтан, олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн дарга, гишүүн, ерөнхий захирал, улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжилт авч |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | тогтоон мөрдүүлэх; | 31 дүгээр зүйл.Хориглох зүйл<br><br>31.1.Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн жинхэнэ албан тушаалд дараахь тохиолдолд авч ажиллуулахыг хориглоно:<br><br>31.1.1.энэ хуулийн 22, 23 дугаар зүйлд заасан шаардлагыг хангаагүй;<br><br>31.1.2.төрийн албанаас сахилгын шийтгэлээр болон хууль тогтоомжид заасан үндэслэл, журмаар халагдсан өдрөөс хойш төрийн албанд эргэж орох хуульд заасан хугацаа дуусгавар болоогүй, тодорхой хугацаагаар төрийн жинхэнэ алба хаах эрх хасагдсан иргэний уг хугацаа дуусаагүй;<br><br>31.1.3.хууль тогтоомжоор зөвшөөрснөөс бусад тохиолдолд албан үүргийн хувьд нэг нь нөгөөдөө шууд захирагдах буюу шууд хяналт тавих албан хаагчтай хамаарал бүхий этгээд нь тухайн ажлын албаны нэгжид хамт ажиллахаар бол;<br><br>31.1.4.хууль тогтоомжид заасан бусад тохиолдолд.<br><br>31.2.Энэ хуульд заасан журмын дагуу төрийн албан хаагчийг сонгон шалгаруулж томилоход Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, гишүүн, Ерөнхий сайд, төсвийн ерөнхийлөн захирагч, улс төрийн албан тушаалтан, улс төрийн нам, эвслийн удирдах болон гүйцэтгэх албан тушаалтан, бусад этгээдийн зүгээс аливаа хэлбэрээр нөлөөлөх, дарамт, шахалт үзүүлэхийг хориглоно.<br><br>31.3.Төрийн албан хаагчийг томилох асуудлаар хууль тогтоомж зөрчих, түүнчлэн дээрх үйл ажиллагаатай холбогдсон хуурамч | Тайлбар:Албан тушаалтан зургаан сарын албан тушаалын цалин хөлс, орлогоос илүү хөрөнгө, орлогыг хууль ёсны дагуу олсон болохыгоо үндэслэлтэй тайлбарлаж чадахгүй тохиолдолд үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэж үзнэ.<br><br>...6.3.Шүүх, прокурор, цагдаа, Авлигатай тэмцэх газар, хуульд өөрөөр заагаагүй бол төрийн захиргааны төв байгууллага болон Засгийн газрын агентлаг байрлаж байгаа байранд түүний үйлчилгээг эрхэлдгээс бусад аж ахуйн нэгж, байгууллага байрлахыг хориглоно.<br><br>6.4.Энэ хуулийн 6.3-д заасан байгууллагын байранд улс төрийн болон шашны үйл ажиллагаа явуулахыг хориглоно.<br><br>АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР<br><br>4.1.1.Шударга, хариуцлагатай, ил тод нийтийн албыг бэхжүүлэх замаар авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, төрийн жинхэнэ албан хаагчийн сонгон шалгаруулалт болон томилгоонд улс төрийн нөлөөллөөс ангид, мэдлэг, боловсролд суурилсан мерит зарчмыг хэрэгжүүлэх зорилтыг хангах чиглэлээр дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:<br><br>4.1.1.1.төрийн албаны төв байгууллагын дүгнэлт, хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянасан байдлыг үндэслэн албан тушаалд томилох тухай хуулийн хэрэгжилтийг хангах, хариуцлагыг дээшлүүлэх; | төрийн тодорхой чиг үүргийг хууль тогтоомжийн дагуу гүйцэтгэж байгаа төрийн бус байгууллагын удирдах албан тушаалтан…”, гэх мэт бусад этгээд хамаарахаар, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4-т “нийтийн албан тушаалтан” гэж энэ хуулийн 4.1-д заасан этгээдийг, 4 дүгээр зүйлийн 4.1-д “Энэ хуулийн үйлчлэлд Авлигын эсрэг хуулийн 4 дүгээр зүйлд заасан албан тушаалтан хамаарна.” гэж тус тус заасан.<br><br>Төрийн албаны тухай хууль /шинэчилсэн найруулга/ /2017/-ийн 57 дугаар зүйлийн 57.4-т зааснаар “Улс төрийн болон тусгай албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагч /сум, дүүргийн Засаг дарга, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын орлогч, зэвсэгт хүчин, хилийн цэрэг ба дотоодын цэрэг, онцгой байдал, тагнуул, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тусгай албан тушаалаас бусад/-ийн албан тушаалын цалингийн хэмжээ, сүлжээг төрийн албаны төв байгууллагатай зөвшилцсөний үндсэн дээр Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал тогтооно.”, Компанийн тухай хуульд зааснаар гүйцэтгэх захирал, төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг компанийн дүрмээр, эсхүл хувьцаа эзэмшигчдийн хурлаас тогтоон |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | тодорхойлолт, гэрчилгээ, баталгаа гаргахыг хориглоно.<br><br>31.4.Төрийн тухайн албан тушаалд тавих шаардлагыг хангасан иргэний төрийн жинхэнэ албан тушаал эрхлэх эрхийг үндэс, угсаа, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, нам, олон нийтийн бусад байгууллагын харьяаллаар ялгаварлаж үл болно.<br><br>34 дүгээр зүйл.Хориглох зүйл<br><br>34.1.Төрийн жинхэнэ албаны шалгалт авах журмыг зөрчих, уг үйл ажиллагаатай холбоотой хуурамч тодорхойлолт, гэрчилгээ, баталгаа гаргахыг хориглоно.<br><br>35 дугаар зүйл.Хариуцлага<br><br>35.1.Энэ хуулийн 34.1, 35.2-т заасныг зөрчсөн төрийн албан хаагчийг төрийн албанд гурван жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр хална.<br><br>35.2.Төрийн жинхэнэ албаны шалгалт авах журмыг зөрчсөн этгээдийг энэ хуулийн 33.9-д заасан Шалгалтын зөвлөлийн бүрэлдэхүүнд дахин оруулахгүй.<br><br>39 дүгээр зүйл.Төрийн албан хаагчийн үйл ажиллагаанд хориглох зүйл<br><br>39.1.Төрийн албан хаагч хуульд зааснаас гадна дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно:<br><br>39.1.1.албан тушаалтанд хуульд нийцээгүй үүрэг, даалгавар өгөх, биелүүлэхийг шаардах; | 4.1.1.2.нийтийн албанд томилогдох албан тушаалтны ёс зүй, мэдлэг, боловсрол, туршлага, ур чадварын шалгуурыг олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэх, албан тушаалтныг мэдлэг, боловсролд суурилсан мерит зарчмыг баримтлан томилох, дэвшүүлэх;<br><br>4.1.1.3.олон улсын жишигт нийцсэн гүйцэтгэлийн үнэлгээний нэгдсэн тогтолцоог бүрдүүлж, нийтийн албан тушаалтны үйл ажиллагааг үнэлэх, дүгнэх, хариуцлага тооцох арга, хэлбэрийг шинэчлэн тодорхойлох эрх зүйн зохицуулалтыг бий болгох;<br><br>4.1.1.4.төрийн жинхэнэ албан хаагчийг томилох, чөлөөлөх асуудлыг төрийн өндөр албан тушаалтан болон улс төрийн намын нөлөөллөөс ангид байлгах; | мөрдүүлэх зэргээр харилцан адилгүй зохицуулалттай байна. Тухайлбал,<br><br>Үндэсний статистикийн хорооноос жил тутамд гаргадаг “Статистикийн мэдээллийн нэгдсэн сан”-д байгаа дундаж цалин хөлсний тоон мэдээллээс үзэхэд Төрийн өмчит үйлдвэрийн газарт ажиллагсад 1,211,100 төгрөгийн, Орон нутгийн өмчит үйлдвэрийн газарт 752,400 төгрөгийн, төсөвт байгууллагад 772,800 төгрөгийн, Төрийн өмчийн аж ахуйн нэгжид 935,100 төгрөгийн, Орон нутгийн өмчийн аж ахуйн нэгжид 714,300 төгрөгийн, төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжид 1,075,000 төгрөгийн, төрийн өмчийн оролцоотой гадаадын аж ахуйн нэгжтэй хамтарсан байгууллагад 2,937,800 төгрөгийн, орон нутгийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжид 753,900 төгрөгийн дундаж цалин хөлстэй47 байна.<br><br>Энэхүү цалин хөлсний харилцан адилгүй байдал нь “үндэслэлгүй хөрөнгөжих” зөрчил гаргасан нийтийн албан тушаалтанд Авлигын эсрэг хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2-т заасан “....энэ хуулийн 7.1-д заасныг зөрчсөн этгээдэд албан тушаал бууруулах, хэрэв албан тушаалыг нь бууруулах боломжгүй албан тушаал бол албан тушаалын цалингийн хэмжээг гурван сар хүртэл хугацаагаар 30 хувиар бууруулах,” ...хууль зүйн хариуцлага хүлээлгэхэд учир дутагдалтай буюу Монгол Улсын Үндсэн |

[47] Статистикийн мэдээллийн нэгдсэн сан (2018 оны статистик мэдээлэл. 2019 оны мэдээлэл тавигдаагүй байсан болно.) http://1212.mn/

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | 39.1.2.албаны эрх мэдлээ хэтрүүлэх;<br>39.1.3.хуульд нийцээгүй шийдвэр гаргах;<br>39.1.4.албан тушаалын бүрэн эрхээ урвуулан ашиглах, хувийн ашиг сонирхолдоо нийцүүлэн бусдыг аливаа хэлбэрээр хавчин гадуурхах, эрхшээлдээ байлгах, түүнчлэн дарамт, хүчирхийлэл, бэлгийн дарамт үзүүлэх;<br>39.1.5.улс төрийн намын гишүүн байх, улс төрийн нам, хөдөлгөөн, улс төрийн намын дэргэдэх төрийн бус байгууллага болон шашны байгууллагын үйл ажиллагаанд хуулиар зөвшөөрснөөс бусад тохиолдолд аливаа хэлбэрээр оролцох;<br>39.1.6.Ерөнхийлөгчийн болон Улсын Их Хурал, аймаг, сум, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн сурталчилгаанд аливаа хэлбэрээр оролцох, түүнд зориулалтын бус төсвийн хөрөнгө зарцуулах, төрийн өмч хөрөнгө, албаны унаа ашиглах;<br>39.1.7.ажил хаялт болон төрийн албаны хэвийн үйл ажиллагааг алдагдуулахад чиглэсэн бусад арга хэмжээ төлөвлөх, зохион байгуулах, тэдгээрт оролцох;<br>39.1.8.албан тушаалын бүрэн эрхээ шашны, эсхүл шашингүй үзлийн ухуулга, сурталчилгаа хийхэд ашиглах;<br>39.1.9.Монгол Улсын Ерөнхийлөгчийн зөвшөөрөлгүйгээр гадаад орны төрийн дээд цол, одон, медаль, төрийн бусад шагнал авах;<br>39.1.10.Монгол Улсын олон улсын гэрээнд заасан болон Монгол Улс, гадаад улсын төрийн байгууллагын хооронд харилцан тохиролцсон албан томилолт болон ажиллаж | | хуулийн “Арван дөрөвдүгээр зүйл”-ийн 1-д заасан “.Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.”, 2-т заасан “Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно.” гэсэн зарчим алдагдахад хүргэж байна.<br>Иймд Монгол Улсын Үндсэн хуульд заасан болон хариуцлага гарцаагүй байх, зөрчил үйлдэгдсэн нөхцөл байдал, зөрчлийн шинж, хохирлын хэр хэмжээнд тохирсон байх зарчмыг баримтлан нийтийн албан тушаалтны “үндэслэлгүй хөрөнгөжих” зөрчлийн шинжийг тэдгээрийн албан тушаалын цалин хөлсний орлогоор бус хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй уялдуулан, хариуцлага хүлээлгэх нь зүйтэй байна. |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | байгаа байгууллагын эрх бүхий албан тушаалтны зөвшөөрснөөс бусад тохиолдолд албан үүргээ гүйцэтгэхдээ аж ахуйн нэгж, иргэн, түүний дотор гадаадын байгууллага, иргэний зардлаар гадаад, дотоодод зорчих;<br><br>39.1.11.албаны бус зорилгод байгууллагын эд хөрөнгө, техник хэрэгсэл, санхүүгийн эх үүсвэр, мэдээллийн хангамж болон албаны мэдээллийг ашиглан завших;<br><br>39.1.12.Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 4.1.5, 4.1.6-д заасан хэлбэрээр иргэнийг ялгаварлан гадуурхах;<br><br>39.1.13.хэвлэл, мэдээллийн хэрэгслээр болон цахим хуудас, нийгмийн сүлжээний хэрэгслээр төрийн бодлоготой холбоотой асуудлаар албан бус байр суурь, улс төрийн үзэл бодлоо илэрхийлэх, улс төрийн нам, эвсэл, нэр дэвшигчийн талаар эерэг, сөрөг мэдээ, мэдээлэл түгээх;<br><br>39.1.14.төрийн бодлого, үйл ажиллагааг эсэргүүцсэн аливаа жагсаал, цуглаанд оролцох, мэдээ, мэдээлэл тараах;<br><br>39.1.15.төрийн албан хаагчийг албан тушаал бууруулсан, төрийн албанаас чөлөөлсөн, халсантай холбоотой маргааныг шүүхээр эцэслэн шийдвэрлэгдэх хүртэл хугацаанд тухайн ажлын байранд томилгоо хийх;<br><br>39.1.16.хуульд заасан үндэслэлээр албан тушаал бууруулсан, төрийн албанаас чөлөөлсөн, халсан тухай шийдвэр гарсан тохиолдолд албан тушаал, ажлын байр, тамга, тэмдэг, холбогдох баримт бичгийг хүлээлгэн өгөхөөс татгалзах;<br><br>39.1.17.нийтийн сонсголыг зохион байгуулах болон сонсголд оролцох журмыг зөрчих; | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | 39.1.18.хууль тогтоомжид заасан бусад.<br>Тайлбар: Энэ хуулийн 37.1.5, 39.1.5, 39.1.6, 39.1.13 дахь заалт нь төрийн улс төрийн албан хаагчид хамаарахгүй. | | |
| | 6.1.7.төрийн байгууллага нээлттэй, иргэдийн ашиг сонирхолд нийцсэн үйл ажиллагаа явуулж байгаа эсэхэд тавих хяналтад төрийн бус байгууллагын оролцоог нэмэгдүүлж, хамтран ажиллах, мэдээллийг харилцан солилцох, олон нийтэд мэдээлли | ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬ<br>9 дүгээр зүйл.Төрөөс төрийн бус байгууллагатай харилцах<br>1.Төрөөс төрийн бус байгууллагын хууль ёсны эрхийг хамгаална.<br>2.Төрийн бус байгууллага нь төрөөс хараат бус байна.<br>3.Төрийн байгууллага төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд санхүүгийн болон бусад хэлбэрийн дэмжлэг үзүүлж болно.<br>4.Төрийн байгууллагын үйл ажиллагаатай холбогдсон төрийн болон албаны нууцад үл хамаарах мэдээлэл төрийн бус байгууллагад нээлттэй байна.<br>5.Хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагаас гаргах шийдвэрийн төсөл боловсруулах, хэрэгжүүлэх үйл ажиллагаанд саналыг нь үндэслэн төрийн бус байгууллагыг оролцуулж болно.<br>6.Төрийн бус байгууллага төрийн байгууллагаас гаргасан шийдвэрийн талаар байр сууриа илэрхийлж мэдэгдэл хийж болно. | НИЙТИЙН МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН ТУХАЙ<br>5 дугаар зүйл.Нийтийн мэдээллийн үйл ажиллагааны зарчим<br>5.1.2.хуульд өөрөөр заагаагүй бол мэдээлэл ил тод, нээлттэй байх;<br>8 дугаар зүйл.Нээлттэй мэдээлэл<br>8.1.Төрийн үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах, төрийн үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгох зорилгоор мэдээлэл хариуцагчийн чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалт, хүний нөөц, төсөв, санхүү, худалдан авах ажиллагаа, үзүүлж байгаа үйлчилгээ болон хуулиар хаалттай, хязгаарлалттай гэж тогтоосноос бусад мэдээллийг ил тод, нээлттэй байлгана.<br>8.2.Мэдээлэл хариуцагч өөрийн чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх дараах мэдээллийг байнга ил тод, нээлттэй байлгана:<br>8.2.1.эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл, тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн;<br>8.2.2.чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, хаяг, байршил, харилцах утасны дугаар, шуудангийн хаяг, олон нийттэй харилцах, мэдээлэл хүргэх нийгмийн сүлжээний хаяг; | Яамдын цахим хуудсан дахь мэдээлэлтэй танилцахад Авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчилсан байдал хангалтгүй, боловсруулсан хууль, Улсын Их Хурал, Засгийн газрын тогтоол, нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төслийг цахим хуудсандаа байршуулдаггүй, эрх, зөвшөөрөл олгож буй шийдвэр, худалдан авах ажиллагааны тайлан, аудитын дүгнэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй шалтгааныг байршуулàх ажил хэвшээгүй. |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | йг тогтмол хүргэж байх; | | 8.2.3.эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт, үйл ажиллагааны тайлан, мэдээлэл хариуцагчийн үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын тайлан, акт, дүгнэлт, албан шаардлага, зөвлөмж;<br><br>8.2.4.хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан;<br><br>8.2.5.хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн тайлан;<br><br>8.2.6.үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, бусад эрх зүйн акт;<br><br>8.2.7.албан тушаалын тодорхойлолт, албан тушаалтны эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албаны харилцах утасны дугаар, албаны цахим шуудангийн хаяг;<br><br>8.2.8.өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан, мэдээ;<br><br>8.2.9.хуульд өөрөөр заагаагүй бол хариуцсан салбарын үйл ажиллагааны статистик мэдээлэл;<br><br>8.2.10.мэдээлэл хариуцагчаас зохион байгуулах олон нийтийн арга хэмжээний хөтөлбөр.<br><br>8.3.Мэдээлэл хариуцагч өөрийн хүний нөөцийн талаарх дараах мэдээллийг байнга ил тод, нээлттэй байлгана:<br><br>8.3.1.ажлын байрны сул орон тооны талаарх мэдээлэл;<br><br>8.3.2.албан хаагч, ажилтныг сонгон шалгаруулах журам; | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | 8.3.3.албан хаагч, ажилтны ёс зүйн дүрэм;<br>8.3.4.хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж үнэлэх журам;<br>8.3.5.хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ;<br>8.3.6.албан хаагчийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх журам.<br>8.4.Мэдээлэл хариуцагч төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх дараах мэдээллийг байнга ил тод, нээлттэй байлгана:<br>8.4.1.өмнөх оны төсвийн гүйцэтгэл, тухайн жилийн төсөв, дараа оны төсвийн төсөл;<br>8.4.2.төсвийн гүйцэтгэлийн биелэлт болон хагас, бүтэн жилийн санхүүгийн тайлан;<br>8.4.3.санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт;<br>8.4.4.хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ;<br>8.4.5.төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбар;<br>8.4.6.таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг;<br>8.4.7.цалингийн зардлаас бусад таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрийн хамт; | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | 8.4.8.бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр;<br>8.4.9.шилэн дансны хөтлөлт, хэрэгжилт, аудитын тайлан, зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний мэдээлэл;<br>8.4.10.төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан;<br>8.4.11.худалдан авах ажиллагаанд хийсэн үнэлгээ болон аудит, бусад хяналт шалгалтын тайлан, дүгнэлт;<br>8.4.12.мэдээлэл хариуцагч болон захиалагч байгууллагын хүсэлтээр холбогдох этгээдийг худалдан авах ажиллагааны мэргэжил, арга зүйн зөвлөгөө, зааварчилгаагаар хангасан тухай мэдээлэл;<br>8.4.13.төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаанд оролцох эрхийг хязгаарласан этгээдийн жагсаалт;<br>8.4.14.Засгийн газрын гадаад улс, олон улсын байгууллагаас авсан зээл, тусламжийн гэрээ, хэлэлцээрийн талаарх мэдээлэл; | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | 8.4.15.улсын төсөв, Нийгмийн даатгалын сангийн төсвийн орлого, зарлага, хөрөнгө оруулалт, төсвийн нэгдсэн үзүүлэлт;<br>8.4.16.Засгийн газрын гадаад зээл, тусламжийн ашиглалтын мэдээлэл;<br>8.4.17.Засгийн газрын гадаад, дотоод өрийн мэдээлэл;<br>8.4.18.улсын төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбар;<br>8.4.19.нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээ;<br>8.4.20.төсвийн гүйцэтгэл болон аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан;<br>8.4.21.төсвийн алдагдлыг санхүүжүүлэх зорилгоор гаргасан Засгийн газрын дотоод үнэт цаасны мэдээлэл;<br>8.4.22.концессын зүйлийн жагсаалт болон түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлт;<br>8.4.23.концессын гэрээ байгуулсан тухай бүрд концесс эзэмшигч, түүний байгууллагын нууцад хамаарахаас бусад мэдээлэл, концессын зүйл, гүйцэтгэх ажил, үзүүлэх үйлчилгээний талаарх мэдээлэл;<br>8.4.24.хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэх зорилгоор гаргасан Засгийн газрын гадаад үнэт цаасны мэдээлэл;<br>8.4.25.улсын төсвийн нэгдсэн үзүүлэлтийг макро эдийн засгийн үзүүлэлт, холбогдох бусад үзүүлэлттэй уялдуулсан судалгаа, тооцоо;<br>8.4.26.төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | хөтөлбөрийн санхүүжилт, хэрэгжилт, явц, үр дүн;<br><br>8.4.27.мэдээлэл хариуцагчийн захиалгаар хийгдсэн судалгаа, шинжилгээний ажил, түүний тайлан;<br><br>8.4.28.хууль тогтоомжид заасан бусад.<br><br>8.5.Мэдээлэл хариуцагч хуульд заасан чиг үүргийн хүрээнд үзүүлж байгаа үйлчилгээний талаар дараах мэдээллийг байнга ил тод, нээлттэй байлгана:<br><br>8.5.1.үйлчилгээний төрөл, шийдвэрлэх журам, хугацаа, бүрдүүлэх баримт бичиг, түүний загвар, төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ, төлбөр төлөх дансны мэдээлэл;<br><br>8.5.2.тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох үндэслэл, журам, олгосон, сунгасан, түдгэлзүүлсэн, сэргээсэн, хүчингүй болгосон тусгай зөвшөөрлийн талаарх мэдээлэл, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, салбар, төлөөлөгчийн газар, зөвшөөрөл олгосон болон зөвшөөрлийн хүчинтэй хугацаа.<br><br>8.6.Мэдээлэл хариуцагч энэ хуулийн 8.2, 8.3, 8.4, 8.5-д зааснаас гадна өөрийн эрхлэх асуудлын хүрээний дараах мэдээллийг байнга ил тод, нээлттэй байлгана:<br><br>8.6.1.олон нийтээр хэлэлцүүлж, санал авч байгаа хууль тогтоомж болон захиргааны хэм хэмжээний актын төсөл, тэдгээрийн танилцуулга, холбогдох судалгаа, бусад байгууллага, иргэнээс өгсөн санал;<br><br>8.6.2.эзэмшиж байгаа оюуны өмчийн эрхийн жагсаалт; | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | 8.6.3.хот болон газар зохион байгуулалтын төлөвлөлт, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах шийдвэрийн явцын талаарх мэдээлэл;<br>8.6.4.мэдээлэл хариуцагчийн эзэмшиж байгаа газрын мэдээлэл;<br>8.6.5.төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээдийн нэр, хаяг, дүрэм, үйл ажиллагааны чиглэл, эрх бүхий этгээдийн оруулсан хөрөнгийн хувь хэмжээ, ашиг, алдагдлын тайлан, нэгдсэн төсөвт төлсөн татварын хэмжээ, ногдол ашиг;<br>8.6.6.төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээдийн удирдах зөвлөл, хяналтын зөвлөлийн бүтэц, бүрэлдэхүүн, тэдгээрийн гишүүн болон гүйцэтгэх удирдлагын эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, авч байгаа цалин хөлс, урамшууллын дүн, албаны цахим шуудангийн хаяг, тухайн хуулийн этгээдийн удирдлагад тавигдах шаардлага, удирдлагыг сонгон шалгаруулах журам, сонгон шалгаруулах ажиллагааны тов, сонгон шалгаруулалтад оролцогчдын талаарх мэдээлэл;<br>8.6.7.стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашиглах тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн хувьд нэгдсэн төсөв болон Үндэсний баялгийн санд оруулж байгаа татвар, хөрөнгийн хэмжээ;<br>8.6.8.төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг хүн, хуулийн этгээдэд ашиглуулах, шилжүүлэх, хувьчлах, төсвийн хөрөнгийн ашиглалт болон түүнийг ашиглалтаас гаргах, | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | ашиглалтаас гаргаснаас орсон орлогын талаарх мэдээлэл;<br><br>8.6.9.хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаа, үйлдвэрлэл, үйлчилгээний явцад байгаль орчинд учруулж болзошгүй сөрөг нөлөөлөл, үр дагавар, тэдгээрийг арилгах арга хэмжээг тогтоосон байгаль орчны нөлөөллийн үнэлгээний талаарх мэдээлэл, газрын хэвлийн баялгийг ашигласнаар байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн мэдээлэл;<br><br>8.6.10.мэдээлэл хариуцагчийн явуулж байгаа үйл ажиллагаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, ашиглаж байгаа техник, технологийн хүн, мал, амьтны эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх буюу үзүүлж байгаа нөлөөллийн талаарх мэдээлэл;<br><br>8.6.11.барилга байгууламжийг ашиглалтад оруулахыг зөвшөөрсөн улсын комиссын дүгнэлт;<br><br>8.6.12.тусгай хамгаалалттай газар нутаг дэвсгэрт олгосон газар ашиглах гэрчилгээ, байгуулсан гэрээ, газар ашигласны төлбөр төлөлтийн байдал;<br><br>8.6.13.Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлд заасны дагуу байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх асуудлаар нутгийн захиргааны байгууллагаас тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй байгуулсан гэрээ;<br><br>8.6.14.шүүн таслах ажиллагааны дүн мэдээ;<br><br>8.6.15.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцэд гаргасан өргөдөл, гомдол, хүсэлтийн дагуу | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | маргаан хянан шийдвэрлэсэн ажиллагааны дүн мэдээ;<br>8.6.16.улс төрийн намын дүрэм, гишүүнчлэл, хөрөнгө, түүнд өгсөн хандивын мэдээлэл;<br>8.6.17.Монгол Улсын нэгдэн орсон олон талт олон улсын гэрээгээр хүлээсэн үүрэг, хүргүүлсэн тайлан, Монгол Улсад өгсөн зөвлөмж, зөвлөмжийн хэрэгжилтийг хариуцах байгууллагын талаарх мэдээлэл;<br>8.6.18.зүй ёсны монополь аж ахуй эрхлэгчийн үнийн бүрдлийн мэдээлэл болон давамгай байдалтай аж ахуй эрхлэгчийн жагсаалт;<br>8.6.19.хуулийн этгээдийн эцсийн эзэмшигч, эцсийн өмчлөгчийн талаарх мэдээлэл;<br>8.6.20.нэвтрэх, ашиглахад хязгаарлалт тогтоогоогүй мэдээллийн сан дахь нээлттэй өгөгдөл;<br>8.6.21.мэдээлэл хариуцагчийн зардлаар суралцагчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, суралцаж байгаа улс, сургуулийн нэр, мэргэжил, суралцах хугацаа, мэдээлэл хариуцагчаас санхүүжүүлсэн сургалтын зардлын дүн, гэрээний хэрэгжилт;<br>8.6.22.хууль болон олон улсын гэрээгээр нээлттэй байхаар заасан бусад мэдээлэл.<br>8.7.Энэ хуулийн 8.4.13, 8.4.14, 8.4.15, 8.4.16, 8.4.17, 8.4.18, 8.4.19, 8.4.20, 8.4.21, 8.4.22, 8.4.23, 8.4.24, 8.4.25, 8.6.7-д заасан мэдээллийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, энэ хуулийн 8.6.9, 8.6.12-т заасан мэдээллийг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, энэ хуулийн 8.6.14-т заасан мэдээллийг Монгол Улсын | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | дээд шүүх, энэ хуулийн 8.6.15-д заасан мэдээллийг Монгол Улсын Үндсэн хуулийн цэц, энэ хуулийн 8.6.16-д заасан мэдээллийг улс төрийн нам, энэ хуулийн 8.6.17-д заасан мэдээллийг гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, энэ хуулийн 8.6.18-д заасан мэдээллийг өрсөлдөөний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, энэ хуулийн 8.6.19-д заасан мэдээллийг улсын бүртгэлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага тус тус хариуцан нээлттэй, ил тод байлгана.<br>8.8.Мэдээлэл хариуцагч энэ хуулийн 8.2, 8.3, 8.4, 8.5, 8.6-д заасан байнга ил тод, нээлттэй байлгах мэдээллийг олон нийтэд хүргэхдээ цахим хуудас, мэдээллийн самбар, мэдээллийн бусад хэрэгсэл ашиглана.<br>8.9.Хуульд өөрөөр заагаагүй бол мэдээлэл хариуцагч энэ хуулийн 8.2, 8.3, 8.4, 8.5, 8.6-д заасан тайлан, мэдээ, үр дүн, статистик мэдээллийг улирал, хагас жил, жилээр гаргах бөгөөд дараагийн улирал, хагас жил, жилийн эхний сард багтаан цахим хуудсандаа байршуулна.<br>8.10.Мэдээлэл хариуцагчийн үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын тайлан, акт, дүгнэлт, албан шаардлага, зөвлөмж, хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан, ажлын байрны сул орон тоо, мэдээлэл хариуцагчийн зардлаар суралцагчийн талаарх зэрэг бусад мэдээллийг мэдээлэл хариуцагч тухай бүр нь цахим хуудсандаа байршуулна.<br>8.11.Мэдээлэлд өөрчлөлт оруулсан бол өөрчлөлт оруулснаас хойш ажлын гурван | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | өдрийн дотор өөрчлөлтийг тусгаж, мэдээллийг шинэчлэн нийтэлнэ.<br>8.12.Мэдээллийн бусад хэрэгсэл ашиглаж байгаагаас үл хамааран мэдээлэл хариуцагч цахим хуудас, мэдээллийн самбарыг заавал ажиллуулах ба цахим хуудсаар нээлттэй мэдээлэлтэй танилцах нөхцөлийг бүрэн хангана.<br>8.13.Нээлттэй мэдээллийг дэлгэрүүлж авах, тодруулах тохиолдолд тус мэдээллийг өгөх эх сурвалжийг цахим хуудсанд тодорхой заасан байна.<br>8.14.Цахим хуудсанд байршуулсан мэдээллийн үнэн зөвийг баталгаажуулж бүртгэл хөтөлнө.<br>8.15.Энэ хуулийн 8.4-т заасан мэдээллийг нээлттэй, ил тод байлгахтай холбогдсон нарийвчилсан харилцааг Шилэн дансны тухай хуулиар зохицуулна.<br>8.16.Энэ хуулийн 8.8-д заасан цахим хуудас хөтлөх, ил тод, нээлттэй мэдээллийг цахим хэлбэрээр байршуулж нийтлэх, шинэчлэх, хяналт тавих нийтлэг журмыг Засгийн газар батална.<br>8.17.Нээлттэй мэдээллийн ил тод байдлын хэрэгжилтийг зохион байгуулах, үнэлгээ хийх, зөвлөмж гаргах чиг үүрэг бүхий, Авлигатай тэмцэх газар, Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс, цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, төрийн бус байгууллагын төлөөллөөс бүрдсэн орон тооны бус зөвлөл хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэд ажиллана. | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | 8.18.Энэ хуулийн 8.17-д заасан зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг хууль зүйн болон цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.<br>8.19.Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журмыг Засгийн газар батална.<br>13 дугаар зүйл.Хүн, хуулийн этгээд мэдээлэл авах<br>13.1.Хүн, хуулийн этгээд мэдээллийг хүсэлт гаргаж, эсхүл цахим хэлбэрээр, нээлттэй, ил тод байршуулсан мэдээллийг хүсэлт гаргалгүйгээр тухайн цахим хуудсанд хандаж авч болно.<br>13.2.Нээлттэй мэдээлэл авах бол хүсэлтийг амаар болон бичгээр, хязгаарлалттай мэдээлэл авах бол хүсэлтийг бичгээр гаргана.<br>13.3.Цаасан болон хуульд заасны дагуу цахим хэлбэрээр гаргасан хүсэлтийг бичгээр гаргасан хүсэлт гэж үзнэ.<br>13.4.Бичгээр гаргасан хүсэлтэд дараах мэдээллийг тусгасан байна:<br>13.4.1.хүсэлт гаргагч нь хувь хүн бол эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, хуулийн этгээд бол хуулийн этгээдийн нэр;<br>13.4.2.хүсэлт гаргагчийн оршин суугаа, эсхүл оршин байгаа газрын хаяг, шуудангийн хаяг, харилцах утасны дугаар;<br>13.4.3.хязгаарлалттай мэдээлэл авах бол мэдээлэл авах зорилго, мэдээллийн эзний зөвшөөрөл; | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | 13.4.4.мэдээллийн агуулга, мэдээлэл хүлээн авах хэлбэр.<br>13.5.Цаасан хэлбэрээр гаргах хүсэлтийг хүн гарын үсэг зурж, хуулийн этгээд бол хуулийн этгээдийг төлөөлөх эрх бүхий этгээд гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарж баталгаажуулна.<br>13.6.Хүн, хуулийн этгээдийн цахим хэлбэрээр гаргасан хүсэлт нь тухайн хүн, хуулийн этгээдийг хуульд заасан журмын дагуу таньж баталгаажуулах боломжтой байна.<br>13.7.Хүсэлт гаргагч хүн хүсэлтдээ хүндэтгэн үзэх шалтгаанаар гарын үсгээ зурж чадахгүй бол түүнийг төлөөлөн хууль ёсны төлөөлөгч нь гарын үсэг зурна.<br>13.8.Хүсэлтийг иргэд хамтран гаргасан бол түүнд бүгд гарын үсэг зурах, эсхүл тэдгээрийн төлөөлөгч гарын үсэг зурж, төлөөлөх эрхийг нотлох баримт бичгийг хавсаргана.<br>13.9.Хүсэлтэд хуульд зааснаас бусад шаардлага тавихыг хориглоно.<br>14 дүгээр зүйл.Хүсэлт гаргагчийн эрх, үүрэг<br>14.1.Хүсэлт гаргагч мэдээлэл авах талаар дараах эрх эдэлнэ:<br>14.1.1.мэдээлэл авах хэлбэрээ сонгох;<br>14.1.2.нээлттэй мэдээлэл авах бол мэдээлэл авах зорилго, үндэслэлээ тайлбарлахгүй байх;<br>14.1.3.мэдээлэлтэй холбогдсон асуудлаар нэмэлт тайлбар авах;<br>14.1.4.мэдээллийн агуулгын талаар тайлбарлуулах; | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | 14.1.5.мэдээллийн албан ёсны эх сурвалжийг мэдэх;<br>14.1.6.мэдээлэл авах эрхийг нь зөрчсөн гэж үзвэл мэдээлэл хариуцагчийн дээд шатны байгууллага, албан тушаалтанд, дээд шатны байгууллага, албан тушаалтан байхгүй бол шүүхэд гомдол гаргах;<br>14.1.7.мэдээллийг нээлттэй өгөгдөл болгох талаар холбогдох мэдээлэл хариуцагчид хүсэлт гаргах;<br>14.1.8.хуульд заасан бусад | |
| | 6.1.8.авлигатай тэмцэх талаар сургалт, сурталчилгаа явуулах, хөрөнгө, орлогын мэдүүлгийг хуульд заасан хугацаанд үнэн зөв гаргуулах, бүртгэх, хянах, зөвлөгөө өгөх асуудлыг бүтцийн нэгждээ | ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬ<br>55.3.Төрийн байгууллага төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ.<br>29 дүгээр зүйл.Албан тушаалын ажлын байрны сургалт<br>29.1.Иргэнийг төрийн албан тушаалд томилсны дараа богино болон дунд хугацааны сургалтад хамруулна.<br>29.2.Энэ хуулийн 29.1-д заасан сургалтыг Засгийн газрын харьяа төрийн албаны сургалтын байгууллага хариуцан зохион байгуулна.<br>29.3.Энэ хуулийн 29.1-д заасан сургалтын агуулга, хөтөлбөрийг төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар тодорхойлно. | АВЛИГЫН ЭСРЭГ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР<br>4.1.Хэрэгжүүлэх арга хэмжээ<br>4.1.10.2.боловсролын байгууллага болон гэр бүлээр дамжуулан авлигыг үл тэвчих, шударга иргэнийг төлөвшүүлэх зорилгоор олон талт арга хэмжээ зохион байгуулах, авлигын эсрэг боловсрол олгох агуулгыг бүх шатны боловсролын байгууллагын сургалтын хөтөлбөр, стандартад тусгах;<br>4.1.10.3.зорилтот бүлэгт зориулсан сургалтын хөтөлбөр, гарын авлага боловсруулах, авлигыг үл тэвчих хандлагыг бий болгоход чиглэсэн сургалтыг үе шаттай зохион байгуулах, цахим сүлжээг ашиглах;<br>4.1.10.4.авлигын эсрэг сургалт, сурталчилгаа явуулах сургагч багшийг бэлтгэх, дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулах; | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | хариуцуу лах; | | | |
| | 6.1.9.төр ийн байгуулл ага тухайн салбары н албан хаагчийн ёс зүйн дүрмийг батлан гаргахын өмнө Авлигата й тэмцэх газраас санал авах; | | | ёс зүй, хяналт, хариуцлагын тогтолцоо сул, тогтворгүй байгаа нь авлигын эрсдэлийг бий болгож байна |
| | 6.1.10.тө рийн байгуулл агаас гаргасан шийдвэр иргэд болон бусад сонирхог ч талуудад ойлгомжт ой, нээлттэй байх; | | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | 6.1.11.иргэдийн өргөдөл, гомдол, хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх шат дамжлагыг цөөрүүлэх энэ чиглэлээр өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх; | АВЛИГЫН ЭСРЭГ ХУУЛЬ<br>18.Авлигатай тэмцэх газрын бүрэн эрх<br>...18.4.6.авлигын холбогдолтой өргөдөл, гомдлыг хүлээн авч шалгах;<br>ИРГЭДЭЭС ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТАНД ГАРГАСАН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ<br>12 дугаар зүйл.Өргөдөл, гомдлыг хүлээн авах, бүртгэх<br>1.Төрийн бүх байгууллага өргөдөл, гомдол гаргагчийг хүлээн авч уулзах байр, өргөдөл, гомдол хүлээн авах цагийн хуваарийг тогтоож, нийтэд мэдэгдэнэ. Хол газраас ирсэн иргэнийг хүлээлгэлгүйгээр хүлээн авч уулзана.<br>2.Иргэдийг хүлээн авах байранд ирж амаар гаргасан өргөдөл, гомдлыг түүнийг хүлээн авах үүрэг бүхий ажилтан тэмдэглэн авч, тусгай бүртгэлд бүртгэнэ.<br>3.Бичгээр болон цахим сүлжээгээр дамжуулан ирүүлсэн өргөдөл, гомдлыг тухайн байгууллагын бичиг хэрэг хариуцсан ажилтан хүлээн авч, дарааллын дагуу бүртгэнэ.<br>4.Энэ зүйлийн 2, 3 дахь хэсэгт зааснаар бүртгэсэн өргөдөл, гомдлыг түүнийг шийдвэрлэх албан тушаалтанд өдөрт нь багтаан шилжүүлнэ.<br>5.Гомдлыг түүнд холбогдож байгаа албан тушаалтанд өөрт нь шилжүүлэхийг хориглоно.<br>6.Өргөдөл, гомдлыг албан тушаалтан шууд хүлээн авч болно.<br>7."Нууц", "гарт нь" гэж хаягласан өргөдөл, гомдлыг тухайн албан тушаалтанд шууд өгнө. | АВЛИГЫН ЭСРЭГ ХУУЛЬ<br>9 дүгээр зүйл.Өргөдөл, гомдол гаргах, мэдээлэл өгөх<br>9.1.Иргэн, хуулийн этгээд авлигын асуудлаар Авлигатай тэмцэх газарт өргөдөл, гомдол гаргаж, мэдээлэл өгч болно.<br>9.2.Авлигатай тэмцэх газар нь өргөдөл, гомдол, мэдээллийг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ<br>АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР<br>4.1.2.Төрийн үйлчилгээний нээлттэй байдлыг хангаж, цахим үйлчилгээг хөгжүүлэх, чанар хүртээмжийг нь сайжруулах, үйлчлүүлэгчийн эрх ашгийг дээдэлж, төрийн албан хаагчийн хариуцлагыг дээшлүүлэх зорилтыг хангах чиглэлээр дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:<br>...4.1.2.6.өргөдөл, гомдол, мэдээлэл өгөх ил тод, нээлттэй суваг ажиллуулах, өргөдөл, гомдол, мэдээллийг цахим хэлбэрээр гаргах, шийдвэрлэх, хяналт тавих нөхцөл боломжийг бүрдүүлэх;<br>... 4.1.5.5.цахим сүлжээг ашиглах, байнгын ажиллагаатай утас ажиллуулах замаар авлига, албан тушаалын гэмт хэрэг, зөрчлийн талаархи мэдээллийг авах, мэдээлэл өгч байгаа иргэнийг урамшуулах тогтолцоог бүрдүүлэх;<br>4.1.5.6.мэдээлэл өгч байгаа иргэн, сэтгүүлчийг хамгаалах эрх зүйн орчинг бүрдүүлэх; | Хөрөнгө, орлогын мэдүүлгээ мэдүүлээгүй гаргаагүй тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг хуульчлах асуудал<br>Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлд “Авлигатай тэмцэх газрын бүрэн эрх”-ийг, мөн зүйлийн 18.4.15-д “мэдүүлэг гаргагчийн хөрөнгө, орлогын мэдүүлэгт хяналт тавих, шалгах, хугацаа хожимдуулсан буюу санаатай худал мэдүүлсэн этгээдэд холбогдох хуульд заасан арга хэмжээг авахуулахаар эрх бүхий байгууллагад шилжүүлэх; 10 дугаар зүйлийн 10.2-т “Мэдүүлэг гаргагч нь өөрийн болон гэр бүлийн гишүүдийн хөрөнгө, орлого, зээлийг үнэн зөв мэдүүлэх үүрэгтэй.”, 10.3-т “Мэдүүлэг гаргагч хөрөнгө, орлогын мэдүүлгээ тухайн албан тушаалд томилогдсон буюу сонгогдсон өдрөөс хойш 30 хоногийн дотор, цаашид тухайн алба хааж байгаа хугацаандаа жил бүрийн 02 дугаар сарын 15-ны дотор шинэчлэн гаргаж энэ хуулийн 11 дүгээр зүйлд заасан байгууллага, албан тушаалтанд өгөх үүрэгтэй.” гэж тус тус хуульчлан тодорхойлсон.<br>Гэвч нийтийн албан тушаалтан ХАСХОМ-ээ мэдүүлээгүй эсхүл Авлигын хууль зөрчсөн бусад тохиолдолд тэдэнд хууль зүйн хариуцлага хүлээлгэх заалт хуульд тусгагдаагүй байна.<br>АТГ-т хөрөнгө, орлогын мэдүүлгээ мэдүүлээгүй, Авлигын эсрэг хуулийг зөрчсөн тохиолдол 2016 онд 2, 2017 онд |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | 8.Өргөдөл, гомдлыг энэ зүйлийн 6,7 дахь хэсэгт зааснаар хүлээн авсан албан тушаалтан дараахь журмыг биелүүлнэ:<br>1/өөрийн эрх хэмжээнд хамаарах өргөдөл, гомдлыг хүлээн авснаас хойш, түүнчлэн албан тушаалтан томилолтоор өөр газар ажиллаж байгаа бол ирснээс хойш ажлын нэг өдөрт багтаан энэ зүйлд заасан бүртгэлд бүртгүүлнэ;<br>2/ирсэн өргөдөл, гомдолд албан тушаалтныг өөрий нь холбогдуулсан, эсхүл өргөдөл, гомдол тухайн албан тушаалтны эрх хэмжээнд хамаарахгүй бол энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасан ажилтанд хүлээлгэн өгнө. | | 2, 2018 онд 1 буюу 548 тохиолдол гарч байсан.<br>Иймд хуулийн хэм хэмжээ хоорондын уялдаа, эрх, үүргийн нэгдлийг хангах, нийтийн албан тушаалтныг хариуцлагажуулах, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх, иргэдийн төрд итгэх итгэлийг дээшлүүлэх нөхцөлийг бүрдүүлэх зайлшгүй шаардлагаар “ХАСХОМ-ээ мэдүүлээгүй, хуульд заасан хугацаанд гаргаагүй этгээдийн хувьд энэ зохицуулалтыг хуульд тусган баталгаажуулж, хуулийн хийдлийг арилгах шаардлагатай. |
| | 6.1.12.бүрэн эрхийнхээ хүрээнд авлигын шалтгаан нөхцөлийг илрүүлэн тогтоох, тэдгээрийг арилгах, авлигын үйлдлийг таслан зогсоох, үр дагавары | АВЛИГЫН ЭСРЭГ ХУУЛЬ<br>6.1.Төрийн байгууллага энэ хуулийн 3.1.6-д заасан арга хэмжээг хэрэгжүүлэх чиглэлээр дараахь нийтлэг үүрэг хүлээнэ:<br>ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ТУХАЙ<br>17 дугаар зүйл.Эрүүл мэндийн даатгалын улсын байцаагчийн эрх, үүрэг, хариуцлага<br>17.4.Шимтгэл төлөхтэй холбогдсон хууль бус үйл ажиллагааг нуух, эрүүл мэндийн даатгалын сангийн хөрөнгийг хувийн зорилгод ашиглах, авлига авах, ёс зүйн хэм хэмжээг зөрчих, мэдээллийн нууц задруулах, эрхээ хэтрүүлэх зэргээр албан үүргээ зохих ёсоор биелүүлээгүй даатгалын улсын байцаагчид хууль тогтоомжид заасан сахилгын, эд | АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР<br>5.2.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хоёр дахь үе шат /2020-2023 он/*нп хүрэх үр дүн:<br>...5.2.6.авлигад илүү өртсөн салбаруудын болон өндөр түвшний авлигын гэмт хэрэг, зөрчил гарах шалтгаан нөхцөлийг бууруулсан байх; | 2022-Авлигын гэмт хэрэг үйлдэгдэхэд нөлөөлсөн шалтгаан, нөхцөлийг арилгуулахаар 162 мөрдөгчийн мэдэгдэл хүргүүлсэн<br>2017-2019 онд анхан шатны шүүхээр шийдвэрлэгдсэн албан тушаалын гэмт хэргийн 119 шийдвэрт дүн шинжилгээ хийж үзэхэд 5 саяас 10 сая төгрөгийн хахуулийн хэрэг болон 150 саяас 600 сая хүртэлх төгрөгийн хахуулийн хэрэгт оногдуулсан хорих ялын дундаж нь бараг ижил буюу 3.6 жил, торгох ялын дундаж хэмжээ 6.1 сая төгрөг байна. |

[48] Авлигатай тэмцэх газрын 2019 оны үйл ажиллагааны тайлан.

| | | | | |
|---|---|---|---|---|
| | г нь арилгах арга хэмжээ авах; | хөрөнгийн болон эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ. | | |
| | 6.1.13.авлигатай тэмцэх зорилго бүхий төрийн бус байгууллага, иргэдийн сайн дурын хөдөлгөөнийг дэмжих; | | | |
| | 6.1.14.энэ хуулийн 2[1] дүгээр зүйлд заасан Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг төрийн байгууллага, албан тушаалтан биелүүлэ | АВЛИГЫН ЭСРЭГ ХУУЛЬ<br><br>2[1] дүгээр зүйл.Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр<br><br>2[1].1.Улсын Их Хурал Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр батлах бөгөөд түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрт заасан хугацаагаар батална. | АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР<br><br>Найм. Хөтөлбөрийн хэрэгжилтийг тайлагнах<br><br>8.1.Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч байгууллагууд хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг жил бүрийн 02 дугаар сарын 01-ний дотор Ажлын албанд хүргүүлнэ.<br><br>8.2.Авлигатай тэмцэх газар тайланг нэгтгэн хөтөлбөрийг хэрэгжүүлэгч байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, үр дүнг үнэлэн, санал дүгнэлтээ Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороонд танилцуулна.<br><br>8.3.Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороо тайлан, үнэлгээ, | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | х, биелэлтийг холбогдох байгууллагад тайлагнах. | | санал, дүгнэлтийг хэлэлцэж, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, зөрчлийг арилгах, ажлаа эрчимжүүлэх талаар чиглэл өгсөн тогтоол гаргаж болно.<br>8.4.Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороо шаардлагатай гэж үзвэл энэхүү хөтөлбөрийн 8.3-т заасан асуудлыг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлж болно. | |
| | 6.2.Төрийн бүх шатны байгууллагын албан хаагч нь албан үүргээ гүйцэтгэж байх явцдаа олж мэдсэн авлигатай холбоотой асуудлыг шалгаж шийдвэрлэх нь өөрийнх нь бүрэн эрхэд хамаарахгүй | АВЛИГЫН ЭСРЭГ ХУУЛЬ<br>8 дугаар зүйл.Авлигын тухай мэдэгдэх<br>8.1.Энэ хуулийн 4.1-д заасан этгээд албан үүрэг гүйцэтгэх явцдаа олж мэдсэн авлигын талаарх мэдээллийг Авлигатай тэмцэх газарт нэн даруй мэдээлэх үүрэгтэй.<br>8.2.Энэ хуулийн 8.1-д заасан мэдээлэх үүргийг хэрэгжүүлэхэд төр, байгууллага, хувь хүний нууцын тухай хуулиар тогтоосон хязгаарлалт хамаарахгүй.<br>НИЙТИЙН АЛБАНД НИЙТИЙН БОЛОН ХУВИЙН АШИГ СОНИРХЛЫГ ЗОХИЦУУЛАХ, АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ТУХАЙ<br>9 дүгээр зүйл.Албан үүрэгт хөндлөнгөөс нөлөөлөх байдлыг мэдэгдэх<br>9.1.Албан тушаалтан бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нөлөөлсөн аливаа дарамт, шахалт, зохимжгүй нөлөөллийн талаар өөрийн удирдах албан тушаалтан, эсхүл эрх бүхий байгууллагад, хуулийн хариуцлага хүлээхээр бол Авлигатай тэмцэх газарт нэн даруй мэдэгдэх үүрэгтэй. | АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР<br>5.2.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хоёр дахь үе шат /2020-2023 он/-нд хүрэх үр дүн:<br>...5.2.7.авлигатай тэмцэх үйл ажиллагаанд олон нийтийн оролцоо, хяналт сайжирсан байх; | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | байвал Авлигатай тэмцэх газарт мэдээлнэ. | | | |
| | 6.5.Авлигаас урьдчилан сэргийлэх талаар аж АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА, ИРГЭНИЙ ХҮЛЭЭН НИЙТЛЭГ ҮҮРЭГ<br><br>6.5.1.Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 30, 31 дүгээр зүйлд заасан эрх, | ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ТУХАЙ ХУУЛЬ<br><br>30 дугаар зүйл.Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН НИЙТЛЭГ ҮҮРЭГ<br><br>30.1.Хуулийн этгээд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар дараах нийтлэг үүрэг хүлээнэ:<br><br>30.1.1.байгууллагынхаа дотоодод болон үйл ажиллагаа явуулж байгаа хүрээндээ гэмт хэрэг, зөрчил гарч байгаа шалтгаан, нөхцөлийг илрүүлэх, арилгах талаар тодорхой арга хэмжээг авах;<br><br>30.1.2.үйл ажиллагаа явуулж байгаа байршил, түүний ойр орчимд гэмт хэрэг, зөрчил гарч байгаа шалтгаан, нөхцөлийг арилгах арга хэмжээг авах;<br><br>30.1.3.гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор холбогдох хууль тогтоомжийг ажилтнууддаа мэдээлэх, сурталчлах;<br><br>30.1.4.гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилго бүхий хөтөлбөр, төлөвлөгөө, арга хэмжээ, үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;<br><br>30.1.5.барилга байгууламжийн гадна орчны аюулгүй байдлыг хангах зорилгоор ашиглаж байгаа стандартад нийцсэн дүрс бичлэгийн | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | нийтлэг үүрэг | техник, хэрэгслийг цагдаагийн байгууллагын мэдээллийн нэгдсэн сүлжээнд үнэ төлбөргүй холбох, шаардлагатай техникийн нөхцөл, боломжийг бүрдүүлэх, хэвийн ажиллагаанд байнгын хяналт тавих;<br>30.1.6.хууль тогтоомжид заасан бусад.<br>30.2.Гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан, нөхцөлийг арилгах, гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэхээс урьдчилан сэргийлэх талаар энэ хуулийн 13.1.4-т зааснаас бусад этгээдийн мэдэгдэл, зөвлөмж, шаардлагыг хүлээн авсан хуулийн этгээд түүний дагуу тодорхой арга хэмжээг авч, хариуг хугацаанд нь өгөх үүрэгтэй.<br>30.3.Энэ хуулийн 30.1.5-д заасан дүрс бичлэгийн техник, хэрэгслийг цагдаагийн байгууллагын мэдээллийн нэгдсэн сүлжээнд холбох журмыг цагдаагийн төв байгууллагын дарга батална.<br>30.4.Гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан, нөхцөлийг арилгах, урьд өмнө гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлж байсан хүнийг гэмт хэрэг, зөрчил үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор тэдэнд зориулсан ажлын байр бий болгох, хөдөлмөрлөх дадал, туршлага олоход нь дэмжлэг үзүүлж болно.<br>31 дүгээр зүйл.Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар ИРГЭНИЙ ЭРХ, ҮҮРЭГ<br>31.1.Иргэн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар дараах үүрэг хүлээнэ:<br>31.1.1.бусдын нэр төр, алдар хүнд, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хохироохгүй байх, өөрийн үзэл бодлыг илэрхийлэхдээ бусдын нэр төр, алдар хүндэд хүндэтгэлтэй хандах, | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | гэмт хэрэг, зөрчилд бусдыг өдөөн хатгахгүй, олон нийтийн аюулгүй байдал, нийтийн хэв журмыг гажуудуулах үйлдэл гаргахгүй байх;<br>31.1.2.оршин суугаа нутаг дэвсгэртээ нийтийн хэв журам сахиулах талаар нутгийн захиргааны байгууллага, гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам сахиулах байгууллагаас хэрэгжүүлж байгаа зохион байгуулалттай арга хэмжээг дэмжиж, сайн дураар оролцох;<br>31.1.3.гэмт хэрэг, зөрчлийн талаар олж мэдсэн зүйлээ холбогдох байгууллагад мэдээлэх;<br>31.1.4.гэмт халдлагаас өөрийн буюу бусдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгийг хуулийн хүрээнд хамгаалах;<br>31.1.5.гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох талаар бусдаас шаардах, шуурхай мэдээлэх, нуун дарагдуулахгүй байх, цагдаа, хуулийн байгууллагатай хуулийн хүрээнд хамтран ажиллаж, туслалцаа үзүүлэх;<br>31.1.6.хууль бусаар галт зэвсэг, хутга, зэвсгийн чанартай зүйл, тусгай хэрэгсэл олж авах, хадгалах, худалдах, биедээ авч явахгүй байх;<br>31.1.7.улсын бүртгэлийн тухай хууль тогтоомжид заасны дагуу холбогдох бүртгэлийг хийлгэж, баримт бичгийг эзэмших талаарх журмыг чанд сахих;<br>31.1.8.үр хүүхэд, өөрийн асрамжид байгаа насанд хүрээгүй хүнийг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг, зөрчилд холбогдуулахгүй байх;<br>31.1.9.хууль тогтоомжид заасан бусад. | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | 31.2.Иргэн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар дараах эрх эдэлнэ:<br>31.2.1.олон нийтийн аюулгүй байдал, нийтийн хэв журам сахихыг бусдаас шаардах;<br>31.2.2.гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан, нөхцөлийг арилгуулах тухай асуудлыг холбогдох байгууллага, албан тушаалтанд тавих, шаардах;<br>31.2.3.гэмт халдлагаас эд хөрөнгө, өөрийн болон бусдын амь нас, эрүүл мэндийг хуулийн хүрээнд хамгаалах;<br>31.2.4.хуульд заасан үүргээ биелүүлсний төлөө учирч болох эрсдэлээс хамгаалуулах;<br>31.2.5.хууль тогтоомжид заасан бусад. | | |
| | 6.5.1.төрийн бус байгууллага гишүүний хээ ёс зүйн дүрмийг баталж, үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг а ил тод мэдээлж байх; | | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | 6.5.2.хувийн хэвшлийн байгууллага үйл ажиллаганыхаа ёс зүйн зарчмуудыг тогтоож, дагаж мөрдөх. | | | |
| АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН БҮРЭН ЭРХ | 8.4.1.авлигын эсрэг явуулах төрийн бодлого, шийдвэр, түүнчлэн авлигын эсрэг хууль тогтоомжийг боловсронгуй болгох талаар санал боловсру | ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬ<br>5 дугаар зүйл.Хууль санаачлах<br>...5.2.Иргэн, хуулийн этгээд хуулийн төслийн тухай саналаа хууль санаачлагчид уламжилна. Хууль санаачлагч уг саналыг үндэслэлтэй гэж үзвэл тухайн асуудлаар хууль санаачилж болно.<br>7 дугаар зүйл.Хууль тогтоомжийн төсөл боловсруулах ажлыг төлөвлөх<br>7.2.Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага холбогдох байгууллагын саналыг авч, нэгтгэн судалсны үндсэн дээр Үндсэн чиглэлийн төслийг Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт нийцүүлэн боловсруулна.<br>7.3.Үндсэн чиглэлийн төсөлд санал өгөх байгууллага нь нийгмийн тухайн харилцааг зохицуулж байгаа хуулийн хэрэгжилтийн үр | | - Хууль санаачлагчаар уламжилсан хууль тогтоомжийн шинэчлэлийн үйл явц удаашралтай.<br>- Хууль тогтоомжийн төслүүдэд санал авах, өгсөн саналыг хэлэлцүүлэх асуудал хангалттай бус<br>- |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | улж эрх бүхий байгууллагад оруулах; | дагаварт үнэлгээ хийсний үндсэн дээр уг асуудлаар шинээр хууль гаргах, эсхүл хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах үндэслэл, шаардлагыг тодорхойлно. | | |
| | 18.4.2.авлига гарч болох нөхцөл боломж бүрдүүлсэн гэж үзвэл төрийн байгууллага, албан тушаалтны гаргасан тушаал, шийдвэр, журам, дүрмийг хянаж хүчингүй болгуулах санал боловсруулж эрх бүхий байгууллагад оруулах; | ЗАХИРГААНЫ ЕРӨНХИЙ ХУУЛЬ<br>48 дугаар зүйл.Хууль бус захиргааны актыг хүчингүй болгох<br>48.1.Сөрөг нөлөөлөл бүхий хууль бус захиргааны актад гомдол гаргах хөөн хэлэлцэх хугацаа өнгөрснөөс үл хамааран захиргааны байгууллага тухайн захиргааны актыг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн хүчингүй болгоно.<br>66 дугаар зүйл.Хянан бүртгэх үйл ажиллагаа<br>...66.3.2.захиргааны хэм хэмжээний акт бүхэлдээ, эсхүл түүний аль нэг заалт энэ хуулийн 60, 61, 62 дугаар зүйлд заасан шаардлагыг хангаагүй тохиолдолд уг зөрчлийг арилгуулах тухай тодорхой үндэслэл, тайлбар бүхий дүгнэлт гаргаж, албан бичгээр хүргүүлэх;<br>66.3.3.тухайн акт энэ хуулийн 59.1-д заасан захиргааны хэм хэмжээний актын шинжийг агуулаагүй бол улсын нэгдсэн бүртгэлд бүртгэх шаардлагагүй тухай хариуг бичгээр мэдэгдэж буцаан хүргүүлэх;<br>66.3.4.энэ хуулийн 66.3.1, 66.3.2, 66.3.3-т заасан арга хэмжээг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний албан бичгээр мэдэгдэх.<br>66.4.Захиргааны хэм хэмжээний акт эрх зүйн зөрчилтэй байгаа тухай хууль зүйн асуудал | | 2020-18<br>2021-18 дүрэм, журам хянаж, 3 байгууллагад шийдвэрийг хүчингүй болгуулах санал хүргүүлж, 2 шийдвэрийг хүчингүй болгуулсан. |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | эрхэлсэн Засгийн газрын гишүүний энэ хуулийн 66.3.2-т заасан дүгнэлтийг хүлээн авсан захиргааны байгууллага өөрийн гаргасан захиргааны хэм хэмжээний актын хууль зүйн үндэслэлийг хянан үзэж, түүний эрх зүйн зөрчлийг арилгасан, эсхүл зохих нэмэлт, өөрчлөлт оруулсан бол энэ тухай ажлын 10 өдрийн дотор бүртгүүлэхээр дахин хүргүүлнэ.<br><br>66.5.Бүртгэгдсэн захиргааны хэм хэмжээний актад нэмэлт, өөрчлөлт оруулсан бол уг актыг хянуулж, улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэхдээ энэ хуулийн 66.1-д заасан баримт бичгийн бүрдлийг хангасан байна.<br><br>66.6.Хуулиар тусгайлан эрх олгогдсон захиргааны байгууллага энэ хуулийн 66.3.2-т заасан дүгнэлтийг хүлээн авах үндэслэлгүй гэж үзвэл энэ тухай хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ажлын 10 өдрийн дотор албан бичгээр хариу мэдэгдэнэ.<br><br>66.7.Энэ хуулийн 66.6-д заасны дагуу ирүүлсэн мэдэгдлийг хүлээж авах үндэслэлгүй гэж үзвэл хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн дүгнэлт гарган Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр ажлын 10 өдөрт багтаан хүргүүлнэ.<br><br>66.8.Засгийн газар энэ хуулийн 66.7-д заасны дагуу ирүүлсэн дүгнэлтийг хуралдаанаараа хэлэлцэж уг дүгнэлтийг үндэслэн захиргааны хэм хэмжээний актыг хүчингүй болгох эсэхийг шийдвэрлэнэ. | | |
| | 18.4.3.ав лигын эсрэг олон нийтийг | АВЛИГЫН ЭСРЭГ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР<br><br>Найм. Хөтөлбөрийн хэрэгжилтийг тайлагнах<br><br>8.1.Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч байгууллагууд хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг жил | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх ажилтай холбогдуулан төрийн байгууллагаас холбогдох мэдээ, судалгаа, тайланг гаргуулан авах; | бүрийн 02 дугаар сарын 01-ний дотор Ажлын албанд хүргүүлнэ.<br>8.2.Авлигатай тэмцэх газар тайланг нэгтгэн хөтөлбөрийг хэрэгжүүлэгч байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, үр дүнг үнэлэн, санал дүгнэлтээ Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороонд танилцуулна.<br>8.3.Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороо тайлан, үнэлгээ, санал, дүгнэлтийг хэлэлцэж, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, зөрчлийг арилгах, ажлаа эрчимжүүлэх талаар чиглэл өгсөн тогтоол гаргаж болно.<br>8.4.Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороо шаардлагатай гэж үзвэл энэхүү хөтөлбөрийн 8.3-т заасан асуудлыг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлж болно. | | |
| | 18.4.4.ажахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан, иргэнээс шаардлагатай мэдээлэл, судалгаа, тайлбар, тодорхойлолт, бусад | ЗАХИРГААНЫ ЕРӨНХИЙ ХУУЛЬ<br>10 дугаар зүйл.Захиргааны байгууллагын харилцан туслах үүрэг<br>10.1.Захиргааны байгууллага дараах тохиолдолд бичгээр хүсэлт гарган бусад захиргааны байгууллагаас туслалцаа авч болно:<br>10.1.1.эрх зүйн хувьд өөрөө тодорхой үйл ажиллагаа явуулах боломжгүй бол;<br>10.1.2.үйл ажиллагаа явуулахад шаардлагатай хүний нөөц, эсхүл бүтэц, тогтолцоо бодитоор дутагдсан бол;<br>10.1.3.чиг үүргээ хэрэгжүүлэхэд бодит нөхцөл байдлын талаарх мэдээлэлгүй, олж авах боломжгүйгээс холбогдох мэргэжлийн байгууллагын туслалцаа шаардлагатай бол. | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | баримт бичгийг үнэ төлбөргүйгээр гаргуулан авах, танилцах, мэргэжлийн дүгнэлт, магадлагаа гаргуулах; | 10.2.Захиргааны байгууллага туслалцаа хүссэн бусад захиргааны байгууллагатай хамтран ажиллах үүрэгтэй.<br>10.3.Энэ хуулийн 10.1-д заасан асуудлыг шийдвэрлэхтэй холбоотой гарсан зардлыг туслалцаа хүссэн байгууллага хариуцна. | | |
| | 18.4.5.авлигын гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох зорилгоор гүйцэтгэх ажил явуулах, гүйцэтгэх ажил эрхэлдэг бусад байгууллагуудтай хамтран ажиллах; | ГҮЙЦЭТГЭХ АЖЛЫН ТУХАЙ ХУУЛЬ<br>9 дүгээр зүйл. Гүйцэтгэх байгууллага<br>9.1.Дараахь байгууллага дор дурдсан зорилгоор гүйцэтгэх ажил явуулах эрхтэй:<br>9.1.6.Авлигатай тэмцэх газар нь авлигын гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох зорилгоор гүйцэтгэх ажил явуулах, гэм буруутай этгээдийг олж тогтоох, гүйцэтгэх ажил явуулах эрх бүхий байгууллагуудтай хамтран ажиллах;<br>9.2.Гүйцэтгэх ажилд хууль тогтоомжийг чанд сахиулах, нууцыг хангуулах зорилгоор Тагнуулын байгууллага энэ зүйлийн 1 дэх хэсгийн 1-д зааснаас гадна дор дурдсан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:<br>9.2.5.нууцлалыг задруулахгүй байх бүх талын арга хэмжээ авсны үндсэн дээр гүйцэтгэх ажлын тухай хууль тогтоомжийн биелэлтийг цагдаа, авлигатай тэмцэх болон хорих ял эдлүүлэх байгууллага дээр хянан шалгах, | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | тэдгээрт байгаа гүйцэтгэх ажлын хэрэгтэй танилцах, шаардлагатай мэдээ баримтыг гаргуулж авах.<br><br>9.3.Гүйцэтгэх ажлыг хуульд заасан тус тусын чиглэлээр бие даан буюу харилцан ажиллах, хувь хүн, хуулийн этгээдийн туслалцаа авах замаар хэрэгжүүлнэ.<br><br>9.4.Гүйцэтгэх ажил явуулахдаа холбоо, мэдээллийн систем, гэрэл зураг, кино, дүрс, дууны болон бусад бичлэг хийх, хүний амь бие, эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд аюулгүй бусад техник хэрэгсэл ашиглана.<br><br>11 дүгээр зүйл. Гүйцэтгэх ажил явуулах үндэслэл<br><br>11.7.Авлигатай тэмцэх газар авлигын гэмт хэрэг болон хуулиар харъяалуулсан эрүүгийн хэрэгт энэ хуулийн 11.2.1-11.2.3, 11.2.5-11.2.6-д заасан үндэслэлээр гүйцэтгэх ажил явуулах эрхтэй. | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | 18.4.7.хуулиар харьяалуулсан хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах; | ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬ<br>2.3 дугаар зүйл.Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах харьяалал<br>1.Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтыг энэ хуульд заасан нутаг дэвсгэрийн харьяаллын дагуу явуулна.<br>2.Энэ хуульд заасны дагуу тагнуулын байгууллага, цагдаагийн байгууллага, Авлигатай тэмцэх газар нь прокурорын шийдвэрээр хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтыг хамтран явуулж болно.<br>6.1 дүгээр зүйл.Мөрдөн шалгах ажиллагаа явуулах байгууллага<br>2.Авлигатай тэмцэх байгууллага дараахь гэмт хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулна:<br>2.1.Эрүүгийн хуулийн 22.1/Эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах/, 22.3/Гадаад улсын төрийн байгууллага, олон улсын байгууллагын албан тушаалтан эрх мэдлээ урвуулан ашиглах/, 22.4/Хахууль авах/, 22.5/Хахууль өгөх/, 22.6/Гадаад улсын төрийн байгууллага, олон улсын байгууллагын албан тушаалтныг хахуульдах/, 22.7/Улсын нөөцийг хууль бусаар зарцуулах, үрэгдүүлэх/, 22.8/Төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах/, 22.9/Төрийн өмчийн төсвийн бус хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах/, 22.10/Үндэслэлгүйгээр хөрөнгөжих/, 22.11/Дураараа аашлах/, 22.12/Хуулийн этгээдийн эрх мэдлийг урвуулан ашиглах/ дугаар зүйлд заасан гэмт хэрэгт; | Авлигатай тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтэст 2022 оны эхний улиралд авлигын 124 хэрэг бүртгэгджээ. Энэ нь өмнөх оны эхний улиралтай харьцуулахад 35-аар буюу 39.3% өссөн дүн юм. Авлигын гэмт хэрэг өмнөх оны мөн үеэс өсөхөд эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах гэмт хэрэг 28-аар буюу 39.4% өссөн нь голлон нөлөөлснийг Үндэсний статистикийн хорооны мэдээлэл гарсан.<br>Бүртгэгдсэн авлигын 124 хавтаст хэргийг Монгол Улсын Эрүүгийн хуулийн 22 дугаар бүлгийн зүйлээр ангилахад<br>99 (75.6%) нь эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах<br>17 (13.0%) нь хахууль авах гэмт хэрэг<br>7 (5.3%) нь хахууль өгөх гэмт хэрэг<br>4 (3.0%) нь үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт хэрэг<br>1 (0.8%) нь дураараа аашлах гэмт хэрэг<br>2 (1.5%) нь төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах гэмт хэрэг<br>1 (0.8%) нь хуулийн этгээдийн эрх мэдлийг урвуулан ашиглах гэмт хэрэг байна. Авлига, мөнгө угаах гэмт хэргийг мөрдөн шалгах ажиллагаанд оролцдог байгууллагуудын нэг нэгэндээ итгэх итгэлийг сайжруулах, тэдгээр байгууллагуудын үйл ажиллагааны давхардлыг арилгах асуудал өнөөдөр яригдаж байна. | Шүүхээр шийдвэрлүүлсэн хэрэг 40.3%-иар өссөн.Гэмт хэргийн улмаас учирсан хохирол нөхөн төлүүлэлт 2.7 дахин өссөн. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд зааснаар учруулсан хохирол, хор уршгийг арилгасан байх шаардлагыг авлигын хэрэг үйлдсэн этгээд хангасан гэж үзэж, хэргийг хялбаршуулж шийдвэрлэж байгааг ч дахин авч үзэх шаардлагатай байна.<br>Тиймээс авлигын гэмт хэрэгт оногдуулах ял шийтгэлийн төрөл хэмжээг гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, учруулсан хохирол, хор уршгийг харгалзан, бусад төрлийн хэргээс ялгамжтай, оновчтой байдлаар тогтоох, хэргийн хөөн хэлэлцэх хугацааг уртасгах, түүнчлэн энэ гэмт хэрэгт хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах нөхцөлийг тусгайлан авч үзэх байдлаар хуульд өөрчлөлт оруулах шаардлагатай байна<br>Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгад албан тушаалын гэмт хэргийн хамгийн хүндрүүлсэн бүрэлдэхүүнд тоолох хөөн хэлэлцэх хугацааг 5 жилээр тогтоосон нь Авлигын эсрэг Конвенцын агуулгад нийцэхгүй байна. Манай улсын хувьд татварын гэмт хэргүүдэд тусгай хугацаа тогтоосон туршлагад үндэслэн авлигын гэмт хэргийн хамгийн хүнд хэлбэрүүдийн хувьд хөөн хэлэлцэх хугацааг тусгайлан тогтоох боломж байгаа юм. Хөөн хэлэлцэх хугацаа богино хуульчлагдсан |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | 2.2.Эрүүгийн хуулийн Хорин хоёрдугаар бүлэгт заасан авлигын гэмт хэргийн хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад илрүүлсэн Эрүүгийн хуулийн 18.6/Мөнгө угаах/ дугаар зүйлд заасан гэмт хэрэгт.<br>БАНКНЫ ТУХАЙ<br>7 дугаар зүйл. Банкинд хориглох үйл ажиллагаа<br>7.2.3.Банк, түүний харилцагч болон гуравдагч этгээд нууц гэж үзсэн аливаа мэдээллийг шүүх, прокурорын байгууллагын удирдлага хүсэлт гаргасан, эсхүл авлигатай тэмцэх байгууллага, цагдаагийн байгууллагын хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагааны шаардлагаар, түүнчлэн тагнуулын байгууллага мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй холбогдсон мэдээллийг шалгах шаардлагаар мөрдөгчийн саналыг прокурор зөвшөөрсөн бол банкны хувьцаа эзэмшигч, төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүн, гүйцэтгэх удирдлага, хянан шалгах зөвлөл, ажилтанд бусдад гаргаж өгөх, задруулах, ашиглах нь хориглолтод хамаарахгүй.<br>ҮНДЭСНИЙ ТӨЛБӨРИЙН СИСТЕМИЙН ТУХАЙ<br>32 дугаар зүйл.Мэдээллийн нууцлал<br>32.1.Монголбанк, Монголбанкны албан тушаалтан, ажилтан энэ хуульд заасан чиг үүргээ гүйцэтгэхдээ олж авсан мэдээллийн нууцлалыг доор дурдсанаас бусад тохиолдолд шууд болон шууд бусаар задруулахыг хориглоно: | | нь хэргийг энэ үндэслэлээр хэрэгсэхгүй болгосон тохиолдлыг нэмэгдүүлж байгаагаас гадна хуулиудын зөрчилдөөний орчинд шүүх хөөн хэлэлцэх хугацааг алдаж тоолох тохиолдол цөөн боловч гарсан нь байдлыг улам дордуулах эрсдэл дагуулж байна. Хөөн хэлэлцэх хугацаанд багтааж авлигын гэмт хэргийг хянан шийдвэрлэх боломжийг нэмэгдүүлэх нэг арга зам түүнийг зөв тоолж сурах явдал мөн |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | 32.1.3.шүүх, прокурорын байгууллагын удирдлага хүсэлт гаргасан, эсхүл авлигатай тэмцэх болон цагдаагийн байгууллагын хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагааны шаардлагаар, түүнчлэн тагнуулын байгууллага мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй холбогдсон мэдээллийг шалгах шаардлагаар тэдгээрийн удирдлагын хүсэлтийг прокурор зөвшөөрсөн; | | |
| | 18.4.8.чиг үүрэгтээ холбогдох асуудлаар мэдээ, мэдээлэл авах, мэдээллийн нууцыг хадгалах; | ТӨРИЙН БОЛОН АЛБАНЫ НУУЦЫН ТУХАЙ ХУУЛЬ<br><br>НИЙТИЙН МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬ | | |
| | 18.4.9. өөрийн байгууллага, ажилтны хаа аюулгүй байдлыг хангах арга хэмжээ авах; | ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ<br>8 дугаар зүйл.Дүрэмт хувцас<br>8.1.Цэргийн алба хаагч, прокурор, гадаадын иргэний хяналтын улсын байцаагч, гаалийн улсын байцаагчаас бусад албан хаагч төсвийн болон байгууллагын хөрөнгөөр дүрэмт хувцас худалдан авахыг хориглоно.<br>Тайлбар: Энэ зүйлд заасан "цэргийн алба хаагч" гэж зэвсэгт хүчин, хилийн ба дотоодын цэрэг, тагнуул, төрийн тусгай хамгаалалт, цагдаа, шүүхийн шинжилгээ, авлигатай тэмцэх, онцгой байдал, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийг ойлгоно. | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | 18.4.10.гүйцэтгэх ажил, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад албан тушаалтан буюу иргэнд ил болсон нууцыг задруулахгүйн тулд уг этгээдээс бичгээр баталгаа гаргуулан авах, баталгааг зөрчсөн тохиолдолд зохих хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэх; | ТӨРИЙН БОЛОН АЛБАНЫ НУУЦЫН ТУХАЙ ХУУЛЬ<br><br>20 дугаар зүйл. Төрийн болон албаны нууцтай танилцах нөхцөл<br><br>20.1.Энэ хуулийн 21 дүгээр зүйлд зааснаас бусад төрийн нууцтай танилцах ажил, албан тушаалд аюулгүй байдлын шалгалтын дүнг үндэслэн тодорхой зэрэглэлийн нууцтай танилцах эрх олгосон иргэнийг ажиллуулна.<br><br>20.2.Хяналт, шалгалтын болон тодорхой ажил, үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор төрийн нууцтай танилцах иргэн, албан тушаалтанд энэ зүйлийн 20.1-д заасан шаардлага нэгэн адил хамаарна.<br><br>20.3.Албаны нууцтай танилцах ажил, албан тушаалд төрийн байгууллага, бусад хуулийн этгээдийн удирдлагын шийдвэрээр тухайн нууцтай танилцах эрх олгогдсон албан тушаалтныг ажиллуулах бөгөөд тэдгээр нь сонгогдсон, эсхүл томилогдсон даруй нууцыг задруулахгүй байх баталгаа гаргана.<br><br>21.6.Энэ зүйлийн 21.1-21.5-д заасан албан тушаалтан, Монголбанкны Ерөнхийлөгч, Улсын Их Хурлаас байгуулагддаг байгууллагын дарга, агентлагийн дарга, бүх шатны Засаг дарга аюулгүй байдлын шалгалтад хамрагдахгүй бөгөөд төрийн болон албаны нууцыг задруулахгүй байх баталгаа гаргана.<br><br>22 дугаар зүйл. Төрийн нууцтай танилцах эрх олгох<br><br>22.1.Төрийн нууцтай танилцах эрхийг дараахь шаардлагыг хангасан иргэнд олгоно: | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | 22.1.1.төрийн нууцтай танилцах эрх олгохтой холбоотойгоор аюулгүй байдлын шалгалт явуулахыг өөрөө бичгээр зөвшөөрсөн;<br>22.1.2.эрх бүхий байгууллагын аюулгүй байдлын шалгалтад хамрагдаж, тэнцсэн;<br>22.1.3.төрийн нууцыг задруулахгүй байх баталгааг бичгээр гаргасан.<br>39 дүгээр зүйл. Төрийн болон албаны нууцын тухай хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага<br>39.1.Төрийн болон албаны нууцын тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу эрүүгийн, зөрчлийн болон сахилгын хариуцлага хүлээлгэнэ.<br>39.2.Төрийн болон албаны нууцын тухай хууль тогтоомж зөрчсөн албан тушаалтны үйлдэлд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол тагнуулын байгууллагаас дараахь хариуцлага хүлээлгүүлэхээр харьяалах дээд шатны байгууллага, албан тушаалтанд санал тавьж шийдвэрлүүлнэ: | | |
| | 18.4.11.х уулиар харьялу улсан хэргийг шалгах явцад илэрсэн авлигын гэмт хэрэгтэй холбоогу | ЗӨРЧИЛ ШАЛГАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬ<br>1.8 дугаар зүйл. Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны харьяалал<br>6.30.Авлигатай тэмцэх байгууллагын эрх бүхий албан тушаалтан Зөрчлийн тухай хуулийн 15.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 15.30 дугаар зүйлд заасан зөрчил.<br>4.1 дүгээр зүйл. Зөрчил шалгах ажиллагаа | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | й хууль зөрчсөн бусад үйлдлийг шалгуулахаар эрх бүхий байгууллагад шилжүүлэх, энэ хуулийн 6.6, 7.1.7, 7.1.8-д заасан зөрчлийг хянан шалгаж, эрх бүхий байгууллагад хүргүүлэх; | 1.Эрх бүхий албан тушаалтан энэ хуульд заасны дагуу зөрчил шалгах ажиллагаа явуулж, нотлох баримт цуглуулж, бэхжүүлнэ.<br>3.Эрх бүхий албан тушаалтан энэ хуульд прокурорын зөвшөөрлөөр явуулахаар зааснаас бусад ажиллагааг явуулах шийдвэрийг бие даан гаргана.<br>4.Зөрчил шалгах ажиллагааны явцад гэмт хэргийн шинжийг илрүүлсэн бол эрх бүхий албан тушаалтан прокурорт даруй мэдэгдэж, холбогдох баримтыг хүргүүлнэ.<br>5.Энэ бүлэгт заасан зөрчил шалгах ажиллагааны тэмдэглэл, шийдвэрийн маягтыг Улсын ерөнхий прокурор батална.<br>4.2 дугаар зүйл.Прокуророос зөвшөөрөл авах ажиллагаа<br>1.Эрх бүхий албан тушаалтан энэ хуульд заасан прокурорын зөвшөөрлөөр явуулах ажиллагааны саналыг тухайн ажиллагааг явуулахаас 24 цагийн өмнө прокурорт хүргүүлнэ.<br>2.Эрх бүхий албан тушаалтан энэ хуулийн 4.3 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 4.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 4.7 дугаар зүйл, 4.11 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан ажиллагаа явуулах саналыг уг ажиллагааг явуулахаас өмнө прокурорт хүргүүлнэ.<br>4.4 дүгээр зүйл.Мэдээлэл, баримт бичиг гаргуулан авах<br>1.Эрх бүхий албан тушаалтан нь байгууллагын нууц, хүний эмзэг мэдээлэлтэй холбоотой мэдээлэл, баримт бичгийг холбогдох байгууллага, албан тушаалтан, | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | хүнээс прокурорын зөвшөөрлөөр гаргуулан авна.<br><br>2.Эрх бүхий албан тушаалтан энэ зүйлийн 1 дэх хэсэгт зааснаас бусад мэдээлэл, баримт бичгийг байгууллага, албан тушаалтнаас гаргуулан авч болно.<br><br>3.Энэ зүйлийн 1, 2 дахь хэсэгт заасан хүн, байгууллага, албан тушаалтан прокурорын зөвшөөрөл, эсхүл эрх бүхий албан тушаалтны даалгаварт заасан хугацаа, хэлбэрийн дагуу мэдээлэл, баримт бичгийг гарган өгч, нууцыг хадгална.<br><br>2.3 дугаар зүйл.Зөрчлийн хэрэг бүртгэлтийг удирдах албан тушаалтан<br><br>1.Зөрчлийн хэрэг бүртгэлтийг удирдах албан тушаалтан дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:<br><br>1.1.зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг зохион байгуулалт, мэргэжлийн удирдлагаар хангах;<br><br>1.2.зөрчлийн талаархи гомдол, мэдээллийг харьяаллын дагуу шилжүүлж, прокурорын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэх;<br><br>1.3.зөрчлийн хэрэг бүртгэлт явуулах үүргийг нэг, эсхүл хэд хэдэн эрх бүхий албан тушаалтанд даалгах;<br><br>1.4.шаардлагатай тохиолдолд зөрчлийн хэрэг бүртгэлтийг явуулах эрх бүхий албан тушаалтныг өөрчлөх;<br><br>1.5.зөрчил шалгах нэмэлт ажиллагаа явуулах шаардлагатай бол хэрэг бүртгэлтийн хугацааг 14 хүртэл хоногоор сунгах; | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | 1.6.зөрчлийн хэрэг бүртгэлтийн хэргийг харьяаллын дагуу шилжүүлэхээр прокурорт танилцуулж, шийдвэрлүүлэх;<br>2.4 дүгээр зүйл.Эрх бүхий албан тушаалтан<br>1.Энэ хуулийн 1.8 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт заасан эрх бүхий албан тушаалтан хуулиар хүлээсэн чиг үүргийн хүрээнд зөрчил шалган шийдвэрлэх явцад дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:<br>1.1.хуулиар харьяалуулсан зөрчлийг өөрөө илрүүлсэн, эсхүл зөрчлийн тухай гомдол, мэдээлэл ирүүлснийг хүлээн авч хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэх;<br>1.2.зөрчлийн талаархи гомдол, мэдээллийг хүлээн авах, бүртгэх;<br>1.3.хуульд заасан үндэслэл, журмын дагуу зөрчлийн талаархи гомдол, мэдээллийг хүлээн авахаас татгалзах, эсхүл зөрчлийн хэрэг нээх;<br>1.4.зөрчлийн талаархи гомдол, мэдээллийг харьяаллын дагуу шилжүүлэх саналыг зөрчлийн хэрэг бүртгэлтийг удирдах албан тушаалтанд гаргах;<br>1.5.зөрчлийн хэрэг бүртгэлтийн ажиллагааг хуульд заасан үндэслэл, журмын дагуу явуулах;<br>1.6.шинжилгээнд зориулж хэв загвар, дээж авах, шинжилгээ хийх;<br>1.7.прокурорын шийдвэр, үйл ажиллагааны талаар хуульд заасан журмын дагуу тухайн нэгжийн дээд шатны прокурорт гомдол гаргах; | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | 1.8.зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд оролцогчийн гаргасан хүсэлтийг хуульд заасан үндэслэл, журмын дагуу шийдвэрлэх;<br>1.9.хуульд заасан үндэслэл, журмын дагуу эрх хязгаарлах арга хэмжээг авах;<br>1.10.хуулиар харьяалуулсан зөрчилд шийтгэл оногдуулж, албадлагын арга хэмжээ авах;<br>1.11.зөрчлийн үр дагаврыг арилгах арга хэмжээ авах, зардлыг нөхөн төлүүлэх;<br>1.12.зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээд шийтгэл оногдуулсан шийдвэрийг тогтоосон хугацаанд биелүүлээгүй, зөрчлийн үр дагаврыг арилгахтай холбоотой зардлыг нөхөн төлөөгүй бол албадан гүйцэтгүүлэхээр шүүхэд хүсэлт гаргах;<br>1.13.шүүхээс зөрчил хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох;<br>1.14.хуульд заасан бусад. | | |
| | 18.4.12.Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд заасан хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх; | ГЭРЧ, ХОХИРОГЧИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬ<br>1 дүгээр зүйл.Хуулийн зорилт<br>1.1.Энэ хуулийн зорилт нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гэрч, хохирогчийн амь нас, эрүүл мэндийг хамгаалах, тэднийг мэдээллээр хангах, дэмжлэг, туслалцаа үзүүлэх эрх зүйн үндсийг тогтооход оршино.<br>23 дугаар зүйл.Хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх байгууллага, түүний үүрэг<br>23.1.Хамгаалалтын арга хэмжээг дараах байгууллагууд өөрийн эрх хэмжээний хүрээнд хэрэгжүүлнэ: | | “Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль”-ийн 23 дугаар зүйлийн 23.5-д Авлигатай тэмцэх газар, Тагнуулын ерөнхий газар энэ хуулийн 7.1.1-7.1.6-д заасан арга хэмжээг өөрийн харьялах асуудлын хүрээнд хэрэгжүүлэхээр заасны дотор “гэрч, хохирогчийн амь нас, эрүүл мэндийг хамгаалах арга хэмжээг шуурхай авах; энэ хуулийн 5.3-т заасан гэрч, хохирогчийн хамаарал бүхий этгээдийг хамгаалах, энэ хуульд заасан туслалцаа үзүүлэх арга хэмжээг багтаж байгаа болно. Мөн тус хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэгт “гэрч, хохирогчийн амь нас, эрүүл мэндийг гэмт халдлагаас хамгаалах |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | 23.1.4.Авлигатай тэмцэх газар;<br><br>23.2.Энэ хуулийн 23.1-д заасан байгууллагууд нь тухайн байгууллагын даргын дэргэд гэрч, хохирогчийг хамгаалах чиг үүрэг бүхий хамгаалалтын тусгай албатай байна.<br><br>23.5.Авлигатай тэмцэх газар, Тагнуулын ерөнхий газар энэ хуулийн 7.1.1-7.1.6-д заасан арга хэмжээг өөрийн эрх хэмжээний хүрээнд хэрэгжүүлнэ. | | зорилгоор биечилсэн хамгаалалтад авах арга хэмжээг хэрэгжүүлэх”-ээр тусгасан.<br><br>АБХШНА-ны үйл ажиллагааны эрх зүйн үндэслэлийг АТГ-ын даргын тушаалаар баталсан журамд зааж өгсөн байна. Журамд зааснаар тус алба нь байгууллагын болон албан хаагчийн аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүргийг гүйцэтгэж байна.<br><br>Дээрх журам болон хуулийн заалтаас үзэхэд АБХШНА нь “Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль”-д заасан болон албан хаагч, байгууллагын аюулгүй байдлыг хангах чиг үүргийг хэрэгжүүлэхээр байгаа боловч эрх хэмжээ нь хязгаарлагдмал, учирч болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх, бусад этгээдийн халдлагаас алба хаагчийг, гэрч, хохирогчийг хамгаалах хууль зүйн баталгаа хангалттай бус байна.<br><br>Тиймээс Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлийн 18.4.12-т заасанчлан АТГ нь “өөрийн үйл ажиллагаанд туслалцаа үзүүлсэн гэрч, бусад этгээдийг шаардлагатай тохиолдолд цагдаагийн байгууллагын хамгаалалтад авахуулах зэргээр хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.<br><br>Иймд АБХШНАлбаны үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг тодорхой болгох, хүрээг нь өргөтгөх, хуульд заасан гэрч, хохирогчийг хамгаалах, тэдэнд биечилсэн хамгаалалт хийх зэрэг арга хэмжээг хэрэгжүүлэх үндэслэлийг бүрдүүлэх, аливаа |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | | болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, гэрч, хохирогч, албан хаагчийн амь нас, эрүүл мэндийг хамгаалах шаардлагаар галт, зэвсэг тусгай хэрэгслийг хуульд заасан үндэслэл, журмын дагуу хэрэглэх эрхийг хуульчлан баталгаажуулах нь зүйтэй байна. |
| | 18.4.13.хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргавал зохих этгээдийн жагсаалтыг холбогдох байгууллагаас гаргуулан авч хянах; | АВЛИГЫН ЭСРЭГ ХУУЛЬ<br>11 дүгээр зүйл.Хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хадгалах<br>11.1.Хөрөнгө, орлогын мэдүүлгийг дараах байгууллага, албан тушаалтан хуульд заасан хугацаанд бүртгэж, хадгална:<br>11.1.1.Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн, Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, түүнчлэн Улсын Их Хурал, Монгол Улсын Ерөнхийлөгч, Засгийн газраас томилогддог албан тушаалтны хөрөнгө, орлогын мэдүүлгийг Авлигатай тэмцэх газар;<br>11.1.2.Авлигатай тэмцэх газрын удирдах болон гүйцэтгэх албан тушаалтны хөрөнгө, орлогын мэдүүлгийг Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо;<br>11.1.3.Үндсэн хуулийн цэцийн гишүүн болон бүх шатны шүүхийн шүүгчийн хөрөнгө, орлогын мэдүүлгийг Шүүхийн ерөнхий зөвлөл;<br>11.1.4.Аймаг, сум, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчийн хөрөнгө, орлогын мэдүүлгийг тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын алба; | | |
| | 18.4.14.хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хадгалах, хяналт тавих, мэдээлэл өгөх журмын | | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | биелэлтийг шалгах | 11.1.5.бусад албан тушаалтны хөрөнгө, орлогын мэдүүлгийг түүнийг томилсон, эсхүл удирдах эрх бүхий албан тушаалтан. | | |
| | 18.4.15.мэдүүлэг гаргагчийн хөрөнгө, орлогын мэдүүлэгт хяналт тавих, шалгах, хугацаа хожимдуулсан буюу санаатай худал мэдүүлсэн этгээдэд холбогдох хуульд заасан арга хэмжээг авахуулахаар эрх бүхий байгууллагад шилжүүлэх; | 11.2.Монгол Улсын Ерөнхийлөгчийн болон Монгол Улсын Их Хурлын гишүүнд нэр дэвшигчийн хөрөнгө, орлогын мэдүүлгийг Авлигатай тэмцэх газар бүртгэж, хадгална.<br>11.3.Энэ хуулийн 11.1.4, 11.1.5-д заасан хөрөнгө орлогын мэдүүлгийг бүртгэх эрх бүхий байгууллага, албан тушаалтан энэ хуулийн 10.3-т заасан хугацаанд хөрөнгө, орлогын мэдүүлгийг авч дууссанаас хойш 14 хоногийн дотор хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргах журмын биелэлтийн талаарх тайланг, хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргасан этгээдийн нэрсийн хамт Авлигатай тэмцэх газарт ирүүлнэ.<br>11.4.Аймаг, сум, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн нэгдсэн дүн гарсны дараа тухайн сонгуульд сонгогдогчийн хөрөнгө, орлогын мэдүүлгийг санал хураалт дууссанаас хойш 14 хоногийн дотор Авлигатай тэмцэх газарт ирүүлж, хадгалуулна.<br>11.5.Авлигатай тэмцэх газар хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргах хууль тогтоомжийн биелэлтийн талаарх мэдээллийг жил бүрийн 4 дүгээр сарын 15-ны дотор Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороонд гаргаж өгнө.<br>12 дугаар зүйл.Захидал харилцааны нууцлал | | |
| | 18.4.16.хөрөнгө, орлогын мэдүүлэг | 12.1.Энэ хуулийн 4.1-д заасан этгээдээс хөрөнгө, орлогын мэдүүлгийг хэрхэн бөглөх талаар Авлигатай тэмцэх газарт хандаж гаргасан захидал, хүсэлт, асуулт, тэдгээрт өгсөн хариулт, зөвлөгөө нь хүний хувийн | 2020-20 байгууллагад 111 асуудал бүхий Зөвлөмж | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | тэй холбоотой асуудлаар бичгээр дүгнэлт, зөвлөмж гаргах; | мэдээлэлд хамаарах бөгөөд түүнтэй холбогдох асуудлыг Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулиар зохицуулна.<br><br>13 дугаар зүйл.Хөрөнгө, орлогын мэдүүлгийг хянан шалгах, хариуцлага хүлээлгэх үндэслэл<br><br>13.1.Авлигатай тэмцэх газар энэ хуулийн 11.1.2-т зааснаас бусад албан тушаалтны хөрөнгө, орлогын мэдүүлгийн бүрдүүлэлтэд хяналт тавьж, дүн шинжилгээ хийнэ.<br><br>13.2.Улсын Их Хурлын гишүүний хөрөнгө, орлогын мэдүүлгийг Улсын Их Хурлын Ёс зүйн дэд хороо, энэ хуулийн 11.1.2-т заасан хөрөнгө, орлогын мэдүүлгийг Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо тус тус өргөдөл, гомдолд үндэслэн шалгах бөгөөд эрүүгийн хариуцлага хүлээлгэх зөрчил илэрвэл зохих байгууллагад шилжүүлнэ.<br><br>13.3.Хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх эрх бүхий албан тушаалтан мэдүүлэг засваргүй, бүрэн гүйцэд бөглөгдсөн, хугацаандаа өгсөн эсэхэд хяналт тавьж, мэдүүлгийг зохих журмын дагуу гаргаж өгөхийг шаардах, хууль зөрчсөн гэж үзэх үндэслэл байвал бүрэн эрхийнхээ хүрээнд хянан шалгах буюу Авлигатай тэмцэх газарт шилжүүлэн шалгуулах үүрэгтэй.<br><br>13.4.Монгол Улсын Их Хурлын гишүүн Засгийн газрын гишүүний албан тушаалыг хавсарч байгаа бол тухайн гишүүний хөрөнгө, орлогын мэдүүлгийг Авлигатай тэмцэх газар шалгана.<br><br>13.5.Авлигатай тэмцэх газар өргөдөл, гомдол, мэдээллийн мөрөөр, эсхүл төлөвлөгөөт хяналтаар шалгалт явуулж болно.<br><br>13.6.Энэ хуулийн 4.1-д заасан этгээд хөрөнгө, орлогын мэдүүлгээ хугацаанд нь гаргаж | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | өгөөгүй, эсхүл эх үүсвэрийг нь заагаагүй буюу түүнийг хэрхэн олсон талаар тайлбар гаргаагүй бол Авлигатай тэмцэх газар тухайн мэдүүлэг гаргагчийн хөрөнгө, орлогын мэдүүлгийг шалгана.<br><br>13.7.Мэдүүлэг гаргагч хөрөнгө, орлогын эх үүсвэрээ бодитой, үнэн зөв тайлбарлах үүрэгтэй.<br><br>13.8.Мэдүүлэг гаргагч хөрөнгө, орлогын мэдүүлгээ хугацаа хожимдуулж гаргасан, эсхүл бүртгүүлээгүй буюу худал мэдүүлсэн бол дараах хариуцлага хүлээлгэнэ:<br><br>13.8.1.нэг сарын цалин хөлстэй тэнцэх хэмжээний хөрөнгө, орлогыг мэдүүлээгүй буюу худал мэдүүлсэн, хөрөнгө, орлогын мэдүүлгийг энэ хуулийн 10.4, 10.5-д заасан хугацаанаас хожимдуулсан нь хүндэтгэн үзэх шалтгаантай бол сануулах;<br><br>13.8.2.зургаа хүртэл сарын цалин хөлстэй тэнцэх хэмжээний хөрөнгө, орлогыг мэдүүлээгүй буюу худал мэдүүлсэн, хөрөнгө, орлогын мэдүүлгээ удаа дараа хугацаа хожимдуулж гаргасан бол албан тушаалын цалингийн хэмжээг гурван сар хүртэл хугацаагаар 30 хувиар бууруулах;<br><br>13.8.3.зургаан сараас дээш нэг жил хүртэлх хугацааны цалинтай тэнцэх хэмжээний хөрөнгө, орлогыг мэдүүлээгүй буюу худал мэдүүлсэн бол албан тушаал бууруулах, эсхүл албан тушаалын цалингийн хэмжээг гурван сар хүртэл хугацаагаар 30 хувиар бууруулах;<br><br>13.8.4.нэг жилийн цалинтай тэнцэх буюу түүнээс их хэмжээний хөрөнгө, орлогыг мэдүүлээгүй, худал мэдүүлсэн, эсхүл хөрөнгө, орлогын мэдүүлгийг гаргаж өгөөгүй, гаргахаас | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | татгалзсан бол албан тушаалаас нь огцруулах буюу ажлаас халах.<br>13.9.Хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хяналт тавих үүргээ биелүүлээгүй, эсхүл холбогдох материалыг энэ хуулийн 10.3-т заасан хугацаанд ирүүлээгүй албан тушаалтныг эрх бүхий байгууллага, албан тушаалтан албан тушаалын цалингийн хэмжээг гурван сар хүртэл хугацаагаар 30 хувиар бууруулах, уг зөрчлийг удаа дараа гаргасан бол албан тушаал бууруулах сахилгын шийтгэл ногдуулна. | | |
| | 18.4.17.авлигатай тэмцэх асуудлаар гадаад орнуудын болон олон улсын холбогдох байгууллагатай хамтран ажиллах, мэдээлэл солилцох. | | | Гадаад хамтын ажиллагаа сайжирснаар оффшор бүс дэх мэдээлэл, гадаад шилжүүлэг гүйлгээг харж, хянах бүрэн боломжтой болсон. Íуугдмал хөрөнгийг тогтоох, илрүүлэх, хөрөнгө царцаах, хураах, хулгайлагдсан хөрөнгийг эх орондоо буцаан авах чиглэлээр 2019-2021 онд олны анхаарал татсан онцлог, өндөр дүнтэй хэргүүдийг шийдвэрлэсэн. Авлигатай тэмцэх газраас гадаад улсын эрх бүхий байгууллагад 2015 оноос хойш эрүүгийн хэрэгт эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай 36 хүсэлт явуулсан бөгөөд 14 улсаа хүсэлтэд заасан хариу ирүүлсэн байна. Үүнд: ОХУ, АÍУ, Австрали, Канад, Швейцарь, Панам, Австри, Британийн Виржиний Арлууд, Украйн, Латви, Франц зэрэг орнуудаас хариу авч, эрүүгийн хэрэгт хавсарган нотлох баримтаар ашиглаж байна |
| | 18.5.Авлигатай тэмцэх газар | | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | Улсын ерөнхий прокурор ын шийдвэр ээр тодорхой хэргийг цагдаа, тагнуулы н байгуулл агатай хамтран шалгаж болно. | | | |
| | 18.6.Авли гатай тэмцэх газар нь тодорхой хэрэгт гүйцэтгэх болон хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт ын ажиллага а явуулахд аа Эрүүгийн хэрэг хянан шийдвэр лэх тухай | | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | хууль, Гүйцэтгэх ажлын тухай хууль, энэ хуульд заасан журмыг баримтал на | | | |
| ОЛОН НИЙТИЙГ СОЁН ГЭГЭЭРҮҮЛЭХ | Олон нийтийг соён гэгээрүүл эх чиглэлээ р АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛ ЛАГА, ИРГЭНИ Й ХҮЛЭЭХ НИЙТЛЭ Г ҮҮРЭГ<br><br>5.1.1.Улс ын Их Хуралд хэлэлцэг дэх хууль, Улсын Их Хурлын бусад | ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ТУХАЙ<br>3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ<br>3.1.Энэ хууль нь хууль тогтоомжийг санаачлан боловсруулах, олон нийтийн оролцоог хангах, эрх зүйн дүгнэлт хийх, өргөн мэдүүлэх, батлагдсан хууль тогтоомжийг нийтлэх, олон нийтэд сурталчлах, түүний хэрэгжилтийг зохион байгуулах болон хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийхтэй холбогдсон харилцааг зохицуулна.<br>38 дугаар зүйл.Хууль тогтоомжийн төслийн хэлэлцүүлэг зохион байгуулах<br>38.1.Хуульд өөрөөр заагаагүй бол хууль санаачлагч хууль тогтоомжийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээс өмнө олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулж, холбогдох материалыг баримтжуулан хууль тогтоомжийн төслийн бүрдүүлбэрт хавсаргана. 38.5.Олон нийтийн хэлэлцүүлгийг дараах хэлбэрээр явуулна:<br>38.5.1.бичгээр санал авах;<br>38.5.2.уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулах;<br>38.5.3.санал асуулга явуулах; | МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТУХАЙ<br>44 дүгээр зүйл.Тамгын газар, түүний эрхлэх ажил<br>44.4.9.Улсын Их Хурлаас хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах үйл ажиллагааг зохион байгуулах;<br><br>АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР<br>2.1.7.авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд иргэд, олон нийтийн хяналт, иргэний нийгмийн байгууллагын үүрэг, оролцоог нэмэгдүүлэн, идэвх санаачилгыг дэмжих;<br>Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд иргэд, олон нийтийн хяналт, иргэний нийгмийн байгууллагын үүрэг, оролцоог нэмэгдүүлэн, идэвх санаачилгыг дэмжих зорилтыг хангах чиглэлээр дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:<br>4.1.7.1.төрийн бодлого боловсруулах, хэлэлцэх, батлах зэрэг шийдвэр гаргах бүх шатанд тухайн асуудлаар үйл ажиллагаа | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | шийдвэрийн төслийн талаар төрийн болон төрийн бус байгууллага, олон нийтийн зүгээс саналаа илэрхийлэх бололцоо, нөхцөлөөр хангах; | 38.5.4.олон нийтийн цахим сүлжээгээр хэлэлцүүлэг явуулах;<br>38.5.5.бусад хэлбэр.<br>38.6.Хууль санаачлагч олон нийтийн хэлэлцүүлгийн хугацаа дууссан өдрөөс хойш 30 хоногийн дотор хуулийн төсөлд тусгасан болон тусгаагүй саналын товъёгийг бэлтгэн албан ёсны цахим хуудсандаа байршуулна.<br>38.7.Хууль санаачлагчийн боловсруулж байгаа хууль тогтоомжийн төслийн үндэсний аюулгүй байдлын үүднээс хуулиар нууцад хамааруулсан асуудалтай холбоотой хэсгээр олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулахгүй.<br>38.8.Хуульд өөрөөр заагаагүй бол энэ хуулийн 12.2-т заасан хууль тогтоомжийн төсөлд олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулахгүй байж болно. | явуулдаг иргэний нийгмийн байгууллагыг татан оролцуулах замаар авлигатай тэмцэх, авлигаас урьдчилан сэргийлэхэд иргэний нийгмийн байгууллагын оролцоог дэмжих;<br>4.1.7.2.төрийн бус байгууллагын үйл ажиллагаа, санхүүжилтийг ил тод, нээлттэй болгох чиглэлээр Төрийн бус байгууллагын тухай хуулийг боловсронгуй болгох;<br>4.1.7.3.төрийн байгууллага, түүний удирдлагын үйл ажиллагаанд төрийн бус байгууллага хяналт тавих боломжийг бий болгох, төрийн зарим ажил үйлчилгээг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх, санхүүжилтийг ил тод, үр ашигтай зарцуулах, түүнд хяналт тавих тогтолцоог бүрдүүлэх;<br>4.1.7.4.орон нутгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл болон яам, агентлагийн дэргэд авлигаас урьдчилан сэргийлэх олон нийтийн хяналтын дэд зөвлөлийг байгуулан ажиллуулах;<br>4.1.7.5.авлигатай тэмцэх газрын дэргэдэх олон нийтийн зөвлөлийн үйл ажиллагааг идэвхжүүлэх;<br>4.1.7.6.авлигын улмаас төр, иргэн, олон нийтийн эрх ашигт эдийн засгийн хохирол учруулсан бол тухайн этгээдийн өмчийн хэлбэрийг харгалзахгүйгээр хохирлыг нөхөн төлүүлэх талаар шүүхэд нэхэмжлэл гаргах эрхийг төрийн бус байгууллагад олгох, | |
| | 5.1.2.төрийн байгууллага авлигын эсрэг | | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, энэ талаархи мэдээллийг иргэд, байгууллага чөлөөтэй авах нөхцөлийг хангах; | | | |
| | 5.1.3.авлигын асуудлаар эрдэм шинжилгээний судалгаа хийх, ном, сургалт, сурталчилгааны хэрэглэгдэхүүн, сургалтын хөтөлбөр, гарын авлага боловсруулах зэрэг ажилд | | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | сургалт, эрдэм шинжилгээний болон төрийн бус байгууллагуудыг оролцуулах; | | | |
| | 5.1.4.сургалтын байгууллагууд эрх зүйн болон ёс зүйн хичээлийн хүрээнд суралцагчдад авлигын нийгмийн хор аюул, түүнээс урьдчилан сэргийлэх талаар зохих мэдлэг эзэмшүүлж, түүнийг үл тэвчих ёс суртахуу | | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | н төлөвшүүлэх; | | | |
| | 5.1.5.албан бус боловсролын байгууллага болон сургуулиас гадуурх сургалт эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллага, иргэн өөрийн үйл ажиллагааны чиглэлийн дагуу авлигын нийгмийн хор аюулыг суралцагчдад тайлбарлан таниулах, түүнээс урьдчилан сэргийлэх талаар | | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | зохих мэдлэг эзэмшүүлэх; | | | |
| | 5.1.6.хэвлэл мэдээллийн байгууллага авлигын аливаа хэлбэрийг үл тэвчих нийгмийн сэтгэл зүйн орчинг төлөвшүүлэхэд нийтлэл, нэвтрүүлгийнхээ бодлогыг чиглүүлэх, энэ талаар байнга мэдээлэл, сурталчилгаа явуулах. | ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ТУХАЙ ХУУЛЬ<br><br>32 дугаар зүйл.Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар хэвлэл мэдээллийн байгууллагын үүрэг<br><br>32.1.Хэвлэл мэдээллийн байгууллага гэмт хэрэг, зөрчлийн тухай мэдээ, сурвалжлага хийх, нэвтрүүлэг бэлтгэхдээ гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, түүний шалтгаан, нөхцөлийг арилгах, гэмт хэрэг, зөрчлийн хор уршгийг олон нийтэд таниулах, сэрэмжлүүлэхийг гол зорилго болгоно.<br><br>32.2.Хэвлэл мэдээллийн байгууллага гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, түүнийг таслан зогсоохтой холбогдсон хойшлуулшгүй мэдээллийг эрх бүхий байгууллагын хүсэлтээр үнэ төлбөргүйгээр яаралтай нийтэлж, нэвтрүүлнэ.<br><br>32.3.Энэ хуулийн 32.2-т заасан хойшлуулшгүй мэдээллийг үнэ төлбөргүй яаралтай нийтэлж, нэвтрүүлэх журмыг хууль зүйн болон харилцаа холбооны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.<br><br>32.4.Хэвлэл мэдээллийн хэрэгслийн мэдээлэл, нийтлэлийн агуулга, хөтөлбөрт гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг, зөрчилд өртөж, хохирох, болзошгүй эрсдэлээс өөрийгөө болон бусдыг хамгаалах, өөрийн эрх, ашиг сонирхлыг хууль ёсны аргаар хамгаалах арга замыг тодорхой тусгаж хэрэгжүүлнэ. | ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ТУХАЙ<br><br>1 дүгээр зүйл.Хуулийн зорилт<br><br>Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын Үндсэн хуульд заасан хүний үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөг баталгаажуулахад оршино.<br><br>2 дугаар зүйл.Хэвлэл мэдээллийн эрх чөлөөг хангах<br><br>Хэвлэл мэдээллийн эрх чөлөө, хэвлэл мэдээллийн хэрэгслийн чөлөөт байдлыг хязгаарласан хууль батлан гаргахыг хориглоно.<br><br>3 дугаар зүйл.Мэдээлэлд хяналт тавихыг хориглох<br><br>3.1.Хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь өөрийн нийтэлж, нэвтрүүлж байгаа зүйлийнхээ төлөө хариуцлага хүлээнэ. Төрөөс олон нийтийн мэдээллийн агуулгад хяналт /цензур/ тогтоохгүй.<br><br>3.2.Төрөөс хэвлэл мэдээллийн хэрэгсэлд нийтлэх, нэвтрүүлэх мэдээлэлд хяналт тавих байгууллага байгуулахгүй бөгөөд иймхяналтын үйл ажиллагааг санхүүжүүлэхгүй.<br><br>4 дүгээр зүйл.Төрийн байгууллагын мэдээллийн хэрэгслийг хориглох<br><br>Төрийн байгууллага өөрийн мэдэлд хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй байхыг хориглоно. | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | 32.5.Энэ хуулийн 32.4-т заасан агуулга бүхий нийтлэл, мэдээллийг тухайн хэвлэл мэдээллийн хэрэгслээр нэвтрүүлж, нийтэлж байгаа нийт мэдээлэлд эзлэх хувь, заавал нэвтрүүлбэл зохих нийтлэл, мэдээллийн доод хэмжээг хууль зүйн болон харилцаа холбооны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.<br><br>32.6.Хэвлэл мэдээллийн хэрэгслээр хүчирхийлэл, аллага хядлага, садар самуун, гэмт хэрэг үйлдэхийг өөгшүүлэн сурталчилсан, гэмт хэрэг үйлдэх аргыг нарийвчлан харуулсан, гэмт хэрэг, зөрчил үйлдэх, түүний ул мөрийг нуун далдлах арга, хэрэгслийг нарийвчлан дүрсэлсэн, гэмт хэрэг, зөрчлийг ашиг, орлогоо нэмэгдүүлэх хэрэгсэл болгон харуулсан, гэмт хэрэг, зөрчил үйлдэх сэдэл төрүүлж болох агуулгатай аливаа мэдээллийг нийтлэх, нэвтрүүлэхийг хориглоно.<br><br>32.7.Шүүхээр гэм буруутай нь нотлогдоогүй байхад хэнийг ч гэм буруутай болон гэмт хэрэг, зөрчил үйлдсэн гэж хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэхийг хориглоно.<br><br>32.8.Хэвлэл, мэдээллийн байгууллага гэмт хэргийн шинжтэй, илт хууль бус нийтлэл, нэвтрүүлэг, зар сурталчилгааны тухай асуудлыг цагдаагийн байгууллагад мэдээлэх үүрэгтэй.<br><br>32.9.Гэрч, хохирогчийн бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр түүний нүүр царай, дуу хоолойг танигдахуйц байдлаар гаргах, хувийн байдалтай холбоотой мэдээллийг тараах, хохирогчийг буруутгасан мэдээ, мэдээлэл, нэвтрүүлэг хийхийг хориглоно. | АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР<br><br>Хөтөлбөрийн зорилт<br><br>2.1.8.иргэний мэдээлэл авах эрхийг баталгаажуулсан хуулийн хэрэгжилтийг хангах, хэвлэл мэдээллийн эрх зүйн орчин, сэтгүүлчийн мэргэжлийн ёс зүй, хариуцлагыг дээшлүүлэх;<br><br>4.1.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиглэл:<br><br>4.1.8.Хэвлэл мэдээллийн эрх зүйн орчин, сэтгүүлчийн мэргэжлийн ёс зүй, хариуцлагыг дээшлүүлэх<br><br>Иргэний мэдээлэл авах эрхийг баталгаажуулсан хуулийн хэрэгжилтийг хангах, мэдээллийн эрх зүйн орчин, сэтгүүлчийн мэргэжлийн ёс зүй, хариуцлагыг дээшлүүлэх зорилтыг хангах чиглэлээр дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:<br><br>4.1.8.1.хэвлэл мэдээллийн байгууллагын мэдээлэл олж авах, түгээх эрхийг баталгаажуулах;<br><br>4.1.8.2.эрэн сурвалжлах замаар авлига, албан тушаалын гэмт хэргийн талаар мэдээлсэн сэтгүүлчийг аливаа дарамт, шахалтаас хамгаалах эрх зүйн зохицуулалтыг бий болгох, сэтгүүлчийг мэргэжлийн үйл ажиллагааных нь улмаас эрүүгийн хариуцлагад татах явдлыг өөрчилж, аюулгүй байдлыг хангах зохицуулалтыг бий болгох;<br><br>4.1.8.3.хэвлэл мэдээллийн байгууллагын бие даасан, хараат бус байдал, хэвлэлийн эрх чөлөөг хамгаалах эрх зүйн орчинг бүрдүүлэх; | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | 4.1.8.4.төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд аливаа нийтлэл, нэвтрүүлэг, зар сурталчилгаа, мэдээ мэдээллийг олон нийтэд хүргэхтэй холбоотой үйл ажиллагааг ил тод, нээлттэй явуулах;<br>4.1.8.5.сэтгүүлчийн мэргэжлийн ёс зүй зөрчсөн асуудлыг хэлэлцэх, холбогдох хариуцлага тооцох чиглэлээр ажиллах Хэвлэл мэдээллийн зөвлөлийн үйл ажиллагааг сайжруулах. | |
| ХӨРӨНГӨ, ОРЛОГЫН МЭДҮҮЛЭГ ГАРГАХ | | ХУУЛИЙН ҮЙЛЧЛЭЛД ХАМААРАХ ЭТГЭЭД<br>10 дугаар зүйл.Хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргах<br>10.1.Энэ хуулийн 4.1-д заасан этгээд /цаашид “мэдүүлэг гаргагч” гэх/ хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргах бөгөөд шаардлагатай тохиолдолд Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо Авлигатай тэмцэх газрын саналыг үндэслэн хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргах албан тушаалын жагсаалтыг батална.<br>10.2.Мэдүүлэг гаргагч нь өөрийн болон гэр бүлийн гишүүдийн хөрөнгө, орлого, зээлийг үнэн зөв мэдүүлэх үүрэгтэй.<br>10.3.Мэдүүлэг гаргагч хөрөнгө, орлогын мэдүүлгээ тухайн албан тушаалд томилогдсон буюу сонгогдсон өдрөөс хойш 30 хоногийн дотор, цаашид тухайн алба хааж байгаа хугацаандаа жил бүрийн 02 дугаар сарын 15-ны дотор шинэчлэн гаргаж энэ хуулийн 11 дүгээр зүйлд заасан байгууллага, албан тушаалтанд өгөх үүрэгтэй. | НИЙТИЙН АЛБАНД НИЙТИЙН БОЛОН ХУВИЙН АШИГ СОНИРХЛЫГ ЗОХИЦУУЛАХ, АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ТУХАЙ ХУУЛЬ<br>101дүгээр зүйл.Оффшор бүсэд банкны данс эзэмших, хөдлөх, үл хөдлөх хөрөнгө өмчлөх, хуулийн этгээд байгуулахтай холбогдсон хориглолт<br>101.1.Хуульд заасны дагуу хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргадаг албан тушаалтан, түүний хамаарал бүхий этгээд нь тухайн албан тушаалтны албан үүрэг гүйцэтгэх хугацаанд оффшор бүсэд өөрийн нэр дээр банкны данс нээлгэх, мөнгөн хөрөнгө байршуулах, хөдлөх, үл хөдлөх хөрөнгө өмчлөх, хувь нийлүүлэх замаар хуулийн этгээд үүсгэн байгуулахыг хориглоно.<br>АВЛИГЫН ЭСРЭГ ХУУЛИЙН ЗАРИМ ЗААЛТЫГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ ХУУЛЬ | ХАСУМ-ийн хяналтаар 2015 онд 40, 2016 онд 39, 2017 онд 39, 2018 онд 25, 2019 онд 28, 2020 онд 8 этгээдийг тухайн албан тушаалд томилоход илт ашиг сонирхлын зөрчил үүсэх тухай хариуг хүргүүлж, нийтийн албанд ашиг сонирхлын зөрчилтэй этгээдийг томилуулахаас урьдчилан сэргийлж, зөрчилтэй этгээдийг нийтийн албанд томилуулахгүй байх практик тогтоон ажиллаж байна. |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | 10.4.Мэдүүлэг гаргагч энэ хуулийн 10.3-т заасан хугацаанд мэдүүлгээ мэдүүлсний дараа хөрөнгө, орлого нь нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх буюу түүнээс дээш хэмжээгээр өөрчлөгдсөн бол түүнийг тухай бүр 30 хоногийн дотор мэдүүлнэ.<br><br>10.5.Хөрөнгө, орлогын мэдүүлгийг энэ хуулийн 10.3, 10.4-т заасан хугацаанаас хожимдуулж гаргасан нь хүндэтгэн үзэх шалтгаангүй бол гаргаж өгөөгүйд тооцно.<br><br>10.6. Монгол Улсын Ерөнхийлөгчийн болон Монгол Улсын Их Хурлын сонгуульд нэр дэвшигч Авлигатай тэмцэх газарт, бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд нэр дэвшигч тухайн аймаг, нийслэл, сум, дүүргийн сонгуулийн хороонд сонгуулийн хуульд заасан хугацаанд тус тус хөрөнгө, орлогын мэдүүлгээ гаргана.<br><br>10.7.Хөрөнгө, орлогын мэдүүлгийн маягт, түүнийг бүртгэх, хадгалах журмыг Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо батална.<br><br>ХӨРӨНГӨ, ОРЛОГЫН МЭДҮҮЛГИЙГ БҮРТГЭХ ҮҮРЭГ ХҮЛЭЭСЭН АЛБАН ТУШААЛТАН<br><br>12.2.Хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх үүрэг хүлээсэн албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэж байхдаа болон тухайн албан тушаалаас чөлөөлөгдсөнөөс хойшхи хугацаанд мэдүүлэг гаргагчийн зөвшөөрөл болон хуульд зааснаас бусад тохиолдолд мэдүүлэг гаргагчийн болон энэ хуулийн 12.1-д | 1 дүгээр зүйл. Авлигын эсрэг хуулийн 10.4, 14.1-д заасан хугацааг 2007 оны хувьд дор дурдсанаар мөрдсүгэй:<br><br>1/хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргах хугацааг 6 дугаар сарын 15-ны дотор;<br><br>2/хөрөнгө, орлогын мэдүүлэг хэвлэн нийтлэх хугацааг 3 дугаар улиралд.<br><br>МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТУХАЙ ХУУЛЬ<br><br>8 дугаар зүйл.Гишүүний бүрэн эрх<br><br>8.1.Гишүүн дараах бүрэн эрхтэй:<br><br>...8.1.25.хөрөнгө, орлогын мэдүүлгийг тогтоосон хугацаанд зохих журмын дагуу үнэн зөв гаргах.<br><br>24.4.5.гишүүний хөрөнгө, орлогын мэдүүлэтэй холбоотой асуулал нь Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны эрхлэх асуудалд хамаарна.<br><br>АЙМАГ, НИЙСЛЭЛ, СУМ, ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН СОНГУУЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ<br><br>31.2.Нэр дэвшүүлсэн нам, эвсэл хуульд заасан нэр дэвшүүлэх ажиллагаа дууссан өдрөөс хойш гурав хоногт багтаан дараах баримт бичгийг тухайн шатны сонгуулийн хороонд ирүүлнэ:<br><br>...31.2.9.нэр дэвшигчийн хөрөнгө орлогын мэдүүлэг; | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | заасан мэдээллийг задруулах, ямар нэгэн зорилгоор ашиглахыг хориглоно.<br>12.3.Энэ хуулийн 12.2-т заасныг зөрчсөн албан тушаалтанд Хүний хувийн мэдээллийг хамгаалах тухай хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.<br>12.4.Мэдүүлэг гаргагч тэтгэвэр тогтоолгох буюу албан тушаалаас огцрох, халагдах, чөлөөлөгдөх зэргээр бүрэн эрх нь дуусгавар болсон тохиолдолд хөрөнгө, орлогынх нь мэдүүлгийг 5 жилийн хугацаанд хадгалах бөгөөд уг хугацаа дуусмагц түүнийг өөрт нь, хэрэв нас барсан бол эхнэр буюу нөхөр, эсхүл хууль ёсны өв залгамжлагчид нь шилжүүлж өгнө<br>АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР<br>18.2.Авлигатай тэмцэх газар хөрөнгө, орлогын мэдүүлгийг хянан шалгах чиглэлээр дараахь чиг үүрэгтэй:<br>18.2.1.хөрөнгө, орлогын мэдүүлгийг үнэн зөв гаргах талаар сургалт явуулах, гарын авлага, зааварчилгаа гаргах;<br>18.2.2.мэдүүлэг гаргагчийн амаар болон бичгээр ирүүлсэн хүсэлтийн дагуу мэдүүлгийг хэрхэн бөглөх, нэмэлт оруулах, бүртгэх, шилжүүлэх талаар урьдчилан зөвлөгөө өгөх, бичгээр хариу мэдэгдэх, асуулт хариултын нууцыг хадгалах.<br>18.3.Авлигатай тэмцэх газар чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн аж ахуйн нэгжийн удирдах албан тушаалтан өөрийн эрх хэмжээний хүрээнд хамтран ажиллана. | ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬ<br>37.1.Төрийн албан хаагч дараахь нийтлэг үүрэг хүлээнэ:<br>7.1.11.холбогдох хуульд заасан журмын дагуу ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгийг зохих байгууллагад мэдүүлэх;<br>МОНГОЛ УЛСЫН ШҮҮХИЙН ТУХАЙ ХУУЛЬ<br>52 дугаар зүйл.Шүүгч, түүний гэр бүлийн гишүүний хөрөнгө, орлогын мэдүүлэг<br>52.1.Шүүгч Авлигын эсрэг хууль болон Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан журмын дагуу хөрөнгө, орлогын мэдүүлэг, хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг үнэн зөв гаргаж өгөх үүрэгтэй. | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлыг шинжлэх ухааны үндэслэлтэй боловсруулан хэрэгжүүлж, авлигыг үл тэвчих үзлийг хэвшүүлэн, ёс зүйтэй шударга иргэн төлөвшүүлэх чиглэлд төрийн болон иргэний нийгмийн байгууллагуудын хамтын үйл ажиллагааг идэвхжүүлж, иргэдийг авлигын эсрэг тэмцэлд идэвхтэй оролцуулах,<br><br>13 дугаар зүйл.Хөрөнгө, орлогын мэдүүлгийг хянан шалгах, хариуцлага хүлээлгэх үндэслэл<br><br>13.1.Авлигатай тэмцэх газар энэ хуулийн 11.1.2-т зааснаас бусад албан тушаалтны хөрөнгө, орлогын мэдүүлгийн бүрдүүлэлтэд хяналт тавьж, дүн шинжилгээ хийнэ.<br><br>13.2.Улсын Их Хурлын гишүүний хөрөнгө, орлогын мэдүүлгийг Улсын Их Хурлын Ёс зүйн дэд хороо, энэ хуулийн 11.1.2-т заасан хөрөнгө, орлогын мэдүүлгийг Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо тус тус өргөдөл, гомдолд үндэслэн шалгах бөгөөд эрүүгийн хариуцлага хүлээлгэх зөрчил илэрвэл зохих байгууллагад шилжүүлнэ.<br><br>13.3.Хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх эрх бүхий албан тушаалтан мэдүүлэг засваргүй, бүрэн гүйцэд бөглөгдсөн, хугацаандаа өгсөн эсэхэд хяналт тавьж, мэдүүлгийг зохих журмын дагуу гаргаж өгөхийг шаардах, хууль зөрчсөн гэж үзэх үндэслэл байвал бүрэн эрхийнхээ хүрээнд хянан шалгах буюу Авлигатай тэмцэх газарт шилжүүлэн шалгуулах үүрэгтэй.<br><br>13.4.Монгол Улсын Их Хурлын гишүүн Засгийн газрын гишүүний албан тушаалыг хавсарч | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | байгаа бол тухайн гишүүний хөрөнгө, орлогын мэдүүлгийг Авлигатай тэмцэх газар шалгана.<br>13.5.Авлигатай тэмцэх газар өргөдөл, гомдол, мэдээллийн мөрөөр, эсхүл төлөвлөгөөт хяналтаар шалгалт явуулж болно.<br>13.6.Энэ хуулийн 4.1-д заасан этгээд хөрөнгө, орлогын мэдүүлгээ хугацаанд нь гаргаж өгөөгүй, эсхүл эх үүсвэрийг нь заагаагүй буюу түүнийг хэрхэн олсон талаар тайлбар гаргаагүй бол Авлигатай тэмцэх газар тухайн мэдүүлэг гаргагчийн хөрөнгө, орлогын мэдүүлгийг шалгана.<br>13.7.Мэдүүлэг гаргагч хөрөнгө, орлогын эх үүсвэрээ бодитой, үнэн зөв тайлбарлах үүрэгтэй.<br>13.8.Мэдүүлэг гаргагч хөрөнгө, орлогын мэдүүлгээ хугацаа хожимдуулж гаргасан, эсхүл бүртгүүлээгүй буюу худал мэдүүлсэн бол дараах хариуцлага хүлээлгэнэ:<br>13.8.1.нэг сарын цалин хөлстэй тэнцэх хэмжээний хөрөнгө, орлогыг мэдүүлээгүй буюу худал мэдүүлсэн, хөрөнгө, орлогын мэдүүлгийг энэ хуулийн 10.4, 10.5-д заасан хугацаанаас хожимдуулсан нь хүндэтгэн үзэх шалтгаантай бол сануулах;<br>13.8.2.зургаа хүртэл сарын цалин хөлстэй тэнцэх хэмжээний хөрөнгө, орлогыг мэдүүлээгүй буюу худал мэдүүлсэн, хөрөнгө, орлогын мэдүүлгээ удаа дараа хугацаа хожимдуулж гаргасан бол албан тушаалын цалингийн хэмжээг гурван сар хүртэл хугацаагаар 30 хувиар бууруулах;<br>13.8.3.зургаан сараас дээш нэг жил хүртэлх хугацааны цалинтай тэнцэх хэмжээний хөрөнгө, орлогыг мэдүүлээгүй | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | буюу худал мэдүүлсэн бол албан тушаал бууруулах, эсхүл албан тушаалын цалингийн хэмжээг гурван сар хүртэл хугацаагаар 30 хувиар бууруулах;<br><br>13.8.4.нэг жилийн цалинтай тэнцэх буюу түүнээс их хэмжээний хөрөнгө, орлогыг мэдүүлээгүй, худал мэдүүлсэн, эсхүл хөрөнгө, орлогын мэдүүлгийг гаргаж өгөөгүй, гаргахаас татгалзсан бол албан тушаалаас нь огцруулах буюу ажлаас халах.<br><br>13.9.Хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хяналт тавих үүргээ биелүүлээгүй, эсхүл холбогдох материалыг энэ хуулийн 10.3-т заасан хугацаанд ирүүлээгүй албан тушаалтныг эрх бүхий байгууллага, албан тушаалтан албан тушаалын цалингийн хэмжээг гурван сар хүртэл хугацаагаар 30 хувиар бууруулах, уг зөрчлийг удаа дараа гаргасан бол албан тушаал бууруулах сахилгын шийтгэл ногдуулна.<br><br>14 дүгээр зүйл.Хөрөнгө, орлогын мэдүүлгийг нийтэд мэдээлэх<br><br>14.1.Дараахь албан тушаалтны хөрөнгө, орлогын мэдүүлгийг тухайн оны 2 дугаар улиралд багтаан цахим мэдээллийн сүлжээнд байрлуулна:<br><br>14.1.1.Монгол Улсын Ерөнхийлөгч;<br><br>14.1.2.Улсын Их Хурлын дарга, дэд дарга, гишүүн;<br><br>14.1.3.Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, Монгол Улсын сайд, дэд сайд;<br><br>14.1.4.Үндсэн хуулийн цэцийн дарга, түүний орлогч, гишүүн; | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | 14.1.5.Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, шүүгч, Шүүхийн ерөнхий зөвлөлийн гүйцэтгэх нарийн бичгийн дарга;<br>14.1.6.Улсын ерөнхий прокурор, түүний орлогч;<br>14.1.7.Монгол банкны Ерөнхийлөгч, тэргүүн дэд, дэд ерөнхийлөгч;<br>14.1.8.Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга;<br>14.1.9.Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга;<br>14.1.10.Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга;<br>14.1.11.Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга;<br>14.1.12.Авлигатай тэмцэх газрын дарга, дэд дарга;<br>14.1.13.Санхүүгийн зохицуулах хорооны дарга, гишүүн, Хяналтын зөвлөлийн дарга, гишүүн;<br>14.1.14.Үндэсний статистикийн газрын дарга, дэд дарга;<br>14.1.15.Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга, гишүүн;<br>14.1.16.Сонгуулийн ерөнхий хорооны дарга, нарийн бичгийн дарга;<br>14.1.17.Төрийн албаны зөвлөлийн дарга, гишүүн;<br>14.1.18.Ерөнхий аудитор, түүний орлогч;<br>14.1.19.Засгийн газрын агентлагийн дарга; | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | 14.1.20.аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн дарга;<br>14.1.21.аймаг, нийслэлийн Засаг дарга.<br>14.1.22.Монгол Улсын Ерөнхийлөгчийн болон Монгол Улсын Их Хурлын гишүүнд нэр дэвшигч.<br>14.2.Энэ хуулийн 14.1-д зааснаас бусад этгээдийн хөрөнгө, орлогын мэдүүлэг олон нийтэд нээлттэй байна.<br>14.3.Энэ хуулийн 4.1-д заасан этгээдийн хөрөнгө, орлогын сүүлийн 5 жилийн мэдүүлэг Авлигатай тэмцэх газрын цахим мэдээллийн сүлжээнд тавигдах ба иргэд мэдээлэл авах боломжийг хангана.<br>14.4.Иргэд бичгээр, амаар, цахим мэдээллийн сүлжээгээр дамжуулан мэдээлэл авч болох бөгөөд тэдгээрт мэдээлэл өгөх журмыг Авлигатай тэмцэх газар батална.<br>14.5.Авлигатай тэмцэх газар хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргах журмын биелэлтийн талаар жил бүр олон нийтэд мэдээлнэ | | |

---oOo---

Хавсралт №3

# АВЛИГЫН ЭСРЭГ ХУУЛИЙН ЗҮЙЛ ЗААЛТЫГ ЭРХ ЗҮЙН ЧИГ ҮҮРГИЙН ШИНЖЭЭР АНГИЛАН ТОДОРХОЙЛСОН ХАРЬЦУУЛАЛТ

ХУУЛИЙН ЗОРИЛТ

авлигатай тэмцэх үйл ажиллагаа, авлигатай тэмцэх байгууллагын эрх зүйн үндсийг тодорхойлж, тэдгээртэй холбогдсон харилцааг зохицуулах

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

ХОЁРДУГААР БҮЛЭГ. ОЛОН НИЙТИЙГ СОЁН ГЭГЭЭРҮҮЛЭХ, АВЛИГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

ГУРАВДУГААР БҮЛЭГ. ХӨРӨНГӨ, ОРЛОГЫН МЭДҮҮЛЭГ ГАРГАХ

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ БАЙГУУЛЛАГА, ТҮҮНИЙ БҮРЭН ЭРХ

ТАВДУГААР БҮЛЭГ. АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БАТАЛГАА

ЗУРГАДУГААР БҮЛЭГ. БУСАД ЗҮЙЛ

| |
|---|
| Тунхагласан хэм хэмжээ |
| **1 дүгээр зүйл.Хуулийн зорилт**<br>1.1.Энэ хуулийн зорилт нь авлигатай тэмцэх үйл ажиллагаа, авлигатай тэмцэх байгууллагын эрх зүйн үндсийг тодорхойлж, тэдгээртэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино. |
| Бэхжүүлсэн хэм хэмжээ |
| **2 дугаар зүйл.Хууль тогтоомж**<br>2.1.Авлигын эсрэг хууль тогтоомж нь Үндсэн хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ. |
| **4 дүгээр зүйл.Хуулийн үйлчлэлд хамаарах этгээд**<br>4.1.Доор дурдсан этгээд энэ хуулийн үйлчлэлд хамаарна:<br>4.1.1.төрийн улс төрийн, захиргааны, тусгай албаны удирдах болон гүйцэтгэх албан тушаалтан;<br>4.1.2.төрийн үйлчилгээний албаны удирдах албан тушаалтан болон ерөнхий нягтлан бодогч, ахлах нягтлан бодогч;<br>4.1.3.төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдах болон компанийн эрх бүхий албан тушаалтан;<br>4.1.4.олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн дарга, гишүүн, ерөнхий захирал;<br>4.1.5.улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжилт авч төрийн тодорхой чиг үүргийг хууль тогтоомжийн дагуу гүйцэтгэж байгаа төрийн бус байгууллагын удирдах албан тушаалтан; |

4.1.6.Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд нэр дэвшигч;

4.1.7.бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, төлөөлөгч;

4.1.8.эрх бүхий байгууллагаас баталсан жагсаалтад заасан албан тушаалтан;

4.1.9.Ирээдүйн өв сангийн тухай хуулийн 4.1.7-д заасан Ирээдүйн өв сан корпорацийн эрх бүхий албан тушаалтан, хяналтын зөвлөлийн гишүүн.

Засварласан хэм хэмжээ

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд авлигын эсрэг хууль тогтоомжоос өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

Оператив хэм хэмжээ

**35 дугаар зүйл.Хууль хүчин төгөлдөр болох**

35.1.Энэ хуулийг 2006 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Тодорхойлсон хэм хэмжээ

**3 дугаар зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт**

3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1.“авлига” гэж энэ хуулийн 4.1-д заасан этгээд албан тушаалын эрх мэдлээ хувийн ашиг хонжоо олоход урвуулан ашиглах, бусдад давуу байдал олгох, иргэн, хуулийн этгээдээс тэрхүү хууль бус давуу байдлыг олж авах үйлдэл, эс үйлдэхүйгээр илрэх аливаа эрх зүйн зөрчлийг;

3.1.2.“ашиг хонжоо” гэж энэ хуулийн 4.1-д заасан этгээд албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашиглаж бусдад давуу байдал олгосны төлөө өөрт нь болон бусдад буй болох эдийн болон эдийн бус ашигтай байдлыг;

3.1.3.“албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашиглах” гэж албан тушаалын эрх мэдлийг албаны эрх ашгийн эсрэг буюу хувийн ашиг сонирхлоо гүйцэлдүүлэх зорилгод ашиглаж хийх ёстой үйлдлийг хийхгүй байх, хийх ёсгүй үйлдэл хийхийг;

3.1.4.“давуу байдал” гэж энэ хуулийн 4.1-д заасан этгээд албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашигласнаар хувь хүн, хуулийн этгээдэд буй болох эдийн болон эдийн бус ашигтай байдлыг;

3.1.5.“олон нийтийг соён гэгээрүүлэх үйл ажиллагаа” гэж олон нийтэд авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, тэдэнд авлигыг үл тэвчих ёс суртахуун төлөвшүүлэх, уг ажиллагаанд тэднийг татан оролцуулах арга хэмжээний цогцолборыг;

3.1.6.“авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа” гэж авлигын шалтгаан, нөхцөлийг судлан тогтоох, тэдгээрийг арилгах, авлигыг таслан зогсооход чиглэгдсэн арга хэмжээний цогцолборыг;

3.1.7.“хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажил” гэж Авлигатай тэмцэх байгууллагад хуулиар харьяалуулсан гэмт хэрэгт явуулж байгаа эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг;

3.1.8.“гүйцэтгэх ажил” гэж Гүйцэтгэх ажлын тухай хуулийн 2 дугаар зүйлд заасан ажиллагааг;

3.1.9.“сонгуульд нэр дэвшигч” гэж Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд нэр дэвшигчийг.

**5 дугаар зүйл.Олон нийтийг соён гэгээрүүлэх үйл ажиллагаа**

Үүрэг болгосон хэм хэмжээ

5.1.Энэ хуулийн 3.1.5-д заасан арга хэмжээг хэрэгжүүлэх чиглэлээр аж ахуйн нэгж, байгууллага, иргэн дараахь нийтлэг үүрэг хүлээнэ:

5.1.1.Улсын Их Хуралд хэлэлцэгдэх хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийн талаар төрийн болон төрийн бус байгууллага, олон нийтийн зүгээс саналаа илэрхийлэх бололцоо, нөхцөлөөр хангах;

5.1.2.төрийн байгууллага авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, энэ талаархи мэдээллийг иргэд, байгууллага чөлөөтэй авах нөхцөлийг хангах;

5.1.3.авлигын асуудлаар эрдэм шинжилгээний судалгаа хийх, ном, сургалт, сурталчилгааны хэрэглэгдэхүүн, сургалтын хөтөлбөр, гарын авлага боловсруулах зэрэг ажилд сургалт, эрдэм шинжилгээний болон төрийн бус байгууллагуудыг оролцуулах;

5.1.4.сургалтын байгууллагууд эрх зүйн болон ёс зүйн хичээлийн хүрээнд суралцагчдад авлигын нийгмийн хор аюул, түүнээс урьдчилан сэргийлэх талаар зохих мэдлэг эзэмшүүлж, түүнийг үл тэвчих ёс суртахуун төлөвшүүлэх;

5.1.5.албан бус боловсролын байгууллага болон сургуулиас гадуурх сургалт эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллага, иргэн өөрийн үйл ажиллагааны чиглэлийн дагуу авлигын нийгмийн хор аюулыг суралцагчдад тайлбарлан таниулах, түүнээс урьдчилан сэргийлэх талаар зохих мэдлэг эзэмшүүлэх;

5.1.6.хэвлэл мэдээллийн байгууллага авлигын аливаа хэлбэрийг үл тэвчих нийгмийн сэтгэл зүйн орчинг төлөвшүүлэхэд нийтлэл, нэвтрүүлгийнхээ бодлогыг чиглүүлэх, энэ талаар байнга мэдээлэл, сурталчилгаа явуулах.

## 6 дугаар зүйл.Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа

### Үүрэг болгосон

6.1.Төрийн байгууллага энэ хуулийн 3.1.6-д заасан арга хэмжээг хэрэгжүүлэх чиглэлээр дараахь нийтлэг үүрэг хүлээнэ:

6.1.1.Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 25-29 дүгээр зүйлд заасан нийтлэг үүрэг;

6.1.2.тодорхой чиглэлээр бодлого боловсруулах, шийдвэр гаргахын өмнө олон нийтийн анхаарал татаж байгаа мэдээллийг нээлттэй болгох, сонирхогч нийгмийн бүлгүүдэд өөрийн бодлого, байр суурийг танилцуулах, хяналтын тодорхой аргыг дэвшүүлэн хэрэгжүүлэх бололцоо олгох зорилгоор харилцан зөвлөлдөж ажиллах боломжийг бүрдүүлэх;

6.1.3.төрийн хяналтын үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах;

6.1.4.төсвийн орлого, түүний зарцуулалт, гадаадын зээл, тусламж, түүний хуваарилалтыг олон нийтэд тухай бүр нь мэдээлэх;

6.1.5.тухайн байгууллагын чиг үүргийн дагуу зөвшөөрөл, эрх олгох, бүртгэл хийх, хяналт тавих, сонгон шалгаруулалт явуулах зэрэг асуудлыг шийдвэрлэх журмыг хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол олон нийтэд ил тод байлгаж, түүнтэй танилцах боломжоор хангах;

6.1.6.төрийн албан хаагч бүрийн ажил үүргийн хуваарийг тодорхой болгох, эрхэлж байгаа ажлын онцлогтой нь холбогдуулж түүнд хориглох зүйлийг Төрийн албаны тухай хууль болон энэ хуульд заасны дагуу тогтоон мөрдүүлэх;

6.1.7.төрийн байгууллага нээлттэй, иргэдийн ашиг сонирхолд нийцсэн үйл ажиллагаа явуулж байгаа эсэхэд тавих хяналтад төрийн бус байгууллагын оролцоог нэмэгдүүлж, хамтран ажиллах, мэдээллийг харилцан солилцох, олон нийтэд мэдээллийг тогтмол хүргэж байх;

6.1.8.авлигатай тэмцэх талаар сургалт, сурталчилгаа явуулах, хөрөнгө, орлогын мэдүүлгийг хуульд заасан хугацаанд үнэн зөв гаргуулах, бүртгэх, хянах, зөвлөгөө өгөх асуудлыг бүтцийн нэгждээ хариуцуулах;

6.1.9.төрийн байгууллага тухайн салбарын албан хаагчийн ёс зүйн дүрмийг батлан гаргахын өмнө Авлигатай тэмцэх газраас санал авах;

6.1.10.төрийн байгууллагаас гаргасан шийдвэр иргэд болон бусад сонирхогч талуудад ойлгомжтой, нээлттэй байх;

6.1.11.иргэдийн өргөдөл, гомдол, хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх шат дамжлагыг цөөрүүлэх энэ чиглэлээр өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх;

6.1.12.бүрэн эрхийнхээ хүрээнд авлигын шалтгаан нөхцөлийг илрүүлэн тогтоох, тэдгээрийг арилгах, авлигын үйлдлийг таслан зогсоох, үр дагаврыг нь арилгах арга хэмжээ авах;

6.1.13.авлигатай тэмцэх зорилго бүхий төрийн бус байгууллага, иргэдийн сайн дурын хөдөлгөөнийг дэмжих;

6.1.14.энэ хуулийн $2^1$ дүгээр зүйлд заасан Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг төрийн байгууллага, албан тушаалтан биелүүлэх, биелэлтийг холбогдох байгууллагад тайлагнах.

<table>
<tr><td colspan="2">6.2.Төрийн бүх шатны байгууллагын албан хаагч нь албан үүргээ гүйцэтгэж байх явцдаа олж мэдсэн авлигатай холбоотой асуудлыг шалгаж шийдвэрлэх нь өөрийнх нь бүрэн эрхэд хамаарахгүй байвал Авлигатай тэмцэх газарт мэдээлнэ.</td></tr>
<tr><td colspan="2">6.5.Авлигаас урьдчилан сэргийлэх талаар аж ахуйн нэгж, байгууллага, иргэн нь Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 30, 31 дүгээр зүйлд заасан эрх, нийтлэг үүргээс гадна дараах үүрэг хүлээнэ:<br>6.5.1.төрийн бус байгууллага гишүүнийхээ ёс зүйн дүрмийг баталж, үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангаа ил тод мэдээлж байх;<br>6.5.2.хувийн хэвшлийн байгууллага үйл ажиллагааныхаа ёс зүйн зарчмуудыг тогтоож, дагаж мөрдөх.</td></tr>
<tr><td>Үүрэг болгосон хэм хэмжээ</td><td>Хамгаалсан хэм хэмжээ</td></tr>
<tr><td>6.6.Авлигатай тэмцэх газраас бүрэн эрхийнхээ дагуу гаргасан хууль ёсны шаардлага, шийдвэрийг хүлээн авсан аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан түүний дагуу холбогдох арга хэмжээг заавал авч, хариуг хугацаанд нь өгөх үүрэгтэй.<br>6.7.Төрийн байгууллага, албан тушаалтан авлига гарах нөхцөл боломж бүрдүүлсэн гэж үзсэн тушаал, шийдвэр, журам, дүрмийг Авлигатай тэмцэх газраас өгсөн саналын дагуу дахин хянаж хүчингүй болгох буюу өөрчилнө.</td><td>6.8.Авлигаас урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх үүргээ биелүүлээгүй албан тушаалтанд эрх бүхий албан тушаалтан сахилгын шийтгэл хүлээлгэнэ.<br>6.9.Энэ хуулийн 6.6-д заасныг зөрчсөн албан тушаалтныг шүүгч нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэгээс тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.</td></tr>
<tr><td>Хориглосон хэм хэмжээ</td><td>Хамгаалсан хэм хэмжээ</td></tr>
<tr><td>6.3.Шүүх, прокурор, цагдаа, Авлигатай тэмцэх газар, хуульд өөрөөр заагаагүй бол төрийн захиргааны төв байгууллага болон Засгийн газрын агентлаг байрлаж байгаа байранд түүний үйлчилгээг эрхэлдгээс бусад аж ахуйн нэгж, байгууллага байрлахыг хориглоно.<br>6.4.Энэ хуулийн 6.3-д заасан байгууллагын байранд улс төрийн болон шашны үйл ажиллагаа явуулахыг хориглоно.</td><td></td></tr>
<tr><td>7 дугаар зүйл.Хориглох зүйл<br>7.1.Энэ хуулийн 4.1-д заасан этгээдэд бусад хууль тогтоомжид тусгайлан хориглосноос гадна авлигын дараах зөрчлийг хориглоно:<br>7.1.1.албан үүргээ зохих ёсоор гүйцэтгэж байгаа төрийн албан хаагчид дарамт, шахалт үзүүлэх, хөндлөнгөөс оролцох, нөлөөлөх;<br>7.1.2.бусдад шан харамж өгөх, өгөхөөр амлах, зуучлах;<br>7.1.3.албан үүргээ гүйцэтгэхдээ хууль бусаар аливаа хувь хүн, хуулийн этгээдэд давуу байдал олгох, олгохоор амлах, бусдын эрхийг хязгаарлах;<br>7.1.4.төсвийн болон хандив, тусламжийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах;<br>7.1.5.албан үүргээ гүйцэтгэх, эсхүл гүйцэтгэхгүй байхтай холбогдуулан бусдаас шан харамж шаардах;<br>7.1.6.албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулах, хэтрүүлэх;</td><td>33.1.2.энэ хуулийн 8.1-д заасан мэдээлэх үүргээ удаа дараа биелүүлээгүй, эсхүл энэ хуулийн 7.1-д заасныг зөрчсөн этгээдэд албан тушаал бууруулах, хэрэв албан тушаалыг нь бууруулах боломжгүй албан тушаал бол албан тушаалын цалингийн хэмжээг гурван сар хүртэл хугацаагаар 30 хувиар бууруулах, авлигын зөрчилтэй нөхцөлд гарсан шийдвэр байгаа бол түүнийг хүчингүй болгох;<br>33.1.3.энэ хуулийн 7.1-д заасныг удаа дараа зөрчсөн этгээдийг төрийн албанаас халах, авлигын зөрчилтэй нөхцөлд гарсан шийдвэр байгаа бол түүнийг хүчингүй болгох;<br>33.2.Шүүгч энэ хуулийн 7.1.7, 7.1.8-д заасныг зөрчсөн этгээдийн тухайн олсон эд хөрөнгө, орлогыг хураах буюу давуу эрхийг хүчингүй болгох.</td></tr>
</table>

| | |
|---|---|
| 7.1.7.албан тушаалын байдлаа ашиглан эд хөрөнгө олж авах, давуу эрх эдлэх;<br>7.1.8.үндэслэлгүйгээр хөрөнгөжих.<br>Тайлбар:Албан тушаалтан зургаан сарын албан тушаалын цалин хөлс, орлогоос илүү хөрөнгө, орлогыг хууль ёсны дагуу олсон болохыгоо үндэслэлтэй тайлбарлаж чадахгүй тохиолдолд үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэж үзнэ. | |
| **Авлигын тухай мэдэгдэх** | |
| **Үүрэг болгосон хэм хэмжээ** | **Хамгаалсан хэм хэмжээ** |
| **8 дугаар зүйл.Авлигын тухай мэдэгдэх**<br>8.1.Энэ хуулийн 4.1-д заасан этгээд албан үүрэг гүйцэтгэх явцдаа олж мэдсэн авлигын талаарх мэдээллийг Авлигатай тэмцэх газарт нэн даруй мэдээлэх үүрэгтэй.<br>8.2.Энэ хуулийн 8.1-д заасан мэдээлэх үүргийг хэрэгжүүлэхэд төр, байгууллага, хувь хүний нууцын тухай хуулиар тогтоосон хязгаарлалт хамаарахгүй. | 33.1.Авлигын эсрэг хууль тогтоомжийг зөрчсөн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол эрх бүхий байгууллага, албан тушаалтан дараах хариуцлага хүлээлгэнэ:<br>33.1.1.энэ хуулийн 8.1-д заасан мэдээлэх үүргээ биелүүлээгүй этгээдийн албан тушаалын цалингийн хэмжээг гурван сар хүртэл хугацаагаар 30 хувиар бууруулах;<br>33.1.2.энэ хуулийн 8.1-д заасан мэдээлэх үүргээ удаа дараа биелүүлээгүй, эсхүл энэ хуулийн 7.1-д заасныг зөрчсөн этгээдэд албан тушаал бууруулах, хэрэв албан тушаалыг нь бууруулах боломжгүй албан тушаал бол албан тушаалын цалингийн хэмжээг гурван сар хүртэл хугацаагаар 30 хувиар бууруулах, авлигын зөрчилтэй нөхцөлд гарсан шийдвэр байгаа бол түүнийг хүчингүй болгох; |
| **Зөвшөөрсөн хэм хэмжээ** | **Бэхжүүлсэн хэм хэмжээ** |
| **9 дүгээр зүйл.Өргөдөл, гомдол гаргах, мэдээлэл өгөх**<br>9.1.Иргэн, хуулийн этгээд авлигын асуудлаар Авлигатай тэмцэх газарт өргөдөл, гомдол гаргаж, мэдээлэл өгч болно. | 9.2.Авлигатай тэмцэх газар нь өргөдөл, гомдол, мэдээллийг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ. |

| | |
|---|---|
| **ГУРАВДУГААР БҮЛЭГ. ХӨРӨНГӨ, ОРЛОГЫН МЭДҮҮЛЭГ ГАРГАХ** | |
| **Үүрэг болгосон хэм хэмжээ** | **Бэхжүүлсэн хэм хэмжээ** |
| 10.2.Мэдүүлэг гаргагч нь өөрийн болон гэр бүлийн гишүүдийн хөрөнгө, орлого, зээлийг үнэн зөв мэдүүлэх үүрэгтэй.<br>10.3.Мэдүүлэг гаргагч хөрөнгө, орлогын мэдүүлгээ тухайн албан тушаалд томилогдсон буюу сонгогдсон өдрөөс хойш 30 хоногийн дотор, цаашид тухайн алба хааж байгаа хугацаандаа жил бүрийн 02 дугаар сарын 15-ны дотор шинэчлэн гаргаж энэ хуулийн 11 дүгээр зүйлд | 10.1.Энэ хуулийн 4.1-д заасан этгээд /цаашид “мэдүүлэг гаргагч” гэх/ хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргах бөгөөд шаардлагатай тохиолдолд Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо Авлигатай тэмцэх газрын саналыг үндэслэн хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргах албан тушаалын жагсаалтыг батална.<br>10.7.Хөрөнгө, орлогын мэдүүлгийн маягт, түүнийг бүртгэх, хадгалах журмыг Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо батална.<br>10.5.Хөрөнгө, орлогын мэдүүлгийг энэ хуулийн 10.3, 10.4-т заасан хугацаанаас хожимдуулж гаргасан нь хүндэтгэн үзэх шалтгаангүй бол гаргаж өгөөгүйд тооцно.<br>10.6. Монгол Улсын Ерөнхийлөгчийн болон Монгол Улсын Их Хурлын сонгуульд нэр дэвшигч Авлигатай тэмцэх газарт, бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд нэр дэвшигч тухайн аймаг, нийслэл, сум, дүүргийн сонгуулийн хороонд |

| | |
|---|---|
| заасан байгууллага, албан тушаалтанд өгөх үүрэгтэй.<br><br>10.4.Мэдүүлэг гаргагч энэ хуулийн 10.3-т заасан хугацаанд мэдүүлгээ мэдүүлсний дараа хөрөнгө, орлого нь нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх буюу түүнээс дээш хэмжээгээр өөрчлөгдсөн бол түүнийг тухай бүр 30 хоногийн дотор мэдүүлнэ. | сонгуулийн хуульд заасан хугацаанд тус тус хөрөнгө, орлогын мэдүүлгээ гаргана.<br><br>**11 дүгээр зүйл.Хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хадгалах**<br><br>11.1.Хөрөнгө, орлогын мэдүүлгийг дараах байгууллага, албан тушаалтан хуульд заасан хугацаанд бүртгэж, хадгална:<br><br>11.1.1.Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн, Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, түүнчлэн Улсын Их Хурал, Монгол Улсын Ерөнхийлөгч, Засгийн газраас томилогддог албан тушаалтны хөрөнгө, орлогын мэдүүлгийг Авлигатай тэмцэх газар;<br><br>11.1.2.Авлигатай тэмцэх газрын удирдах болон гүйцэтгэх албан тушаалтны хөрөнгө, орлогын мэдүүлгийг Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо;<br><br>11.1.3.Үндсэн хуулийн цэцийн гишүүн болон бүх шатны шүүхийн шүүгчийн хөрөнгө, орлогын мэдүүлгийг Шүүхийн ерөнхий зөвлөл;<br><br>11.1.4.Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчийн хөрөнгө, орлогын мэдүүлгийг тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын алба;<br><br>11.1.5.бусад албан тушаалтны хөрөнгө, орлогын мэдүүлгийг түүнийг томилсон, эсхүл удирдах эрх бүхий албан тушаалтан.<br><br>11.2.Монгол Улсын Ерөнхийлөгчийн болон Монгол Улсын Их Хурлын гишүүнд нэр дэвшигчийн хөрөнгө, орлогын мэдүүлгийг Авлигатай тэмцэх газар бүртгэж, хадгална.<br><br>11.3.Энэ хуулийн 11.1.4, 11.1.5-д заасан хөрөнгө орлогын мэдүүлгийг бүртгэх эрх бүхий байгууллага, албан тушаалтан энэ хуулийн 10.3-т заасан хугацаанд хөрөнгө, орлогын мэдүүлгийг авч дууссанаас хойш 14 хоногийн дотор хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргах журмын биелэлтийн талаарх тайланг, хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргасан этгээдийн нэрсийн хамт Авлигатай тэмцэх газарт ирүүлнэ.<br><br>11.4.Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн нэгдсэн дүн гарсны дараа тухайн сонгуульд сонгогдогчийн хөрөнгө, орлогын мэдүүлгийг санал хураалт дууссанаас хойш 14 хоногийн дотор Авлигатай тэмцэх газарт ирүүлж, хадгалуулна.<br><br>11.5.Авлигатай тэмцэх газар хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргах хууль тогтоомжийн биелэлтийн талаарх мэдээллийг жил бүрийн 4 дүгээр сарын 15-ны дотор Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороонд гаргаж өгнө. |

| **12 дугаар зүйл.Захидал харилцааны нууцлал** | | |
|---|---|---|
| **Бэхжүүлсэн хэм хэмжээ** | **Хориглосон хэм хэмжээ** | **Хамгаалсан хэм хэмжээ** |
| 12.1.Энэ хуулийн 4.1-д заасан этгээдээс хөрөнгө, орлогын мэдүүлгийг хэрхэн бөглөх талаар Авлигатай тэмцэх газарт хандаж гаргасан захидал, хүсэлт, асуулт, тэдгээрт өгсөн хариулт, зөвлөгөө нь хувь хүний нууцад хамаарах бөгөөд түүнтэй холбогдох асуудлыг Хувь хүний нууцын тухай хуулиар зохицуулна.<br><br>12.4.Мэдүүлэг гаргагч тэтгэвэр тогтоолгох буюу албан тушаалаас огцрох, халагдах, | 12.2.Хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх үүрэг хүлээсэн албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэж байхдаа болон тухайн албан тушаалаас чөлөөлөгдсөнөөс хойшхи хугацаанд мэдүүлэг гаргагчийн зөвшөөрөл болон хуульд заасанаас | 12.3.Энэ хуулийн 12.2-т заасныг зөрчсөн албан тушаалтанд Хувь хүний нууцын тухай хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ. |

| | | |
|---|---|---|
| чөлөөлөгдөх зэргээр бүрэн эрх нь дуусгавар болсон тохиолдолд хөрөнгө, орлогынх нь мэдүүлгийг 5 жилийн хугацаанд хадгалах бөгөөд уг хугацаа дуусмагц түүнийг өөрт нь, хэрэв нас барсан бол эхнэр буюу нөхөр, эсхүл хууль ёсны өв залгамжлагчид нь шилжүүлж өгнө | бусад тохиолдолд мэдүүлэг гаргагчийн болон энэ хуулийн 12.1-д заасан мэдээллийг задруулах, ямар нэгэн зорилгоор ашиглахыг хориглоно. | |

| 13 дугаар зүйл.Хөрөнгө, орлогын мэдүүлгийг хянан шалгах, хариуцлага хүлээлгэх үндэслэл | | | |
|---|---|---|---|
| Бэхжүүлсэн хэм хэмжээ | Үүрэг болгосон хэм хэмжээ | Зөвшөөрсөн хэм хэмжээ | Хамгаалсан хэм хэмжээ |
| 13.1.Авлигатай тэмцэх газар энэ хуулийн 11.1.2-т зааснаас бусад албан тушаалтны хөрөнгө, орлогын мэдүүлгийн бүрдүүлэлтэд хяналт тавьж, дүн шинжилгээ хийнэ.<br><br>13.2.Улсын Их Хурлын гишүүний хөрөнгө, орлогын мэдүүлгийг Улсын Их Хурлын Ёс зүйн дэд хороо, энэ хуулийн 11.1.2-т заасан хөрөнгө, орлогын мэдүүлгийг Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо тус тус өргөдөл, гомдолд үндэслэн шалгах бөгөөд эрүүгийн хариуцлага хүлээлгэх зөрчил илэрвэл зохих байгууллагад шилжүүлнэ | 13.3.Хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх эрх бүхий албан тушаалтан мэдүүлэг засваргүй, бүрэн гүйцэд бөглөгдсөн, хугацаандаа өгсөн эсэхэд хяналт тавьж, мэдүүлгийг зохих журмын дагуу гаргаж өгөхийг шаардах, хууль зөрчсөн гэж үзэх үндэслэл байвал бүрэн эрхийнхээ хүрээнд хянан шалгах буюу Авлигатай тэмцэх газарт шилжүүлэн шалгуулах үүрэгтэй.<br><br>13.4.Монгол Улсын Их Хурлын гишүүн Засгийн газрын гишүүний албан тушаалыг хавсарч байгаа бол тухайн гишүүний хөрөнгө, орлогын мэдүүлгийг Авлигатай тэмцэх газар шалгана.<br><br>13.6.Энэ хуулийн 4.1-д заасан этгээд хөрөнгө, орлогын мэдүүлгээ хугацаанд нь гаргаж өгөөгүй, эсхүл эх үүсвэрийг нь заагаагүй буюу түүнийг хэрхэн олсон талаар тайлбар гаргаагүй бол Авлигатай тэмцэх газар тухайн мэдүүлэг гаргагчийн хөрөнгө, орлогын мэдүүлгийг шалгана. | 13.5.Авлигатай тэмцэх газар өргөдөл, гомдол, мэдээллийн мөрөөр, эсхүл төлөвлөгөөт хяналтаар шалгалт явуулж болно. | 3.8.Мэдүүлэг гаргагч хөрөнгө, орлогын мэдүүлгээ хугацаа хожимдуулж гаргасан, эсхүл бүртгүүлээгүй буюу худал мэдүүлсэн бол дараах хариуцлага хүлээлгэнэ:<br><br>13.8.1.нэг сарын цалин хөлстэй тэнцэх хэмжээний хөрөнгө, орлогыг мэдүүлээгүй буюу худал мэдүүлсэн, хөрөнгө, орлогын мэдүүлгийг энэ хуулийн 10.4, 10.5-д заасан хугацаанаас хожимдуулсан нь хүндэтгэн үзэх шалтгаантай бол сануулах;<br><br>*/Энэ заалтад 2014 оны 1 дүгээр сарын 24-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/*<br><br>13.8.2.зургаа хүртэл сарын цалин хөлстэй тэнцэх хэмжээний хөрөнгө, орлогыг мэдүүлээгүй буюу худал мэдүүлсэн, хөрөнгө, орлогын мэдүүлгээ удаа дараа хугацаа хожимдуулж гаргасан бол албан тушаалын цалингийн хэмжээг гурван сар хүртэл хугацаагаар 30 хувиар бууруулах;<br><br>13.8.3.зургаан сараас дээш нэг жил хүртэлх хугацааны цалинтай тэнцэх хэмжээний хөрөнгө, орлогыг мэдүүлээгүй буюу худал мэдүүлсэн бол албан тушаал |

| | | | |
|---|---|---|---|
| | 13.7.Мэдүүлэг гаргагч хөрөнгө, орлогын эх үүсвэрээ бодитой, үнэн зөв тайлбарлах үүрэгтэй. | | бууруулах, эсхүл албан тушаалын цалингийн хэмжээг гурван сар хүртэл хугацаагаар 30 хувиар бууруулах;<br>13.8.4.нэг жилийн цалинтай тэнцэх буюу түүнээс их хэмжээний хөрөнгө, орлогыг мэдүүлээгүй, худал мэдүүлсэн, эсхүл хөрөнгө, орлогын мэдүүлгийг гаргаж өгөөгүй, гаргахаас татгалзсан бол албан тушаалаас нь огцруулах буюу ажлаас халах.<br>13.9.Хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хяналт тавих үүргээ биелүүлээгүй, эсхүл холбогдох материалыг энэ хуулийн 10.3-т заасан хугацаанд ирүүлээгүй албан тушаалтныг эрх бүхий байгууллага, албан тушаалтан албан тушаалын цалингийн хэмжээг гурван сар хүртэл хугацаагаар 30 хувиар бууруулах, уг зөрчлийг удаа дараа гаргасан бол албан тушаал бууруулах сахилгын шийтгэл ногдуулна. |

**Бэхжүүлсэн хэм хэмжээ**

**14 дүгээр зүйл.Хөрөнгө, орлогын мэдүүлгийг нийтэд мэдээлэх**

14.1.Дараахь албан тушаалтны хөрөнгө, орлогын мэдүүлгийг тухайн оны 2 дугаар улиралд багтаан цахим мэдээллийн сүлжээнд байрлуулна:

14.1.1.Монгол Улсын Ерөнхийлөгч;

14.1.2.Улсын Их Хурлын дарга, дэд дарга, гишүүн;

14.1.3.Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, Монгол Улсын сайд, дэд сайд;

14.1.4.Үндсэн хуулийн цэцийн дарга, түүний орлогч, гишүүн;

14.1.5.Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, шүүгч, Шүүхийн ерөнхий зөвлөлийн гүйцэтгэх нарийн бичгийн дарга;

14.1.6.Улсын ерөнхий прокурор, түүний орлогч;

14.1.7.Монгол банкны Ерөнхийлөгч, тэргүүн дэд, дэд ерөнхийлөгч;

14.1.8.Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга;

14.1.9.Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга;

14.1.10.Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга;

14.1.11.Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга;

| |
|---|
| 14.1.12.Авлигатай тэмцэх газрын дарга, дэд дарга;<br>14.1.13.Санхүүгийн зохицуулах хорооны дарга, гишүүн, Хяналтын зөвлөлийн дарга, гишүүн;<br>14.1.14.Үндэсний статистикийн газрын дарга, дэд дарга;<br>14.1.15.Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга, гишүүн;<br>14.1.16.Сонгуулийн ерөнхий хорооны дарга, нарийн бичгийн дарга;<br>14.1.17.Төрийн албаны зөвлөлийн дарга, гишүүн;<br>14.1.18.Ерөнхий аудитор, түүний орлогч;<br>14.1.19.Засгийн газрын агентлагийн дарга;<br>14.1.20.аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн дарга;<br>14.1.21.аймаг, нийслэлийн Засаг дарга.<br>14.1.22.Монгол Улсын Ерөнхийлөгчийн болон Монгол Улсын Их Хурлын гишүүнд нэр дэвшигч.<br>14.2.Энэ хуулийн 14.1-д зааснаас бусад этгээдийн хөрөнгө, орлогын мэдүүлэг олон нийтэд нээлттэй байна.<br>14.3.Энэ хуулийн 4.1-д заасан этгээдийн хөрөнгө, орлогын сүүлийн 5 жилийн мэдүүлэг Авлигатай тэмцэх газрын цахим мэдээллийн сүлжээнд тавигдах ба иргэд мэдээлэл авах боломжийг хангана.<br>14.4.Иргэд бичгээр, амаар, цахим мэдээллийн сүлжээгээр дамжуулан мэдээлэл авч болох бөгөөд тэдгээрт мэдээлэл өгөх журмыг Авлигатай тэмцэх газар батална.<br>14.5.Авлигатай тэмцэх газар хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргах журмын биелэлтийн талаар жил бүр олон нийтэд мэдээлнэ. |

| ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ БАЙГУУЛЛАГА, ТҮҮНИЙ БҮРЭН ЭРХ | | | |
|---|---|---|---|
| **Тодорхойлсон хэм хэмжээ** | **Бэхжүүлсэн хэм хэмжээ** | **Зөвшөөрсөн хэм хэмжээ** | **Хориглосон хэм хэмжээ** |
| **15 дугаар зүйл.Авлигатай тэмцэх газар**<br>15.1.Авлигатай тэмцэх газар нь авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх, авлигаас урьдчилан сэргийлэх, авлигын гэмт хэргийг илрүүлэх зорилгоор гүйцэтгэх ажил, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах, энэ хуульд заасан этгээдийн хөрөнгө, орлогын мэдүүлгийг хянан шалгах чиг үүрэг бүхий хараат бус, бие даасан, төрийн тусгай байгууллага мөн. | 15.3.Авлигатай тэмцэх газрыг өөрчлөн байгуулах, татан буулгах асуудлыг Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмжийг үндэслэн Улсын Их Хурал шийдвэрлэнэ.<br>15.4.Авлигатай тэмцэх газар бэлгэ тэмдэгтэй байх бөгөөд түүний тодорхойлолт, загвар, хэрэглэх журмыг Авлигатай тэмцэх газрын дарга батална.<br>15.5.Авлигатай тэмцэх газар тогтоосон журмаар үйлдсэн тамга, тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ. | 15.2.Энэ хуулийн 15.1-д заасан газрын харьяанд авлигатай тэмцэхтэй холбогдсон судалгаа шинжилгээ хийх үүрэг бүхий бүтцийг байгуулж болно. | 16.2.Аливаа албан тушаалтан, хувь хүн, хуулийн этгээд Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагаанд нөлөөлөх, хөндлөнгөөс оролцохыг хориглоно. |

<table>
<tr><th colspan="2">Бэхжүүлсэн хэм хэмжээ</th></tr>
<tr><td colspan="2">16 дугаар зүйл.Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагааны үндсэн зарчим<br><br>16.1.Авлигатай тэмцэх газар нь нэгдмэл удирдлагатай, бие даасан байх бөгөөд үйл ажиллагаандаа хууль дээдлэх, хараат бус, ил тод байх, нууцыг чанд сахих зарчмыг баримтална.<br><br>17 дугаар зүйл.Авлигатай тэмцэх газрын бүтэц<br><br>17.1.Авлигатай тэмцэх газрын зохион байгуулалтын бүтэц, орон тоог Улсын Их Хурал батлах бөгөөд урьдчилан сэргийлэх, судалгаа дүн шинжилгээний, хяналт шалгалтын, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаах, гүйцэтгэх ажлын, захиргааны чиглэлийн гэсэн үндсэн бүтэцтэй байна</td></tr>
<tr><th colspan="2">18 дугаар зүйл.Авлигатай тэмцэх газрын чиг үүрэг, бүрэн эрх</th></tr>
<tr><th>Үүрэг болгосон хэм хэмжээ</th><th>Зөвшөөрсөн хэм хэмжээ</th></tr>
<tr><td rowspan="3">18.1.Авлигатай тэмцэх газар олон нийтийг соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:<br><br>18.1.1.улсын хэмжээнд авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах, үйл ажиллагааг нь уялдуулан зохицуулах, нэгдсэн хөтөлбөр боловсруулах, арга зүйн удирдлагаар хангах, хэрэгжилтэнд нь хяналт тавих;<br><br>18.1.2.авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах, үйл ажиллагааг нь уялдуулан зохицуулах талаар аймаг, нийслэл, сум, дүүрэг дэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх орон тооны бус зөвлөлд үүрэг, чиглэл өгөх;<br><br>18.1.3.авлигын цар хүрээ, хэлбэр, шалтгааныг 2 жилд нэгээс доошгүй удаа судлан авлигын индексийг гаргаж олон нийтэд мэдээлэх;<br><br>18.1.4.төрийн бус байгууллага, иргэдээс авлигатай тэмцэх талаар явуулж байгаа үйл ажиллагаа, гаргасан санал, санаачилгыг дэмжин туслах, тэдний оролцоог нэмэгдүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авах;<br><br>18.1.5.авлигын нийгмийн хор аюулыг олон нийтэд ухуулан сурталчлах ажлыг тасралтгүй явуулах, олон нийтийн авлигын талаархи мэдлэгийг дээшлүүлэх, түүнтэй тэмцэх арга барилд сургах ажлыг зохион байгуулах чиглэлээр сургалт, сурталчилгаа хийх;<br><br>18.1.6.авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх ажлын талаар зөвлөмж гаргах, байгууллага, иргэний хүсэлтээр түүний үйл ажиллагаан дахь авлигад өртөх боломжийг багасгах талаар заавар, зөвлөгөө өгөх;<br><br>18.1.7.төрийн үйлчилгээ авсан иргэд, байгууллагын судалгаанд тулгуурлан төрийн байгууллагын шударга байдлын түвшинд 2 жил тутамд үнэлгээ гаргаж, олон нийтэд мэдээлэх.<br><br>18.2.Авлигатай тэмцэх газар хөрөнгө, орлогын мэдүүлгийг хянан шалгах чиглэлээр дараахь чиг үүрэгтэй:<br><br>18.2.1.хөрөнгө, орлогын мэдүүлгийг үнэн зөв гаргах талаар сургалт явуулах, гарын авлага, зааварчилгаа гаргах;<br><br>18.2.2.мэдүүлэг гаргагчийн амаар болон бичгээр ирүүлсэн хүсэлтийн дагуу мэдүүлгийг хэрхэн бөглөх, нэмэлт оруулах, бүртгэх, шилжүүлэх талаар урьдчилан зөвлөгөө өгөх, бичгээр хариу мэдэгдэх, асуулт хариултын нууцыг хадгалах.<br><br>18.3.Авлигатай тэмцэх газар чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн аж ахуйн нэгжийн удирдах албан тушаалтан өөрийн эрх хэмжээний хүрээнд хамтран ажиллана.</td>
<td>18.5.Авлигатай тэмцэх газар Улсын ерөнхий прокурорын шийдвэрээр тодорхой хэргийг цагдаа, тагнуулын байгууллагатай хамтран шалгаж болно.</td></tr>
<tr><th>Бэхжүүлсэн хэм хэмжээ</th></tr>
<tr><td>18.6.Авлигатай тэмцэх газар нь тодорхой хэрэгт гүйцэтгэх болон хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулахдаа Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Гүйцэтгэх ажлын тухай хууль, энэ хуульд заасан журмыг баримтална.</td></tr>
</table>

| | |
|---|---|
| 18.4.Авлигатай тэмцэх газар дараахь бүрэн эрхтэй:<br>18.4.1.авлигын эсрэг явуулах төрийн бодлого, шийдвэр, түүнчлэн авлигын эсрэг хууль тогтоомжийг боловсронгуй болгох талаар санал боловсруулж эрх бүхий байгууллагад оруулах;<br>18.4.2.авлига гарч болох нөхцөл боломж бүрдүүлсэн гэж үзвэл төрийн байгууллага, албан тушаалтны гаргасан тушаал, шийдвэр, журам, дүрмийг хянаж хүчингүй болгуулах санал боловсруулж эрх бүхий байгууллагад оруулах;<br>18.4.3.авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх ажилтай холбогдуулан төрийн байгууллагаас холбогдох мэдээ, судалгаа, тайланг гаргуулан авах;<br>18.4.4.аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан, иргэнээс шаардлагатай мэдээлэл, судалгаа, тайлбар, тодорхойлолт, бусад баримт бичгийг үнэ төлбөргүйгээр гаргуулан авах, танилцах, мэргэжлийн дүгнэлт, магадлагаа гаргуулах;<br>18.4.5.авлигын гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох зорилгоор гүйцэтгэх ажил явуулах, гүйцэтгэх ажил эрхэлдэг бусад байгууллагуудтай хамтран ажиллах;<br>18.4.6.авлигын холбогдолтой өргөдөл, гомдлыг хүлээн авч шалгах;<br>18.4.7.хуулиар харьяалуулсан хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах;<br>18.4.8.чиг үүрэгтээ холбогдох асуудлаар мэдээ, мэдээлэл авах, мэдээллийн нууцыг хадгалах;<br>18.4.9. өөрийн байгууллага, ажилтныхаа аюулгүй байдлыг хангах арга хэмжээ авах;<br>18.4.10.гүйцэтгэх ажил, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад албан тушаалтан буюу иргэнд ил болсон нууцыг задруулахгүйн тулд уг этгээдээс бичгээр баталгаа гаргуулан авах, баталгааг зөрчсөн тохиолдолд зохих хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэх;<br>18.4.11.хуулиар харьяалуулсан хэргийг шалгах явцад илэрсэн авлигын гэмт хэрэгтэй холбоогүй хууль зөрчсөн бусад үйлдлийг шалгуулахаар эрх бүхий байгууллагад шилжүүлэх, энэ хуулийн 6.6, 7.1.7, 7.1.8-д заасан зөрчлийг хянан шалгаж, эрх бүхий байгууллагад хүргүүлэх;<br>18.4.12.Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд заасан хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх;<br>18.4.13.хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргавал зохих этгээдийн жагсаалтыг холбогдох байгууллагаас гаргуулан авч хянах;<br>18.4.14.хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хадгалах, хяналт тавих, мэдээлэл өгөх журмын биелэлтийг шалгах;<br>18.4.15.мэдүүлэг гаргагчийн хөрөнгө, орлогын мэдүүлэгт хяналт тавих, шалгах, хугацаа хожимдуулсан буюу санаатай худал мэдүүлсэн этгээдэд холбогдох хуульд заасан арга хэмжээг авахуулахаар эрх бүхий байгууллагад шилжүүлэх;<br>18.4.16.хөрөнгө, орлогын мэдүүлэгтэй холбоотой асуудлаар бичгээр дүгнэлт, зөвлөмж гаргах;<br>18.4.17.авлигатай тэмцэх асуудлаар гадаад орнуудын болон олон улсын холбогдох байгууллагатай хамтран ажиллах, мэдээлэл солилцох. | |
| **19 дүгээр зүйл.Авлигатай тэмцэх газрын албан хаагчид тавигдах шаардлага** | |

| Бэхжүүлсэн хэм хэмжээ | Хамгаалсан хэм хэмжээ | Хориглосон хэм хэмжээ |
|---|---|---|
| 19.1.Авлигатай тэмцэх газрын удирдах болон гүйцэтгэх албан тушаалд мэргэжлийн болон зохих нөхцөл, шалгуурыг хангасан, авлига, албан тушаалын хэргээр шалгагдаж сахилгын, захиргааны, эрүүгийн хариуцлага хүлээж байгаагүй иргэнийг томилно.<br><br>19.2.Авлигатай тэмцэх газрын албан хаагчийн ёс зүйн болон сахилгын дүрмийг Авлигатай тэмцэх газрын дарга батална.<br><br>19.3.Авлигатай тэмцэх газрын албан хаагч зэрэг дэвтэй байх бөгөөд түүнийг олгох журмыг Улсын Их Хурал батална.<br><br>19.4.Авлигатай тэмцэх газрын захиргаа, үйлчилгээний ажилтны эрх зүйн байдлыг Төрийн албаны тухай, Хөдөлмөрийн тухай хууль болон хууль тогтоомжийн бусад актаар зохицуулна.<br><br>**20 дугаар зүйл.Авлигатай тэмцэх газрын албан хаагчийн тангараг**<br><br>20.1.Авлигатай тэмцэх газрын албан хаагч томилогдсон даруйдаа "Авлигатай тэмцэх газрын ажилтан би хэний ч нөлөөнд үл автан, зөвхөн хуульд захирагдан үнэнч шударгаар авлигатай тэмцэхээ батлан тангараглая. Миний бие энэ тангаргаасаа няцвал хуулийн хариуцлага хүлээнэ." гэж Монгол Улсын Үндсэн хуульд тангараг өргөнө.<br><br>**21 дүгээр зүйл.Авлигатай тэмцэх газрын дарга, дэд даргыг томилох, тэдгээрийн бүрэн эрхийн хугацаа**<br><br>21.1.Авлигатай тэмцэх газрын даргыг Ерөнхий | **22 дугаар зүйл.Авлигатай тэмцэх газрын дарга, дэд даргыг чөлөөлөх, түдгэлзүүлэх, огцруулах**<br><br>22.1.Авлигатай тэмцэх газрын дарга, дэд даргыг дараахь тохиолдолд үүрэгт ажлаас нь чөлөөлнө:<br><br>22.1.1.өөрөө хүсэлт гаргасан;<br><br>22.1.2.биеийн эрүүл мэндийн байдлаас үүрэгт ажлаа гүйцэтгэх боломжгүй болсон;<br><br>22.1.3.бүрэн эрхийн хугацаа дуусгавар болсон.<br><br>22.2.Авлигатай тэмцэх газрын дарга, дэд дарга гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдож, шүүхийн шийтгэх тогтоол хүчин төгөлдөр болсон бол энэ өдрөөс эхлэн түүнийг албан тушаалаас нь огцруулсанд тооцно.<br><br>22.3.Авлигатай тэмцэх газрын дарга, дэд дарга огцрох тухай хүсэлтээ Улсын Их Хуралд бичгээр гаргаж болох бөгөөд уг хүсэлтийг Улсын Их Хурлын чуулганы үед гаргасан бол 21 хоногийн дотор, чуулганы чөлөө цагт гаргасан бол чуулган эхэлснээс хойш 21 хоногийн дотор хэлэлцэж шийдвэрлэнэ.<br><br>22.4.Авлигатай тэмцэх газрын дарга, дэд дарга гэмт хэрэгт холбогдсон, түүнчлэн энэ хуулийн 31.2-т заасны дагуу баривчлагдсан бөгөөд Улсын ерөнхий прокурор түүний бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх тухай санал Улсын Их Хуралд оруулсан бол уг саналыг хүлээж авснаас хойш 14 хоногийн дотор хэлэлцэж шийдвэрлэнэ. | 22.5.Хуульд зааснаас бусад үндэслэлээр Авлигатай тэмцэх газрын дарга, дэд даргыг үүрэгт ажлаас нь чөлөөлөх, бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх буюу огцруулахыг хориглоно. |

| | | |
|---|---|---|
| сайдын санал болгосноор Улсын Их Хурал томилгооны сонсгол хийж 6 жилийн хугацаагаар томилно.<br><br>21.2.Авлигатай тэмцэх газар дэд даргатай байна. Дэд даргыг Авлигатай тэмцэх газрын даргын санал болгосноор Улсын Их Хурал томилгооны сонсгол хийж 6 жилийн хугацаагаар томилно.<br><br>21.3.Авлигатай тэмцэх газрын дарга, дэд дарга энэ хуулийн 19.1-д зааснаас гадна дараах шаардлагыг хангасан байна:<br><br>21.3.1.Авлигатай тэмцэх газрын дарга төрийн албанд 15-аас доошгүй жил ажилласан, 45 нас хүрсэн, эрх зүйч мэргэжилтэй, удирдах болон мэргэжлийн ажлын мэдлэг туршлагатай, сүүлийн 5 жил улс төрийн албан тушаал эрхэлж байгаагүй;<br><br>21.3.2.Авлигатай тэмцэх газрын дэд дарга төрийн албанд 10-аас доошгүй жил ажилласан, эрх зүйч мэргэжилтэй, гүйцэтгэх болон мөрдөн байцаах ажлын мэдлэг, туршлагатай, сүүлийн 5 жил улс төрийн албан тушаал эрхэлж байгаагүй.<br><br>21.4.Авлигатай тэмцэх газрын дарга, дэд даргыг нэг удаа улируулан томилж болно.<br><br>21.5.Авлигатай тэмцэх газрын дарга, дэд даргын бүрэн эрх нь түүнийг томилсон тухай Улсын Их Хурлын шийдвэр гарснаар эхэлж, дараагийн дарга, дэд дарга томилогдсоноор дуусгавар болно.<br><br>21.6.Авлигатай тэмцэх газрын дарга, дэд дарга нөхөн томилогдвол түүний бүрэн эрх нь томилогдсон өдрөөс эхлэн энэ хуулийн 21.1, 21.2-т заасан бүрэн эрхийн үлдсэн хугацааг дуустал үргэлжилнэ. | | |

| | | |
|---|---|---|
| | | |

| Үүрэг болгосон хэм хэмжээ | Эрх олгосон хэм хэмжээ |
|---|---|
| **23 дугаар зүйл.Авлигатай тэмцэх газрын даргын бүрэн эрх**<br>23.1.Авлигатай тэмцэх газрын дарга дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:<br>23.1.1.Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагааг нэгтгэн зохион байгуулж, удирдах;<br>23.1.2.Авлигатай тэмцэх газрыг дотоод, гадаад харилцаанд төлөөлөх;<br>23.1.3.эрх тэгш байх, харилцан хүндэтгэх, дотоод хэрэгт нь үл оролцох зарчмын үндсэн дээр гадаад улсын тусгай алба, байгууллагатай харилцан ажиллах;<br>23.1.4.Авлигатай тэмцэх газрын албан хаагчийг томилох, чөлөөлөх, зэрэг дэв, нэмэгдэл олгох, урамшуулах, сахилгын шийтгэл ногдуулах;<br>23.1.5.Авлигатай тэмцэх газрын дотоод үйл ажиллагаатай холбогдсон дүрэм, журам, заавар баталж мөрдүүлэх;<br>23.1.6.Авлигатай тэмцэх газрын хүний нөөц, зохион байгуулалт, үйл ажиллагаатай холбоотой асуудлаар тушаал гаргах;<br>23.1.7.гүйцэтгэх болон хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажилтай танилцах;<br>23.1.8.Гүйцэтгэх ажлын тухай хуульд заасны дагуу нууц арга, хэрэгсэл ашиглах зөвшөөрөл олгох;<br>23.1.9.гүйцэтгэх ажлын техник хэрэгсэл олж авах, | **24 дүгээр зүйл.Авлигатай тэмцэх газрын гүйцэтгэх ажил, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт эрхэлсэн албан хаагчийн эрх**<br>24.1.Авлигатай тэмцэх газрын гүйцэтгэх ажил, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт эрхэлсэн албан хаагч хуульд заасан журмын дагуу дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:<br>24.1.1.Гүйцэтгэх ажлын тухай хуульд заасан гүйцэтгэх ажилтны эрх, үүргийг эдэлж, хуульд заасан үндэслэл, журмын дагуу гүйцэтгэх ажил явуулах;<br>24.1.2.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан мөрдөгчийн эрх, үүргийг эдэлж, хуульд заасан үндэслэл, журмын дагуу хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулах;<br>*/Энэ заалтад 2017 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/*<br>24.1.3.аж ахуйн нэгж, байгууллагын байранд нэвтрэн орох;<br>24.1.4.аж ахуйн нэгж, байгууллага, иргэний банкинд байгаа данс, гүйлгээг шалгах, түр зогсоох;<br>24.1.5.хуульд заасан үндэслэл, журмын дагуу хөрөнгө битүүмжлэх;<br>24.1.6.албан тушаалтан, иргэнээс тайлбар гаргуулах, мэдүүлэг авах, түүнийг албадан ирүүлэх;<br>24.1.7.албан үүргээ гүйцэтгэх явцдаа хойшлуулшгүй тохиолдолд дипломат төлөөлөгч, төрийн өндөр болон түүнтэй адилтгах албан тушаалтан, үүргээ гүйцэтгэж яваа эмнэлгийн түргэн тусламж, гал унтраах алба, техникийн ослын дуудлагынхаас бусад авто тээврийн болон холбооны хэрэгслийг өмчийн төрөл, хэлбэр харгалзахгүйгээр дайчлах, ашиглах;<br>24.1.8.албан үүргээ гүйцэтгэх явцдаа галт зэвсэг, бие хамгаалах тусгай хэрэгсэл, мэх хэрэглэх;<br>24.1.9.албан үүргээ гүйцэтгэх явцдаа зорчигч тээврийн болон холбооны хэрэгслээр дараалал харгалзахгүйгээр үйлчлүүлэх;<br>24.1.10.Авлигатай тэмцэх газрын чиг үүрэгт хамаарах бусад бүрэн эрх.<br>24.2.Галт зэвсэг, бие хамгаалах тусгай хэрэгсэл, мэх хэрэглэх журмыг Улсын ерөнхий прокурор, Авилгатай тэмцэх газрын дарга хамтран батална.<br>24.3.Энэ хуулийн 24.1.7-д заасны дагуу хувийн өмчийн тээврийн хэрэгслийг ашигласан бол холбогдох хөлс болон гарсан зардлыг нөхөн төлнө. |

| | |
|---|---|
| эзэмших, ашиглах, захиран зарцуулах шийдвэр гаргах;<br>23.1.10.байгууллагынхаа ажилд тавих дотоод хяналтыг хэрэгжүүлэх;<br>23.1.11.хуульд заасан бусад бүрэн эрх.<br>23.2.Авлигатай тэмцэх газрын даргын түр эзгүйд түүний шийдвэрээр дэд дарга бүрэн эрхийг нь хэрэгжүүлнэ. | |

**Хориглосон хэм хэмжээ**

**25 дугаар зүйл.Авлигатай тэмцэх газрын албан хаагчийн үйл ажиллагаанд хориглох зүйл**

25.1.Авлигатай тэмцэх газрын албан хаагч Төрийн албаны тухай хууль болон энэ хуулийн 7 дугаар зүйлд заасан хориглох үйлдлээс гадна дараахь үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

25.1.1.нам, үйлдвэрчний эвлэл, шашны байгууллага, тэдгээртэй адилтгах бусад байгууллагын гишүүнээр элсэх, удирдах албан тушаалд сонгогдох, томилогдох;

25.1.2.албан үүрэгтэй нь холбогдож илэрхий болсон буюу өөрт нь итгэмжлэн мэдэгдсэн төр, байгууллага, хувь хүний нууцыг задруулах;

25.1.3.удирдлагын тусгайлан өгсөн зөвшөөрөлгүйгээр албан ажлын-хаа талаар нийтэд болон бусдад мэдээлэл өгөх, мэдээлэл дамжуулах;

25.1.4.Авлигатай тэмцэх газрын даргын зөвшөөрөлгүйгээр албаны болон хувийн ажлаар гадаадад зорчих;

25.1.5.дотоод, гадаадын байгууллага, аж ахуйн нэгж, хувь хүний зардлаар аялах, жуулчлах, амрах;

25.1.6.тогтоосон журмыг зөрчиж бусдаас бэлэг дурсгалын зүйл авах.

25.2.Авлигатай тэмцэх газрын албан хаагчид нь хоорондоо нэг гэр бүлийн буюу төрөл садангийн холбоотой байхыг хориглоно.

25.3.Авлигатай тэмцэх газрын албан хаагч албан үүрэг гүйцэтгэж байх үедээ өөрт нь илэрхий болсон нууцыг үүрэгт ажлаасаа чөлөөлөгдсөнөөс хойш ямар нэгэн зорилгоор ашиглахыг хориглоно.

**Бэхжүүлсэн хэм хэмжээ**

**26 дугаар зүйл.Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагаанд тавих хяналт**

26.1.Улсын Их Хурал авлигатай тэмцэх хууль тогтоомжийн хэрэгжилт, авлигын ерөнхий нөхцөл байдлын талаар Авлигатай тэмцэх газрын мэдээллийг жил бүр мэдээлнэ.

*/Энэ хэсэгт 2008 оны 5 дугаар сарын 29-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/*

26.2.Авлигатай тэмцэх газар гүйцэтгэх ажлын тухай хууль тогтоомжийг хэрхэн биелүүлж байгааг Улсын Их Хурлын Тусгай хяналтын дэд хороо хянан шалгана.

26.3.Прокурорын байгууллага нь Авлигатай тэмцэх газрын гүйцэтгэх болон хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын үйл ажиллагаанд Гүйцэтгэх ажлын тухай хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Прокурорын байгууллагын тухай хуульд заасан үндэслэл журмын дагуу хяналт тавина.

**ОЛОН НИЙТИЙН ЗӨВЛӨЛ**

| Бэхжүүлсэн хэм хэмжээ | Хориглосон хэм хэмжээ |
|---|---|

| | |
|---|---|
| 27.1.Авлигатай тэмцэхэд олон нийтийг идэвхтэй оролцуулах, тэдний санал бодлыг хүргэх, авлигын нөхцөл байдал, авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар зөвлөмж өгөх зорилго бүхий орон тооны бус олон нийтийн зөвлөл Авлигатай тэмцэх газрын дэргэд ажиллана.<br><br>27.2.Олон нийтийн зөвлөл 15 гишүүний бүрэлдэхүүнтэй байх ба зөвлөлийн гишүүнээр ял шийтгэлгүй, иргэний нийгмийг төлөөлөх иргэнийг Монгол Улсын Ерөнхийлөгч 4 жилийн хугацаагаар томилно.<br><br>27.5.Олон нийтийн зөвлөлийн ажиллах журмыг Монгол Улсын Ерөнхийлөгч батална. | 27.3.Олон нийтийн зөвлөлийн гишүүнд төрийн улс төрийн болон төрийн жинхэнэ албан хаагчийг нэр дэвшүүлэхгүй.<br><br>27.4.Олон нийтийн зөвлөлийн гишүүн Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагаанд хамаарах нууцыг задруулахыг хориглоно. |

**АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БАТАЛГАА**

| Хориглосон хэм хэмжээ | Бэхжүүлсэн хэм хэмжээ | Үүрэг болгосон хэм хэмжээ |
|---|---|---|
| **28 дугаар зүйл.Улс төрийн баталгаа**<br><br>28.1.Авлигатай тэмцэх газрын байранд улс төрийн нам, эвсэл, холбоо, хөдөлгөөний болон шашны үйл ажиллагаа явуулахыг хориглоно.<br><br>**30 дугаар зүйл.Нийгмийн баталгаа**<br><br>30.1.Авлигатай тэмцэх газрын албан хаагчийг хуульд заасныас бусад тохиолдолд ажлаас чөлөөлөх, огцруулах, түүнчлэн өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр өөр ажил, албан тушаалд шилжүүлэхийг хориглоно.<br><br>**31 дүгээр зүйл.Хууль зүйн баталгаа**<br><br>31.1.Авлигатай тэмцэх газрын дарга, дэд даргыг Улсын Их Хурлын зөвшөөрөлгүйгээр, бусад албан хаагчийг Авлигатай тэмцэх газрын даргын зөвшөөрөлгүйгээр албадан саатуулах, цагдан хорих, баривчлах, орон байр, албан тасалгаа, унаа болон биед нь үзлэг, нэгжлэг хийхийг хориглоно.<br><br>**32 дугаар зүйл.Бусад баталгаа**<br><br>32.1.Авлигатай тэмцэх газрын албан хаагч эрдэм шинжилгээнийхээс бусад хуулиар тогтоосон үүрэгт нь | 28.2.Авлигатай тэмцэх газрын албан хаагч үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөө эдлэхдээ өөрийн албандаа хүндэтгэлтэй хандана.<br><br>**29 дүгээр зүйл.Эдийн засгийн баталгаа**<br><br>29.1.Авлигатай тэмцэх газрын зардлыг улсын төсвөөс санхүүжүүлж, үйл ажиллагаа явуулах эдийн засгийн баталгааг төр хангана.<br><br>29.2.Авлигатай тэмцэх газрын төсвийг улсын төсөвт тусгайлан тусгах бөгөөд энэхүү төсөв нь үйл ажиллагаагаа хараат бусаар хэрэгжүүлэх шаардлагыг хангасан байна.<br><br>29.4.Авлигатай тэмцэх газрын гүйцэтгэх ажлын төсвийг Улсын Их Хурлын Тусгай хяналтын дэд хороооос хянаж, санал болгосноор Улсын Их Хурал батална.<br><br>29.5.Авлигатай тэмцэх газрыг ажлын байр, шаардлагатай тоног төхөөрөмж, тээврийн болон техник хэрэгсэл, албан хаагчийг орон сууцаар хангах, авлигатай тэмцэх үйл ажиллагааны явцад туслалцаа үзүүлсэн этгээд, гэрчийг хамгаалах, тэдгээрт санхүүгийн туслалцаа үзүүлэхтэй холбогдсон зардлыг улсын төсөвт тусгаж санхүүжүүлнэ.<br><br>29.6.Авлигатай тэмцэх газрын дарга, дэд дарга, албан хаагчийн цалин хөлс нь албан тушаалын цалин, албан ажлын онцгой нөхцөлийн, төрийн алба хаасан хугацааны, зэрэг дэвийн, эрдмийн зэргийн нэмэгдлээс бүрдэх бөгөөд тэдгээрийн хэмжээг Улсын Их Хурал тогтооно.<br><br>29.7.Авлигатай тэмцэх газарт тогтвор суурьшилтай, үр бүтээлтэй ажилласан | 32.4.Бүрэн эрхийнхээ хүрээнд Авлигатай тэмцэх газрын албан хаагчийн тавьсан хууль ёсны шаардлагыг иргэн, албан тушаалтан харьяалал харгалзахгүйгээр биелүүлэх үүрэгтэй. |

| | | |
|---|---|---|
| үл хамаарах ажил, албан тушаал хавсран гүйцэтгэхийг хориглоно. | албан хаагчид аминдаа орон сууц барих, амьдралын нэн тэргүүний хэрэгцээт зүйл худалдан авах, өөрийн хүсэлтээр суралцах болон хүүхдээ сургахад нь төрөөс хөнгөлөлттэй зээл олгох, шаардлагатай бол зээлийн баталгаа гаргаж өгнө.<br><br>29.8.Авлигатай тэмцэх газрын дарга, дэд дарга нь Засгийн газрын гишүүнтэй адил бүрэн эрхийн баталгаа, хангамжтай байна.<br><br>**30 дугаар зүйл.Нийгмийн баталгаа**<br><br>...30.2.Авлигатай тэмцэх газрын албан хаагч албан үүргээ гүйцэтгэж байхдаа хөдөлмөрийн чадвараа түр алдсан буюу хөгжлийн бэрхшээлтэй болсон бол түүний авч байсан цалин, тэтгэвэр, тэтгэмжийн зөрүүг, хэрэв хиймэл эрхтэн хийлгэсэн бол түүний зардлыг төр хариуцна.<br><br>30.3.Авлигатай тэмцэх газрын албан хаагч албан үүргээ гүйцэтгэж байхдаа амь насаа алдсан буюу албан үүрэгтэй нь холбогдуулан амь насыг нь хохироосон бол түүний ар гэрт 5 жилийн цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн буцалтгүй тусламж олгоно.<br><br>30.4.Авлигатай тэмцэх газарт 10-аас доошгүй жил ажилласан албан хаагч өндөр насны тэтгэвэр тогтоолгох бол түүнд албан тушаалынх нь 36 сар хүртэл цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн буцалтгүй тусламж олгоно.<br><br>30.5.Авлигатай тэмцэх газрын албан хаагчийн амь нас, эрүүл мэндийг заавал даатгах бөгөөд даатгалын төлбөрийг тухайн байгууллагын төсвөөс төлнө.<br><br>30.6.Авлигатай тэмцэх газрын албан хаагчийн ээлжийн амралтын үндсэн хугацааг Хөдөлмөрийн тухай хуулиар тогтоох бөгөөд гүйцэтгэх ажил эрхэлсэн, түүнчлэн мөрдөгчөөр ажилласан 5 жил тутамд ажлын 3 өдрийн нэмэгдэл амралт олгоно.<br><br>30.7.Авлигатай тэмцэх газрын албан хаагч төрийн албаны тухай хууль тогтоомжид заасан төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, баталгаа, нэмэгдэл баталгаа, цалин хөлс, нөхөн төлбөр, тусламж, шагнал урамшил, тэтгэмжээс гадна энэ хуульд заасан баталгаагаар хангагдана.<br><br>30.8.Энэ хуулийн 30.7-д заасан баталгааг Авлигатай тэмцэх газрын албан хаагчид эдлүүлэхдээ ижил төрлийн тэтгэвэр, тэтгэмж, тусламж, нэмэгдлийг давхардуулж олгохгүй бөгөөд сонголтыг Авлигатай тэмцэх газрын албан хаагч өөрөө хийнэ. | |

<table>
<tr><td></td><td>30.9.Авлигатай тэмцэх газарт гүйцэтгэх ажилтан, мөрдөгчөөр ажилласан хугацааг цэргийн алба хаасан хугацаанд тооцно.<br><br>30.10.Авлигатай тэмцэх газрын мөрдөгч, гүйцэтгэх ажилтан тусгай ажиллагаанд оролцохдоо байгууллагын бэлгэ тэмдэг бүхий зориулалтын хувцас хэрэглэх бөгөөд уг хувцасны загварыг Авлигатай тэмцэх газрын дарга батална.<br><br>31 дүгээр зүйл.Хууль зүйн баталгаа<br><br>...31.2.Авлигатай тэмцэх газрын албан хаагчийг гэмт хэрэг үйлдэж байхад нь буюу гэмт хэргийн газар гэмт үйлдлийнх нь нотлох баримттайгаар баривчилсан бол Авлигатай тэмцэх газрын дарга, дэд даргын талаар Улсын Их Хуралд, бусад албан хаагчийн талаар Авлигатай тэмцэх газрын даргад 48 цагийн дотор мэдэгдэнэ.<br><br>31.3.Авлигатай тэмцэх газрын албан хаагч гэмт хэрэгт холбогдсон, түүнчлэн энэ хуулийн 31.2-т заасны дагуу баривчлагдсан бөгөөд эрх бүхий байгууллагаас түүний бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх тухай санал тавьсан бол түүнийг хүлээн авснаас хойш 10 хоногийн дотор Авлигатай тэмцэх газрын дарга шийдвэрлэнэ.<br><br>31.4.Авлигатай тэмцэх газрын албан хаагч бүрэн эрхээ хэрэгжүүлэх явцад гаргасан алдааны улмаас учирсан хохирлыг төр хариуцна.<br><br>32 дугаар зүйл.Бусад баталгаа<br><br>...32.2.Авлигатай тэмцэх газрын албан хаагч албан дайчилгаанаас чөлөөлөгдөнө.<br><br>32.3.Албаны чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбогдуулан Авлигатай тэмцэх газрын албан хаагч болон гэр бүлийнх нь гишүүдийн амь нас, эрүүл мэндэд бодит аюул заналхийлсэн тохиолдолд цагдаагийн байгууллага тэдний аюулгүй байдлыг хангах арга хэмжээ авна.<br><br>...32.5.Авлигатай тэмцэх газрын албан хаагч эрх бүхий албан тушаалтны өгсөн тушаал, даалгаврыг ёсчлон биелүүлснээс үүссэн хохирол, сөрөг үр дагаврыг тушаал, даалгавар өгсөн албан тушаалтан хариуцна.<br><br>32.6.Авлигатай тэмцэх газрын байр төрийн хамгаалалтад байна.</td><td></td></tr>
<tr><td colspan="3">Бэхжүүлсэн хэм хэмжээ</td></tr>
<tr><td colspan="3">$32^{1}$ дүгээр зүйл.Хуулийн хэрэгжилтэд хяналт тавих этгээд<br><br>$32^{1}$.1.Энэ хуулийг холбогдох байгууллага, албан тушаалтан хэрхэн дагаж мөрдөж байгаад дараах байгууллага хяналт тавина:</td></tr>
</table>

$32^{1}$.1.1.Авлигатай тэмцэх газар, Шүүхийн ерөнхий зөвлөлийн үйл ажиллагааг Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо;

$32^{1}$.1.2.энэ хуулийн $32^{1}$.1.1-д зааснаас бусад төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагааг Авлигатай тэмцэх газар;

$32^{1}$.1.3.Олон нийтийн зөвлөл нь Авлигатай тэмцэх газрын хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт болон гүйцэтгэх ажил явуулахаас бусад үйл ажиллагаанд хяналт тавих.

**Бэхжүүлсэн хэм хэмжээ**

**34 дүгээр зүйл.Авлигын гэмт хэргийн улмаас учирсан үр дагаврыг арилгах**

34.1.Авлигын гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг арилгах, зөрчигдсөн эрхийг сэргээн тогтоох, хууль бус аливаа шийдвэрийг хүчингүй болгох асуудлыг Иргэний хууль болон холбогдох бусад хуульд заасны дагуу шийдвэрлэнэ.